



Хүний Эрхийн Үндэсний Комисс

**“ЗОХИСТОЙ АЮУЛГҮЙ ХООЛ ХҮНСЭЭР
ЖИГД, ХҮРТЭЭМЖТЭЙ ХАНГАГДАХ
ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ”**

СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**Улаанбаатар хот
2005 он**

АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт.....	i
Оршил	1

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

1.1. Судалгааны зорилго, зорилтууд.....	3
1.2. Судалгааны арга аргачлал, хамрах хүрээ.....	3
1.3. Судалгааны мэдээлэл боловсруулалт.....	4

ХОЁРДУГААР ХЭСЭГ: СУДАЛГААНЫ ҮР ДҮН

2.1. Зохистой хоол хүнсээр хангагдах эрхийн эрх зүйн зохицуулалт.....	6
2.1.1. Хүнсний эрхийн олон улсын эрх зүйн зохицуулалт	6
2.1.2. Хүнсний асуудлаарх хүний эрхийн олон улсын стандартыг үндэсний хууль тогтоомжид тусгасан байдал.....	13
2.1.3. Хүнсний эрхийг үндэсний хууль тогтоомжоор баталгаажуулсан байдал.....	18
2.2. Хүнсний хангамж баталгаа.....	20
2.2.1. Хүнсний хангамж, баталгааг хангах талаар төрөөс авч буй арга хэмжээ.....	21
2.2.2. Хүнсний хангамжийн өнөөгийн байдал.....	23
2.3. Хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдал.....	36
2.3.1. Хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдлын талаар төрөөс авч буй арга хэмжээ.....	37
2.3.2. Хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдлын өнөөгийн төлөв.....	47
2.4. Хоол тэжээл, түүний шимт чанартай холбоотой эрүүл мэндийн эрсдэл.....	56
2.4.1. Хоол тэжээлийн талаар төрөөс авч буй арга хэмжээ.....	56
2.4.2. Хоол тэжээл, түүнтэй холбоотой өвчлөлийн өнөөгийн байдал.....	62
2.5. Өрхийн хүнсний хангамж, баталгаа.....	73
2.5.1. Ядуурал ба өрхийн хүнсний хангамж, баталгаа.....	75

ГУРАВДУГААР ХЭСЭГ: ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ.....	84
--	----

ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ: АШИГЛАСАН ХЭВЛЭЛИЙН ЖАГСААЛТ.....	87
--	----

Хавсралт

© Хүний эрхийн үндэсний комисс. 2005 он

Судалгааны тайлан бичсэн

Д.Чимэддулам




ОИП.МН
СУДАЛГААНЫ САН

Товчилсон үгийн тайлбар:

ААД – А аминдэмийн дутал
АБТ – Амьжиргааны баталгаажих түвшин
АНУ – Америкийн Нэгдсэн Улс
АХБ – Азийн хөгжлийн банк
БЗД – Баянзүрх дүүрэг
БНХАУ – Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БСШУЯ – Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яам
ДНБ – Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДДТ – пестицидийн нэр томъёо
ДХХААБ – Дэлхийн Хүнс Хөдөө Аж Ахуйн Байгууллага
ДЭМБ – Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
ЖАЙКА (JICA – Japan International Cooperation Agency) – Японы олон улсын хамтын ажиллагааны агентлаг
ЗДТГ – Засаг Даргын Тамгын Газар
ЗДХ – Зөвшөөрөгдөх дээд хэмжээ
ИДЭ – Иод дутлын эмгэг
МХГ – Мэргэжлийн хяналтын газар
МЭҮХА – Мал эмнэлэг, үржлийн хяналтын алба
НЗД – Нийслэлийн засаг дарга
НМХГ – Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар
НҮБ – Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮБХС – НҮБ-ын Хүүхдийн сан
НЭМС – Нийгмийн эрүүл мэндийн сургууль
НЭМХ – Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн
НЭМХХ – Нийгмийн эрүүл мэндийн хяналтын хэлтэс
ОУ – Олон улс
ОХУ – Оросын Холбооны Улс
СХД – Сонгинохайрхан дүүрэг
ТББ – Төрийн бус байгууллага
ТҮЦ – Түргэн үйлчилгээний цэг
УИД – уураг илчлэгийн дутал
УИХ – Улсын Их Хурал
УМХГ – Улсын Мэргэжлийн Хяналтын Газар
ҮСГ - Үндэсний Статистикийн Газар
ҮХХХ - Үйлдвэрлэл, худалдааны хяналтын хэлтэс
ХАА – Хөдөө аж ахуй
ХАБ – Хүнсний аюулгүй байдал
ХАБХААХХ – Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн хяналтын хэлтэс
ХМХА – Хилийн мэргэжлийн хяналтын алба
ХӨСҮТ – Халдварт өвчин судлалын үндэсний төв
ХСТ – Хоол судлалын төв
ХТД – Хоол тэжээлийн дутал
ХҮТХА – Хүнсний үйлдвэр, технологийн хяналтын алба
ХҮҮСЧХА – Худалдаа, үйлдвэр, үйлчилгээ, стандарт чанарын хяналтын алба
ХХААБ – Хүнс Хөдөө Аж Ахуйн Байгууллага
ХХААЯ – Хүнс Хөдөө Аж Ахуйн Яам
ХЭДКГ – Хүний Эрхийн Дээд Комиссиарын Газар
ХЭҮК – Хүний Эрхийн Үндэсний Комисс
ШУБ – Шинжлэх ухаан, боловсрол

UIN.MN
СУДАЛГААНЫ САН



ЭАХС – Эрүүл ахуй, халдвар судлал

ЭАХСХА – Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын алба

ЭЗНСЭОУП – Эдийн засаг, нийгэм-соёлын эрхийн олон улсын Пакт

ЭЗНСЭХ – Эдийн Засаг, Нийгэм-Соёлын Эрхийн Хороо

ЭМНХЯ – Эрүүл мэнд, нийгэм хамгааллын яам

ЭМХХ – Эрүүл мэндийн хяналтын хэлтэс

ЭМШУИС – Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль

ЭМЯ – Эрүүл Мэндийн Яам

ЭСОБ – Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүн

Англи товчилсон үгийн тайлбар:

CAC (Codex Alimentarius Commission) – Хүнсний Хууль, Эрх зүйн Хороо

HACCP (Hazard Analysis and Critical Control Point) – Аюулын шинжилгээ ба хяналтын эгзэгтэй цэг

GHP (Good Hygiene Practice) – Эрүүл ахуйн зохистой дадал

GMP (Good Manufacture Practice) - Үйлдвэрлэлийн зохистой дадал

UNICEF (United Nation International Children and Education’s Fundation) -

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



Оршил

Хүн бүр эсэн мэнд амьдарч, хөдөлмөрлөх, эрүүл бие, саруул оюун ухаантай байх үндсэн нөхцөл бол хоол хүнс билээ.

Хүрэлцээтэй, шимт бодисын зохистой хэмжээ, агууламжтай, аюулгүй хоол хүнсийг авбал зохих хамгийн бага хэмжээ буюу өлсөхгүй байх хэмжээг хүний эрхэд тооцдог бөгөөд уг хүнсний эрхийг баталгаажуулах нь Олон улсын эрх зүйн нэг чухал асуудал мөн. Өнөөдөр манай улс нэгдэн орсон буюу соёрхон баталсан хүний эрхийн хэд хэдэн баримт бичгүүдэд зохистой хоол хүнсээр хангагдах эрхийг хүлээн зөвшөөрөөд байна. Тухайлбал: Хүний эрхийн түгээмэл тунхаглалд (1948): “Хүн бүр хоол хүнс . . . оролцуулаад өөрхийн болон ам бүлийнхээ эрүүл мэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхтэй” гэж заасан байдаг. Тэгвэл “Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай” Олон улсын Пактад (1966) эдгээр эдгээр асуудлыг улам боловсронгуй болгож: “хүн бүр . . . зохистой хоол хүнсээр хангагдах эрх”-ийг цохон тэмдэглээд, нэн тэргүүнд “өлсгөлөн, тэжээлийн доройтлоос ангид байх эрх”-ийг онцлон заасан байдаг. Өлсгөлөнгөөс ангид байх эрх нь амьдрах эрхтэй салшгүй холбоотой байдгаараа хүний үндсэн эрх юм.

Италийн ром хотноо 1992 онд болсон Олон улсын хоол тэжээлийн бага хурлаас гаргасан тунхаглалд “Хүнсний зохих нөөц болон оюуны сан хүрэлцээтэй байгаа манай гаригт өлсгөлөн, өлөн зэлмүүн байдал гарах учиргүй бөгөөд тэжээллэг, чанар, аюулгүй хүнс хэрэглэх явдал хүн бүрийн эдлэх эрх мөн” гэж тодохойлсон бол 1996 оны Дэлхийн Хүнсний дээд хэмжээний уулзалт дээр 185 орны төлөөлөгчид болоод Европын холбооны төрийн эрх баригчид Дэлхийн Хүнсний аюулгүй байдлын (Food Security) Ромын тунхаглалд: “Зохистой хоол хүнсээр хангагдах эрхэд нийцүүлэн хүн бүр аюулгүй, шим тэжээллэг хүнсээр хангагдах эрх болон хүн бүр өлсгөлөнгөөс ангид байх үндсэн эрх”-ийг дахин баталгаажуулсан юм. Тэд мөн 2015 он гэхэд дэлхийн өлсгөлөн хүмүүсийн тоог хагаслан бууруулахаа амласан юм.

Өнөөдөр дэлхий дээр 840 гаруй сая хүмүүс өлсгөлөнд нэрвэгдэж, сая сая хүмүүс байгалийн гамшиг, иргэний дайнд өртөж өлсгөлөн, өлөн зэлмүүн байдлын улмаас зовж тарчилж байна. Гэвч өлсгөлөн болон өлөн зэлмүүн байдлын үндэс нь дэлхийн хүн амын ихэнхийнх нь хувьд хоол хүнсний хомсдолтой холбоотой бус харин ядуу зүдүү байдлаасаа болж хэрэгцээт хоол хүнсээ авч чадахгүй байгаагаас шалтгаалж байна.¹

Монгол улсад 1990-ээд оноос эхэлсэн эдийн засгийн уналтаас болж хүнсний үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт 1995 онд 1990 оныхоос 2 дахин, 2000 онд 1995 оныхоос 1.5 дахин буурчээ. Мөн тэрчлэн сүүлийн жилүүдэд тус оронд тохиолдсон ган, зуд зэрэг байгалийн гамшгийн улмаас хүн амын хүнсний хангамж, баталгаа алдагдаж, хүн ам, түүний дотор хүүхдүүд хоол тэжээлийн доройтолд орж, бие бялдрын өсөлт хөгжилт хоцрогдож, улмаар хүүхэд төдийгүй нийт хүн амын дунд хоол хүнсний дутагдалтай холбоотой өвчлөл ихсэж байна.

Ийнхүү дотоодын үйлдвэрлэл буурснаас үүдэн гарсан дээрх хүнсний хомсдлыг арилгах зорилгоор манай улс махнаас бусад гол нэрийн бүтээгдэхүүний 70-100%-ийг импортоор хангаж, зах зээлд нийлүүлж байгаа нийт бүтээгдэхүүний 60-70%-ийг импортын хүнсний зүйл эзэлж, улмаар өргөн хэрэглээний хүнсний бараа, бүтээгдэхүүний хувьд манай орон гадаад орноос үлэмж хамааралтай болжээ. Тухайлбал, 2003 онд гэхэд 31 нэрийн хүнсний бүтээгдэхүүн импортлогдсоны дотор хэрэгцээт үр тарианы 33%, гурилын 70%, хүнсний ногооны 50 гаруй хувь, сүү, цагаан идээний 30 орчим хувийг импортоор хангадаг байна.

Олон нэрийн хүнсний бараа, бүтээгдэхүүнийг импортолж байгаа нь өнөөгийн нөхцөлд химийн хорт болон цацраг идэвхит бодис, хүнд металлын агууламж өндөртэй, хадгалах, тээвэрлэх явцад эрүүл ахуйн горим алдагдсанаас элдэв нян, хөгц мөөгөнцрөөр бохирлогдсон хүнс хилээр орж ирэх эрсдэл өндөр байна.

¹ Ерөнхий зөвлөмж 12-ын 11 дүгээр зүйлийн 5, ЭЗНСЭХ, (Е/С.12/1999/5)

Манай улсын нийт хүн амын 35.6%-ийг ядуу, нэн ядуу хүн ам эзэлж байна.² Хүн амын амьжиргааны түвшин доройтон, бодит орлого буурсаар байгаа бөгөөд ядуучуудын тоо жилээс жилд нэмэгдэж байгаа нь эмзэг бүлгийнхний, ялангуяа, бага насны хүүхдийн хоол тэжээл, бичил тэжээлийн хангамжинд сөргөөр нөлөөлж иржээ. Өрхийн орлого багасах тутам хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл, хэрэглэх хэмжээ эрс багасч байна. Үүнтэй холбоотойгоор АБТ-ээс доогуур орлоготой өрхийн нэг гишүүн хоногт хоол хүнсээр авах физиологийн хэрэгцээт илчлэгийн ердөө 68.5%-ийг авч байгаа нь физиологийн нормоос ихээхэн доогуур үзүүлэлт юм.

Дээр дурьдсанчлан сүүлийн 2 жилд дараалан ган, зуданд нэрвэгдсэн бус нутагт 6-59 сартай хүүхдүүдийн 36.1% нь хоол тэжээлийн дутагдал(ХТД)-ын архаг хэлбэр болох өсөлт хоцорсон нь бусад бүс нутагтай харьцуулахад 11.2%-аар илүү байна.

Гэтэл хүнсний хангамж, аюулгүй байдлын дээрх нөхцөлд хүн амын хоол тэжээл, эрүүл мэндийн байдалд хийсэн судалгаа, дүн шинжилгээ хийсэн олон эх сурвалж, мэдээлэл байгаа ч тэдгээрийг нэгтгэж хүний эрхтэй холбон судалж, үнэлгээ дүгнэлт өгсөн судалгаа одоогоор байхгүй байна.

Иймд хүн амын зохистой хоол хүнсээр хангагдах эрхийн төлөв байдал ямар түвшинд байгааг улс орны хоол хүнсний хангамж, аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл болон тэдний амьжиргааны түвшинтэй уялдуулан судалж, дүн шинжилгээ хийж, шаардлагатай санал, зөвлөмжийг боловсруулах нэн шаардлагатай болсон юм.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



² Амьжиргааны түвшний түүвэр судалгаа, ҮСГ, 1998 он

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

1.1. Судалгааны зорилго, зорилтууд

Хүн амын зохистой, аюулгүй хоол хүнсээр жигд хүртээмжтэй хангагдах эрхийн төлөв байдлыг судалж, дүгнэн, шаардлагатай санал, зөвлөмжийг боловсруулахад судалгааны зорилго оршино.

▪ Судалгааны зорилтууд

1. Монгол улсад хүнсний хангамж, чанар, аюулгүй байдлын өнөөгийн түвшинг тогтоох;
2. Хүн амын зохистой, аюулгүй хоол хүнсээр хангагдах эрхийг хамгаалсан хууль, тогтоомж, хөтөлбөр болон тэдгээрийн хэрэгжилтийн байдлыг судалж, үнэлэх;
3. Хүнсний хууль, эрхийг хангаж хэрэгжүүлэх, түүний хэрэгжилтийг хянах тогтолцоо, тэдгээрийн үйл ажиллагааны явц, үр дүнг шалгаж судлах;
4. Ядуу, эмзэг бүлгийн хүн амын хооллолтын байдлыг судлах;
5. Хүн амын хоол хүнсний шимт чанар болон аюулгүй байдалтай холбоотой өвчлөлийн өнөөгийн түвшинг тогтоох;
6. Хүн амын зохистой, аюулгүй хоол хүнсээр жигд хүртээмжтэй хангагдах эрхээ эдлэхэд нь шаардлагатай зөвлөмж, саналыг боловсруулан, 2005 онд УИХ-д өргөн барих илтгэлд энэ асуудлыг тусгах.

1.2. Судалгааны арга аргачлал, хамрах хүрээ

Судалгааны зорилго, ач холбогдолтой уялдан нийгмийн судалгааны уламжлалт аргууд болох баримтын судалгааны арга, ганцаарчилсан санал асуулгын болон фокус бүлгийн ярилцлагын аргаар судалгааны мэдээллийг цуглууллаа.

Судалгааны мэдээллийг цуглуулахдаа дараах үндсэн аргуудыг ашиглана.

▪ Хоёрдогч мэдээллийн эх уусвэрийн судалгаа (баримтын)

Уг судалгааны аргыг дараах үйл ажиллагаануудад ашиглав. Үүнд:

- тухайн сэдэвтэй холбоотой статистик тоо баримт;
- өмнө нь хийгдэж байсан судалгаа шинжилгээний ажлын тайлан, илтгэл, эрдэм шинжилгээний бүтээлүүд;
- холбогдох хууль, засгийн газрын болон төв, орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллагуудаас гаргасан тогтоол, шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт;
- “Хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол тэжээл” Үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, ажлын хэсгийн бүрэлдэхүүн, үүрэг оролцоог судлах;
- бодлогын санал зөвлөмж гаргахад ашиглах;

▪ Асуулгын арга (Ганцаарчилсан ярилцлага)

Судалгааны энэхүү аргыг “Өрхийн хүнсний хангамж, баталгаа” асуулга судалгааны үндсэн мэдээлэл цуглуулах гол арга болгон ашиглав. Уг судалгааны аргыг дараах үйл ажиллагаануудад ашиглав. Үүнд:

- Хүн амын зохистой, аюулгүй хоол хүнсээр хүрэлцэхүйц хэмжээгээр хангагдах эрхийн төлөв байдлыг судалж, дүн шинжилгээ хийх;
- Хүн ам хүрэлцээтэй хоол хүнсээр хангагдах болон хоол хүнсний тэгш шударга хуваарилалттай холбоотой хүнсний эрхээ эдлэхэд амьжиргааны түвшин хэрхэн нөлөөлж буйг судлан тогтооход ашиглах;

Судалгааны асуулгыг АНУ-ын ХАА-н Хэлтсийн Шинжилгээ, Хоол тэжээл ба Үнэлгээний Албанаас 2000 онд гаргасан Өрхийн хүнсний хангамж, баталгааг тодорхойлох аргачлалын дагуу боловсруулж, баяжуулан бэлтгэв. Судалгааны асуулгын бүтэц нь 1) судалгаанд хамрагдагсдын талаарх ерөнхий мэдээлэл, 2) Өрхийн түвшинд хүн амын хүнсний хангамж, баталгаат байдлын түвшин хэмээх 2 хэсэг бүхий нийт 32 асуултаас бүрдэнэ.

Түүврийн болон түүврийн бус алдаа бага гаргах, үнэн зөв судалгааны үр дүнг гаргаж авахын тулд судалгааны асуулга авагч нарт сурвалжлага авах удирдамж, заавар зөвлөгөө өгөв. Судалгааны асуулгыг ХЭҮК-ын гишүүд, мэргэжлийн судлаачидтай санал солилцон асуумжийн логик бүтэц, хариултын хувилбаруудын үндэслэл зохимжтой эсэхийг шалган, дахин нягтлан боловсрууллаа.

■ Фокус бүлгийн ярилцлагын арга

Уг арга нь асуумжийн аргаар тодруулах боломжгүй нарийн мэдээллийг бүрэн гаргах боломжтой арга юм. Энэ нь бодлого, стратегийн төлөвлөлтөнд чухал нөлөө үзүүлдэг. Уг аргыг дараах зорилгоор ашиглана. Үүнд:

- Хүнсний аюулгүй байдлын бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгчид, хяналтын байгууллагууд болон ТББ-ын холбогдох хүмүүстэй уулзаж бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн байдлыг судлах;
- Хүнсний үйлдвэрлэл, худалдаа эрхлэгчдийн дунд үйл ажиллагаагаа явуулахад гарч буй хүндрэл бэрхшээлүүдийг тогтооход ашиглах;

■ Бүлгийн ярилцлага

Энэхүү судалгааны аргаар хүнсний хараат бус байдлын талаарх асуудлаар хүнс үйлдвэрлэгчид, худалдаачдын хандлага, энэ чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагуудын удирдлага, мэргэжилтнүүдийн санаа бодол, тэдэнд тулгарч буй хүндрэл, бэрхшээл, шийдвэрлэх арга зам, өнөөгийн бодлого хэрэгжиж буй орчны зохистой харьцаа судлан тодорхойлно.

■ Ажиглалтын арга (Судалгааны бүх нэгжээс)

Нийгмийн судалгааны ажиглалтын аргыг судалгааны бусад аргуудтай хослуулан явуулах нь ихээхэн үр дүнтэй байдаг. Судалгааны мэдээллийн үнэн, зөв, эсвэл алдаатай байдлыг илрүүлэн гаргахад ач холбогдолтой байдаг тул уг аргыг судлаач бүр судалгааны үндсэн нэгжээс мэдээлэл авахад ашиглана.

■ **Судалгааны мэдээлэл боловсруулалт**

Судалгааны тоон мэдээлэл оруулах, боловсруулах ажил, мэдээллийн шинжилгээг компьютерийн SPSS 11.0 программыг ашиглан гүйцэтгэлээ. Судалгааны мэдээллийг шалган, хагас нээлттэй болон задгай хэлбэрийн асуултуудыг кодлох, бүлэглэх, судалгааны анкетийн логик бүтцийг оруулах, шивэх, мэдээллийг нэг ба хоёр хүчин зүйлийн хамаарлын шинжилгээг эмперик түвшний судалгааг явуулдаг горимын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Дисперс болон регрессийн хүчин зүйлүүдийг харгалзан гүнзгийрүүлсэн шинжилгээ хийв.

Фокус бүлгийн ярилцлага болон оролцооны аргаар цуглуулсан мэдээллийг тусгайлан багцлаж боловсруулав.

■ **Судалгааны хамрах хүрээ**

Энэхүү судалгаа нь маш өргөн хүрээг хамарч хийсэн судалгаа бөгөөд судалгааны агуулга тус бүрт шинжилгээний нэгж нь өөр өөр байх юм.

○ Баримтын судалгаагаар:

- Хүнсний хангамжийн асуудлыг судлахад хөдөө аж ахуй болон хүнсний үйлдвэрлэл;
- Хүнсний аюулгүй байдлыг судлахад хүнсний түүхий эд болон бүтээгдэхүүн;
- Хоол тэжээлийн байдлыг судлахад хүүхэд болон насанд хүрсэн хүн ам тус тус судалгааны нэгж болж байна.

○ Асуулга судалгааны нэгж нь амьжиргааны баталгаажих түвшин(АБТ)-ээс доогуур орлоготой өрх байсан ба судалгаанд олон шатат, зорилтот болон санамсаргүй түүвэрлэлтийн аргыг ашиглав.

Судалгаанд нийт 731 өрх хамрагдсан бөгөөд Улаанбаатар хотын Сүхбаатар, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн нийт 387 өрх хамрагдсан нь нийт түүврийн 52.9%, Хэнтий аймгийн төвийн Хэрлэн сумаас 47 өрх, хөдөөгийн Бэрх, Баян-Овоо сумаас нийт 49 өрх, нийт аймгийн хэмжээнд 96 өрх хамрагдсан нь нийт түүврийн 13.1%, Говь-Алтай аймгийн төвийн Есөнбулаг сумын 50 өрх, хөдөөгийн Баян-Уул, Цогт сумын нийт 50 өрх, нийт аймгийн хэмжээнд 100 өрх хамрагдсан нь нийт түүврийн 13.7%,

Архангай аймгийн төвийн Эрдэнэбулган сумаас 50 өрх хамрагдсан нь нийт түүврийн 6.8%, Дорноговь аймгийн төвийн Сайншанд хотоос 48 өрх, хөдөөгийн Эрдэнэ, Айраг сумаас нийт 50 өрх, нийт аймгийн хэмжээнд 98 өрх хамрагдсан нь нийт түүврийн 13.4%-ийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 1.1. Түүврийн нэгж

Аймаг, хот	Сум, дүүрэг	Өрхийн тоо	Аймаг, хот/ Нийт дүнд эзлэх хувь
Улаанбаатар	Баянзүрх	138	35,7%
	Сүхбаатар	140	36,2%
	Сонгионохайрхан	109	28,2%
	Дүн	387	52,9%
Хэнтий	Хэрлэн	47	49,0%
	Бэрх	24	25,0%
	Баян-Овоо	25	26,0%
	Дүн	96	13,1%
Говь-Алтай	Есөнбулаг	50	50,0%
	Баян-Уул	25	25,0%
	Цогт	25	25,0%
	Дүн	100	13,7%
Архангай	Эрдэнэбулган	50	100,0%
	Дүн	50	6,8%
Дорноговь	Сайншанд	48	49,0%
	Эрдэнэ	26	26,5%
	Айраг	24	24,5%
	Дүн	98	13,4%
Нийт	Дүн	731	100,0%

Түүвэрлэлтэнд хот хөдөөгөөр ялгааг харуулах зорилгоор Хэнтий, Говь-Алтай, Дорноговь аймгуудад аймгийн төвийн нэг сум, хөдөөгийн 2 сумаас тус тус 50 өрх хамруулахаар төлөвлөсөн бөгөөд судалгаанд тухайн аймгуудын аймгийн төвийн тус бүр 1, хөдөөгийн сумыг төлөөлж тус бүр 2 сумын өрхүүд ойролцоогоор тус бүр 50%-аар хамрагдав.

Хүснэгт 1.2. Түүврийн нэгж, хот хөдөөгөөр

Аймаг, хот	хот		хөдөө		Нийт	
	Б/тоо	хувь	Б/тоо	хувь	Б/тоо	хувь
Улаанбаатар	387	52,9%			387	52,9%
Хэнтий	47	6,4%	49	6,7%	96	13,1%
Говь-Алтай	50	6,8%	50	6,8%	100	13,7%
Архангай	50	6,8%			50	6,8%
Дорноговь	48	6,6%	50	6,8%	98	13,4%
Нийт	582	79,6%	149	20,4%	731	100,0%



ХОЁРДУГААР ХЭСЭГ: СУДАЛГААНЫ ҮР ДҮН

2.1. Зохистой хоол хүнсээр хангагдах эрхийн эрх зүйн зохицуулалт

2.1.1. Хүнсний эрхийн олон улсын эрх зүйн зохицуулалт

Хүн бүр эсэн мэнд амьдарч, хөдөлмөрлөх, эрүүл бие, саруул оюун ухаантай байхын тулд зохистой, аюулгүй, хүрэлцээтэй хоол хүнсээр жигд хүртээмжтэй хангагдах ёстой бөгөөд үүнийг хүний ХҮНСНИЙ ЭРХ хэмээх ойлголтод хамааруулж байна. Харин хүрэлцээтэй, шимт бодисын зохистой харьцаатай, аюулгүй хоол хүнсийг авбал зохих хамгийн бага хэм хэмжээг зайлшгүй тогтоож өгөх ёстой бөгөөд хүн хоол хүнсээ түүнээс багагүй хэмжээгээр олж авч байж сая хүнсний эрхээ эдэлж байна гэж үзэх үндэстэй юм. Энэ утгаараа уг хэм хэмжээ нь хүний эрхтэй салшгүй холбоотой ойлголт юм.

Хүнсний эрхийг баталгаажуулах нь Олон улсын хууль эрх зүйн нэг чухал асуудал бөгөөд өнөөдөр манай улс соёрхон баталсан хүний эрхийн хэд хэдэн баримт бичгүүдэд уг эрх тусгагдаад байна.

Хүний эрхийн түгээмэл Тунхаглалд (1948) “хүн бүр хоол хүнс . . . оролцуулаад өөрийн болон ам бүлийнхээ эрүүл мэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхтэй” гэж тунхагласан байдаг. Үүнээс хойш бараг 20 жилийн дараа “Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай” Олон улсын Пактад (1966) эдгээр асуудлыг илүү боловсронгуй болгож “хүн бүр . . . зохистой хоол хүнс тэй байх эрх”-ийг цохон тэмдэглээд, нэн тэргүүнд “өлсгөлөн, тэжээлийн доройтлоос ангид байх үндсэн эрх”-ийг онцлон заасан байдаг.

Дээрх заалтуудаас харахад хүний хүнсний эрх нь өлсгөлөнгөөс ангид байх эрх болон зохистой хоол хүнсээр хангагдах эрх гэсэн хоёр үндсэн эрхүүдийг багтааж байна.

➤ **Өлсгөлөнгөөс ангид байх эрх болон зохистой хоол хүнсээр хангагдах эрхийн хооронд ямар ялгаа байна вэ?**

ӨЛСГӨЛӨНГӨӨС АНГИД БАЙХ ЭРХ бол хүмүүсийг өлсгөхгүй байх хамгийн доод хязгаарыг баталгаажуулах үүрэг хариуцлагыг хүлээх гэсэн утгатай хүний үндсэн эрх юм. Энэ утгаараа ч уг эрх нь хүний амьдрах эрхтэй салшгүй холбоотой юм. Тэгвэл хүмүүсийн идэж ууж буй хоол хүнс нь цаг хугацаа, орон зайн хувьд хүрэлцээтэй байхын дээр аюулгүй, шимт бодисын зохистой агууламжтай байх шаардлагатай. Тэрчлэн хэдийгээр тухайн улсын Засгийн газар өөрийн газар нутагт амьдарч буй хүн бүрийг зохистой хоол хүнсээр хангагдах эрхээ бүрэн эдлэхэд боломжтой бүхнээр дэмжих ёстой боловч нөгөө талаар хүмүүс эрүүл саруул, үр бүтээлтэй амьдрахын тулд зохистой хэмжээ, чанар бүхий хоол хүнсээр өөрсдийгөө ямар ч үед хангах (олж авах) бие бялдар, эдийн засгийн чадавхитай байх ёстой юм. Тэгвэл хоол хүнс нь зохистой байхын тулд ёс заншилд нийцсэн байх бөгөөд хүрээлэн буй орчныг хамгаалах болоод нийгмийг дэмжих байдлаар үйлдвэрлэгдсэн (бүтээгдсэн) байх ёстой. Эцсийн эцэст үүнийг хангахын тулд хүмүүс бусад эрхээ орхигдуулах учиргүй юм. Тухайлбал: зохистой хооллоход хүрэлцэхүйц хоол хүнсээ олж авах (худалдан авах)-ын тулд нийгэм, эдийн засгийн бусад эрхээ эдлэх аргагүй буюу иргэний болон улс төрийн эрхээ хохироохоор өндөр үнэ төлөх ёсгүй юм.

Тэгэхээр **ЗОХИСТОЙ ХООЛ ХҮНСЭЭР ХАНГАГДАХ ЭРХ** гэдэг нь хүн бүр бүхий л амьдралынхаа туршид хүрэлцэхүйц хоол хүнсээ олж авах буюу түүнд нийцсэн бие бялдар болон эдийн засгийн чадвартай байхыг хэлнэ. Зохистой хоол хүнсээр хангагдах эрх нь Олон улсын хэд хэдэн баримт бичгүүдэд тусгагдан, 1996, 2002 онуудад болсон Дэлхийн хүнсний дээд хэмжээний уулзалтуудын дүнд гарсан баримт бичгээр дахин баталгаажигдсан байдаг.

ЭЗНСЭОУ-ын Пактад энэхүү эрхийн талаар бусад баримт бичигт зааснаас илүү тодорхой заасан байдаг. Зохистой хоол хүнсээр хангагдах эрх нь бусад эрхээ эдлэхэд чухал ач холбогдолтой.

ЭЗНСЭХ-ны Ерөнхий зөвлөмж (1999) 12-т зохистой хоол хүнсээр хангагдах эрхийг маш дэлгэрэнгүй тайлбарласан байдаг. Тухайлбал: Уг зөвлөмжид:

“4. Хороо нь зохистой хоол хүнсээр хангагдах эрх нь хүний төрөлхийн нэр хүндтэй салшгүй холбоотой бөгөөд хүний эрхийн талаарх олон улсын Билльд заасан хүний бусад эрхийг эдлэхэд чухал болохыг баталж байна. Энэ ойлголтыг нийгмийн шударга ёсны тухай ойлголтоос салгаж авч үзэх аргагүй бөгөөд үндэстний хийгээд олон улсын түвшинд ядуурлыг арилгах, бүх хүмүүст бусад эрхийг нь эдлүүлэхэд чиглэсэн зөв зүйтэй, оновчтой, эдийн засаг, хүрээлэн буй орчин, нийгмийн бодлогыг баталж мөрдөхийг шаардаж байна.

6. Аливаа эрэгтэй, эмэгтэй хүн, хүүхэд зэрэг бүх хүн ганцаараа юмуу нийгэм дотроо хүрэлцээтэй хоол хүнс хэрэглэх, эсвэл уг хоол хүнсээр хангах аргад нэвтрэх эдийн засгийн боломжоор хангагдаж байж эрхээ эдэлнэ. Тэгэхээр зохистой хоол хүнсээр хангагдах эрх гэдгийг явцуу утгаар илч, уураг болон бусад шимт бодисын хамгийн бага хэрэглээ гэж ойлгож болохгүй юм.” гэж заасан байдаг.

Зохистой хоол хүнсээр хангагдах эрхэд хоол хүнс нь хүрэлцээтэй, аюулгүй, шимт бодисын зохистой хэмжээ, харьцаатай байх гэсэн ойлголтууд багтаж байдаг.

Мөн зөвлөмжид зохистой хоол хүнсээр хангагдах эрхийг дараахь ойлголтуудаар тайлбарласан байна. Үүнд:

➤ **Хоол хүнсний зохистой болон тогтвортой байдал**

7. Зохистой байдлын тухай ойлголт нь тухайн үед зонхилж байгаа нийгэм, эдийн засаг, соёл, цаг уур, экологийн болон бусад нөхцөлөөр тодорхойлогддог байхад “тогтвортой” байдал нь урт удаан хугацаанд боломжтой, хүртээмжтэй байх эсэх тухай ойлголтыг өөртөө агуулж байдаг. Тогтвортой байдлын ойлголт нь хүрэлцээтэй хоол хүнс, хүнсний хангамж, баталгаа гэсэн ойлголтуудтай салшгүй холбоотой бөгөөд хоол хүнсийг өнөө үеийнхэн болон хойч үеийнхэндээ аль алинд нь хүрэлцээтэй байлгах тухай ойлголт юм.

8. Зохистой хоол хүнсээр хангагдах эрхийн үндсэн агуулга нь Хорооноос үзэж буйгаар:

- Хоол хүнс нь тоо хэмжээ, чанараараа хувь хүний өдөр тутмын хүнсний хэрэгцээг хангахуйц байхын дээр янз бүрийн хорт бодис агуулаагүй, тухайн соёл, ахуйн хүрээнд нийцсэн байх ёстой.
- Хоол хүнсний хэрэглээ нь тогтвортой урт хугацаанд хэрэглэгдэхээр байхын дээр хүнийг бусад эрхээ эдлэхэд нь саад болохгүй байх ёстой.

9. **Өдөр тутмын хоол хүнсний хэрэгцээ** гэдэг нь бүхэлдээ хүний хүйс, ажил, мэргэжилд нь тохируулан амьдралынх нь бүхий л үе шатны физиологийн хэрэгцээг хангахуйц, биеийн хөдөлмөр хөгжилд оюуны болон биеийн өсөлтөнд шаардагдах шим тэжээлийн бодисуудыг агуулсан хоол хүнсийг хэлнэ. Иймээс хүний өдөр тутмын хоол хүнсний олон төрөл, тохиромжтой хэрэглээ, хөхөөр хооллох г.м. зөв хооллох хэв маягийг тогтоож чанаржуулах арга хэмжээнүүдийг авах хэрэгтэй бөгөөд ингэхдээ хоол хүнсний хангалтын хүртээмж, боломжийн энэхүү өөрчлөлт нь минимум хэмжээгээрээ өдөр тутмын хоол хүнсний найрлага, хэмжээнд сөргөөр нөлөөлөхгүй байхыг нягтлах хэрэгтэй.

10. **Янз бүрийн хортой бодисын хольцгүй байна** гэдэг нь хүнсний аюулгүй байдал болон хүнсний бүтээгдэхүүнийг хуурамчаар үйлдвэрлэх, эрүүл ахуйн шаардлага хангахгүй орчинд хадгалах, хүнсний бүтээгдэхүүнийг хэрэлэгчийн гарт хүрэх замд буруу харьцах, тээвэрлэх зэрэг замуудаар муудахаас урьчилан сэргийлэхийн тулд улс, хувь хүмүүс, байгууллагууд янз бүрийн хамгаалалтын арга хэрэгслийг авах шаардлагыг бий болгож байгаа бөгөөд хортой бодис хүнсний зүйлд гаднаас орох буюу бий болсон эсэхийг таньж тогтоох, бий болгохоос зайлсхийх, бий болсон тохиолдолд устгах тал дээр онцгой анхаарах хэрэгтэй.

12. **Олдоц** (Availability) гэдэг нь шим тэжээлтэй газраас юм уу, эсвэл байгалийн бэлэн нөөцөөр хүн өөрийгөө шууд хооллох эсвэл сайтар зохицуулсан боловсруулалт, хуваарилалтаар бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн газраас нь эрэлттэй байгаа газарт нь хүргэж өгөх зах зээлийн боломжийг хэлж байгаа хэрэг юм.

13. **Хүртээмж (Accessibility)** гэдэг нь зах зээлд байгаа хоол хүнс болон эх үүсвэрийг бодитойгоор олж авах боломж юм. Олонхи улс оронд хүртээмж нь бодит олдцоосоо илүү тулгамдсан асуудал болж байдаг. Хүртээмж нь дотроо эдийн засгийн хувьд хийгээд бие бялдрын хувьд зохистой хоол хүнсэнд хүрэх боломжийн тухай ойлголтуудыг багтаана. **Эдийн засгийн хувьд хүрэх боломж** гэдэг нь зохистой хоол хүнс олж авахтай холбоотой хувь хүний болон өрх гэрийн санхүүгийн зардал нь бусад хэрэгцээт зүйлээ авах түвшинд нөлөөлөхгүй хэмжээнд байх ёстой гэсэн үг. Эдийн засгийн хувьд хоол хүнсээ олж авах боломж нь хүмүүсийн хүнсээ бэлтгэдэг ёс заншил болон тоо хэмжээнд хамаатай ойлголт бөгөөд хир зэрэг хэмжээний хоол хүнсийг хэрэглэвэл эрхээ бүрэн эдэлж байна гэж үзэж болохыг хэмжих хэмжүүр болж өгдөг юм. Хувьдаа газаргүй хүмүүс, бусад тодорхой үгүйрсэн хүн ам г.м. нийгмийн эмзэг бүлгийнхэнд зориулж тусгай хөтөлбөр боловсруулж онцгой анхаарал тавих хэрэгтэй.

Бие бялдрын хувьд хүрэх боломж гэдэг нь нярай буюу нялх хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, оюуны хомсдолтой хүмүүс, өндөр настангууд, хүнд өвчтэй болон эмнэлгийн байнгын хяналтанд байдаг хүмүүс г.м. бие эрхтэний хувьд эмзэг хүмүүст хамаатай зохистой хоол хүнсэнд хүрэх боломж юм. Байгалийн гамшигт өртөгсөд, гамшиг тохиолдож болохуйц газар амьдардаг иргэд болон бусад өртөмтгий бүлгүүдэд тусгай анхаарал хандуулах хэрэгтэй бөгөөд заримдаа хоол хүнсээр хангах талаар нэн тэргүүнд анхаарал тавих хэрэгтэй.

➔ **Хүнсний аюулгүй байдал бол зайлиггүй чухал зүйл мөн.**

Хүнсний чанар, аюулгүй байдал бол хүнсний эрхийн чухал хэсэг мөн. **ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ** гэдэг нь хоол хүнс нь бохирдуулагч нян, хортой бодис зэрэг эрүүл мэндийг хохироох бусад бодисуудыг агуулаагүй байх буюу тэдгээр нь хоол хүнсэнд аюул учруулахааргүй түвшинд байхыг хэлнэ.

Хэрэглэгчдийн эрүүл мэндийг хамгаалах болон хүнсний худалдаа арилжаа шударга явагдаж байгааг баталгаажуулахын тулд ДХХААБ болон ДЭМБ нь 1962 онд Хүнсний хууль эрх зүйн хороо(Codex Alimentarius Commission)-г байгуулсан. Уг хороо нь засгийн газар хоорондын байгууллага бөгөөд одоогоор хүнсний стандарт болон хүнсний чанар, аюулгүй байдлыг хамгаалах бусад зөвлөмжүүдийг бэлтгэдэг 162 гишүүн орнуудтай. Codex Alimentarius буюу Хүнсний хууль эрх зүй нь хэрэглэгч, хүнсний үйлдвэрлэгч болон боловсруулагчид, үндэсний хүнсний хяналтын агентлаг болон олон улсын худалдааны байгууллагын дэлхий дахин дахь лавлах болдог. Энэ нь Засгийн газарт үндэсний хүнсний хяналтын хууль тогтоомж боловсруулах болон хүнс нь аюулгүй байх бөгөөд зах зээлээс шударгаар худалдаалагдах хэрэглэгчийн эрхийг хамгаалах тогтолцоог бүрдүүлэхэд ашиглах үндэс болдог байна.



Чидун жимсэнд шимэгч хорхойг микроскоп ашиглан лабораторийн нөхцөлд тодорхойлж байгаа нь

➔ **Хүнсний эрхийн зөрчил (Violations of the Right to Food)**

Зохистой хоол хүнсээр хангана гэдэг нь өлсгөлөн, тэжээлийн доройтол, өлөн зэлмүүн байдлыг арилгана гэсэн үг юм. Гэтэл зохистой хоол хүнсээр хангагдах эрх зөрчигдөж буй нэг илрэл бол хоол хүнсний хүрэлцээ, хангамж алдагдаж, хоол хүнсний шимт чанар буурах явдал бөгөөд түүний уршгаар өлсгөлөн, өлөн зэлмүүн байдал болон түүнтэй холбоотой хоол тэжээлийн дутлын шалтгаант өвчин эмгэг үүсдэг. Өлсгөлөн, хоол тэжээлийн дутал болон өлөн зэлмүүн байдал нь дэлхий нийтийн тулгамдсан асуудал болоод байна.

Өлсгөлөн гэдэг нь хүн хүрэлцэхүйц хоол хүнс олж авах аргагүй байх нөхцөл байдал юм. Өлсгөлөн нь хүмүүсийн оюун ухааныг доройтуулж, хөдөлмөрийн бүтээмжийг бууруулснаар тэдний нөөц боломжоо ашиглахаас эхлээд нийгмийг бүхэлд нь хөгжихөд саад болдог байна. Өлсгөлөнтэй холбоотой өвчин эмгэг нь хөгжиж буй

орны ядуу өрхүүдэд өрхийн зарлагыг эрс нэмэгдүүлж, байнгын амь зуулгын төлөө тэмцэж буй өрхийн гишүүдийн эрүүл мэндэд үзүүлэх тусламжийн хэрэгцээг улам бүр ихэсгэдэг байна. Ингэснээр өлсгөлөнгийн шалтгаан болдог ядуурал нь өөрөө түүний үр дагавраар үүсдэг байна.

➔ **Хоол хүнсний хомсдол болон өлсгөлөн, хоол тэжээлийн дутлын шалтгаан юу вэ?**

Хүнсний эрхийг дэлхийн улс орнууд шууд ба шууд бус байдлаар хүлээн зөвшөөрч байгаагаас үл хамааран өлсгөлөн аль нэг улс оронд дайн дажин, байгалийн гамшиг буюу эсвэл ядуурлаас шалтгаалан гарч, улмаар өргөн олныг хамарч байна. Хүнсний үйлдвэрлэл, түгээлтийн зогсолт нь өлсгөлөн болон хоол тэжээлийн дутлын бас нэг гол шалтгаан болдог. Ган, зуд, үер, хуй салхи зэрэг байгалийн гамшиг нь хүнсний үйлдвэрлэл, далайн боомт болон зах зээлийг хаагдуулах буюу зогсоож болох ба ингэснээрээ хүнсний хомсдлыг бий болгодог. Дайн байлдаан зэрэг хүний үйл ажиллагаатай холбоотой гамшиг нь хүнсний байнгын шилжилт хөдөлгөөн болон түгээлт хуваарилалтыг тасалдуулдгаас хүнсний хүртээмжийг байнга хязгаарлаж байдаг.

Өнөөдөр манай дэлхий дээр 840 гаруй сая хүмүүс өлсгөлөнд нэрвэгдэж, байгалийн гамшиг, иргэний дайны улмаас сая сая хүмүүс хоол хүнсний хомсдолд орж өлсгөлөн, өлөн зэлмүүн байдалд зовж тарчилж байна. Дэлхий дээр 2 тэр бум гаруй хүн ард “далд хэлбэрийн өлсгөлөн” буюу бичил тэжээлийн дуталд орж, тухайлбал, хүүхдүүдийн хэвийн өсөлт, хөгжилт нь алдагдах, өсөлт хоцрон, зарим үед буруу хөгжих буюу оюуны чадамж нь доройтож, дархлалын тогтолцоо нь алдагдаж байна. Өдөрт 7 секунд тутамд 10-аас доош насны нэг хүүхэд өлсгөлөн буюу өлсгөлөнтэй холбоотой өвчний улмаас нас барж байна.³

Гэвч өлсгөлөн болон өлөн зэлмүүн байдлын үндэс нь дэлхийн хүн амын ихэнхийнх нь хувьд хоол хүнсний хомсдолтой холбоотой бус харин ядуу зүдүү байдлаасаа болж хэрэгцээт хоол хүнсээ авч чадахгүй байгаагаас шалтгаалж байна. Ядуу зүдүү амьдарч буй хүмүүс хоол хүнсний хангамж, баталгаагаар хязгаарлагддаг. Хоол тэжээлийн дутлын ихэнх нь хүрэлцээтэй хоол хүнс худалдан авах эдийн засгийн чадавхигүй байдлаас үүдэн үүсдэг. Ядуу зүдүү амьдарч буй хүн өөрийн хоол хүнсээ үйлдвэрлэх газар олж авч чаддаггүй. Ядуу гэр бүлд амьдарч буй эмэгтэйчүүд болон хүүхдүүд эрэгтэйчүүдээс ч бага хоол хүнсээр хангагддаг байж болох юм.

➔ **Өлсгөлөн болон хоол тэжээлийн дуталд хэн хамгийн их өртөх эрсдэлтэй вэ?**

Таваас доош насны хүүхдүүд хоол тэжээлийн дуталд хамгийн их өрттөг байна. ДЭМБ жил бүр ойролцоогоор 10 сая хүүхдийн наад зах нь тал нь хоол тэжээлийн дутлын улмаас үхэж байгааг онцлон заасан байдаг. Бага насны хүүхдүүд хоол тэжээлийн дутлаас үүдсэн өвчин эмгэгт илүү их өртөмтгий байдаг ба тэд мөн амьдралынхаа туршид бие бялдар болон оюун ухааны нөхөн төлшгүй хохиролд өртөж байдаг.

Хүүхдийн эрхийн Конвенци (1989) нь зохистой хоол хүнсний хэрэгцээ шаардлагад анхаарлаа хандуулсан байдгийн зэрэгцээ хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээлийн сайн сайхан байдлын асуудалд ундны цэвэр усыг оруулахын чухлыг шууд заасан байдаг.

Иймд зохистой хоол хүнсээр хангагдах эрх болон өлсгөлөнгөөс ангид байх үндсэн эрхийг баталгаажуулах нь олон улсын хууль эрх зүйн нэг асуудал мөн. Хүнсний эрхийн хэрэгжилт нь зөвхөн хүнсний салбар буюу хүнстэй холбоотой салбар төдийгүй эрүүл мэнд, хоол тэжээлийн боловсрол, ариун цэврийн байгууллага болон дэд бүтэц зэрэг бусад салбар дахь үйл ажиллагааг шаарддаг.⁴

³ ESCR-The right to food, Report submitted by the Special Rapporteur on the right to food, Jean Ziegler, (E/CN.4/2003/54)

⁴ Report of the United Nations High Commissioner for Human Rights to the Economic and Social Council, Substantive session of 2003, Economic and Social Council, E/2003/100

◆ **Хүнсний эрхийг үндэсний түвшинд баталгаажуулан хэрэгжүүлсэн нь**

Зохистой хоол хоол хүнсээр хангагдах эрх болон өлсгөлөнгөөс ангид байх эрхийг баталгаажуулах нэн чухал үүрэг хариуцлагыг тухайн улсын Засгийн газар хүлээдэг. Энэ нь ерөнхий утгаараа өлсгөлөн нь хүний төрөлхийн нэр хүндийг үгүйсгэж, эрүүл мэнд, оюун ухаан, хөдөлмөрлөх чадварыг доройтуулснаар нийгэм, улс төр, эдийн засгийн хөгжилд саад болдгийг хүлээн зөвшөөрч байна гэсэн үг юм. Дэлхий дээр хүнсний эрхийг Үндсэн хуулиндаа тусгасан 20 гаруй улс орон байдаг. (Зураг 2.1.1.)



Зураг 2.1.1.
Бангладеш, Бразил,
Колумб, Конго, Куб,
Эквадор, Итиоп,
Гуатемал, Хайти, Энэтхэг,
Иран, Малави, Никарагуа,
Нигери, Парагва,
Пакистан, Хойд Африк,
Шри Ланк, Уганда, Украин

Оролцогч улсуудын хүлээх хууль ёсны үүргийн мөн чанарын талаар ЭЗНСЭОУ-ын Пактын 2 дугаар зүйлийн 1-д: “Энэхүү Пактад оролцогч улс бүр ганцаар болон олон улсын тусламж, хамтын ажиллагаагаар дамжуулан, нэн ялангуяа эдийн засаг, техникийн салбарт, энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг бүрэн хэрэгжүүлэх явдлыг аажмаар хангахын тул хууль, тогтоомжийн арга хэмжээг оролцуулан, зохистой арга хэмжээг байгаа бүх бололцооныхоо хирээр авах үүрэгтэй.” хэмээн зааж, үүнийг Оролцогч улсууд хүлээн зөвшөөрсөн билээ.

Мөн Пактын 11 дүгээр зүйлийн 1-д: “Энэхүү Пактад оролцогч улсууд хүн бүрийн болон түүний гэр бүлийн хүрэлцээтэй хоол хүнс ... оролцуулан, амьдралын хүрэлцээтэй түвшинд аж амьдрах, амьдралынхаа нөхцөлийг байнга сайжруулах эрхийг нь хүлээн зөвшөөрнө.” хэмээн заасан байдаг.

Тус хорооны Ерөнхий зөвлөмж 12-т Пактын хүнсний эрхийг хэрэгжүүлэх Оролцогч улсуудын үүргийг дэлгэрэнгүй тодорхойлсон байдаг.

“15. Зохистой хоол хүнсээр хангагдах эрх нь хүний эрхийн бусад хэлбэрийн адилаар улс орон бүрт “дагаж мөрдөх”, “хамгаалах”, “биелүүлэх” гэсэн 3 түвшний үүргийг оноодог. Үүнд:

Дагаж мөрдөх: үүрэг нь Оролцогч улс нь бүх хүн зохистой хоол хүнсээр хангагдах эрхтэйг мэддэг байх ёстой бөгөөд хүмүүст түүнийг олж авах эрхийг олгох ёстой. Зохистой хоол хүнсээр хангагдах эрхийг “дагаж мөрдөх” үүрэг нь Оролцогч улсыг энэ эрхийг эдэлж чадахгүйд хүргэх ямар нэг алхмыг хийхгүй байхыг шаарддаг.

Хамгаалах: үүрэг нь Засгийн газар нь өөрөө хүн амаа зохистой хоол хүнс олж авахад нь саад болохгүй байхаас гадна тэднийг гуравдагч этгээдээр эрхээ зөрчүүлэхээс хамгаалах ёстой. Энэ нь жижиг үйлдвэрүүд болон хувь хүмүүс хүмүүсийн зохистой хоол хүнсэндээ хүрэх боломжийг олгож байгаа эсэхийг нягтлахыг шаарддаг.

Хэрэгжүүлэх: Оролцогч улс хүн амынхаа хүнсний хэрэгцээг хангахын тулд хүмүүст туслах болон хоол хүнсээр шууд хангах гэсэн 2 үүргийг хүлээдэг. Туслах болон хангах үүргийг хүнсний хомсдол, хоол тэжээлийн дутлын үед урт болон богино хугацаагаар хэрэгжүүлж болно. Туслах үүргийн хүрээнд Засгийн газар хүнсний хангамж, баталгааг бий болгох хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхлэх ёстой. Энэ нь хүнсний эрхээ эдэлж чадахгүй байгаа хүмүүст хоол хүнсээр өөрсдийгөө хангах боломжийг бүрдүүлэх байдлаар тусална гэсэн утгатай юм. Үүнд хүмүүсийг нөөц боломжийг хамгийн үр ашигтай ашиглахад сургах, тариалангийн газрын шинэтгэл болон/буюу хуваарилалт, хүмүүст хоол хүнсээ худалдан авах санхүүгийн эх үүсвэр

болох ажил эрхлэх боломжоор хангах зэрэг багтана. Засгийн газар туслах үүргийн хүрээнд хараат бус байдал болон хоол хүнсний өргөн сонголт бий болгох зэрэг янз бүрийн арга замаар хоол хүнсээ олж авах боломжийг бүрдүүлэх ёстой. Эцэст нь хувь хүн буюу аливаа бүлэг уг эрхийг хүчин мөхөсдөж, эдэлж чадахгүйд хүрвэл Оролцогч улс уг эрхийг эдлэх боломжийг нэн даруй хангах хэрэгтэй. Хангах үүрэг нь бусад бүх үүргээр уг эрхийг хангаж чадахгүй болсон онцгой нөхцөлд зориулж нөөцлөгдөнө. Ийм нөхцөлд засгийн газар ард иргэдэд хоол хүнсийг шууд өгөх болно. Ард иргэд нь байгалийн болон бусад гамшигт өртсөн тохиолдолд оролцогч улс мөн дээрх үүргийг хүлээнэ. Уг үүргийг мөн байгалийн болон бусад гамшиг тохиолдсон үед хэрэгжүүлнэ.”

➤ **Мөн Ерөнхий зөвлөмжид зохистой хоол хүнсээр хангагдах эрхийг үндэсний түвшинд хэрэгжүүлэх талаар:**

“21. Пактын гол шаардлага нь хамгийн гол нь ард иргэдээ өлсгөлөнгөөс ангид байлгах, зохистой хоол хүнсээр хангагдах эрхийг аль болох хурдан хангах явдал юм. Энэ нь үндэстнүүдийг зорилт, бодлогын зохицуулалт болон тохирох жишгийг тодорхойлж, хүний эрхийн зарчимд үндэслэсэн хүн амын хүнс болон хоол тэжээлийн хангамж, баталгааг хангах стратегийг батлахыг шаарддаг. Энэхүү стратегид мөн зорилтыг хангах боломжит нөөцийг илрүүлэн тогтоож, түүнийг хэрэглэх хамгийн бага өртөгтэй аргыг тодорхойлсон байх шаардлагатай.

25. Стратегид үйлдвэрлэлт, боловсруулалт, түгээлт, хуваарилалт, зах зээлд борлуулалт, аюулгүй хүнсний хэрэглээ зэрэг хүнсний тогтолцооны бүхий л асуудлыг хамарсан эгзэгтэй асуудлууд болон арга хэмжээ, түүнчлэн нийгмийн аюулгүй байдал, ажил эрхлэлт, боловсрол, эрүүл мэндийн салбарын уг эрхтэй холбоотой арга хэмжээг хөндөх хэрэгтэй. Мөн үндэсний, бүсийн, айл өрхийн түвшинд хүнсний байгалийн болон бусад нөөцийг ашиглах, мөн хамгийн тогтвортой менежменттэй байхад онцгой анхаарал хандуулах ёстой.

26. Стратегид хоол хүнс болон хоол хүнсний нөөцөд хүрэхэд ямар нэг ялгаварлан гадуурхах байдал гаргахгүйн тулд онцгой анхаарал тавих хэрэгтэй.

27. Хүний хоол хүнсний нөөцийн үндсийг хамгаалах асуудал нь үүргийн нэг хэсэг болж өгдөг учраас Оролцогч тал хувийн бизнесийн салбарынхны болон иргэний нийгмийн явуулж буй үйл ажиллагаа нь хүнсний эрхэд нийцэж буй эсэхийг хянах тохиромжтой арга хэмжээг авах ёстой.


28. Оролцогч улс эдийн засгийн тэгшитгэл, эдийн засгийн уналт, цаг уурын хүчин зүйл болон бусад хүчин зүйлүүдээс шалтгаалан бий болсон нөөцийн хязгаарлалтын үед хүртэл хүн амын эмзэг бүлэг болон хувь хүмүүст зохистой хоол хүнсээр хангагдах эрхийг нь баталгаажуулах шаардлагатай.” хэмээн заасан.

➤ **Зөвлөмжид зохистой хоол хүнсээр хангагдах эрхийг хэрэгжүүлэхэд Олон улсын (Оролцогч бусад улс болон Олон улсын байгууллагууд) үүрэг оролцоог дараахь байдлаар тодорхойлсон байна. Үүнд:**

37. Оролцогч улсууд цаг ямагт өөр бусад орны хүнсний үйлдвэрлэл болон хүрэх арга замд хориг саад болохыг цээрлэх хэрэгтэй. Хүнсний зүйлийг хэзээ ч улс төрийн болон эдийн засгийн дарамт шахалт үзүүлэх хэрэгсэл болгож болохгүй.

38. Эмзэг бүлгийн хүмүүст хүнсний яаралтай тусламж үзүүлэх хэрэгтэй.

39. Хүнсний тусламж нь тухайн орон нутгийн хүнсний үйлдвэрлэл эрхлэгчид болон зах зээлд сөргөөр нөлөөлөхөөргүй байхаар, тусламж хэрэгтэй болсон хүмүүсийг өөрсдийнхөө хүнсний хэрэгцээг хангах чадвараа аль болох богино хугацаанд сэргээхэд нь дэмжлэг болох байдлаар зохион байгуулагдана. Хүнсний тусламж нь ямар нэгэн хөндлөнгийн туслалцаа зайлшгүй хэрэгтэй болсон хүмүүст зориулагдсан байх хэрэгтэй. Олон улсын хүнсний худалдаа болон тусламжийн хөтөлбөрт орж байгаа бүтээгдэхүүн нь хүнсний аюулгүй байдлын шаардлагыг хангасан, хүлээн авагч ард түмний соёл, зан заншилд нийцсэн хэрэглэж болохуйц байх шаардлагатай юм.”



➔ **Хүнсний эрхийн Олон улсын хууль, эрх зүйн орчин**

Хүнсний эрх нь Олон улсын хууль эрх зүйн хэд хэдэн баримт бичгүүдэд тусгагдсан байдаг тухай дээр өгүүлсэн билээ. Хүнсний эрхийг баталгаажуулсан Олон улсын гол баримт бичгүүдийг жагсаавал:

1. Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1948 он

25 дугаар зүйлийн 1-д:

Хүн бүр хоол хүнс ... оролцуулаад өөрийн болон ам бүлийнхээ эрүүл мэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхтэй

2. Дэлхийн хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын дүрэм, 1965 он

Удиртгал: Энэ дүрмийг хүлээн зөвшөөрч буй улс үндэстнүүд

3. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пакт, 1966 он

Пактын 11 дүгээр зүйлийн 1-д:

Энэхүү Пактад оролцогч улсууд хүн бүрийн болон түүний гэр бүлийн хүрэлцээтэй хоол хүнс ... оролцуулан, амьдралын хүрэлцээтэй түвшинд аж амьдрах, амьдралынхаа нөхцөлийг байнга сайжруулах эрхийг нь хүлээн зөвшөөрч, ... эрхийг ханган хэрэгжүүлэх зохистой арга хэмжээ авна.

Пактын 2-т:

Энэхүү Пактад оролцогч улсууд хүн бүрийн өлсөхгүйгээр аж төрөх үндсэн эрхийг хүлээн зөвшөөрч, ... шаардлагатай арга хэмжээг дараахь зорилгоор авна. Үүнд:

а/ байгалийн нөөцийг хамгийн үр ашигтай эзэмших, ашиглах зорилгоор техник, шинжлэх ухааны мэдлэгийг өргөн хэрэглэх, хүнс тэжээлийн тухай мэдлэгийг дэлгэрүүлэх, газар тариалангийн системийг боловсронгуй болгох, шинэтгэл хийх замаар хоол хүнсний бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, хадгалах, хуваарилах арга ажиллагааг сайжруулах;

б/ хүнсний бүтээгдэхүүн экспортлогч буюу импортлогч орнуудыг анхааралдаа авч, тэдний хэрэгцээний дагуу дэлхийн хоол хүнсний нөөцийг шударгаар хуваарилах явдлыг хангах.

4. Хүүхдийн эрхийн тухай Конвенци, 1989

Конвенцийн 24 дүгээр зүйлийн 2-ын с-д:

Хүүхдийг ... зохих тэжээллэг хоол хүнсээр хангах, мөн хөнгөн хялбар технологи хэрэглэх замаар өвчин эмгэг, өлмөн зэлмэн байдалтай тэмцэх
е/ хүүхдийн ... хоол тэжээл, хөхний сүүгээр тэжээхийн давуу тал ...-ын тухай мэдээллээр нийгмийн бүх давхарга, тухайлбал, эцэг, эх, хүүхдийг хангах

Конвенцийн 27 дугаар зүйлийн 3-т

Оролцогч улсууд үндэснийхээ нөхцөлийг харгалзан, ... шаардагдсан нөхцөлд материалын тусламж үзүүлж ялангуяа хоол тэжээл, хувцас хунар, орон сууцаар хангахад чиглэсэн программыг дэмжинэ.

5. Хөхөөр хооллолтыг хамгаалах, хангах, дэмжих Инносентийн Тунхаглал, 1990 он

Уг тунхаглал нь эхийг хүүхдээ хөхөөр хооллох эрх болон нялхсыг төрснөөс хойш 4-6 сар хүртлээ хөхөөр хооллох эрхийг хамгаалдаг.

6. Хоол тэжээлийн Дэлхийн Тунхаглал болон үйл ажиллагааны төлөвлөгөө, 1992

Уг тунхаглал нь хүнсний хангамж, баталгаа болон хөхөөр хооллолтыг дэмжих байдлаар нялхсын өвчнөөс урьдчилан сэргийлэлтийг дэмжинэ.

7. Дэлхийн хүнсний Дээд хэмжээний үүлзалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, 1996 он

Амлалт 7-д:

Бид уг Үйл ажиллагааны төлөвлөгөөг олон улсын нийгэмлэгүүдийн хамтын ажиллагааны бүхий л түвшинд хэрэгжүүлж, хяналт тавин, дагаж мөрдөх болно.

Зорилго 7.4

ЭЗНСЭОУП-д болон бусад холбогдох олон улсын болон бүсийн баримт бичгүүдэд тусгагдсан зохистой хоол хүнсээр хангагдах эрх болон өлсгөлөнгөөс ангид байх үндсэн эрхийн агуулгыг тодорхой болгох, уг эрхийг бүрэн утгаар нь, өргөн хүрээтэй ойлгож, хэрэгжүүлэхэд гол анхаарлаа хандуулж, хүн бүрийн хүнсний хангамж баталгааг бүрдүүлнэ.

8. ЭЗНСЭХ-ны Ерөнхий зөвлөмж 12, Хорьдугаар чүүлган, 1999 он
Уг зөвлөмжид хүнсний эрхийн хэм хэмжээг дэлгэрэнгүй тайлбарлаж, уг эрхийг хэрэгжүүлэх Оролцогч улсуудын үүрэг хариуцлагыг тодорхой зааж, авч хэрэгжүүлэх арга хэмжээ болон Олон улсын үүрэг оролцоог тусгасан байна.
9. ЭЗНСЭХ-ны Ерөнхий зөвлөмж, 2000 он, хуу. 142
Эдийн засаг, Нийгэм, Соёлын Эрхийн Хороо Монгол улсын эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пактын ээлжит гурав дахь илтгэлийг 2000 оны 8-р сарын 17, 18-нд болсон 34, 35, 36 дугаар хуралдаанууд дээр авч хэлэлцээд, 2000.08.28-ы өдрийн өөрийн 49 дүгээр хуралдаан дээр дараах уг ерөнхий зөвлөмжийг гаргажээ.
10. НҮБ-ын ХЭДКГ-ын Хүнсний эрхийн тусгай илтгэгч Жин Зиглер (Jean Ziegler)-ийн илтгэл, 2002 он (E/CN.4/2002/58)
11. НҮБ-ын ХЭДКГ-ын Хүнсний эрхийн тусгай илтгэгч Жин Зиглер (Jean Ziegler)-ийн илтгэл, 2003 он (E/CN.4/2003/54)
Уг илтгэлд Тусгай илтгэгч хүнсний эрхийг илүү их мэдээлж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн үйл ажиллагаагаа танилцуулж, олон улсын түвшинд авч хэрэгжүүлэх 2 гол санаачилгыг дэвшүүлсэн: ДХХААБ-ын ивээн тэтгэлгээр хүнсний эрхийн талаар олон улсын “сайн дурын удирдамж” боловсруулах болон ЭЗНСЭХ-оос усны эрхийн талаар шинэ Ерөнхий зөвлөмж №5-ийг үйлдвэрлэх. Дэлхий дээр гарч буй хүнсний эрхийн зөрчлийн талаарх мэдэгдлийг хүлээн авч, хариу өгөх үйл явцыг тодорхойлж байсан ба үүний зорилго нь зөрчлийн эргэн тойрон дахь ял шийтгэл хүлээдэггүй байдлыг багасгахад оршино.
12. НҮБ-ын ХЭДКГ-ын Хүнсний эрхийн тусгай илтгэгч Жин Зиглер (Jean Ziegler)-ийн илтгэл, 2004 он (E/CN.4/2004/10)
13. “Ядуурлыг бууруулах стратеги боловсруулахад хүний эрхийг тусгах нь”
Зөвлөмж, 2003 он
Уг зөвлөмжийн 6-д ядуурлыг бууруулах стратегид зохистой хоол хүнсээр хангагдах эрхийн ач холбогдлыг зааж, стратеги боловсруулахад уг эрхийн хамрах хүрээ, зорилтууд, авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж өгсөн байна.

2.1.2. Хүнсний асуудлаархь хүний эрхийн олон улсын стандартыг үндэсний хууль тогтоомжид тусгасан байдал

Монгол улсын үндсэн хуульд “өлсгөлөнгөөс ангид байх эрх” болон “зохистой хоол хүнсээр хангагдах эрх” шууд утгаараа тусгагдаагүй боловч хуулийн 16 дугаар зүйлийн 2-т заасан “Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” заалт болон 6-д заасан “эрүүл мэндээ хамгаалуулах . . . эрхтэй” гэсэн заалтуудаар үндсэндээ зохицуулагдаж байгаа юм.

Хүний эрхийн олон улсын дээрх стандартуудыг үндэсний хууль, тогтоомжуудад, тухайлбал хүнсний тухай, Эрүүл мэндийн тухай, Ариун цэврийн тухай, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах тухай, Стандарчлал, Тохирлын үнэлгээний тухай зэрэг 10 шахам хууль, тогтоомжид ямар нэг байдлаар тусгасан байдаг. Хүний зохистой хоол хүнсээр хангагдах эрхийг баталгаажуулсан гол хууль болох одоогийн дагаж мөрдөж байгаа хүнсний тухай (1999 оны) хуулийг өмнөх хүнсний тухай (1995 оны) хуультай харьцуулан үзэж, хүний эрхийн олон улсын стандарт, олон улсын байгууллагуудаас

гаргасан зөвлөмж, чиглэлүүдийг хэрхэн тусгасныг нарийвчлан судалж, дараахь дүгнэлтийг хийж байна.

Хүнсний тухай (1995 оны) хуульд хүний эрхийн олон улсын стандарт, олон улсын байгууллагуудаас гаргасан зөвлөмж, чиглэлийн заалтыг нэлээд дэлгэрэнгүй тусгаж, хүний зохистой хоол хүнсээр хангагдах эрхийг баталгаатай болгож хэрэгжүүлэхэд төрийн гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг маш тодорхой тусгасан байдаг.

Гэтэл 4 жилийн дараа энэхүү хуулийг шинэчлэн найруулж, одоогийн дагаж мөрдөж байгаа хүнсний тухай (1999 оны) хуулийг батлан гаргахдаа хүний зохистой хоол хүнсээр хангагдах эрхийг баталгаажуулж, хэрэгжүүлэхтэй холбоотой олон чухал заалт, төрийн бодлого, зохицуулалтын шинж чанартай зорилт, чиг үүрэг, хүн амд эерэгээр хандсан гол гол асуудлыг хассан байх юм.

Энэ талаар Монголын хүнсчдийн холбооны танилцуулгад:

Монгол оронд “хүнсний аюулгүй байдал” гэдгийг зөвхөн ариун цэвэр, эрүүл ахуйн хувьд ойлгож байгаа нь төрийн бодлогын том асуудлын зөвхөн нэг хэсэгт анхаарал төвлөрөхөд хүргэж байгаа хандлагыг улам лавшруулж байна.

Хүн амын хүнсний хангамжийг хэвийн байлгах, өлсгөлөн, өлөн зэлмүүн байдал үүсэхээс сэргийлэх, нялхас, хүүхэд, эхчүүд, хөгшидийг хоол хүнсээр хангах, хувь хүн, айл өрх хүнсний хангамжаа хэвийн байлгахад дэмжлэг үзүүлэх зэрэг төр, засгийн бодлогын гол асуудлыг хүнсний анхны хуульд тусгагдсан байсныг шинэчилсэн найруулга хийхдээ хасчээ.” гээд “Хүнсний баталгаа, хангамж, хүрэлцээний аюулгүй байдлыг шийдвэрлэх гол бодлого нь хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх асуудал боловч энэ талаар анхны хуульд байсан заалтыг хасчээ.

Ийнхүү хүнсний хангамж, хүрэлцээ, баталгааны тухай хуулинд тодорхой заалт байхгүй болсноор “Хүнсний тухай “ хуулинд “хүнсний аюулгүй байдал”-ын үндсэн асуудлын нэг нь орхигдож, төрийн бодлогын гадна хоцорчээ гэж үзэж болох юм.” гэсэн дүгнэлт хийснийг хуучин, шинэ хоёр хуулийн доорхи харьцуулалт давхар нотолж байна.

Хүнсний тухай (1995 оны) хуулийн “Засгийн газрын бүрэн эрх” гэсэн 7дугаар зүйлд: *“1/ хүнсний аюулгүй байдлыг хангах, хүнсний зүйлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг дэмжих, хүн амын хүнсний зүйлийн хэрэглээний зохистой хэм хэмжээг хангах, өлсгөлөн, өлмөн зэлмүүн байдал, хоол тэжээлээс шалтгаалах өвчнөөс сэргийлэх бодлого, хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх,”* гээд мөн зүйлийн 2-т “Засгийн газар нь хүнсний зүйлийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг дараахь байдлаар хөхүүлэн дэмжих:

1/ сүү, мах, гурил тэдгээрээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн болон хүүхдийн хоол тэжээлийг чанар сайтай, байнга тогтвортой үйлдвэрлэж байгаа аж ахуйн нэгжийн худалдааны албан татварыг хөнгөлөх, чөлөөлөх;

2/ хүнсний зүйлийн үйлдвэрлэл, үйлчилгээний тэргүүний технологи эзэмших, импортыг орлох хүнсний зүйлийг үйлдвэрлэх зориулалтаар импортлосон үйлдвэрлэлийн хэрэгсэл болон хүүхдийн хоол тэжээл, жимс, жимсгэний гааль, худалдааны татварыг хөнгөлөх;

3/ хүүхдийн хоол тэжээл үйлдвэрлэгчидэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

4/ мал аж ахуй, газар тариалангийн нэгжээс авах хүнсний бүтээгдэхүүнийг тогтвортой нэмэгдүүлэх болон эрчимтэй технологи нэвтрүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг урамшуулах журам тогтоож хэрэгжүүлэх.

3. Засгийн газар нь хүнсний зүйлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг хөхүүлэн дэмжих, хүнсний аюулгүй байдлыг хангах зорилгоор хүнсний зүйлийн улсын сан байгуулж, түүний дүрмийг батална.” гэсэн заалтууд байсныг хассан байна. Гэтэл одоогийн дагаж мөрдөж буй хуулиар Засгийн газрын бүрэн эрх гэсэн 5-р зүйлд доорхь 8 асуудлыг тусгажээ. Үүнд:

“– улсын нөөцийн хүнсийг бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх, зарцуулах, нөхөн сэлбэх журмыг тогтоох, шаардагдах хөрөнгийг жил бүр улсын төсөвт тусгаж шийдвэрлүүлэх;

- хүн амын ундны усны хайгуул хийх, усны нөөц, уст цэгийг нэмэгдүүлэх, ус цэнгэгжүүлэх бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;
- хүн амын ундны усны эх үүсвэр, усан хангамжийн байгууламжийг хамгаалалтад байлгах, түүнд хяналт тавих журам тогтоох;
- стратегийн хүнсний үйлдвэрлэлд улсын захиалга өгөх, хөнгөлттэй зээл олгох;
- өргөн хэрэглээний хүнсийг баяжуулах үйлдвэрлэлийг дэмжих;
- хүн амын хүнсний бодит хэрэглээ, хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл, найрлага, шим тэжээлийн зохистой харьцаа, болон зориулалтын хүнс хэрэглэгчийн хоолны нормын хангалтад судалгаа, дүгнэлт хийж, жил тутам Улсын Их Хуралд мэдээлэх;

-хүнсний аюулгүй байдалд тавих хяналтын дүрмийг батлах. гэсэн заалтууд байгаа бөгөөд эдгээр нь мэдээлэх, олгох, дэмжих, журам тогтоох, дүрэм батлах” гэх мэт гол төлөв эрх эдлэх төдий үүрэг хүлээгээгүй шахам заалтууд байна.

Тэрчлэн өмнөх хүнсний тухай (1995 оны) хуулийн “Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх” гэсэн 8-р зүйлд:

“1. Хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- хүнсний зүйлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, үндэсний уламжлалт болон дэвшилт технологи нэвтрүүлэх, хүнсний зүйлийн бүтэц, тэжээллэг чанарыг нь сайжруулах, нэр төрлийг олшруулах бодлогыг хэрэгжүүлэх;

- аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд нь мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, сургалт зохион байгуулах;

2. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- эрүүл ахуйн аюулгүй байдлыг хангах талаар хүнсний зүйл, түүний үйлдвэрлэлийн хэрэгсэлийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн нийтлэг мөрдөх журам, зааврыг батлах, биелэлтийг нь хянан шалгах;

- зориулалтын хүнс хэрэглэгчдийн хэрэглэх хүнсний зүйлийн зохистой хэм хэмжээг тогтоох;

- хүн амын хэрэглэсэн хүнсний зүйлийн бүтэц, чанар, илчлэг нь зохистой хэм хэмжээ болон эрүүл ахуйн шаардлагыг хэрхэн хангаж байгаад судалгаа хийж, дүгнэлт гаргах.” гэсэн заалтууд байсныг хасч харин журам, зааврыг баталж, биелэлтийг хянан шалгах, журам тогтоож мөрдүүлэх, биелэлтэд хяналт тавих гэсэн заалтуудын хянан шалгах, хяналт тавих гэсэн гол чиг үүргийг хасч, ... журам тогтоох, ... дүрэм, заавар батлах заалтыг хэвээр үлдээжээ.

Одоогийн мөрдөж хүнсний тухай хуулийн “Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх” гэсэн 6-р зүйлд доорх 6-н асуудлыг тусгасан байна. Үүнд:

6.1. Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- хүнсний хангамж, аюулгүй байдлыг харгалзан тухайн жилд импортлох, экспортлох мал, стратегийн хүнсний нэр төрөл, хэмжээний талаар олон нийтэд мэдээлэх;

- хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөх технологи болон ургамал, амьтны гаралтай түүхий эдийн ариун цэвэр, эрүүл ахуйн нийтлэг журам, хэм хэмжээ, шаардлагыг тогтоох;

- хүнсний тэжээллэг чанарыг сайжруулах, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, уламжлалт болон дэвшилтэт технологийг нэвтрүүлэх бодлогыг хэрэгжүүлэх.

6.2. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүнсний асуудлаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- хүнс, түүний үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч этгээдээс хүнсний эрүүл ахуй, ариун цэвэр, аюулгүй байдлыг хангах талаар мөрдөх нийтлэг журам, заавар, үзүүлэлтийг батлах;

- хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрт хэрэглэж байгаа пестицид, эм, даавар, бордоо, химийн бусад бодис, хүнд металлын үлдэгдэл, цацраг идэвхт бодис, бичил

биетэн, хүнсний нэмэлт, бусад хольцын эрүүл ахуйн зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтоож, үндэсний стандартад тусгах;

- хүнсийг баяжуулахад шаардагдах бичил бодисийн зохистой хэмжээг тогтоох” гэсэн эдгээр заалтуудыг тусгасан байна.

Дээрх хуулийн өөрчлөлтийн хандлага нь хүний зохистой хоол, хүнсээр хангагдах эрхийг хэрэгжүүлэх талаар хүнсний тухай (1995 оны) хуульд Засгийн газрын (ямд оролцоод) зүгээс нилээд идэвхтэй үйл ажиллагаа явуулах, өргөн эрх хэмжээ, үүрэг, хариуцлага хүлээсэн байсныг шинэчлэн найруулсан одоогийн хуулиар хязгаарлаж идэвхгүй үйл ажиллагаа явуулж, байдлыг танилцуулах, мэдээлэх, уламжлах, батлах, журам тогтоох зэрэг хэлбэрийн төдий чиг үүрэгтэй болгож хуульчилсан байх юм. Энэ нь Монгол Улсын үндсэн хуулийн 19-р зүйлийн “1”-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэсэн зарчмын заалтыг биелүүлээгүйтэй холбоотой юм.

НҮБ-ын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооны 1999 оны XX чуулганаас гаргасан 12-р ерөнхий зөвлөмжид “Оролцогч талийн гол үүрэг нь хүмүүсийг хүрэлцээтэй хоол хүнс хэрэглэх эрхээ дэвшилттэйгээр бүрэн эдлэхэд туслах арга хэмжээг авах явдал юм. Энэ зорилгодоо хүрэхийн тулд аль болох түргэн ажиллахыг үүрэг болгож байна. Оролцогч улс бүр иргэдээ шим тэжээл сайтай, найдвартай хүнс хэрэглэж байгаа эсэх, өлсөхгүй байгаа эсэхийг хянах үүрэгтэй.

Хүрэлцээтэй хоол хүнсийг хэрэглэх эрх нь хүний эрхийн бусад хэлбэрийн адилаар улс орон бүрт “Дагаж мөрдөх”, “хамгаалах”, “биелүүлэх” гэсэн 3 түвшиний үүргийг оноодог. “Дагаж мөрдөх” үүрэг нь нэмэр болох, хангах гэсэн 2 үүргийг дотроо агуулж байдаг. Тохиромтой хоол тэжээлд хүрэх “Дагаж мөрдөх” үүрэг нь оролцогч улсыг энэ эрхийг эдэлж чадахгүйд хүргэх ямар нэг алхмыг хийхгүй байхыг шаарддаг. “Хамгаалах” үүрэг нь жижиг үйлдвэрүүд болон хувь хүмүүс хүмүүсийн тохиромжтой хоол хүнсэндээ хүрэх боломжийг олгож байгаа эсэхийг нягтлахыг шаарддаг. “Биелүүлэх” үүрэг гэдэг нь оролцогч улсууд хүнсний аюулгүй байдал гэх мэт амжиргаагаа баталгаажуулахын тулд нөөцийг ашиглах, нөөцөд хүрэх, бэхжүүлэх зорилго бүхий үйл ажиллагааг идэвхтэй явуулах гэсэн үг. Эцэст нь хувь хүн юмуу аливаа бүлэг уг эрхийг хүчин мөхөсдөж, эдэлж чадахгүйд хүрвэл оролцогч улс уг эрхийг эдлэх боломжийг нэн дариу хангах хэрэгтэй. Ард иргэд нь байгалийн болон бусад гамшигт өртсөн тохиолдолд оролцогч улс мөн дээрх үүргийг хүлээнэ.”⁵ гэж заасныг хайхарч үзээгүй байна.

Хүн амыг түүний дотор нийгмийн эмзэг бүлэгт хамрагдаж буй хүмүүсийг зохистой хоол хүнсээр хангахад дэмжлэг үзүүлэх нь төрийн нэн чухал үүрэг бөгөөд энэ асуудлыг төр, засгийн бодлогын түвшинд авч үзэж хүнсний тухай хуульд тусган хэрэгжүүлэх ёстой. Гэтэл одоогийн мөрдөж буй Хүнсний тухай хуульд тусгаагүйгээр барахгүй өмнөх (1995 оны) хуулийн 7-р зүйлийн Засгийн газрын бүрэн эрх гэсэн хэсэгт: “... шаардагдах хүнсний зүйлийн хангамж, бүтцийн зохистой хэмжээг тогтоож, ... амжиргааны баталгаажих түвшингээс бага орлоготой, нэн ядуугаас болж өлсгөлөн, өлмөн зэлмүүн байдалд хүрсэн иргэдийн судалгаа гаргаж, өөрийгөө хүнсний зүйлээр хангахад нь тусламж дэмжлэг үзүүлэх, ... амжиргааны баталгаажих түвшингээс бага орлоготой өрхийн 4 нас хүрээгүй хүүхэд, жирэмсэн эмэгтэй болон хөхүүл хүүхэдтэй эх, хөдөлмөрийн чадваргүй, тахир дутуу иргэд өндөр настай хүмүүсийг хүнсний хувьд эмзэг хэсэгт тооцож, тэдэнд дэмжлэг үзүүлэх арга хэмжээг жил бүр улсын төсөвт тусгаж хэрэгжүүлэх ..” гэсэн эмзэг бүлгийн эрхийг хангах нэн чухал заалтуудыг одоогийн хуулиас хасч орхигдуулсан нь Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактаар хүлээсэн үүрэг, олон улсын байгууллагын чиглэл, зөвлөмжөөс няцаж, ухарахад хүрсэн идэвхгүй үйл ажиллагаа гэж (хатуухан) хэлэхэд хилсдэхгүй бизээ.

⁵ Хүний эрхийн конвенцуудын хорооноос батлан гаргасан Ерөнхий санал, зөвлөмжүүдийн эмхтгэл 55-р талд.

Нийгмийн эмзэг бүлэгт хамрагдаж буй ихэнх иргэд ядуу зүдүүгийн улмаас гол хэрэгцээт хоол хүнсээ олж авахын тулд чанарыг үл хайхран аль болох хямдхан төсөр хүнсний зүйлийг худалдан авч хүнснийхээ хэрэгцээг хангаж байна.

Тиймээс ч хүн амын хоол хүнсний хэрэгцээ, шаардлагыг дотооддоо хангаж чадахгүй байгаа одоогийн хүндрэл бэрхшээлтэй байдлыг далимдуулж зарим бизнесийнхэн чанар муутай, хугацаа дууссан, стандартын бус хямд хүнсний зүйл импортгоор оруулж ирэн худалдаж хэрэглэгчдийн эрх ашгийг хохироож байна.

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооны 1999 оны ХХ чуулганаас гаргасан 12-р ерөнхий зөвлөмжид: “Олон улсын эрх зүйн хэд хэдэн баримт бичигт хүрэлцээтэй хоол хүнстэй байх эрхийг хүлээн зөвшөөрсөн байдаг. Эдийн засаг, нийгэм, соёлын Пактад энэ эрхийн талаар бусад баримт бичигт зааснаас илүү дэлгэрэнгүй заасан байдаг. Пактын 11-р зүйлийн 1-рт заасан “хүн бүрийн хүрэлцээтэй хоол хүнс, хувцас хунар, орон сууцыг оролцуулан амьдралын хүрэлцээтэй түвшинд аж амьдрах, амьдралынхаа нөхцөлийг байнга сайжруулах эрхийг” Пактад оролцогч улсууд хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд 11-р зүйлийн 2-рт заасны дагуу оролцогч улсууд иргэдээ “өлсгөхгүйгээр аж төрөх үндсэн эрхийг хангахын” тулд шаардлагатай арга хэмжээг авч байхыг хүлээн зөвшөөрч байна. Хүрэлцээтэй хоол хүнстэй байх эрх нь бусад эрхээ эдлэхэд тун чухал ач холбогдолтой.” гээд мөн зөвлөмжид: “Хороо нь хүрэлцээтэй хоол хүнстэй байх эрх нь хүний төрөлхийн нэр хүндтэй холбоотой бөгөөд хүний эрхийн талаарх олон улсын Билльд заасан хүний бусад эрхийг эдлэхэд чухал болохыг баталж байна.”⁶ гэж тус тус заасан байна. Мөн хорооноос гаргасан зөвлөмжид: “89 ... Зохистой хоол хүнсээр хангагдах эрхийг эдлэх нь эрүүл байх эрх, сурч боловсрох эрх, ажил хийх эрх зэрэг бусад эрхийг хангахад чухал үүрэгтэй.”, “91 ... Зохистой хоол хүнсээр хангагдах эрх нь бүх хүмүүс дангаараа болон бусадтайгаа хамт хоол хүнсээ хангалттай бэлтгэх эдийн засгийн чадавх эсвэл арга барилтай байхыг хэлнэ.”, “92 ... Хоол хүнсээр хангагдах эрх нь:

а/ уламжлалд нийцсэн, чанартай хоол хүнс бүх нийтэд хүрэлцээтэй байх,

б/ байгаа хоол хүнсээ бусад эрхээ эдлэхэд харшлахгүйгээр тогтвортой арга замаар авч хэрэглэх боломжтой байхыг хэлнэ.”⁷ гэж тус тус заажээ.

Ийнхүү зохистой хоол хүнсээр хангагдах эрхийн эрх зүйн үндсийг тодорхойлсон байна.

Олон улсын эрх зүйн дээрх баримт бичгийн заалт, чиглэлийг үндэсний хууль, тогтоомжид тусгаж баталгаажуулах нь манай улсын төрөөс олон улсын гэрээ конвенцээр хүлээсэн нэн чухал үүрэг юм.

Гэтэл Хүнсний тухай (1995 оны) хуулийн 4-р зүйлд: “Хоол хүнстэй байх эрх” гэсэн хэсгийн “1. Монгол улсын нутаг дэвсгэрт амьдарч байгаа хүн бүр эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, бие махбодийнхоо хэвийн үйл ажиллагаа, өсөлт төлжилтийг хангах, илч зарцуулалтыг нөхөх хоол, хүнс хэрэглэх эрхтэй.

2. хөдөлмөрийн хүнд, хортой, халуун нөхцөлд болон газрын дор ажиллагч, 4 нас хүрээгүй хүүхэд, жирэмсэн эмэгтэй ба хөхүүл хүүхэдтэй эх, өвчтэй (цаашид “зориулалтын хүнс хэрэглэгч” гэх) зориулалтын хүнсний зүйлээр хангагдах эрхтэй.” гэсэн хүний зохистой хоол, хүнсээр хангагдах эрхийг баталгаажуулсан чухал заалтыг энэ хуулийг өөрчлөн найруулахдаа одоогийн дагаж мөрдөж байгаа Хүнсний тухай хуулиас (1999 оны) хассан нь хүний энэ чухал эрхийг хангах эрх зүйн баталгаагүй болгоход хүргэсэн гэж үзэж болохоор байна.

Хүнсний тухай хуучин хуулийн 17-р зүйлд: “Хүнсний зүйлийн чанар, эрүүл ахуйн аюулгүй байдалд төрийн хяналт тавих төв, орон нутгийн эрх бүхий байгууллага, тэдгээрийн байцаагчид дараахь нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.” гээд мөн зүйлийн 2.3-т “Хүнсний зүйлийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийн үйлдвэрлэж, тээвэрлэж, хадгалж, худалдаалж байгаа хүнсний зүйлийн чанар, эрүүл ахуйн байдал, түүнийг баталгаажуулсан баримт бичигтэй танилцах, шаардлагатай гэж үзвэл шинжилгээ хийх

⁶ Хүний эрхийн конвенцуудын хорооноос батлан гаргасан ерөнхий санал, зөвлөмжүүдийн эмхтгэлийн 52, 53 дахь талд.

⁷ Зөвлөмж: Ядуурлыг бууруулах стратеги боловсруулахад хүний эрхийг тусгах нь (2004 он УБ) номын 24 дэх талд.

зорилгоор хүнсний зүйлийн дээж, загварын зохих баримт бүрдүүлж үнэ төлбөргүй авах” гэсэн хүнсний аюулгүй байдал, хүний зохистой хоол хүнсээр хангагдах эрхийг хангах чухал ач холбогдол бүхий төрийн хяналтыг хэрэгжүүлэх чиг үүргийг хассан нь энэ талаар тавих төрийн хяналтын чиг үүргийг бүрхэгдүүлж, хүчийг сулруулахад хүргэсэн байна.

Одоогийн дагаж мөрдөж буй Хүнсний тухай хуулийн 12-р зүйлд: “Хүнсний аюулгүй байдалд тавих хяналтыг улсын хэмжээнд мэргэжилийн хяналтын байгууллага, ... эрхлэн зохион байгуулна” гээд “мэргэжилийн хяналтын байгууллагын нийтлэг бүрэн эрхэд хүнсний аюулгүй байдлын үзүүлэлтийг тодорхойлж, хүнсийг улсын хилээр нэвтрүүлэхэд зөвшөөрөл олгох, аймаг, нийслэл, хилийн хяналтын албыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд сургалт зохион байгуулах, ... боловсон хүчнийг давтан сургах, мэргэжилийг нь дээшлүүлэх ажлыг зохион байгуулах, чанар, эрүүл ахуйн шаардлага хангаагүй хүнс, түүний үйлдвэрлэлийн хэрэгсэлийг импортлох, экспортлохыг хориглох, хүнсний чанар эрүүл ахуйн аюулгүй байдал, хүн амын эрүүл мэндэд үзүүлж байгаа нөлөөлийг судалж дүгнэлт гарган, авах арга хэмжээний талаар санал боловсруулж, холбогдох байгууллагад орууулах, хүнсний аюулгүй байдлын талаар мэдээллийн сан бүрдүүлэх, байнгын ажиллагаатай хилийн боомтод хүнсний аюулгүй үзүүлэлт, бусад боомтод хүнсний аюулгүй байдлын анхан шатны үзүүлэлтийг тодорхойлох лаборатори бүхий хяналтын алба ажиллуулна.” гэсэн 6-7 зүйлийг хамруулжээ. Энэ нь хүнсний чанар, эрүүл ахуй, аюулгүй байдалд тавих төрийн хяналтын чиг үүрэг, энэ талаар тавигдах шаардлагыг бүрэн хангаж чадахгүй бөгөөд энэ хуулийн 13-р зүйлд уг асуудлаар тавигдах зарим шаардлага, чиг үүргийг хяналтын хэдэн байцаагчид хариуцуулсан төдий хуулийн зохицуулалт хийсэн нь хүний энэ чиглэлийн эрхийг хангах талаар хуулиар хүлээх үүрэг, хариуцлагаас аль болох зайлсхийсэн юм уу даа гэж үзэж болохоор байна.

Хүнсний тухай энэхүү хуулийн хүнсний ариун цэвэр, эрүүл ахуй, аюулгүй байдалд тавих хөндлөнгийн хяналт гэсэн 15-р зүйлийн 1-д “Итгэмжлэгдсэн сорилтын лаборатори, баталгаажуулалт, техникийн хяналтын байгууллага хүнсний эрүүл ахуй, чанар, аюулгүй байдалд хөндлөнгийн хяналт тавьж болно.”, мөн зүйлийн 2-т “Хүнсний хөндлөнгийн байгууллагад стандартчиллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага итгэмжлэл олгоно.” гэсэн 2 заалт байгаа боловч хөндлөнгийн энэ хяналтыг ямар арга, хэлбэрээр хэрхэн хэрэгжүүлэх асуудлыг хуульчилж өгөөгүйгээс ийм сорилтын лаборатори, баталгаажуулалт, техникийн байгууллага зохих шаардлагын дагуу ажиллаж чаддаггүй юм байна.

2.1.3. Хүнсний эрхийг үндэсний хууль тогтоомжоор баталгаажуулсан байдал

➔ Хүнсний эрхийн Монгол улсын хууль, эрх зүйн орчин

Монгол улс хүнсний асуудлыг хэд хэдэн хууль эрхийн актуудаар баталгаажуулсан байдаг. Манайд одоо мөрдөгдөж байгаа хүнсний асуудалтай холбоотой хууль тогтоомжийг жагсаавал:

▪ Монгол улсын хуулиуд:

1. Хүнсний тухай (шинэчилсэн найруулга), 1999
2. Ариун цэврийн тухай,
3. Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах тухай
4. Стандартчлал, тохирлын үнэлгээний тухай
5. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай
6. Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай
7. Ургамал хамгааллын тухай
8. Таримал ургамлын үр, сортын тухай
9. Давс иоджуулж, иод дутлаас сэргийлэх тухай

- Бодлогууд:
 - Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого
 - Монгол улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого
 - Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого
- Хөтөлбөрүүд:
 1. “Хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол тэжээл” үндэсний хөтөлбөр, (2001-2010)
 2. Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр, (2003-2015)
 3. Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр, (2003-2008)
 4. “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр, (1999-2010)
 5. “Малын чанар, үржлийн ажил, үйлчилгээг сайжруулах” үндэсний хөтөлбөр (1997-2005)
 6. “Шилмэл хээлтүүлэгч” дэд хөтөлбөр (2002-2005)
 7. Газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээх хөтөлбөр (1998-2005)
 8. “Иод дутлын эмгэгтэй тэмцэх” үндэсний шинэчилсэн хөтөлбөр (2002-2006)
 9. Өрхийн орлогыг нэмэгдүүлэх “Ногоон хувьсгал” үндэсний хөтөлбөр (1997-2004)
 10. “Цагаан хувьсгал” үндэсний хөтөлбөр (1999-2004)
 11. “Үр” дэд хөтөлбөр (2001-)
 12. Мал сүргийг ган, зудаас хамгаалахад туслах үндэсний хөтөлбөр (2001-2005)
 13. “Үхэр, хонь, ямаан сүргийн бруцеллёзтай тэмцэх” төсөл (1999-2010)
 14. “Малын гоц халдварт өвчнийг оношлох чадавхийг дээшлүүлэх “ төсөл ()
 15. “Махны экспорт” төсөл (1999)
 16. “Үхрийн арьсны гууртай тэмцэх “ төсөл (2002-2004)
 17. “Уринш-2001” төсөл
 18. “Хадлан, тэжээл-2001” төсөл
 19. Малын зарим архаг халдаврт өвчинтэй тэмцэх төсөл (2003-2007)
- Дээрх хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Төрийн захиргааны төв байгууллага болон орон нутгийн засаг захиргаанаас тогтоосон дүрэм, журам, стандарт, хэм хэмжээ нилээд олныг баталсан байдаг.



2.2. Хүнсний хангамж, баталгаа (Food security)

Хүн амын хүнсний хангамж, баталгаа нь нийгмийн тогтвортой байдлыг хангах, улс төр, эдийн засгийн тусгаар тогтнолыг хамгаалахад чухал баталгаа болдог учир төрийн бодлогоор зохицуулагдах чухал асуудлуудын нэг юм.

Засгийн газар хүнсний хангамж, баталгааг бий болгох хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж хүнсний эрхээ эдэлж чадахгүй байгаа хүмүүст хоол хүнсээр өөрсдийгөө хангах боломжийг бүрдүүлэх ёстой. Ингэснээр ард иргэдээ өлсгөлөнгөөс ангид байх, зохистой хоол хүнсээр хангагдах эрхийг баталгаажуулж байгаа юм. Үүний тулд улс орнуудын зорилт, бодлогын зохицуулалт болон тохирох жишгийг тодорхойлж, хүний эрхийн зарчимд үндэслэсэн хүн амын хүнс болон хоол тэжээлийн хангамж, баталгааг хангах стратегийг батлахыг шаарддаг.⁸

ДХХААБ-ын тодорхойлсноор ХҮНСНИЙ ХАНГАМЖ, БАТАЛГАА гэж хүн бүр амьдралынхаа туршид эрүүл саруул, үр бүтээлтэй амьдрахын тулд хоногийн хоолны хэрэгцээг хангахуйц шим тэжээллэг, аюулгүй, хүрэлцэхүйц хэмжээний хоол хүнсийг олж авах (хүртэх) бие бялдрын болон эдийн засгийн чадвартай байхыг хэлнэ. Мөн байгууллага хүнсний хангамж, баталгааг хангах 4 үндсэн нөхцөлийг тодорхойлжээ.

- Хоол хүнсний хангамж, хүрэлцээ (Availability) - үржил шимт газар болон байгалийн нөөцөөс буюу эсвэл шаардлага хангасан үйлдвэрлэлээс гарсан хүрэлцэхүйц хэмжээний хоол хүнсийг зөв хуваарилалт, түгээлтээр дамжуулан шууд авч хэрэглэх боломж.
- Хангамжийн тогтвортой байдал (Stability or Sustainability of supply) – хүнсний хангамж нь улирал хооронд буюу жилээс жилд ямар ч хэлбэлзэл, хомсдолгүйгээр тогтвортой байх.
- Хүртээмж буюу хүрэх боломж (Accessibility or Affordability) – хувь хүн болон өрх гэр хоногийн хоолны хэрэгцээгээ хангахын тулд зохистой хоол хүнсийг олж авах болон худалдан авах зохих орлого буюу эх үүсвэртэй байх
- Хүнсний чанар, аюулгүй байдал (Quality and Safety of food) – хоол хүнсийг зориулалтын дагуу бэлтгэж хэрэглэхэд хүний эрүүл мэндэд хор хөнөөл учруулахгүй байх баталгаа.

Аливаа улс гүрэн хүнсний гол нэрийн бүтээгдэхүүнээр хүн амынхаа хэрэгцээг өөрийн үйлдвэрлэлээс хангах боломжтой эсэх нь тухайн орны нөөцөөс ихээхэн шалтгаалдаг. Хэрэв хүн амынхаа хэрэгцээг хангаж хүрэхүйц нөөцтэй бол хүнсний хангамжийн **чадавхитай** орон гэж үздэг. Харин хүнсний нөөцийг хэр зэрэг ашиглаж байгаагаар нь хүнсний хангамжийн **баталгаатай** гэж үздэг байна.

Тус байгууллагын үзэж байгаагаар улс гүрний хүнсний хангамж, баталгааг дараахь үндсэн 2 үзүүлэлтээр үнэлж болдог байна. Үүнд:

- **Дараагийн ургац хүртэл хадгалах буудайн нөөцийн хэмжээ.** Хэрэв буудайн энэхүү шилжих нөөц улсын нийт хэрэгцээг 60 хоног хангахад хүрэлцээтэй байвал хүнсний хангамжийн баталгаа хангагдсан гэж үзнэ.
- **Хүн амын жишсэн нэг хүнд оногдох үр тарианы үйлдвэрлэлийн хэмжээ.** Энэ үзүүлэлт хүн амын өсөлтийг даган нэмэгдэж байвал хүнсний хангамж баталгаатай гэж үздэг ажээ.

Хүнсний хангамжийн эх үүсвэр нь эх орны үйлдвэрлэлийн болон импортын бүтээгдэхүүн байх учраас тухайн улс орны хүнсний баталгааны бас нэг чухал үзүүлэлт нь дотоодын үйлдвэрлэл, импортын харьцаа байдаг. Олон улсын хэмжээнд тогтсон жишгээр хүнсний хэрэгцээний 30-аас дээш хувийг импортоор авдаг орныг хүнсний хангамжийн баталгаагүй гэж үзэх бөгөөд нэг төрлийн бүтээгдэхүүний хэрэгцээний 20-оос илүү хувийг зөвхөн ганц орноос импортолдог бол уг улсыг тухайн гүрнээс хүнсний хангамжийн хувьд хараат байдалтай гэж үнэлдэг. Үүнээс үзвэл хүнсний хангамж, баталгаа гэдэг нь зөвхөн хүн амыг хүнсний зүйлээр хангах асуудал төдийгүй улс орны

⁸ ЭЗНСЭХ-ны Ерөнхий зөвлөмж 12, Хорьдугаар чуулган, 1999 он, 15, 21-р заалтаас

тусгаар тогтнол, улс төр, эдийн засгийн хувьд бие даасан байдлыг илтгэх үндэсний аюулгүй байдлын чухал үзүүлэлт болдог байна.

Үндэсний уламжлал, заншил, байгаль, цаг уурын нөхцөлийг харгалзан турайг улс гүрний хувьд хүнсний ямар нэг бүтээгдэхүүн шийдвэрлэх ач холбогдолтой байх бөгөөд үүнийг стратегийн хүнсний бүтээгдэхүүн гэж нэрлэнэ.

Улс гүрний түвшинд хүнсний хангамжийн баталгааны асуудал тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлын чухал үзүүлэлт болдог бол тухайн улсын доторхи нутаг дэвсгэрт хүн ам оршин сууж, ажиллаж амьдрах үндсэн нөхцөл юм. Ийм учраас нэг гүрний хэмжээнд хүн ам жигд тархан амьдрах нөхцөл бололцоог бүрдүүлэх төрийн бодлогын бас нэг чухал хэсэг нь хүнсний хангамжийн баталгааг буй болгох зорилт болдог. Жишээлбэл, манай орны Төвийн нутагт тариа, будааны нөөц бололцоо байдаг бол Хангайн нутгаар мах, сүү, цагаан идээ харьцангуй элбэг байдаг.

Улс даяар тархан байрласан хүнсний түүхий эд, нөөцийг зах зээлийн эргэлтэнд оруулж, хүн амын хэрэгцээг хангах нь төрөөс алс хэтийн бодлого, үйл ажиллагаа явуулахыг шаарддаг цогц асуудал юм. Энэ бодлогын хүрээнд хөдөө аж ахуй, хүнсний аж үйлдвэрийг хөгжүүлэх, үндэсний үйлдвэрлэгчдийг төрөөс эдийн засгийн бодлогоор дэмжих, хүнсний импорт, экспортын зохистой харьцааг тогтворжуулах, хүн амын худалдан авах чадварыг дээшлүүлэх, ядуурлыг бууруулах, өтгөс, нялхас, амьжиргааны түвшингээс доош орлоготой хүмүүс зэрэг нийгмийн эмзэг бүлгийн хүнсний хангамжийн асуудлыг төр зохицуулан шийдвэрлэх зэрэг олон асуудлууд багтдаг байна.

2.2.1. ХАНГАМЖ БАТАЛГААГ ХАНГАХ ТАЛААР ТӨРӨӨС АВЧ БУЙ АРГА ХЭМЖЭЭ

■ Төрийн бодлого, хууль эрх зүйн орчин

Хөдөө аж ахуйн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр гаргасан хууль, эрхийн актууд нь бүхэлдээ хүнсний хангамж, баталгааг сайжруулах зорилттой холбоотой юм.

УИХ-аас 1999 онд баталсан “Хүнсний тухай”, 2001 оны “Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай”, 2004 оны “Тариалангийн тухай”, 2004 оны “Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай” зэрэг хуулиудыг хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр хүнсний хангамж, баталгааг хангахад баримталж байна.

Уг зорилтыг хэрэгжүүлэхээр хуульд тусгасан заалтуудыг дурьдвал, УИХ-ын бүрэн эрхийн хүрээнд:

“Хүнсний тухай” хуулийн зорилт нь “хүн амын хүнсний хэрэгцээ ... –г хангах”-ад оршиж байгаа нь хүн амын хэрэгцээтэй хүнсний нийлүүлэлт, хангалтыг хариуцна гэсэн утгатай байна. Гэвч хүнсний хэрэгцээ гэдгийг хуулийн нэр томъёоны тайлбартаа тайлбарлаагүй болохоор үүнийг шууд утгаар ингэж ойлгох нь бас учир дутагдалтай. Хүнсний хангамж, баталгааг хангах талаар УИХ уг хуулийн 4.1.1-д “хүн амын хүнсний хангамж . . . –ийн талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох, хэрэгжилтэнд нь хяналт тавих” болон 4.1.2-т “стратегийн хүнс үйлдвэрлэдэг үйлдвэрлэгчдийг Засгийн газрын саналыг үндэслэн төрийн санхүү, зээл, татварын бодлогоор дэмжих” бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр тусгасан байдаг. Мөн УИХ нь 4.1.3-т заасан улсын нөөцийн хүнсний нэр төрлийг тогтоох, өөрчлөх эрхтэй байна.

“Стратегийн хүнс” гэдгийг 3.1.6-д “монгол хүн хүнсэндээ хэрэглэж дадсан, хүний физиологийн хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай мах, буудай, тарианы үр, давс, ундны усыг хэлнэ” хэмээн тодорхойлсон байна. Гэтэл манай улсад үр тариа, газар тариаланг эрхэлж байсан түүхэн уламжлал байгаагүй харин 1921 оны хувьсгалын дараагаас 60-аад оны өмнөөс хөгжиж ирсэн түүхтэй одоо хүн амын хэрэглэж дадсан хоол хүнсний нэг төрөл хэдий нь болжээ. Харин манай эрт үеэс уламжлан ирсэн мал аж ахуй, түүний ашиг шим болох мах, сүүг монгол хүн жилийн 4 улиралд зохицуулан амьдралынхаа туршид хэрэглэж ирсэн түүхэн уламжлал бий. Мах бол малаас нэг л удаа гардаг ашиг шим, түүнийг хэрэглэснээс хойш тухайн малыг дахин ашиглах боломжгүй болдог нь тодорхой. Тэгвэл сүү, цагаан идээ бол малаас жилийн 4 улиралд

гардаг, тухайн нэг малаас хэдэн ч удаа авч болох ашиг шим мөн. Түүгээр ч үл барам сүү, цагаан идээ хүний бие махбодид зайлшгүй шаардлагатай шимт болон биологийн өндөр идэвхит бодисыг хамгийн зохистой хэмжээгээр агуулсан, маш сайн шингэж боловсордог байгалийн бүтээгдэхүүн юм. Сүү өөрөө төгөлдөр сайн чанартай төдийгүй бусад хоол хүнсний зүйлийг шингэж боловсроход нэмэр болдог онцлогтой. мөн билээ. Гэтэл тэргүүлэгч хүнсний зүйл болох сүү, цагаан идээг стратегийн хүнсэнд оруулаагүй бөгөөд сүүний үйлдвэрлэл сүүлийн 15 жил урсгал байдалтай байгаа нь хүн амын ихэнх нь кальци, магнийн дутагдалд орж, хүүхэд, хөгшчүүл яс сийрэгжих, бие бялдрын өсөлт хоцрох эмгэг байнга тохиолдсоор байгаа билээ.

Засгийн газар хуульд зааснаар хүнсний бодит хэрэглээ, нэр төрөл, нарлага, шим тэжээлийн талаар судалгаа, дүгнэлт хийж, УИХ-д жил тутам мэдээлж байхаар хуулинд заагдсан боловч олон нийт энэ талаар бодитой мэдээлэл, нэгдсэн ойлголтгүй хэвээр байна.[44(15)]

Уг хуулинд хүн амыг хоол хүнсээр өөрсдийгөө хангах боломжийг хэрхэн олгох талаар огт тусгагдаагүй байгаа нь нэгдүгээрт, хоол хүнсний үнэ ямар нэг зохицуулалтгүй болж, үнийн хөөрөгдөл бий болох, хоёрдугаарт, гуравдагч этгээд хүн амын хүнсний хангамжийг зориудаар гачигдуулах боломжийг олгож байна. Мөн түүнчлэн, хүн амын ядуу, эмзэг хэсэгт болон ажилгүйдэл, ган гачиг тохиолдсон үед төрөөс тухайн эмзэг бүлгийн хүн амыг нэн тэргүүнд хоол хүнсээр хангах эрхийг талаар уг хуульд ямар нэг заалт тусгагдаагүй байна.

УИХ бүрэн эрхийнхээ хүрээнд тодорхойлох “Хүнсний тухай” хуулийн 4.1.1-д заасан хүн амын хүнсний хангамж, аюулгүй байдлын талаар төрөөс баримтлах бодлого нь 2003 онд УИХ-ын 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого” ажээ. Энэхүү бодлогын зорилго нь эдийн засаг, бизнесийн таатай орчинг бүрдүүлэх, үйлдвэрлэлийн бүтээмж, чадавхийг нэмэгдүүлэх, мал аж ахуй, газар тариалан, хүнсний салбарын тогтвортой хөгжлийг хангах, экологийн цэвэр, аюулгүй хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэжээ. Төрөөс баримтлах энэхүү бодлогын зорилт нь хүнс, хөдөө аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн мах, сүү, гурил, төмс, хүнсний ногооны хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангаж, импортыг бууруулж, экспортыг нэмэгдүүлэхэд оршиж байна.

▪ Төрөөс авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

Засгийн газраас 2001 онд 242-р тогтоолоор “Хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол тэжээл” Үндэсний хөтөлбөрийг батлан гаргасан нь хүнсний хангамж, хэрэглээ, эрүүл ахуйн аюулгүй байдлын асуудлуудыг цогц байдлаар шийдвэрлэх зорилтыг агуулсан чухал алхам болсон байна. Үүнээс гадна сүүлийн 10 жилд “Малын эрүүл мэнд”, “Мал сүргийг ган, зудаас хамгаалахад туслах”, “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих”, “Ногоон хувьсгал”, “Цагаан хувьсгал” хөтөлбөр болон бусад холбогдох олон чухал, хөтөлбөр, төслүүдийг батлан хэрэгжүүлж байна. Эдгээр зарим хөтөлбөр нь “Хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол тэжээл” Үндэсний хөтөлбөрийн нэг хэсэг болж хэрэгжиж байгаа аж.

Хөтөлбөрийн зорилго нь хүн амыг тэжээллэг, чанартай, аюулгүй хүнсээр жигд хүртээмжтэй ханган, хоол, тэжээлийн байдлыг дээшлүүлж, улмаар эрүүл мэндийг сайжруулахад оршиж байна. Уг хөтөлбөр нь 3 багц асуудал тус бүрт тодорхой зорилтуудыг дэвшүүлсэн бөгөөд хүнсний хангамжийн асуудлаар дараахь зорилтуудыг дэвшүүлсэн байна. Үүнд:

1. Мах, сүү, үр тариа, төмс, хүнсний ногооны чиглэлээр хэрэгжиж байгаа хөтөлбөр, төслүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлж, хүнсний аюулгүй байдлыг хангах;
2. Гурил, гурилан бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлж, гурилын хэрэгцээ, чанар, аюулгүй байдлыг хангах;
3. Дэвшилтэт технологийг нэвтрүүлж, олон улсын стандарт, аюулгүйн шаардлага хангасан зарим төрлийн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, шинэ төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг бий болгох.

2.2.2. Хүнсний хангамжийн өнөөгийн байдал

Монгол улс хүнсний нөөцийн хувьд өнөө ба ойрын ирээдүйд, тэр ч байтугай нилээд алс хэтдээ хүнснийхээ гол хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах бүрэн чадавхитай орон юм. (Хүснэгт 2.2.1.) Ийм боломжийг манай орны өргөн уудам нутаг дэвсгэр, мал сүрэг, хүнсэнд ашиглах байгалийн баялаг маань олгодог байна.

Хүснэгт 2.2.1. Монгол улсын хүнсний нөөц

Мал сүргийн тоо, сая толгой, Үүнээс:	24,0-30,0
эх мал	12,0-14,0
жилд бойжуулах төл	9,0-11,0
Жилд үйлдвэрлэх мах, няд. жин мян. т	230,0-300,0
Жилд үйлдвэрлэх сүү, сая л	500,0-600,0
Хөдөө аж ахуйн эдэлбэр газар, мян.га, Үүнээс:	126000,0
Хадлан, бэлчээр талбай	124000,0
Эргэлтийн талбай	1340,0
Жил бүр тариалах боломжтой талбай, Үүнээс:	800,0
Үр тарианы	600,0
Төмсний	11,0
Хүнсний ногооны	3,0
Жилд авах ургац, мян. т	
Үр тариа, бүгд	600,0
Буудай	400,0
Төмс	130,0
Хүнсний ногоо	50,0
Ундны ус, км. куб	34000,0

Монгол улс 1990-ээд оноос өмнө хөдөө аж ахуйн үйлдвэрлэлээр хүн амын хүнсний хэрэгцээг бүрэн хангаад, улмаар тодорхой хэсгийг гадаадад экспорлогч орон байжээ. 1991 оноос эхлэн Монгол улсын эдийн засаг, нийгмийн тогтолцоо шинэчлэгдэж, дотоод, гадаад нөхцөл байдал өөрчлөгдөн, зах зээлийн харилцаанд шилжиж эхэлснээс улс, ардын аж ахуйн бүх салбарт учирсан эдийн засгийн хямрал үйлдвэрт нилээд хүнд тусаж, түүхий эд, материал, сэлбэг хэрэгсэл тасалдаж, түлш, эрчим хүч, шатахууны хангамж доголдон, үйлдвэрлэлийн жигд ажиллагаа алдагдаж эхэлсэн. Үүнээс шалтгаалан уг салбарын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт 1995 онд 1991 оныхоос 3 дахин, 2003 онд 1995 оныхоос 1.5 дахин буурсан байна.

Хүн амын хүнсний хангамжийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дээшлүүлэх зорилгоор төрөөс янз бүрийн арга хэмжээ авч байгааг дээр дурьдсан үндэсний хөтөлбөр, түүний салбар, дэд хөтөлбөр, төслүүдээс олж харж болох юм. Гэвч хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэлд гарч буй дараахь хүндрэл бэрхшээл нь хүн амын хүнсний хангамжинд зүй ёсоор нөлөөлж байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Манай орон хүнсний нөөцөө хэрхэн ашиглаж байгааг харахад махны нөөцийг бүрэн ашиглаж, хүн амын хэрэгцээг хангаж, улмаар малын махыг экспортолдог байна. (Хүснэгт 2.2.2.) Харин сүүний нөөцийн 50-60 хувийг л ашиглаж, энэ нь хүн амынхаа хэрэгцээг үйлдвэрлэлтээр бараг хангаж байгаа мэт боловч зохистой хэрэглээний бүтцээр бодвол сүү, цагаан идээний хэрэглээний жишиг бодит байдлаас доогуур тогтоогдсон байх магадлалтай. Учир нь 1980 оны Монголын хүн амын хоол хүнсний физиологийн нормд сүү, сүүн бүтээгдэхүүний жишсэн нэг хүний дундаж хэрэгцээг 740 мл байхаар тооцож байсан бол 1997 онд шинэчилсэн нормоор энэ хэмжээг 380 мл хүртэл бараг 2 дахин бууруулсан байгаа нь жилийн хэрэгцээ хангахад нөлөөлсөн байх талтай. Тэгвэл сүү, цагаан идээ нь хүн амын хоол тэжээлийн хэрэгцээнд ямар их ач

холбогдолтой болохыг тайлангийн 2.4.1-д дурьдах болно. Хүнсний нөөц ашиглалтын байдлаас үзвэл үр тариа, ялангуяа буудай, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлт ихээхэн анхаарал татаж байна.

Хүснэгт 2.2.2. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үйлвэрлэлт, хэрэгцээ

№	Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	Жилийн үйлдвэрлэлт	Жилийн хэрэгцээ	Зөрүү (+ ; -)
1	Малын мах	нядалгааны жин мян. т	226,4	180,0	+46,4
2	Сүү	сая. л	290,3	297,4	+7,1
3	Үр тариа, бүгд Үүнээс: буудай	мян.т	142,2 138,7	370,0 350,0	-227,8 -211,3
4	Төмс	мян.т	58,0	90,0	-32,0
5	Хүнсний ногоо	мян.т	44,5	150,0	-105,5
6	Өндөг	сая.шир	7,7	25,6	-17,9

Ийм учраас газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлэх асуудал ойрын 10-15 жилд төрийн бодлогын тулгамдсан зорилт болжээ. Нэгэнт эх орны хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлтээр махнаас бусад хэрэгцээг бараг хангаж чадахгүй байгаа болохоор хэрэгцээний дутууг импортоор авч байна. Манай улс гурилын хэрэгцээний 80-аад хувь, төмс, хүнсний ногоо, өндөгний дийлэнх хувь, цөцгийн тос, хатаасан болон өтгөрүүлсэн сүү, ургамлын тос, загасан бүтээгдэхүүн, чихрийн зүйл, төрөл будааны хэрэгцээг зөвхөн импортын эх үүсвэрээр хангаж байна. Гурил, төмс, хүнсний ногооны импортын зонхилох хувь зөвхөн хөрш хоёрхон орон эзэлж байна. Ийнхүү Монгол улс хүнсний тодорхой нөөцтэй боловч хэрэгцээнийхээ зонхилох хэсгийг импортоор хангадаг болж, хангамжийн баталгаа алдагдсан, гурил, төмс, хүнсний ногооны хувьд гадаад орноос хараат байдалтай байгааг тоо баримтууд харуулж байна.

Хүнсний хангамжийн бодит байдлыг үнэлэх шалгуур нь хүний бие махбодид шаардлагатай хоол тэжээлийн бодисуудын зөвлөмж хэмжээ болно. Монгол хүний хоол тэжээлийн бодисуудын зөвлөмж хэмжээг судалгааны үндсэн дээр анх 1981 онд тогтоож, 1997 онд шинэчилж, Эрүүл мэндийн сайд баталж байжээ.

**Хүснэгт 2.2.3. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний жилийн хэрэглээ
Жишсэн дундаж хүнд кг-аар**

№	Бүтээгдэхүүн	Зөвлөмж	1990	1995	1999	2000	2001	2002
1	Мах,махан бүт.	84,0	97,0	96,7	112,8	120,0	97,2	120,0
2	Сүү,цагаан идээ	138,7	118,0	125,5	146,4	130,8	100,8	130,8
3	Цөцгийн тос	9,8	3,0	4,2	2,4	2,4	2,4	2,4
4	Гурил, гурилан бүтээгдэхүүн	124,1	97,0	94,3	99,6	108,0	110,4	108,0
5	Будаа	16,4				14,4	15,6	14,4
6	Чихрийн зүйл	21,9	23,0	8,7	8,4	10,8	12,0	10,8
7	Загас,загасан бүт	3,1	1,0	0,7	0,00	0,00	2,4	0,00
8	Өндөг, шир	85,0	29,0	2,5	3,6	8,4	14,4	8,4
9	Төмс	43,8	23,0	11,3	16,8	21,6	26,4	21,6
10	Хүнсний ногоо	73,0	20,0	7,9	12,0	12,0	16,8	12,0
11	Жимс,жимсгэнэ	102,2	9,0	0,3	2,4	3,6	3,6	3,6
12	Ургамлын тос	9,1	1,0	0,9	1,2	4,8	6,0	2,4


Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний зөвлөмж хэмжээ, бодит хэрэглээний статистикийн судалгааг зэрэгцүүлэн үзэхэд өнөөгийн байдлаар монгол хүний хэрэгцээ зөвхөн мах, махан бүтээгдэхүүнээр бүрэн хангагдаж байна (хүснэгт 2.2.3.). Харин бусад бүтээгдэхүүн хүн амын хүнсний хэрэгцээний, ялангуяа аминдэм, аминхүчил,

эрдэс бодисын гол эх үүсвэр болох төмснийх 49,3%, хүнсний ногооных 16,4%, цөцгийн тосных 24,4%, өндөгнийх 9,8%, жимс, жимсгэнийх дөнгөж 3,1%, ургамлын тосных 26,3%-ийг тус тус дөнгөж хангаж байгаа бөгөөд загасаар бараг хангагдахгүй байна.

➤ **Хөдөө аж ахуйн зарим түүхий эдийн нөөц, хүнсний хангамжинд учирч буй бэрхшээл.**

▪ **Мал аж ахуй** - Мал аж ахуй нь манай орны эдийн засгийн уламжлалт салбар төдийгүй зах зээлийн нөхцөлд дэлхийн түвшинд өрсөлдөхүйц чанар сайтай, байгалийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтойгоороо үлэмж давуутай юм. Монгол улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих эхний үе шатанд махны экспорт эрс багассан, малыг хувьчилсан, цаг агаарын нөхцөл зэрэг нь малын тогтвортой өсөлтийг хангахад эерэг нөлөө үзүүлсэн юм. Гол нь цаг агаар, өвөлжилтийн байдлаас шалтгаалан манай улсын малын тоо 24-33 саяд хэлбэлзэж байгаа бөгөөд нийт малын 80 хувь орчмыг бог (хонь, ямаа), 20 хувь орчмыг бод (үхэр, адуу, тэмээ) эзэлдэг. Нийт малын толгойн тоонд эх малын эзлэх хувийн жин 42 хувь байгаа нь жилд дунджаар 10 сая орчим төл хүлээж авч, хэрэглээнд зарцуулах болон бусад хорогдлыг нөхөж, цэвэр өсөлтийг 1,5 сая толгой байлгах үндсэн нөхцөл юм.

Зураг 2.2.1. Мах үйлдвэрлэлт, зориулалт, төрөл



Засгийн газрын 1997оны 105 дугаар тогтоолоор баталсан Малын чанар, үржлийн ажил үйлчилгээг сайжруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нэлээд ажил хийгдэж байгаа ч хөтөлбөрт заагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг бүхий мэргэжлийн албадын бүтэц, тогтолцоо бүрдэж чадаагүй, хөрөнгө санхүүгийн эх үүсвэр байхгүйгээс тавьсан зорилгоо бүрэн биелүүлж чадахгүй байна. [23]

Сүүлийн жилүүдэд өндөр ашиг шимт цэвэр, эрлийз малын нийт сүрэг 1.2 хувь болтлоо цөөрч, сүүний чиглэлийн үхэр, нарийн, нарийвтар ноост хонины тоо 1990 оныхоос 82.4-89.8 хувиар буурсан төдийгүй Орхон, Ерөө, Жаргалант, Сүмбэр үүлдрийн хонь, ноосны чиглэлийн Өнжүүл үүлдрийн хэсгийн ямааны тоо үлэмж хэмжээгээр цөөрч, удмын санд нь сөргөөр нөлөөлж болзошгүй нөхцөлд хүрээд байна.

Сүүний цэвэр үүлдрийн үнээ 10 дахин, эрлийз нь 15 дахин цөөрч нэг үнээнээс жилдээ дунджаар 1800 литр сүү ашиглаж байна. 2002 оны статистикийн мэдээгээр улсын хэмжээнд 61.6 мянган шувуу, 13.2 мянган гахай тоологдсон нь 1990 оныхоос даруй 6-9 дахин цөөрсөн байна. Жилд 8.1 сая ширхэг өндөг, 1.1 мянган тонн гахайн мах үйлдвэрлэсэн нь өндөгний бодит хэрэглээний 17, шаардагдах гахайн махны 25 орчим хувийг эзэлж байгаа юм.

Сүргийн бүтцэд эр малын эзлэх хувь өсч, махны экспорт эрс багассанаар дотоод дахь мах үйлдвэрлэл нэмэгдэж, нэг хүний жилийн жишсэн дундаж хэрэглээ 120 кг-д

хүрчээ. Гэвч бэлчээрийн малын мах нь гарц, чанар, найрлагын хувьд зах зээлийн эрэлт хэрэгцээг зарим талаар бүрэн хангахгүй байна.

Урьд нь ажиллаж байсан тэжээлийн 13 аж ахуй, 27 үйлдвэр, 290 гаруй цех устаж, тэжээлийн ургамал тариалах ажил үндсэндээ орхигдон гахай, шувууны зориулалтын бүрэн найрлагат тэжээлийг импортоор авч байна. Газар тариалангийн үйлдвэрлэл уналтын байдалд орсон нь эрчимжсэн мал аж ахуйн тэжээлийн хангамжинд сөргөөр нөлөөлжээ.

Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дагуу бүсийн тулгуур төвүүдийн ойролцоо, мөн тариалангийн бүс нутагт газар тариалан, эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлэх, бэлчээрийн нөөцийг зохистой ашиглах, бүтээмж өндөртэй мал, амьтан үржүүлэх ажлуудыг янз бүрийн хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлж байна.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2003 оны үндсэн чиглэлийн дагуу хүн амын мах, сүүний хангамжийн найдвартай байдлыг хангах зорилгоор эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байна. [25]

Сүү, цагаан идээний үйлдвэрлэл, хангамжийн өнөөгийн байдал. Сүү, цагаан идээний үйлдвэрлэлт 1992 оноос эрс багассаар 2003 онд дөнгөж 150 сая литр болж, цөцгийн тосыг 1995 оноос хойш бараг үйлдвэрлэхээ больжээ. Энэ нь 1993-1995 онд гадаадаас тусламж хэлбэрээр 5-6 мянган тонн цөцгийн тос ирж байсантай зарим талаараа холбоотой байна.[51(3)]

Сүүлийн жилүүдэд мал сүргийн тоо өсч байгаагийн хэрээр сүү, цагаан идээ бэлтгэх боломж нөөц нэмэгдэж байна. Мал хувийн өмчид шилжиж эдийн засгийн чөлөөт зах зээлийн орчин бий болсноор малчид, мал бүхий иргэд малынхаа саалийг ашиглаж сүү, цагаан идээгээ борлуулж, ашиг орлогоо нэмэгдүүлэх таатай нөхцөл бүрдэж эхэллээ.

Үндэсний уламжлалт технологиор бэлтгэсэн цагаан идээний зах зээл бий болон өргөжиж байгаа боловч орон нутагт саавал зохих малыг саалинд бүрэн хамруулж чадахгүй байгаагаас сүүний их нөөцийг алдаж байна. Сүү, цагаан идээ бэлтгэх, боловсруулах, борлуулах ажил урсгал байдалтай байна.

Саалийн механикжсан фермүүд задарч сүүг жилийн турш бэлтгэн нийлүүлэх технологи алдагдаж, сүүний үүлдрийн үхрийн тоо, ашиг шим буурснаас аймаг, нийслэл, төв суурин газрын хүн амын сүүний хангамжид бэрхшээл учирч байна.

Байгаа нөөцийг зохистой ашиглан сүү, цагаан идээгээр хүн амыг хангах талаар төр, засгийн чиглэсэн зорилготой бодлого, зохицуулалт шаардагдаж байгааг харгалзан 1999 онд Засгийн газраас “Цагаан хувьсгал” үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлж дуусаад байна. Хөтөлбөрийн зорилго нь мал аж ахуйн үйлдвэрлэлийн дотоод нөөц бололцоог дайчлан ашиглаж, сүү, цагаан идээний үйлдвэрлэл эрхэлж ирсэн уламжлалыг сэргээх, боловсруулах жижиг үйлдвэрийг хөгжүүлэх, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх тогтолцоо бүрдүүлэх замаар хүн амын сүү, цагаан идээний хангамжийг сайжруулах, малчид, хөдөөгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэн орон нутагт ажлын байр шинээр буй болгоход хөтөлбөрийн зорилго оршиж байв.[22]

ХХААЯ-ны мэдээгээр хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авч ажилласнаар төвлөрсөн хот, суурин газрын хүн амын хэрэгцээнд зориулан аж үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний хэмжээ 2000 онд 1.5 сая, 2001 онд 1.2 сая, 2002 онд 3.2 сая, 2005 оны эхний 8 сарын байдлаар 3.1 сая литр болж нэмэгджээ. Энэ нь нийт улсын хэмжээнд саасан сүүний ердөө 2%-ийг эзэлж байна.

Ган, зудын байдал, түүний давтамж: Бэлчээрийн мал аж ахуй нь олон зууны туршид Монголчуудын нүүдлийн амьдралын гол хэв маяг, эдийн засгийн үндсэн салбар байсаар ирсэн бөгөөд байгалийн гамшигт өртөх магадлал ихтэй байдаг онцлогтой. Азийн эрс тэс уур амьсгалтай манай оронд байгалийн гамшиг, түүний

дотор ган, зудын давтамж ойртож, эдийн засаг, нийгэмд ихээхэн хохирол учруулж байна.

Монгол орны бэлчээрт одоогоор тогтоогдоод буй 2600 гаруй ургамлаас 600 гаруй нь малын тэжээлийн үндсэн хэрэгцээг хангадаг. Хангайн өндөр уулын бэлчээрийн ургац зуншлага сайтай жилүүдэд олон жилийн дундаж ургацаас 26-38 хувиар ихсэж, гантай жилүүдэд 12-48 хувиар багасч байхад цөлөрхөг хээрийн бэлчээрийн ургац зуншлага, ургац сайтай жил 23.1-58.3 хувиар нэмэгдэж, гантай жилүүдэд 28-60.3 хувиар багасдаг байна.

Бэлчээрийн ургамлын шимт чанар өвөл хаврын улиралд зуныхаас 2-3 дахин, шингэх протеин 3-4 дахин буурдаг байна. Өвөл хаварт мал хоногт шаардагдах тэжээлийнхээ дөнгөж 40-50 %-ийг бэлчээрээс авдаг. Ган, зудтай жилүүдэд бэлчээрийн даац хэвийн жилийнхээс 23-39 хувиар буурч, мал аж ахуйн үйлдвэрлэлд багагүй хохирол үзүүлсээр ирсэн юм.

Сүүлийн 60 жилийн судалгаанаас үзэхэд манай оронд ган, зудын давтамж богиносох хандлагатай болж үлэмж хэмжээний хохирол учруулж, түүхэн сургамж үлдээсэн байна. [5]

Хүснэгт 2.2.4. Байгалийн гамшигийн улмаас гарсан малын хорогдол

Он	Жил	Гамшиг- гийн төрөл	Хамарсан нутаг дэвсгэр (%)	Малын хорогдол /сая.тол/			
				Том мал		Төл	
				Тоо	Хувь	Тоо	Хувь
1944-1945	Бич, тахиа жил	Ган-зуд	9 аймгийн 65 хувь	8.1	33.2	1.1	17.0
1954-1955	Морь, хонь жил	Зуд	9 аймаг	1.9	8.2	0.3	4.0
1956-1957	Бич, тахиа жил	Зуд	11 аймаг	1.5	6.2	0.9	12.0
1967-1968	Хонь, бич жил	Ган-зуд	13 аймгийн 80 хувь	2.7	11.9	1.7	21.6
1976-1977	Луу, могой жил	Зуд	15 аймгийн 116 сумын 90 хувь	2.0	8.6	1.6	10.7
1986-1987	Туулай, луу жил	Зуд	11 аймгийн 198 сумын 80 хувь	0.8	3.6	0.9	9.0
1993	Тахиа жил	Зуд	Завхан, Баянхонгор, Говь-Алтай аймгийн 30 сум	1.6	6.4	1.2	13.0
1996-1997	Хулгана, үхэр жил	Зуд	11 аймгийн 39 сум зудтай, 12 аймгийн 30 сум зудархуу	0.6	2.1	0.5	5.4
1999-2000	Туулай, луу жил	Ган-зуд	12 аймгийн 157 сум	3.0	8.9	1.2	12.1

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн санаачилга, дэмжлэгээр зохион байгуулсан “1999-2000 оны зудын сургамж” судалгаа

Сүүлийн 2 жил дараалан манай орны 13 аймгийн 152 сумын нутгаар гантай, хэт халуун болсноос бэлчээрийн гарц муудаж, мал сүрэг тарга хүч дутуу авах, малчид хадлан бэлчээр хомс бэлтгэх, газар тариалангийн аж ахуйнууд ургац алдах зэрэг хүндрэл учирч, өвөл нь цас их хэмжээгээр үргэлжлэн орж хүйтэрснээс зарим нутагт гамшиг нүүрлэн хүн ам хоол хүнсний хомсдолд орсон билээ. Монгол орны хатуу хахир өвлийн дараах хавар, зуны эхэн саруудад дээрх аймаг, сумдад хүн ам хоол хүнсээр дутагддаг байна.

■ **Газар тариалан** – Монгол Улс далай тэнгисийн чийглэг уур амьсгал хойноосоо Сибирийн их ой, Хэнтий Хангай, Соёны их уулсаар, өмнөөсөө Зүүнгарын цөл, их говийн хуурай халуун элсэн манхнаар тусгаарлагдсан учир эх газрын эрс тэс уур амьсгалтай, таримал ургамлын ургах хугацаа богино (85-103хоног), чийг дутагдалтай (5-9 дүгээр сард дөнгөж 240-156 мм тундас унадаг, 5-6 дугаар сарын ган 3 жилд нэг удаа, 5-7 дугаар сарын ган 8 жилд нэг удаа, 8-9 дүгээр сарын ган 10 жилд нэг удаа тохиолддог) учир усалгаагүй үр тарианы үйлдвэрлэл эрхлэхэд нэн тааламжгүй

нөхцлийг бүрдүүлдэг бөгөөд ийм байдалд тогтвортой ургац авахын тулд ихээхэн хөрөнгө, өндөр мэдлэг, дадлага, ур чадвар, техник хангамж, технологийн хатуу сахилга шаарддаг.

Газар тариалан бол хүн амын хүнсний хэрэгцээг хангах гол эх үүсвэрийн нэг яах аргагүй мөн билээ. Иймд газар тариалангийн хөгжлийн өнөөгийн төлөвийг ярихын тулд түүний үүсэл хөгжлийг тоймлон авч үзвэл:

Монгол оронд 1960-аад оноос бий болсон нийгэм, эдийн засгийн идэвхитэй, эрчтэй өөрчлөлтийн үр дүнд хөдөө аж ахуйд газар тариалан нь үр тариа, төмс, хүнсний ногоо гэсэн үндсэн хоёр чиглэлтэй бие даасан том салбар болон гарч ирсэн билээ.

Манай орны эдийн засаг зах зээлийн тогтолцоонд шилжиж төсвийн татаас, хөнгөлөлттэй зээл, тусламж зогссоноор газар тариалангийн үйлдвэрлэл сүүлийн 7 жил дараалан унаж, нийт эргэлтийн талбайн 50 орчим хувь ашиглагдахгүй болж, хүн амын хэрэгцээт гурил, төмс, хүнсний ногооны 50 хүртэл хувийг хангах төдийд хүрлээ. Манай улс 1996 онд үр тариа 225,0 мянган тонн, төмс 47,0 мянган тонн, хүнсний ногоо 22,6 мянган тонныг тус тус хураан авсан нь 1985-1990 оны жилийн дундажтай харьцуулахад үйлдвэрлэсэн үр тариа 3,4 дахин, төмс 2,7 дахин, хүнсний ногоо 2,0 дахин буурчээ.


Зөвхөн 1997 онд газар тариалангийн үйлдвэрлэлийн уналт зогсох хандлага гарч 1996 оныхоос үр тарианы үйлдвэрлэл 8,9 хувиар, төмснийх 14 хувиар, хүнсний ногооных 32 хувиар өслөө. Энэ салбарт машин техник хуучирсан, бордоо, гербицид хэрэглэхгүй болсон, үрийн чанар муудсан зэрэг үйлдвэрлэлийн уналтад нөлөөлж байгаа хүчин зүйл олон байна. Хамгийн гол нь тухайн салбарыг зах зээлд бүрэн шилжүүлэх талаар төрийн бодлого цогцолбор болж чадаагүй байна. Урьд жилүүдэд Засгийн газраас тус салбарын уналтыг зогсоох зарим арга хэмжээ авч улсын төсөв, банкны зээлээр дэмжсэн боловч үр дүнд хүрсэнгүй, уналт нь үргэлжилж, өр авлага улам нэмэгдсэн байна. Газар тариалангийн бүтээгдэхүүний үнийг удаан хугацааны туршид хатуу тогтоон барьж байсан нь сайн ажилласан компанийн ашиг орлогод ч муугаар нөлөөлж байв.

Газар тариалангийн аж ахуйнуудыг үндсэндээ хувьцаат компанийн хэлбэрээр хувьчилсан боловч хувьцаа эзэмшигчид үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хяналт тавих, шийдвэр гаргахад оролцох байдал хангалтгүй, гүйцэтгэх захирлын гарт эрх мэдэл төвлөрсөн, түүнтэй хариуцлага тооцох механизмгүй байснаас ихээхэн өмч хөрөнгө үрэгдэж, газар тариалангийн аж ахуйн нэгжүүд ажиллах чадваргүй болжээ.

Хүнсний хангамж, баталгаат байдалд гарч буй хүндрэл бэрхшээлүүдийн зонхилох ихэнх хэсэг нь газар тариалангийн уналт эзэлж байгааг төр, засгаас анхааран энэ салбарын үйл ажиллагааг сэргээн хөгжүүлэхэд чиглэсэн олон хөтөлбөр, төсөл хэрэгжүүлж, газрын бодлогын хүрээнд эрх зүйн шинэтгэл хийж байгаа аж. Эрх зүйн орчны хувьд Газрын тухай, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг батлан мөрдүүлж, Үрийн даатгалын тухай хуулиудад өөрчлөлт оруулж, хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн бодлогын асуудал, тариалангийн тухай багц хуулийн үзэл баримтлалыг боловсруулжээ. Засгийн газраас Газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээх хөтөлбөр (1998), Өрхийн орлогыг нэмэгдүүлэх “Ногоон хувьсгал” үндэсний хөтөлбөр (1997), “Үр” дэд хөтөлбөр (2001), “Уринш-2001, 2002” төсөл, “Хадлан тэжээл-2001” төсөл зэрэг хөтөлбөр, төслүүдийг батлан хэрэгжүүлж байна.

“Газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээх хөтөлбөр”-ийг 1998 онд боловсруулан хэрэгжүүлж байгаа боловч нэг талаас төсөлд заагдсан арга хэмжээнүүдийг бүрэн хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр хүрэлцээгүй, нөгөө талаас газар тариаланг сэргээх наад захын гол нөхцөл болсон сайн чанарын үрийн хэрэгцээг хангаж чадахгүй байгаагаас Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд олигтой үр дүнгээ өгч энэ салбарын бууралтыг сааруулж чадахгүй байна.

Мэргэжлийн байгууллага, эрдэмтэд, тариаланчдаас үр тарианы үйлдвэрлэлийг сэргээх үндсэн нөхцөл нь сайн чанарын үрээр хангах, уриншийн боловсруулалтыг сайжруулах, тариаланчдыг зээлжих боломж, нөхцөлөөр хангах, техник, технологийн шинэчлэл хийх явдал гэж санал нэгтэй дүгнэж байгааг үндэслэн манай орны хүнсний гол таримал болох буудай, төмсний үр үйлдвэрлэлийг зах зээлийн тогтолцоонд



нийцүүлэн өөрчлөн зохион байгуулахаар 2001 онд “Үр” дэд хөтөлбөрийг боловсруулсан аж.[12]

Уг хөтөлбөр болон “Уринш-2001, 2002” төслүүдийн хүрээнд газар тариалан эрхлэгчдэд 5 шахам тэрбум төгрөгийн зээл олгож, “Хүнсний хангамжийг сайжруулах КР-2” төслөөс 2.4 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг хөнгөлттэй нөхцөлөөр нийлүүлсэн байна. Гэвч байгаль, цаг уурын тааламжгүй байдал сүүлийн жилүүдэд давтагдаж байгаагаас газар тариалан, ялангуяа буудайн үйлдвэрлэлт тодорхой үр дүнд хүрэхэд нэн бэрхшээлтэй болсон байна. Энэ нь Монгол орны нөхцөлд газар тариалангийн үйлдвэрлэлийн технологийн бодлогын шинэтгэл хийх шаардлагатайг харуулж байна.

Газар тариалангийн гол бүтээгдэхүүн болох буудай, төмс, хүнсний ногооны тариалалт (үндэсний үйлдвэрлэл), хангамж баталгаа дараахь байдалтай байна.

Улаан буудайн үйлдвэрлэл сүүлийн 10-н жил дараалан буурч дотоодын хэрэгцээнийхээ дөнгөж 30 хувийг хангах болжээ. Газар тариалангийн үйлдвэрлэлд уналт, хямрал улам гүнзгийрч, үр тариа, ялангуяа улаан буудайн үйлдвэрлэл 2003 онд 1990 оныхоос 5.1 дахин, 1995 оныхоос бараг 2 дахин багасчээ. Үүнээс үүдэн гурилын үйлдвэрлэлт 1993 оноос буурч, 1995 онд бага зэрэг ахиц гарсан боловч газар тариалангийн уналт үргэлжилж, 2003 онд гурилын үйлдвэрлэлт 1990 оныхоос 4.7 дахин багассан байна.

Талх, нарийн боов, чихэр, жигнэмэгийн үйлдвэрлэлт 1991 оноос буурч, 2003 оны байдлаар талхны үйлдвэрлэлт 1990 оныхоос 3.1 дахин, нарийн боов, чихэр жигнэмэгийнх 5.2 дахин багасчээ.

Эдгээр гурил, гурилан бүтээгдэхүүний түүхий эд болох буудайн үйлдвэрлэл буурах болсон гол шалтгааныг доорхи байдлаар тодорхойлжээ. Үүнд:

а/ улсын зээлээр санхүүжүүлж байсан аж ахуйнуудыг эргэлтийн хөрөнгийн нөөцгүйгээр зах зээлд шилжүүлж, улмаар зээлийн эх үүсвэрээр хангаагүйгээс тариалангийн ажлын (уринш бэлтгэх, тарих, хураах г.м.) технологийн горим алдагдсан;

б/ зах зээлийн тогтолцоонд нийцсэн үрийн аж ахуйн тогтолцоог бий болгож хэрэгжүүлээгүйгээс элит сортын үр үйлдвэрлэл бүр мөсөн зогсож чанар муутай үрээр тариалж байгаа;

в/ бордох, гербицид цацах зэрэг ургац нэмэгдүүлэх арга хэмжээг орхигдуулсан;

г/ хоцрогдож, хуучирсан техник хэрэглэж байгаа;

д/ шинээр бий болсон аж ахуйн удирдлагууд нь зах зээлийн нөхцөлд аж ахуй эрхлэх чадвар муутай байгаа зэрэг болно.

1984, 1986, 1989, 1990 онуудад ган гачиг тохиолдож байсан боловч үр тарианы улсын дундаж ургац 750-880 мянган тонноос буураагүйн гол нөхцөл нь нийт тариалсан үр тарианы талбайн 80-85 хувь (400-420 мянган га) нь чанар сайтай уриншид тариалж байсантай холбоотой. Энэ нь чанар сайтай уриншид тариалалт хийвэл цаг уурын нөхцөл таагүй жилд ч тогтвортой ургац авах боломжтой гэдгийг харуулж байна.⁹

Төмс, хүнсний ногоо тариалж хоол хүнсэнд өргөн хэрэглэснээр улаан буудайн гурилын хэрэгцээг наад зах нь 2 дахин багасгах, шувуу, загас зэрэг уламжлалт бус аж ахуйн үйлдвэрлэлээс махан бүтээгдэхүүний тодорхой хэсгийг орлуулах, цагаан будааны импортыг шар будаа, гурвалжин будаа, овъёос, вандуй, шошны хэрэглээгээр үлэмж бууруулах, мөн элсэн чихэр буюу цэвэр сахарозыг фруктоз (чацаргана, бөөрөлзгөнө, үхрийн нүд, тошлой, нохойн хошуу г.м.), зөгийн бал, тарвасаар баяжуулж хэрэглээний бүтцэд үндсэн эргэлт хийх, айл өрхүүд зардлаа хэмнэснээр ашиг орлогоо нэмэгдүүлэх бүрэн боломжтой юм.

1996 оны хэрэглээг 1989 оныхтой харьцуулахад төмс ба хүнсний ногоо 2,5 дахин, жимс жимсгэнэ 40 дахин буурч, хэрэглэвэл зохих хэмжээнээс төмс, хүнсний ногоо 4,5-11,8, жимс, жимсгэнэ 121,7 дахин бага байв.

⁹ “Уринш-2001” төсөл

Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлтийн 2001-2002 оны дунжийг жилийн хэрэгцээтэй харьцуулахад жилд дунджаар 58.0 мян. тонн төмс тариалж байгаа нь жилийн хэрэгцээний 64.4%-ийг, 44.5 мян. тонн хүнсний ногоо тариалж байгаа нь жилийн хэрэгцээний 30%-ийг л ердөө хангаж байна. (Хүснэгт 2.)

Дээрх төмс, хүнсний ногооны хомсдол, хүн амын ажилгүйдэл, ядуурлыг багасгах, өрхийн амьжиргааг дээшлүүлэх зорилгоор 1997 онд Засгийн газраас Өрхийн орлогыг нэмэгдүүлэх “Ногоон хувьсгал” үндэсний хөтөлбөрийг батлан, хэрэгжүүлж байна.

2003 онд 1996 онтой харьцуулахад төмсний тариалалт 1.7 дахин, хүнсний ногооных 2.5 дахин өсч, сүүлийн 5 жилд төмс, хүнсний ногооны хэрэглээнд бага боловч ахиц гарч 2003 онд 1996 онтой харьцуулахад төмсийг 2 дахин, хүнсний ногоог 1.5 дахин их хэрэглэх болсон хэдий ч жишсэн дундаж хүнд хэрэглэвэл зохих төмсний жилийн хэрэгцээний 50%-ийг, хүнсний ногооны ердөө 16.4%-ийг л дөнгөж хэрэглэж байна.

1991 онд Улаанбаатар хотын хэмжээнд 800 айл өрх 117 га-д төмс, хүнсний ногоо тариалж байсан бол 1996 онд 21,0 мянган өрх 498,2 га-д хүнсний ногоо, 1013 га-д төмс тариалж, тариалан эрхлэх айл өрхийн тоо энэ хугацаанд 26 дахин нэмэгджээ.[9]

Газар хувьчлал хүнсний хараат бус байдалд нөлөөлөх нь: Газар тариалангийн аж ахуйн нэгжүүдийн төрийн өмчид ногдох хэсгийн хувьчлалыг удаашруулж, үнэт цаасны хоёр дахь зах зээл нээх хугацааг сунжруулснаас болж хувьцаа төвлөрч өмч эзэнтэй болох үйл явц зогсонги байдалд орж, улмаар өртөг зардлыг багасгах, өмч хөрөнгийг үр дүнтэй ашиглахад сөргөөр нөлөөлөв. Аж ахуй эрхлэгчид зах зээлийн шинэ нөхцөлд үр ашигтай ажиллаж импорттой өрсөлдөхийн тулд бизнес, санхүүгийн менежмент, маркетингийн мэдлэг чадварт суралцах талаар идэвхтэй ажилласангүй.


Дампуурлын байдалд орсон аж ахуйнуудыг босгох гэж улсын төсөв, банкны ихээхэн хэмжээний хөрөнгө, зээл зарцуулагдсан ч нэгэнт зах зээлийн суурь харилцаа тогтолцоо бүрдээгүй учир энэ нь цогцолбор болж чадаагүй, авсан арга хэмжээ нь мэдэгдэхүйц үр дүнд хүргэсэнгүй. Шинэтгэл хийгдээгүйгээс газрын ашиглалт нь муу, түүнд зах зээлийн харилцаа хөгжиж чадаагүй байна. [2]

Хортон шавьж устгах хорны Ази-Номхон далайн сүлжээ “Хүнсний хараат бус байдлын төлөөх Хүмүүсийн цуваа-2004”-аас гаргасан “Бидний газар болон хүнсний эрхийг баталгаажуулах нь” тулгуур бичигтээ: “Газар бол хүнсний үйлдвэрлэлийн гол хүчин зүйлийн нэг юм. Нийгмийн хамгийн гадуурхагдсан бүлгийн хүмүүсийн өлсгөлөн ядуурлын үргэлжилсэн цикл нь жинхэнэ хүмүүсийн төлөө гэсэн газрын шинэчлэл дутагдсанаас үүдэж байна. Газартай байх боломжоос гадна, үр, ус зэрэг бусад эх сурвалжаас хүртэх эрх нь Хүнсний хараат бус байдалд амин чухал юм.” хэмээн хүнсний хараат бус байдал дахь газрын эрхийг баталгаажуулахын чухлыг заасан байдаг.

Манай оронд 1992 онд батлагдсан анхны ардчилсан үндсэн хуулиар газар хувийн өмчид байж болохыг баталгаажуулснаар газар өмчлөлийн асуудал яригдах болсон. Харин газар өмчлөл тодорхой шалтгааны улмаас хойшлогдсоор 2002 онд “Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай” хуулийг батлан гаргасан нь манай улсын хувьд анхдагч, түүхэн ач холбогдолтойн дээр газрын шинэтгэлийн эрх зүйн орчныг бүрдүүлсэн алхам болсон.

Гэвч эрх баригчид газар өмчлөлийн хуулиудыг гаргахдаа хуулийн төслийг ард түмэнд танилцуулж санал, хүсэлтийг нь шүүн тусгахын оронд газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн удирдах цөөхөн хүмүүс, хот суурингийн төрийн удирдах ажилтнуудаас санал аван яаравчлан гаргасан байна. Ийм байдлаар батлагдан гарсан хууль тогтоомжууд нь:

- Монгол улсын үндсэн хуулийн шударга ёс, тэгш байдлын зарчмаас ухарсан,
- иргэнээ оршин суугаа нутаг дэвсгэр, эрхэлж байсан ажил мэргэжил, гэрлэсэн хугацаагаар нь ялгаварласан төдийгүй, газар тариалангийн газрыг өмчлөх эрх хөрөнгөтэй хүмүүст нээлттэй болсон,
- газар өмчлөлийн асуудлыг ганц засаг дарга үзэмжээрээ шийдэх эрхтэй болсон,



- үндсэн хууль болон иргэний хуулиар баталгаажсан иргэний хувийн өмчид шүүхийн шийдвэргүйгээр халдах боломж үүсгэсэн,
- төрийн албан хаагчид хахууль авах үүд нээсэн, газар өмчлөлийн асуудалд тухайн орон нутгийн иргэд, төрийн бус байгууллагууд хяналт тавих боломжийг орхигдуулснаараа гарсан цагаасаа иргэдийн нилээд хэсгийн хууль ёсны болон жам ёсны эрх ашгийг хөндөн тэдний бүхмдлыг төрүүлсэн хууль болжээ.

Газар тариалангийн бүс нутагт болох сэлэнгэ, төв аймагт нэг ч иргэн хүнсний ногооны газар өмчилж аваагүй байна. Улсын хэмжээнд газар тариалан эрхэлж байгаа иргэд 76546 байгаа боловч үүнээс дөнгөж 31 иргэн хүнсний ногооны 12 га газар өмчилж авсан (Архангай) байна.

Нийслэлийн хэмжээнд иргэдээс гаргаж байгаа гомдол шаардлагын дийлэнхийг газрын маргааны талаарх асуудал эзэлж байна. Үүнд нийслэлийн ИТХ, ЗД, түүний тамгын газрын зүгээс анхаарал тавьж байгаа гэх боловч засагдаж буй нь иргэнд мэдэгдэхгүй байна. Тэр ч байтугай засгийн газар солигдож байгаатай зэрэгцэн газрын алив маргаан тэмцэл хотын төв төдийгүй захын гэр хорооллын орчмоор ч дэгдэж түшмэлүүд албан тушаалаа ашиглан газрын бизнес хийж жирийн иргэдийг хохироосоор байна.

Нэгдэлд нийгэмчилсэн малыг малчдад буцаан олгосноор малчдын эдийн засгийн чөлөөт байдал нэмэгдэж нэлээдийнх нь аж ахуй бэхжин, төрөөс хараат бус байх боломж эрс өссөн. Гэтэл өөрийн буюу эцэг эхийнхээ нэгдэлд нийгэмчилсэн малаас цөөнийг ч атугаа буцааж авах боломж уугуул нутгаасаа олон жилийн өмнө гарсан тариаланчдад огт олдоогүй.

Тариаланчид гэдэг нь атрыг эзэмших хоёр удаагийн аянаар монголын өнцөг булан бүрээс нам, эвлэлийн илгээлт өвөрлөн ирсэн хүмүүс, тэдний үр хүүхдүүд бөгөөд тэд өмч хувьчлалын өгөөжөөс гадуурхагдан хоцроход хүрч байгаа аж. Ингээд зогсохгүй эдийн засгийн эргэлтэнд оруулж амьжиргаагаа дээшлүүлэх газаргүй учраас ажилгүйдэл, ядууралд нэрвэгдэж байгаа ажээ.

1990 оны байдлаар тус улсад 53 сангийн аж ахуй, 20 тэжээлийн аж ахуй газар тариалан эрхэлж байсан ба эдгээр аж ахуйнуудын төв нь сумын төв болж байсан. Дунджаар нэг аж ахуйд 482 хүн ажиллаж байсны 105 нь механикжуулагчид байсан. Чухам эдгээр хүмүүс болон тэдний гэр бүлийн асуудал монгол улсын хүнсний хангамж, баталгаатай амин чухал холбоотой юм.

Монголын төр засаг өөрийн болон олон улсын байгууллагын зээл тусламжийн нилээд хувийг хөдөө аж ахуйд чиглүүлж хүнс, хөдөө аж ахуйн нилээд олон хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэхэд олон миллиард төгрөг зарцуулж байгаа ч үр дүн нь маш бага, жирийн тариаланчдад огт тусахгүй байна. Өөрөөр хэлбэл 2003 оны байдлаар нэг хүнд оногдох зээл тусламж 85 ам.долларт хүрч байгаа ч энгийн тариаланчид өгөөжгүй байна. “Үр”, “Уринш” зэрэг хөтөлбөр, төслүүдэд зарцуулсан хөрөнгө яам, агентлаг, аймгийн ЗДТГ, танилтай газрын эзэн компаниудын эздийн гар дээр очихоос биш энгийн тариаланч, жижиг үйлдвэрлэгчид хүртэхгүй байна.

Монгол улсын хүнсний хангамж, баталгаа нь газар тариаланг фермерийн хэлбэрээр эрхлэн чанар сайтай үндэсний гурил, төмс, хүнсний ногоогоор иргэдийг хангаж, улмаар тариаланчдын аж амьдрал дээшилснээр хангагдах аж.[51(2)]

■ **Байгалийн баялаг** – Манай улсад мал аж ахуй, газар тариалангаас гадна хүнсний зориулалтаар ашиглах байгалийн баялгийн их нөөц байдаг бөгөөд үүнийг монголчууд эрт дээр үеэс арвиг хямгатай хэрэглэж ирсэн уламжлалтай. Монгол орны байгалийн гаралтай хүнсний баялаг нь жинхэнэ экологийн цэвэр бүтээгдэхүүний эх үүсвэр юм. Монгол орны байгалийн өгөөж арвин, түүний нэр төрөл олон янз, хэрэглээ зориулалтаараа ч ялгаатай бөгөөд хөнгөн үйлдвэрийн, хүнсний, эмийн түүхий эдээр баялаг билээ. Байгалийн өгөөж нь хүний хүч хөдөлмөр оролцохгүйгээр өөрөө нөхөн төлжиж байдаг асар их нөөц юм.

Хүн төрөлхтөн химийн бордоогоор бохирдсон хүнсний зүйл хэрэглэхээс улам бүр зайлсхийх болсноор байгалийн цэвэр гаралтай бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ ихэсч, түүний үнэ өртөг нэмэгдэх хандлагатай болсоор байна. Манай орон ургамал,

амьтны гаралтай экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэж, улмаар экспортлох бүрэн боломжтой юм.

Жимс, жимсгэнэ. Барагцаалсан тооцоогоор манай улсад жил бүр байгалийн 1000 гаруй тн төрөл бүрийн жимс, жимсгэнэ ашиглах нөөц байгаа бөгөөд түүний бараг тал хувь нь чацаргана жимс юм. Жимс, жимсгэнэ нь төрөл бүрийн аминдэм, биологийн идэвхит бодисоор нэн баялаг учраас таримал жимсээр хомс манай орны хүн амын хоол тэжээлд чухал үүрэгтэй билээ. Харамсалтай нь монгол орны жимс, жимсгэний тархац, нөөц бүрэн тогтоогдоогүй, тэр ч бүү хэл зарим зүйлийн бүтэц, найрлага, технологийн чанар, хоол тэжээлийн ач холбогдол нь шинжлэх ухааны өнөөгийн түвшинд нарийн тодорхой тайлбарлагдаагүй хэвээр байна. Гэтэл сүүлийн жилүүдэд жимс, жимсгэнийг боловсорч гүйцээгүй байхад мод, бут сөөгийг нь гэмтээн түүж, эрүүл ахуйн горим зөрчсөн нөхцөлд гадаа ил задгай худалдаалж, эсвэл архи, дарсны үйлдвэрлэлд зонхилон ашиглаж байгаа нь экологийн цэвэр бүтээгдэхүүн хэрэглэх асуудал амин дэмийн байнгын дутагдалтай манай орны хувьд ямар ч төрийн бодлого зохицуулалтгүйтэй холбоотой юм.

Жимс, жимсгэнэ, самар, мөөг ургадаг газрын нэг болох ойн сангийн 40-50% нь сүүлийн 30 жилд хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс шалтгаалж ямар нэгэн хомсдол доройтолд өртсөн байна. Сүүлийн 10-аад жилд уул, уурхайн малталтаар 30 сая гаруй шоо метр уулын чулуулгийг газрын хэвлийгээс гаргаж, жил бүр уул уурхайн ашиглалтаар 270-560 мянган шоо метр үржил шимт хөрсийг хуулсан байна. [35(3)]

Хүнсний зориулалттай ургамлууд. Манай орны хангай, тал хээр, говийн нутгуудаар халиар, хүнхээл, гогод, гоньд, мэхээр, чихэр өвс, суль, цульхир, таана, хүмэл, гишүүнэ, халгай, шар, цагаан төмс гэх мэт хүнс тэжээлийн ач холбогдолтой ургамлууд элбэг байдаг бөгөөд эдгээр нь цэвэр ариун экологийн нөхцөлд ургасан, биологийн идэвхит байгалийн нэгдлийн эх үүсвэр юм. Ийм ч учраас монголчууд эрт дээр үеэс байгалийн ургамлуудыг ашиглаж, аминдэм, биологийн идэвхит бусад бодисын дутагдлыг нөхөх, бие махбодийн үйл ажиллагааг сайжруулах, эмийн эмчилгээнд тус нэмэр болгох зорилгоор хоол хүнсэндээ өргөн ашиглаж ирсэн уламжлалтай билээ.

Суль, цульхир нь Өмнөговь, Говь-Алтай, Завхан аймгуудын нутагт орших өргөн говиуд, Их нуурын хотгор зэрэг газруудад тархан ургадаг, нэг ёсондоо зэрлэг ургадаг үр тариа учраас үнэт хүнс юм. Эдгээр нь бидний өнөө, маргаашийн хүнсний хэрэгцээнд нэмэр, ашигтай төдийгүй, онцгой нөхцөлд хэрэглэх стратегийн хүнс болно. Суль, цульхир нь 21-26 хувийн уураг агуулах бөгөөд үл орлогдох хэд хэдэн амин хүчил агуулсан, уураг, өөх тосны хувьд улаан буудай, хөх тариа, арвайнаас хол давуу болохыг манай эрдэмтэд судлан тогтоожээ.

Манайд зарим ургамлын ач холбогдлыг төдийлөн анзаардаггүй тал байдгийг өвөлжөө, бууц, хаа сайгүй ургадаг халгай, гишүүнээр жишээлж болох билээ.

Мөөг нь уураг, өөх тос, нүүрс ус, усанд болон тосонд уусдаг аминдэм, тосны ханаагүй хүчил, фосфор, кальци, магни, зэс, иод зэрэг эрдэс бодис агуулса байгалийн бүтээгдэхүүн юм. Манай оронд хүнсний зориулалтаар ашиглах боломжтой ойн болон тал хээрийн мөөг элбэг байдаг. Ойн мөөгний нөөц маш их боловч энэ их нөөцийг ашиглах асуудал өнөө хүртэл хэвшээгүй байгаа нь анхаарвал зохих асуудал болно.

Загас. Монгол орны гол мөрөн, нууруудад 70 гаруй зүйл загас байдаг, тэдгээрийн ихэнх нь агнуурын ач холбогдолтой, загас, агнуурыг жилд дунджаар 180 хоног явуулж, энэ хугацаанд улсын хэмжээгээр 600-аад тн загас олборлох боломжтойг Биологийн хүрээлэнгийн эрдэмтэд тооцоолжээ. Манай орон 1950-аад оны үед жилд дунджаар 630 тн загас олборлож, гадаад, дотоодын хэрэгцээнд нийлүүлж байв.

Загас нь төгс уураг, олон молекулт ханаагүй тосны хүчлийн агууламж өндөртэй, бие махбодод зайлшгүй шаардлагатай А амин дэм, В-ийн төрлийн амин дэмүүд, эрдэс бодисууд, нэн ялангуяа фосфор, иод зэргээр үлэмж баялаг хүнсний үнэт түүхий эд юм.

Өндөр хөгжилтэй орнуудын хүн амын хүнсний хэрэглээнд загас чухал байр суурь эзэлдэг. Дэлхийн зах зээлд цэнгэг нуур, голын загас нь үнэтэй, ховор бүтээгдэхүүний нэг байдаг.

Манай улсад хүн амын загас, загасан бүтээгдэхүүний хэрэгцээний дөнгөж 10-аад хувь нь хангагддаг бөгөөд үүний гол эх үүсвэр нь импортын загасан нөөш юм. Харин улсын хэмжээгээр жилд 300-400 тн загас олборлож, бараа солилцооны нөхцөлтэй, хямд үнээр арилжаалж байгаа билээ. Үүний гол шалтгаан нь загас олборлох, боловсруулах, хадгалах, тээвэрлэн худалдаалах технологи нэвтрээгүй, загасны зах зээлийн менежмент хөгжөөгүйтэй холбоотой аж. Үүнээс үзэхэд манай улс агнуурын загасны зохих нөөцтэй бөгөөд түүнийг боловсруулж, бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологийг эзэмшин, жижиг үйлдвэрлэл зохион байгуулж, хүн амыг зохистой хоол хүнсээр хангах шаардлагатай байна.

Рашаан. Манай орны 400 гаруй рашаанаас 260 орчмыг судалсны дотор савлахад тохиромжтой, нүүрс хүчлийн хийн агууламж ихтэй рашаан 60 орчим байдаг нь эрдэмтдийн судалгаагаар тогтоогджээ. Гэтэл өнөөгийн байдлаар ОХУ болон бусад орноос рашаан импортлох явдал үргэлжилсээр байна. Байгалийн рашааныг унаган төрхөөр нь савлаж зах зээлд нийлүүлэх технологи, менежментийн асуудлыг оновчтой шийдвэрлэснээр зөвхөн ундааны зүйлийн хэрэгцээг хангах төдийгүй, бичил элементээр баялаг, чиглэсэн үйлчлэл бүхий бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх бололцоо байна.

■ **Хүнсний аж үйлдвэр** – Монгол улсын Хүнсний аж үйлдвэрийн гал голомт нь 1924 оноос өмнөх гар ажиллагаатай, жижиг үйлдвэрүүд бөгөөд тэдгээр нь өргөжин хөгжсөөр 1930 оны үед бие даасан салбар бий болсон юм.

1960 оноос хойш хүнсний аж үйлдвэр эрчимтэй хөгжиж дотоодын нийт бүтээгдэхүүний 29.6%-ийг үйлдвэрлэдэг, хүн амын хэрэгцээг хүнсний гол бүтээгдэхүүнээр хангадаг хүчирхэг салбар болжээ.

1991 оны эхнээс учирсан эдийн засгийн хямрал нь Хүнсний аж үйлдвэрт туйлийн хүнд тусаж, хэвийн ажиллагаа нь алдагдсанаар хүнсний хангамж ноцтой хүндэрсэн билээ. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт 1990 оны түвшингээс эрс буурсан боловч өнөөгийн хүнсний аж үйлдвэрийн ажиллагаанд хэд хэдэн дэвшилттэй эхлэл ажиглагдаж байна. Салбарын бүтэц сүүлийн 10 жилд эрс өөрчлөгдөж, 50 хүртэл ажиллагсадтай жижиг, дунд үйлдвэрүүд төв, хөдөөд олноор бий болж, нийт бүтээгдэхүүний 80 гаруй хувийг үйлдвэрлэх болов.

2002 оны байдлаар манай улсад хувийн болон төрийн өмчийн 14331 аж ахуйн нэгж хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаагаас хүнсний үйлдвэр 1524, нийтийн хоолны газар 3039, хүнсний дэлгүүр, мухлаг 6859, хүнсний зах 2256, хүнсний агуулах, зоорь 653 байна. Эдгээрээс мах, махан бүтээгдэхүүн боловсруулах 90, гурилын 700, талх, чихэр, нарийн боовны 542, архи, пиво, спиртийн 200-аад, ундааны 300 гаруй гол төлөв жижиг, дунд хүчин чадалтай үйлдвэрүүд ажиллаж байна. Өөрөөр хэлбэл хүн амыг хүнсний үндсэн нэрийн бүтээгдэхүүнээр хангахад үйлдвэрлэлийн хүчин чадал, бааз нэгэнт бүрдсэн гэж үзэж болох байна.

Хүнсний аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт 1999 оноос эхлэн дээшлэх хандлага бий болж байна. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дээрх хугацаагаар авч үзвэл 2003 онд үйлдвэрийн аргаар бэлтгэсэн мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл 79.7%, нарийн боов, талх 4.5-22%, хиам 9.8%-аар тус тус өссөн байна. Архины үйлдвэрлэл 2001 онд 1999 оныхоос 56.5%, спирт 25.6%-аар тус тус нэмэгдсэн нь хүнсний бусад бүтээгдэхүүний өсөлтөөс давамгайлж байна.

Гэвч түүхий эдийн хангамж, эдйн засгийн бэрхшээл, төрийн бодлого, зохицуулалт төгөлдөржөөгүй зэрэг олон шалтгааны улмаас нэгэнт суурилагдсан үйлдвэрлэлийн хүчин чадлын ашиглалт тун хангалтгүй байгаа юм. Үүний нэг жишээ бол үр тарианы дутагдалтайгаас хүч чадлынхаа өчүүхэн хэсгийг ашиглан, зарим нь зогсоход хүрсэн гурилын үйлдвэрүүд юм. Махны хэрэглээ өсч байгаа ч нийт хэрэглэсэн мах, махан бүтээгдэхүүний дөнгөж 10 гаруйхан хувийг үйлдвэрлэлийн аргаар боловсруулж байна. Үйлдвэрийн аргаар экспортын мах, нийт хэрэглээний хиам, махан

бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, харин малыг хээр гадаа нядалж, маханд анхан шатны боловсруулалт хийлгүйгээр зах дээр худалдаалж байна. Мөн сүү боловсруулах үйлдвэрийн салбарт ч ийм байдал хэвээр байгаа билээ. Хүнсний бүтээгдэхүүний хэрэглээ, түүхий эд, үйлдвэрлэлийг өөр хооронд нь ойртуулж, хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан нөхцөлд бэлтгэсэн баталгаатай хүнсний бүтээгдэхүүнээр хангах стратегийн тодорхой зорилтуудыг Монгол улсын Засгийн газрын “Хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол тэжээл”, “Цагаан хувьсгал”, “Ногоон хувьсгал” үндэсний хөтөлбөрүүд, “Махны экспорт” зэрэг төслүүдэд тодорхойлж, тэдгээрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна. Гэвч хүнсний хэрэглээний чиг хандлага, эрүүл ахуйн шаардлага нь аль болох байгалийн унаган төрхт бүтээгдэхүүнд чиглэгдэж байгаа өнөө үед хүнсний үйлдвэрлэлийн технологийн шинэчлэлд гол анхаарал төвлөрөх нь чухал байна.

■ **Хүнс импортлолт** –Манай улсад дотоодын үйлдвэрлэл буурахын хирээр нийт хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээний дотор импортын бүтээгдэхүүний эзлэх хувийн жин шууд хамааралтайгаар өсөж байна.

Манай улс нэгэнтээ хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний жилийн хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээрээ бүрэн хангаж чадахгүйгээс хүнсний хомсдол жил бүр гардаг тул уг хомсдлыг импортоор арилжааны болон тусламжын шугамаар нөхөж байна.

УИХ, Засгийн газраас үндэсний үйлдвэрлэлийг сайжруулах талаар эрх зүйн олон баримт бичиг баталж, арга хэмжээ авч байгаа боловч үнэн хэрэгтээ хүнсний хангамжийн хараат байдал бодитой оршиж байна. Монгол улс хүнсний зах зээлд нийлүүлж байгаа махнаас бусад хүнсний гол нэрийн тухайлбал, үр тариа, төмс, хүнсний ногоо, цөцгийн ба ургамлын тос зэрэг бүтээгдэхүүний 70-100%-ийг импортоор оруулж хэрэгцээгээ хангаж байна. Бүрэн бус мэдээгээр 1996-2003 онд жил бүр 17.3-46.5 мян. тн улаанбуудай импортолсон байна. ҮСГ-ын мэдээгээр 2003 онд 55.1 тн цөцгийн тос импортолж, хүн амын хүнсний хэрэгцээнд нийлүүлж буй гурилын 60%, төмсний 33.8%, согтууруулах ундааны 55.1%, шар айрагны 83.9%-ийг тус тус импортоор хангадаг болжээ.[37] Ялангуяа буудай, гурилын хувьд ОХУ, БНХАУ, Казакстанаас манай орон шууд хараат байдалд орсон байна. Ялангуяа нийт импортлогдож буй таваарын улаан буудайн 80%-ийг Казакстан улсаас оруулж байна. Монгол оронд үйлдвэрлэдэггүй элсэн чихэр, ургамлын тос, цагаан, шар будааны хэрэгцээ бүхэлдээ, жимс, жимсгэний зонхилох хэсэг импортоор хангагдаж байна.

Монголд үйлдвэрлэх боломжгүй, зайлшгүй шаардлагатай бүтээгдэхүүнийг импортлохоос өөр арга үгүй боловч 1999 онд л гэхэд хүнсний 31 нэрийн бүтээгдэхүүн импортлогдсоны дотор сүү, цөцгийн тос, төмс, хүнсний ногоо, гурил, талх, талхан бүтээгдэхүүн, рашаан, ус, архи, согтууруулах ундаа, иоджуулсан давс зэрэг дотооддоо үйлдвэрлэлээр бүрэн хангаж болох бүтээгдэхүүнүүд байна.

Мөн хэрэглээний 25 нэрийн барааны 18 төрөл нь гаднаас бүрэн хамааралтай, 3 бүтээгдэхүүний хувьд хагас хамааралтай, зөвхөн хоёрхон бүтээгдэхүүнээр бага хамааралтай гэсэн судалгаа ч байдаг.[51(3)]

Импортоор эдгээр бүтээгдэхүүнийг оруулж ирж байгаа наймаачдыг буруутгах аргагүй ч ийм хэмжээний бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэж, борлуулах боломжийг алдсан нь үйлдвэрлэгчдийн хувьд дүгнэлт, судалгаа хийвэл зохих асуудлын нэг юм.

Сүүлийн жилүүдэд хүнсний бүтээгдэхүүний импортын хэмжээ, импортлогч орнуудын тоо өссөөр байгаа нь зах зээлийн багтаамж багатай манай орны хувьд хэдийгээр хүн амын хүнсний хэрэглээ хангамж сайжирч, өргөн сонголт хийх боломж бий болж байгаа боловч бэлэнчилж амарчлах сэтгэхүй улам нэмэгдсээр уламжлалт хоол хүнсний төрөл, бүтэц алдагдаж болзошгүйг үгүйсгэх аргагүй юм.

Импортын хүнсний бүтээгдэхүүн нь үндсэн 2 замаар манай улсад орж ирж байна. Нэгд, аж ахуйн нэгж, байгууллагуудын гадаад худалдаа, арилжаагаар, хоёрт, ОУ-ын байгууллага болон бусад улсын Засгийн газрын тусламжаар орж ирж байна.

Монгол улсад хүнсний хомсдол бодитойгоор оршиж байгаа тухай 1996 онд Ромын чуулга уулзалт дээр Монгол улсы Ерөнхий сайд албан ёсоор мэдэгдэж байсан

бөгөөд тэр үеэс хойш хандивлагч орнуудаас хүнсний тусламжийн шугамаар гурил, будаа, цөцгийн тос жил бүр тодорхой хэмжээгээр нийлүүлэгдэх болжээ.

ОУ-ын тусламжийн байгууллагууд болон бусад улс орны Засгийн газраас үзүүлж буй тусламж нь ихэвчлэн хүн амд хүнсний зүйл, түүний түүхий эдийг шууд бэлнээр хангахад зориулагдаж, харин хүнсний үйлдвэрлэл, газар тариалангийн үйл ажиллагаанд техник, технологийн тусламж үзүүлэхгүй байгаагийн учир шалтгаан нь ОУ-ын хамтын ажиллагааны гэрээгээр ОУ-ын тусламжинд техник, технологийг огт оруулахгүй байхаар тохиролцсон байдаг аж. (Н.Батсуурь)

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



2.3. Хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдал (Food Safety and Hygiene)

Хүнсний аюулгүй байдал нь Монгол улсын үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолын баталгаа, хүний амьдрах эрхийг хангах үндсэн арга зам, цаашдын хөгжлийн тулгуур багана болох нь тодорхой юм.

Хүмүүс хэрэглэж буй хүнсээ аюулгүй, хэрэглэхэд зохимжтой байхыг хүсэн хүлээх бүрэн эрхтэй. Хоол хүнсээр дамжих өвчин эмгэг нь хүнийг наанадаж тааламжгүй байдал, цаашилбал үхэлд ч хүргэдэг. Түүгээр ч зогсохгүй өөр бусад үр дагавар авчирдаг. Хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлт нь худалдаа, аялал жуулчлалд саад тотгор учруулан, ашиг орлогоо алдах, ажилгүйдэл нэмэгдэх зэрэг олон янзын сөрөг үзэгдэлд хүргэдэг. Хүнс гэмтэж муудсанаар эдийн засгийн үргүй зардалд хүргэж, худалдаа наймааны болон хэрэглэгчдийн итгэл үнэмшилд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй байдаг.

Эрүүл ахуйн үр дүнтэй хяналт нь хүнс гэмтэж муудах, хоолноос хордох, улмаар хоол хүнсээр дамжих өвчин эмгэгийн хүний эрүүл мэнд, эдийн засагт учруулах муу үр дагавраас урьдчилан сэргийлэхэд чухал шаардлагатай юм. Мал аж ахуй эрхлэгчээс тариаланч, үйлдвэрлэгч, боловсруулагч, хүнс бэлтгэгч, хэрэглэгч хүртэл хүн бүр хүнсний аюулгүй бөгөөд хэрэглэхэд тохиромжтой байдлыг хангахад хариуцлага хүлээнэ.[53, 54]

Үүнээс үзэхэд хүнсний эрүүл ахуйг хангаснаар хэрэглэхэд тохиромжтой, аюулгүй хүнсийг үйлдвэрлэн түгээж, улмаар хүн амд хэрэглэх боломж бүрдэнэ гэж ойлгож байна. Хүнсний хууль эрх зүйн хорооны тодорхойлсноор:

ХҮНСНИЙ ЭРҮҮЛ АХУЙ гэдэг нь хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний аюулгүй, тохиромжтой байдлыг хангахад шаардлагатай бүхий л нөхцөл, арга хэмжээ юм.

ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ гэдэг нь хоол, хүнсийг зориулалтын дагуу бэлтгэж, хэрэглэхэд хүний эрүүл мэндэд хор хөнөөл учрахгүй байх баталгааг хэлнэ.


ХҮНСНИЙ ТОХИРОМЖТОЙ БАЙДАЛ гэдэг нь зориулалтын дагуу хэрэглэхэд тухайн хүнс хүний хэрэглээнд тохирно гэсэн баталгаа юм.

Хүнсний аюулгүй байдал алдагдсанаар хоол хүнсээр дамжиж хүний биед өвчин эмгэг үүсгэж, хүний эрүүл мэндэд хор хөнөөл учруулдаг зүйлсийг хүнсний аюул гэсэн ойлголтонд багтааж байна. Тэгвэл мөн хорооны тодорхойлсноор:

ХҮНСНИЙ АЮУЛ гэж хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй биологи, физик, химийн хүчин зүйлс хүнсэнд агуулагдах, эсвэл тийм нөхцөл байдлыг хэлнэ.

Хүнсний аюулгүй байдалтай холбоотой үүсдэг өвчин эмгэгийг ерөнхийд нь хоол хүнсээр дамжих өвчин эмгэг гэж нэрлэдэг бөгөөд ДХХААБ, Хүнсний хууль эрх зүйн хороо (САС)-ын тодорхойлсноор хүн амын хүнсний аюулгүй байдалд гарах эрсдлүүдэд халдвар, хордлого, бие махбодийн хямрал, харшил, ямар нэг эрхтнийг барьж өвчлүүлэх зэрэг болно.

Дээрх өвчин эмгэгээс хүний эрүүл мэндэд хамгийн их хор уршиг үзүүлдэг эрсдэл бол хоолны хордлого бөгөөд үүнийг үүсч буй хугацаагаар нь хурц ба архаг гэж хоёр ангилдаг. Хурц хордлого нь хоол хүнсийг хэрэглэснээс хойш дунджаар 24 -72 цагийн дотор илэрдэг бөгөөд ихэвчлэн нянгаар үүсгэгдсэн хоолны хордлого хурц хэлбэрээр тохиолддог. Зарим үед гадны химийн хортой бодис их хэмжээгээр санамсаргүйгээр орсон тохиолдолд хурц хэлбэрийн хордлогод ордог. Жишээлбэл, хиамны найрлагад маш бага тунгаар ордог нитритийн давсыг хоолны давстай андуурах тохиолдол манайд багагүй тохиолдож байсан. Үүнд манайд 1997 онд гарсан нэгэн хордлогын тохиолдлыг дурьдая.



Тохиолдол: Ахуйн нөхцөлд хэрэглэсэн нитритын давсны 3 удаагийн хордлого /СХД, траншинд амьдрагч, БЗД/ гарч 10 хүн хордож, 4 хүн нас барсан байна.

Хурц хордлогууд нь гол төлөв хүнд хэлбэрээр илэрч, өвчний явц маш богинохон байдаг бөгөөд хорыг хурдан хугацаанд сааруулж чадвал амархан идгэдэг боловч хэрэв шуурхай арга хэмжээ аваагүй тохиолдолд үхэлд хүргэдэг аюултай байдаг. нянгийн гаралтай хоолны хордлого нь дээрх онцлогоос гадна нэг дор олон хүнийг зэрэг өвчлүүлэх, цааш хоёрдогч, гуравдагч этгээдэд халдвар дамжуулж тархаах магадлал өндөр байдаг.

Архаг хордлогод ихэвчлэн гадны химийн бодис(ксенобиотик)-ын удаан хугацааны маш бага тунгаар хүний биед орж үйлчилсний улмаас хэдэн арван жилийн дараа ч илэрч болох ужиг явцтай, ихэвчлэн ямар нэг эрхтэнг гэмтээх буюу эрхтэн тогтолцооны үйл ажиллагаанд нөлөөлж өвчний явц хүндрэх байдлаар илрэх, аль эсвэл бүр хорт хавдар үүсгэх, үр хөврөл, удамд нөлөөлж болох аюултай байдаг. Ийм архаг хордлого үүсгэдэг хоруудад хүнд металл, пестицид, химийн бордоо, хүнсний нэмэлтүүд, мал эмнэлгийн эмийн бодисууд, цацраг идэвхит бодисууд болон бусад химийн хортой бодисууд, хөгц мөөгөнцөрийн хорууд ордог. Архаг хордлогын нэг онцлог нь тухайн хороор бохирдсон хоол хүнсийг удаан хугацаанд хэрэглэхэд нилээд хэсэг хугацааны дараа хүний биед эрхтэн тогтолцооны эмгэг байдлаар тохиолддог тул тэр бүр шалтгааныг олж тогтооход хүндрэлтэй байдаг ба аль эсвэл өөр өвчний шалтгаантай андуурагдах тохиолдол ч их байдаг.

Дээрх хүнсний химийн хортой бодисууд нь мөн хүний биеийн мэдрэмтгий чанарыг ихэсгэж, харшил өвчин үүсгэдэг.

Монгол улсын Ерөнхийлөгч “Хүнсний аюулгүй байдал” үндэсний зөвлөлдөх уулзалтад оролцогчдод явуулсан илгээлтдээ:

“Хүнсний аюулгүй байдлын эрх зүйн орчин бүрэлдэж, хүнсний чанар, аюулгүй байдалд хяналт тавин, шинжилгээ хийх байгууллагууд ажиллаж байгаа боловч чанар, эрүүл ахуйн шаардлага хангахгүй хүнсний улмаас хэрэглэгчдийн эрх ашиг, эрүүл мэнд хохирсоор байна.

Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид, борлуулагчдын хууль эрх зүйн мэдлэг, хүнсний бүтээгдэхүүнд хандах болон түүгээр үйлчлэх соёлын түвшинг дээшлүүлэх нь хүнсний чанар, аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой юм. Хэрэглэгчид ч гэсэн хүнсний чанар, эрүүл ахуйд тавих шаардлагаа сулруулж болохгүй.” гэжээ.

2.3.1. ХҮНСНИЙ ЭРҮҮЛ АХУЙ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААР ТӨРӨӨС АВЧ БУЙ АРГА ХЭМЖЭЭ

▪ **Төрийн бөдлого, хууль эрх зүйн орчин** - Төр засгаас хүнсний аюулгүй байдалд онцгой анхаарч энэ чиглэлээр хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, боловсронгуй болгох, төрийн болон олон нийтийн хяналтыг эрчимжүүлэх, олон улсын жишигт хүргэх, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах, хяналтын тогтолцооны бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөн шинэчлэх, давхардлыг арилгах зэрэг олон талт арга хэмжээ авч хэрэгжүүлж, тодорхой үр дүнд хүрч байгаа юм байна.

Тухайлбал, 1999 онд Монгол улсын Их хурлаас “Хүнсний тухай” Монгол улсын хуулийг батлан гаргасан бөгөөд хуулийн зорилго нь хүн амыг аюулгүй хүнсээр хангах явдал юм. Уг хуулинд хүнсний үйлдвэрлэл үйлчилгээ, импортлолтын явцад хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангахад голлон анхаарчээ. Хүнсний аюулгүй байдлыг хангуулах талаар төрийн байгууллагуудын бүрэн эрх, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, импортлогчдын хүлээх үүргийг тодорхойлж өгсөн бөгөөд хуулийн агуулга үндсэндээ хүнсний аюулгүй байдлыг хангуулахад хуулийн этгээдүүдийн эрх, үүрэг, үндсэн шаардлагуудыг тодорхойлж, түүнд тавих төрийн хяналт болон түүний бүтэц, ажлын зааг, уялдааг тодорхой зааж оруулан, төрийн хяналтанд хөндлөнгөөс оролцох бусад хяналтын оролцоог тусгасан нь хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбогдон гарах бүх талын харилцааг хуулиар зохицуулах боломжийг бүрдүүлсэн юм.

Гэвч Засгийн газраас бүрэн эрхийнхээ хүрээнд хэрэгжүүлэх 5.1.3-т заасан “хүнсний аюулгүй байдлын үзүүлэлтийг тодорхойлох, хүнсийг улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих журам тогтоох” гэсэн заалт болон 5.1.9-д заасан “хүнсний аюулгүй байдалд тавих хяналтын дүрэм батлах” гэсэн заалтууд одоог хүртэл хэрэгжээгүй байна. Харин хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдалд ЭАХС-ын Хяналтын Улсын Ерөнхий байцаагчийн 1995 оны 09 тоот тушаалаар баталсан “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлт”-ийг үндэслэдэг боловч тэр нь бүрэн бус, хэрэглэхэд учир дутагдалтай байдаг тул гол төлөв ОХУ-д мөрдөж буй үзүүлэлтүүдийг үндэслэн үнэлгээ өгдөг байна.

1998 оны “Эрүүл мэндийн тухай” Монгол улсын хуулинд эрүүл мэндийн талаарх төрийн бодлого, үндсэн зарчмыг тодорхойлж, иргэний эрүүл мэндээ хамгаалуулах, нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах эрхийг хангахад байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтны гүйцэтгэх үүргийн эрх зүйн үндсийг тогтоох зорилт тавьжээ. Хуулийн 49 дүгээр зүйлийн 1-ийн 4-т: *Эрүүл мэндийг хамгаалах, дэмжихэд аж ахуйн нэгж, байгууллагын үүргийг “Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлж болзошгүй үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага уг нөлөөллөөс сэргийлэн хамгаалах арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг жил бүр төсөв, төлөвлөгөөндөө тусгаж, үйлдвэрлэл, үйлчилгээний эрүүл ахуй, технологийн нөхцөл, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаандаа зарцуулна”* хэмээн тодорхойлжээ.

Мөн онд гарсан “Ариун цэврийн тухай” хуулийн 11 дүгээр зүйлд хүнсний ариун цэвэрт тавих шаардлагыг *“Хүнсний үйлдвэрлэл, тээвэрлэлт, хадгалалт, худалдаа, хэрэглээ нь чанар, эрүүл ахуйн аюулгүй байдлын стандарт, зохистой хэм хэмжээний шаардлага хангасан байхаас гадна хүнсний нийтийн үйлдвэрлэл, үйлчилгээг холбогдох эрүүл мэндийн болон ариун цэврийн байгууллагаас тусгай зөвшөөрөл олгогдсон хүн эрхэлнэ”* хэмээн тодорхойлсон байна. Мөн хуулийн 13 дугаар зүйлд *“Хилийн ариун цэвэрт тавих шаардлагыг “Үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх технологи, бараа бүтээгдэхүүн, бодис, бэлдмэлийг экспортолж, импортлоход ариун цэврийн болон мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлт гаргуулсан байна.”* гэж тодорхойлжээ. Түүнчлэн энэхүү хуулийн 14 дүгээр зүйлд Импортын бүтээгдэхүүн, бодис, бэлдмэл, материал, техник, технологид тавигдах шаардлагад дараахь зүйлүүдийг оруулжээ.

14.1. Импортын бүтээгдэхүүн, бодис, бэлдмэл, материал, техник, технологи нь хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд хор аюулгүй, Монгол улс, олон улсын болон бус нутгийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартын шаардлага хангасан, чанарын баталгаатай байна.

14.2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь бүтээгдэхүүн, бодис, бэлдмэл, материал, техник, технологи импортлоходоо энэ хуулийн 14.1-д заасан шаардлагыг гэрээ, хэлэлцээрт урьдчилан тусгаж, хуульд заасан тохиолдолд гадаад худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авч, улсын хилээр нэвтрүүлэхдээ уг гэрээ, хэлэлцээр болон тухайн бүтээгдэхүүн импортлох зөвшөөрөл, чанарын баталгааг хилийн мэргэжлийн хяналтын байгууллагад шалгуулна.

14.3. Импортолсон бүтээгдэхүүн, бодис, бэлдмэл, материал, техник, технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлж, хэрэглээнд гаргахдаа мэргэжлийн хяналтын байгууллагаар дүгнэлт гаргуулсан байна.” гэж зааж хилийн мэргэжлийн хяналтын үйл ажиллагааг анх хуульчилж өгснөөрөө уг хуулийн ач холбогдол оршиж байна.

Дээрх хуулиудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд төрөөс баримтлах хэд хэдэн бодлого стратегид хүнсний чанар, аюулгүй байдалтай холбоотой заалтуудыг тусгасан байна.

2001 оны Улсын их хурлын 81 дүгээр тогтоолоор “Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого” батлагдан гарсан нь ойрын 10-15 жилийн хугацаанд нийгмийн эрүүл мэндийн хөгжлийн хэтийн чиглэл нь хүн амыг хамгаалах,

дэмжих үйл ажиллагааг эрүүл хүнд хандуулах, эрүүл аж төрөх ёсыг төлөвшүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүн, хамт олны идэвхтэй оролцоог нэмэгдүүлэхэд чиглэж байна. Эрүүл мэндийн анхны тусламжийн хүрээнд монгол хүн амьдралынхаа туршид тэжээллэг чанар бүхий аюулгүй экологийн цэвэр хоол хүнсээр хангагдах, зөв хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээг заасан байдаг.

Харин УИХ бүрэн эрхийнхээ хүрээнд “Хүнсний тухай” (1999 оны) хуулийн 4.1.1-д заасан хүн амын ... хүнсний аюулгүй байдлын талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлохоор заасан боловч уг бодлогыг гаргаагүй бөгөөд харин 2003 онд “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого” гэсэн баримт бичиг батлан гаргасан юм. Энэхүү баримт бичгийн:

1. хүн амын хэрэгцээ, түүхий эдийн нөөцөд түшиглэн, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, орчин үеийн технологи бүхий хүнсний жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх

3 хүнсний бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн аюулгүй байдалд тавих хяналтын тогтолцоог боловсронгуй болгож лабораторийн шинжилгээг олон улсын жишигт хүргэх

4. хот суурин газрын хүн амыг эрүүл ахуй, ариун цэврийн аюулгүй байдалд бэлтгэгдсэн махаар хангаж, үйлдвэрлэлд шинэ технологи нэвтрүүлж, мах махан бүтээгдэхүүний чанарыг дэлхийн жишигт хүргэж, экспортыг нэмэгдүүлэх гэсэн заалтууд нь хүнсний аюулгүй байдлын талаар төрөөс баримтлах бодлогын нэг хэсэг юм. Гэвч хүнсний аюулгүй байдлын талаар төрөөс баримтлах бодлогыг ердөө эдгээр 3 заалтаар хязгаарлах нь туйлын учир дутагдалтай юм.

УИХ-ын 2004 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого”-ын зорилго нь хүн амын тогтвортой өсөлтийг хангаж, хүн ардаа урт удаан, эрүүл энх, бүтээлчээр амьдрах, хөгжих таатай орчинг бүрдүүлэхэд оршиж байгаа ба бодлогын баримтлах үндсэн чиглэлд хүний амьдралын чанарыг сайжруулах үйл ажиллагаа орж байгаа бөгөөд уг чиглэлийн 3.6-д хоол хүнсний 6 заалт орсон бөгөөд 3.6.3-т “Хүн амын хүнсний аюулгүй байдалд тавих эрүүл ахуй, халдвар судлалын хяналтыг тогтмолжуулах” асуудал багтжээ.

Филлипин улсын Манил хотноо 2000 оны 11 дүгээр сард болсон ДЭМБ-ын Номхон далайн баруун бүсийн “Хүнсний аюулгүй байдлын стратеги боловсруулах” хурлаас бүсийн хүнсний аюулгүй байдлын өнөөгийн байдлыг тодорхойлж, бүсээс энэ талаар баримтлах тэргүүлэх асуудлуудыг тодорхойлсон бөгөөд 2001 онд бүсийн хорооны удаах хурлаар уг стратегийг баталж, гишүүн орнуудын үүрэг, бүсийн төвөөс хийх ажлыг тодорхойлсон билээ.[49(1)]

Бүсийн хүнсний аюулгүй байдлын талаар баримтлах тэргүүлэх асуудлуудад:

- Салбар дундын бодлого, засгийн газар үйлдвэрийн хамтын ажиллагааг өргөжүүлж,
- Хүнсний аюулгүй байдал, хоол тэжээлийн асуудлыг хүнсний хангамж, ядуурлыг бууруулах асуудалтай уялдуулах,
- Эрсдэлд тулгуурласан хууль, дүрэм зааврыг боловсруулж мөрдөх,
- Хууль эрхийн хорооны стандартуудыг батлуулж мөрдөх,
- Хоол хүнснээс гаралтай өвчний хяналт, тандалтыг хангах,
- Үндэсний лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх
- Түүхий эдээс хэрэглээ хүртэл үр дүнтэй хяналт тавих,
- НАССР-ыг өргөнөөр нэвтрүүлэх зэрэг асуудлуудыг дэвшүүлэн тавьсан билээ.

■ **Төрөөс авч хэрэгжүүлж буй арга хэмжээ** - Хүнсний аюулгүй байдал, хоол тэжээлийн талаарх дэлхийн хэмжээнд болон бүс нутгийн хэмжээнд тавьж буй зорилтын агуулга, үзэл санаа нь “Хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол тэжээл” үндэсний хөтөлбөрт тусгалаа олсон юм. Уг хөтөлбөрийн хүрээнд дараахь арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үндэсний хэмжээнд авч хэрэгжүүлж буй хүнсний аюулгүй байдлын арга хэмжээнүүдийг олон улсын стандарттай уялдуулах, хүнсний хяналтын салбар хоорондын хамтын ажиллагааны уялдаа холбоог сайжруулах;

- Хүнсний аюулгүй байдлын хяналт болон эрсдлийн шинжилгээний стандарт аргуудыг боловсруулах;
- Хүнсний хууль эрх зүйн хорооны зөвлөмжийн дагуу үндэсний хууль эрх зүйн хороо (техникийн хороо)-ны үйл ажиллагааг идэвхижүүлэх;
- Лабораториудыг хөгжүүлэх төсөл боловсруулан хэрэгжүүлэх;
- Хүнсний аюулгүй байдлын хяналтын чиглэлээр үндэсний боловсон хүчнийг мэргэшүүлэх;
- Хүнсний үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний байгууллагад эрүүл мэндийн сургалт, сурталчилгаа явуулж зохистой хэрэглээний дадал заншилд иргэдийг сургах зорилт тавигдсан нь хөтөлбөр хэрэгжсэнээр манай улсад хүнсний эрүүл ахуйн хяналтанд эрсдэлд тулгуурласан аргыг нэвтрүүлэх тогтолцоо бүрдэж, улсын нэгдсэн болон бүсийн нэгдсэн лаборатори бий болох юм.

Хүнсний аюулгүй байдал(ХАБ)-ын асуудлыг хариуцан гүйцэтгэх байгууллагын талаар товч дурьдвал:

- Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, түүхий эдийн ханган нийлүүлэлтийн асуудлыг- ХХААЯ, хүнсний аюулгүй байдлын эрдэм шинжилгээ судалгаа, дипломын дараахь сургалт,
- Биологийн нэмэлт хүнсний бүтээгдэхүүнийг улсын бүртгэлд бүртгэн мэдээлэх, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээнд Эрсдлийн шинжилгээ ба хяналтын эгзэгтэй цэг(НАССР)-ийн тогтолцоо, Эрүүл ахуйн зохистой дадал (GHP), Үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP) нэвтрүүлэх, хүн амын дунд явуулах ХАБ-ын сургалт, сурталчилгааны асуудлыг - ЭМЯ, түүний харьяа НЭМХ,
- Импортын болон дотоодын үйлдвэрлэлийн хүнсний бүтээгдэхүүнд тавих урьдчилсан ба байнгын хяналтыг УМХГ,
- Хэрэглэгчдийн ХАБ-ын мэдлэг, боловсролыг дээшлүүлэх асуудлыг ХЭАХНХ хариуцах үүргийг тус тус гүйцэтгэж байна.

2000 онд Монгол улсын Ерөнхийлөгч Н.Багабанди “Хүнсний аюулгүй байдлын хяналтыг сайжруулах зарим арга хэмжээний тухай” зарлигтаа “”Хүнсний тухай” тухай хуулиар хүн амын хүнсний аюулгүй байдалд тавих хяналт, түүний тогтолцоог хуульчлан баталсан боловч хяналтын бүтцийг хуульд заасны дагуу бий болгох, холбогдох эрхийн актуудыг уг хуульд нийцүүлэх ажил удаашралтай байгааг” тэмдэглээд Засгийн газарт холбогдох арга хэмжээ авахуулахаар дараахь чиглэлүүдээр үүрэг болгосон байна. Үүнд:

1. Хүнсний чанар, аюулгүй байдлын хяналтыг мэргэжлийн нэгдмэл удирдлагаар хангах бүтцийг зохион байгуулж, үйл ажиллагаатай нь холбогдон гарах бусад асуудлыг шийдвэрлэх;

2. Үйлдвэрлэлт, борлуулалтын бүх шатанд хүнсний чанар, аюулгүй байдлын дотоод хяналтын тогтолцоог бий болгох арга хэмжээ авах;

3. Хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын хяналтын үндэсний лавлах лаборатори байгуулж, хүнсний бүтээгдэхүүний хяналтын лабораторийн сүлжээг бэхжүүлэх.

Уг зарлигийн дагуу Засгийн газар 2002 оноос мэргэжлийн хяналтын үйл ажиллагааг үр дүнтэй болгох, салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах, хяналт шалгалтын давхардлыг арилгах, үр дүнг сайжруулах зорилгоор мэргэжлийн хяналтын байгууллагуудын удирдлага, бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөн, хүнсний аюулгүй байдлын асуудалд оролцдог Засгийн газрын тохируулагч 8 агентлагийг нэгтгэн Засгийн газрын харьяа Улсын Мэргэжлийн Хяналтын Газрыг (УМХГ) байгуулсан байна.

2 дахь чиглэлийн хүрээнд УМХГ-аас үйлдвэрүүдэд НАССР, GMP, GHP нэвтрүүлэх арга хэмжээг авч байна.

Харин 3 дахь чиглэлийн дагуу лавлагаа лаборатори одоо хүртэл байгуулагдаагүй байгаа ба хүнсний бүтээгдэхүүний хяналтын лабораторийн сүлжээг бэхжүүлж чадаагүй байгаа нь судалгааны явцад ажиглагдлаа. Үүнээс болж хяналтын шинжилгээний үнэн магадлалыг тогтоож, лабораториудын шинжилгээний дүнг нэгтгэсэн мэдээллийн тогтолцоо бүрдэхгүй байгаагаас хүнсний аюулгүй байдлыг хүн

амын өвчлөлтэй холбон судалж, хяналтын шинжлэх ухааны үндэслэл боловсруулах үгүйлэгдэж, улмаар ХАБ-ын эрүүл мэндийн эрсдэлтэй холбоотой бэрхшээл хүндрэл гарсаар байна.[36]

■ **Хүнсний аюулгүй байдлын хяналтын бүтэц, зохион байгуулалт** - УМХГ-ын Эрүүл мэндийн хяналтын хэлтэс (ЭМХХ), Үйлдвэр, худалдааны хяналтын хэлтэс, Боловсролын хяналтын хэлтэс, ХАБ, хөдөө аж ахуйн хяналтын хэлтэс хамтран хүнсний аюулгүй байдлын хяналт тавих үүрэгтэй.

Хүнсний аюулгүй байдалд тавьж буй эрүүл мэндийн хяналтын гол зорилго нь хоол, хүнсний бүтээгдэхүүн хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхээс сэргийлэх, хоолны хордлого, халдвар гарсан тохиолдолд шалтгааныг судлан тогтоох, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг нэгэн зэрэг үзүүлэх цогцолбор арга хэмжээ юм.

Хүнсний аюулгүй байдлын хяналтыг Монгол улсын “Ариун цэврийн тухай”, “Хүнсний тухай”, “Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах тухай”, “Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай”, “Хилийн тухай”, “Усны тухай” зэрэг хууль, УИХ, засгийн газрын тогтоол, үндэсний хөтөлбөр, үндэсний стандартууд зэрэг хууль эрхийн актуудын хүрээнд гүйцэтгэж байна.

Монгол улсын хэмжээнд хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдлын төрийн хяналтыг УМХГ эрхлэн, санхүү, байгаль орчин, дэд бүтцийн, үйлдвэрлэл, худалдааны, хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн, эрүүл мэндийн, боловсрол, соёл, шинжлэх ухааны, хилийн мэргэжлийн зэрэг хяналтын 12 газар, хэлтэс, 11 алба, нэгдсэн төв лаборатори болон салбар 4 лаборатори, Нийслэл, 21 аймгийн мэргэжлийн хяналтын газрууд гэх мэт бүтэцтэйгээр хэрэгжүүлж байна.

Хүнсний аюулгүй байдалд УМХГ-ын:

○ Үйлдвэрлэлийн салбараас:

1. Үйлдвэрлэл, худалдааны хяналтын хэлтсийн Худалдаа, үйлдвэр, үйлчилгээ, стандарт чанарын хяналтын алба;

➤ Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн хяналтын хэлтэс:

2. Хүнсний үйлдвэр, технологийн хяналтын алба,

3. Мал эмнэлэг, үржлийн хяналтын алба,

4. Газар тариалан, ургамал хамгаалал хорио цээрийн хяналтын албадтайгаар;

○ Нийгмийн салбараас:

5. Эрүүл мэндийн хяналтын хэлтсийн Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын алба;

6. Боловсрол, соёл шинжлэх ухааны хяналтын хэлтсийн Шинжлэх ухаан, цацрагийн хяналтын алба;

7. Хилийн мэргэжлийн хяналтын алба

○ Санхүүгийн салбараас:

8. Нэгдсэн төв лабораторийн:

• Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын лаборатори,

• Таримал ургамлын үр, хорио цээрийн лаборатори

• Цацрагийн хяналтын лаборатори

9. Нийслэл, 21 аймгийн мэргэжлийн хяналтын газар зэрэг УМХГ-ын 4 хэлтэс, 7 алба болон түүний харьяа Орон нутгийн Мэргэжлийн хяналтын 22 газар тус тус хяналт тавьж, Нэгдсэн төв лабораторийн дээрх 3 салбар лабораториуд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд шинжилгээ явуулж байна.

УМХГ нь Засгийн газрын 2003 оны 37 дугаар тогтоолоор баталсан “УМХГ-ын нийтлэг дүрэм”-ийн дагуу дээрх хэлтэс, албадууд хүнсний аюулгүй байдалд дараахь чиглэлүүдээр тус тус хяналт тавьж байна.

1. Үйлдвэрлэл, худалдааны хяналтын хэлтсийн Худалдаа, үйлдвэр, үйлчилгээ, стандарт чанарын хяналтын алба – Хүнсний бараа, бөөний худалдааны болон хоол үйлдвэрлэл, үйлчилгээний гэсэн 2 үндсэн чиглэлээр хүнсний аюулгүй байдалд хяналт тавьж байна.

• Хүнсний бараа, бөөний худалдааны чиглэлээр:

□ Худалдаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад холбогдох хууль, дүрмийн хэрэгжилт, стандартын шаардлагыг хэрхэн мөрдөж ажиллаж

байгаад хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөхөд гол зорилтоо чиглүүлж байна.

- Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр:
 - Хоол үйлдвэрлэлийн салбарын холбогдох хууль тогтоомж, стандарт, дүрэм журам, Засгийн газрын тогтоолоор батлагдсан үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавих;
 - Хэрэглэгчдэд **орц норм, жор технологи** нь таарсан чанартай, аюулгүй хоол хүнсээр соёлтой үйлчлэхэд тус дөхөм үзүүлэх;
 - Хоол үйлдвэрлэлийн **түүхий эд, бэлдэц материалын чанар, аюулгүй байдал, баталгаажилт**, хадгалалтын нөхцөл, стандартад нийцэж байгаа эсэх,
 - Ажиллагсдын мэргэжлийн ур чадвар;
 - Хоол үйлдвэрлэлийн ажилын байрны технологи дамжлага стандартын дагуу зөв оновчтой төлөвлөгдсөн эсэх;
 - **Бэлэн бүтээгдэхүүний амт чанар, орц, гарцын хэмжээ** нь батлагдсан жор технологид тохирч байгаа эсэхэд хяналт тавих зэрэг үйл ажиллагаа явуулж байна.

➤ Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн хяналтын хэлтэс – нь хүнсний аюулгүй байдлыг хангах зорилготой бөгөөд ХАБ-ыг хүнсний зүйлийн хангамж, бүтцийн болон чанар, эрүүл ахуйн зохистой хэм хэмжээ хангагдахыг хэлнэ хэмээн тодорхойлсон байна. Уг хэлтэс нь 3 албадаас бүрдэнэ.

2. Хүнсний үйлдвэр, технологийн хяналтын алба - Үйл ажиллагааны чиглэл:

- Хүнсний холбогдолтой хууль тогтоомж, стандарт, дүрэм журам, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хянаж албадан сахиулж, хэрэглэгчдэд цэвэр, аюулгүй, хүнсээр хангахад тус дөхөм үзүүлэх;
- Хүнсний үйлдвэрлэлийн **түүхий эд, материалын чанар, баталгаажилт**, хадгалалтын нөхцөл нь стандартын шаардлага хангаж байгаа эсэх, мэргэжлийн технологич, мэргэшсэн ажилчид, лабораторийн үйл ажиллагаа, дотоод хяналтын тогтолцоог сайржуулахад хяналт тавих.

3. Мал эмнэлэг, үржлийн хяналтын алба - Үйл ажиллагааны чиглэл:

- Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, чанарыг сайжруулахтай холбогдсон хууль, тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангуулах;
- **Мал, амьтан, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийг** экспортлох, импортлоход олон улсын гэрээ, хэлэлцээр, үндэсний стандартын шаардлага хангаж байгаа эсэхэд хяналт тавих;
- Мал эмнэлэг, үржлийн хяналтын тогтолцоог боловсронгуй болгож, улсын байцаагч нарыг мэргэжил арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах, мэргэшлийг нь дээшлүүлж чадваржуулах, үйл ажиллагаанд нь хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт өгөх;
- Мал эмнэлэг, үржлийн чиглэлийн хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийн байдалд шинжилгээ дүгнэлт хийж, тэдгээрийг боловсронгуй болгох мэдээллээр төр, засгийн холбогдох байгууллагуудыг хангах.


4. Газар тариалан, ургамал хамгаалал хорио цээрийн хяналтын алба - Үйл ажиллагааны чиглэл:

- Үйлдвэрлэсэн болон импортын **үр тариа, төмс, хүнсний ногоо**, олон наст таримал үр, тарьц, суулгацын чанар, баталгаажуулалт;
- Үр, сортын хянан баталгаа хийгдсэн, үр үржүүлгийн технологийн мөрдөлт, үрийн тариаланг даатгалд хамруулсан байдал;
- Хаврын тариалалт, ургац хураалтын бэлтгэл хангалт;
- Услалтын системийн хангамж, ашиглалт;
- Тарималын хөнөөлт шавьж, өвчин, хог ургамалтай механик, хими, биологийн аргаар тэмцсэн ажлын чанар;
- Ургамал хамгаалах бодис, бордооны хадгалалт, хамгаалалт, зарцуулалт.

➤ Эрүүл мэндийн хяналтын хэлтсийн гол зорилго нь “Эрүүл мэндийн тухай” хууль, “Ариун цэврийн тухай” хууль, “Эмийн тухай” хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэнд мэргэжлийн хяналт тавьж, байгаль, ахуйн орчноос хүний эрүүл мэндэд

сөрөг нөлөөлөл үзүүлж буй хүчин зүйлсийг илрүүлэх, түүний үр дагавраас шалтгаалан үүсэх өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, ариун цэврийн хэвийн нөхцөлийг хангуулах, эмийн болон эмнэлгийн тусламж үзүүлэх бололцоог бүрдүүлэх замаар хүн амын эрүүл мэндийг хамаалахад оршино.

5. Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын алба – Хүнсний аюулгүй байдалд тавих хяналтын үйл ажиллагааны чиглэл:
 - Хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагын эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийг хэрэгжүүлж байгаа байдалд дүгнэлт гаргах;
 - **Хүнсний бүтээгдэхүүнээс гарсан хордлого, халдварын шалтгааныг** судлан тогтоох, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа байдалд дүгнэлт гаргах;
 - **Согтууруулах ундааны чанар, эрүүл ахуйн үзүүлэлтэнд** дүгнэлт гаргах;
6. Боловсрол, соёл шинжлэх ухааны хяналтын хэлтсийн Шинжлэх ухаан, цацрагийн хяналтын алба - Хүнсний аюулгүй байдалд тавих хяналтын үйл ажиллагааны чиглэл:
 - Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон хууль тогтоомж, дүрэм, цацрагийн аюулгүйн норм, стандартын хэрэгжилтэнд хяналт тавих, илрүүлсэн зөрчлийг засуулах арга хэмжээ авах;
 - Түүхий эд, бүтээгдэхүүн, гадаад орчны дээж, унд, ахуйн хэрэглээний ус, **хүнсний зүйл зэргийн цацрагийн бохирдлыг** байнга хянаж, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх нөхцөл бүрдэж байгаа эсэхийг тогтоох, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авах;
7. Хилийн мэргэжлийн хяналтын алба:
 - **Зорилго** - Монгол улсын хууль, тогтоомж, олон улсын гэрээ, хэлэлцээрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд олон улсын хөл хориот, мал, амьтны “А” ангиллын өвчин, ургамлын хорио цээртэй өвчин, хөнөөлт шавьж, мэрэгч амьтан, хог ургамал улсын хилээр нэвтрэхээс урьдчилан сэргийлэх, бараа, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангуулахад чиглэгдсэн мэргэжлийн хяналт, шалгалтыг улсын хилийн боомт, гүний гаальд хэрэгжүүлэх замаар үндэсний аюулгүй байдлыг хангуулахад оршино.
 - **Бүгц, бүрэлдэхүүн** – 2003 онд УМХГ-ын дэд даргын эрхлэх асуудлын хүрээнд ХМХА-ыг шинэр зохион байгуулсан.
Төвдөө: - албаны дарга 1,
 - ЭАХС-ын улсын ахлах байцаагч 1, улсын байцаагч 3,
 - мал эмнэлгийн хяналтын улсын ахлах байцаагч 1, улсын байцаагч 3,
 - ургамлын хорио цээрийн хяналтын улсын ахлах байцаагч 1, улсын байцаагч 4,
 - стандарт, чанарын хяналтын улсын ахлахбайцаагч 1, улсын байцаагч 3,
 - батлан хамгаалахын хяналтын улсын байцаагч 3,
 - бүгд 20 байцаагч ажиллаж байна.
 - Монгол улсын хилийн үндсэн 10 боомт, олон улсын 3 боомт, харьяа 7 боомт, орон нутгийн чанартай 3 боомтод мал эмнэлэг, ургамлын хорио цээр, эрүүл ахуй, халдвар судлал, стандарт, чанарын хяналтын нийт 138 улсын байцаагч ажиллаж байна.
 - **Үйл ажиллагаа** – Улсын хил дээр ажиллаж буй байцаагчдаараа дамжуулан Монгол улсын хилээр нэвтэрч буй хүн, мал, амьтан, ургамал, бодис, бараа бүтээгдэхүүнд эрүүл ахуй, халдвар судлал, мал эмнэлэг, ургамлын хорио цээр, стандарт чанарын хяналтыг хэрэгжүүлснээр Монол улсын үндэсний аюулгүй байдал, ниймийн эрүүл мэндийг хамгаалах үндсэн үүрэг гүйцэтгэдэг байна.
Үүнд:
 - Хилийн боомт дахь ХМХА-ын хяналт шалгалтын үйл ажиллагааг улсын хэмжээнд нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах, зохион байгуулах, тэдгээрийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх;
 - **Экспорт, импортын бараа, бүтээгдэхүүнийг** олон улсын жишигт нийцүүлэн хянаж, баталгаажуулах (гэрчилгээжүүлэх), хяналт тавих;



- ХМХА-ын чиглэлээр УМХГ-ыг төлөөлөн гадаад орнуудтай гэрээ, хэлэлцээр байгуулах;
- **Импорт, экспортын бараа, бүтээгдэхүүнийг гүний хяналт, баталгаажуулалтад** хамруулан хэрэглээнд болон экспортод гаргах зэрэг үйл ажиллагаа явуулдаг.

8. Нэгдсэн төв лаборатори:

- Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын лаборатори - Үйл ажиллагааны чиглэл:

- Ундны ус, хүнсний химийн лаборатори нь бүх төрлийн импортын болон эх орны үйлдвэрийн хүнсний бүтээгдэхүүн, ундны усны найрлага дахь бүтэц, найрлагыг тодорхойлох зориулалттай шинжилгээний лаборатори юм.
- Хор судлалын лаборатори нь импорт, экспортын бүх төрлийн хүнсний бүтээгдэхүүн, тамхинд агуулагдаж байгаа хүний эрүүл мэндэд хортой химийн бодисуудыг илрүүлэн таньж, хоол хүнснээс шалтгаалан хүн, амьтан эрсэдсэн болон хордлого, хордлогот халдвар гарсан тохиолдолд сөрөг нөлөөлөл үүсгэсэн эх үүсвэрийг тогтоох зориулалттай шинжилгээний лаборатори юм.
- Паразитологи, биотуршилтын лаборатори нь импорт, экспортын бүх төрлийн хүнсний бүтээгдэхүүнд хүнд өвчин дамжуулагч үе хөлтөн шавьж, шимэгч хорхойн өндөг, авгалдайг илрүүлэн, төрөл зүйлийг нь тодорхойлж, хүн эмнэлгийн холбогдлыг тогтоох, хүнсний бүтээгдэхүүн, химийн хортой бодис, ахуйн химийн болон гоо сайхны бүтээгдэхүүний хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөллийг туршлагын амьтанд туршиж хордуулах үйлчилгээг тогтоох зориулалттай лаборатори юм.
- Хүнсний нян судлалын лаборатори нь импорт, экспортын бүх төрлийн хүнсний бүтээгдэхүүнд эмгэг төрөгч нянуудыг илрүүлэн таних, тэдгээрийн хүний эрүүл мэндэд нөлөөлж болох сөрөг хүчин зүйлүүдийг тодорхойлох зориулалттай лаборатори юм.
- Хөгц мөөгөнцрийн лаборатори нь импортын хүнсний бүтээгдэхүүн, өрөө тасалгаанд хөгц мөөгөнцөр илрүүлэх шинжилгээг хийж, төрөл зүйлийг тодорхойлох зориулалттай лаборатори юм.

- Таримал ургамлын үр, хорио цээрийн лаборатори - Үйл ажиллагааны чиглэл:

- Таримал ургамлын тарих үр, хүнсний буудайн болон дээд үржүүлгийн сортын үрийн технологийн чанарыг тодорхойлох;
- Хөрс, ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд задлан шинжилгээ хийж, гадаад, дотоод хорио цээртэй хөнөөлт шавьж, өвчин, хог ургамлаар халдварлагдсан эсэхийг илрүүлэх, тодорхойлох;
- Хөрс ба ургамалд химийн хорт бодисын үлдцийг тодорхойлох.
- **Цацрагийн хяналтын лаборатори - Үйл ажиллагааны чиглэл:**
 - Түүхий эд, бүтээгдэхүүн, гадаад орчны дээж, унд, ахуйн хэрэглээний ус, хүнсний зүйл зэргийн цацрагийн бохирдлыг байнга хянаж, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх нөхцөл бүрдэж байгаа эсэхийг тогтоох;

9. Нийслэл, 21 аймгийн мэргэжлийн хяналтын газар

“Хүнсний тухай” хуулийн 13.1-д “Хүнсний аюулгүй байдалд тавих хяналтыг хүнсний үйлдвэрлэлийн техник, технологи, эрүүл ахуй, үр, ургамал, хорио цээр, мал эмнэлэг, ариун цэврийн мэргэшсэн улсын байцаагч хийнэ” хэмээн зааж, тэдний бүрэн эрхийг хэрэгжүүлэх чиглэлийг мэргэжил тус бүрээр ялган зааглаж өгсөн байдаг. Тэгвэл УМХГ-ын бүтцээс харахад хүнсний үйлдвэр, үйлчилгээний хяналтын улсын байцаагч нар ҮХХХ-ийн ХҮҮСЧХА болон ХАБХААХХ-ийн ХҮТХА-д тус тус ХАБ-ын хяналт тавьж байгаа нь үндсэн үүргийнхээ хувьд нэг хэлтэст байж болохоор байгаа нь харагдаж байна. ХАБХААХХ-ийн ХҮТХА нь хүнсний үйлдвэрлэлийн түүхий эд, материалын чанар, баталгаажилт, хадгалалтын нөхцөлд хяналт тавих үүрэг нь үйл

ажиллагаанд тусгагдсан байгаа ба харин үйлдвэрлэлийн ажиллагаанд тавих технологийн хяналтын талаар үндсэн чиглэлд тусгагдаагүй байна. ХАБХААХХ-ийн МЭҮХА нь мал, амьтан, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийг экспортлох, импортлоход олон улсын гэрээ, хэлэлцээр, үндэсний стандартын шаардлага хангаж байгаа эсэхэд хяналт тавих үүрэг нь ХМХА-ны үйл ажиллагааны үндсэн чиглэлтэй давхцаж болох талтай байна. Гэтэл уг албаны мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг дотооддоо хянах, судалж, дүгнэх асуудлыг үйл ажиллагааны чиглэлдээ оруулалгүй орхигдуулсан дутагдал ажиглагдаж байна. Энэ нь “Хүнсний тухай” хуулийн 13 дугаар зүйлийн 1.2-т заасан “мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч нь зах зээлд борлогдож байгаа болон нийтийн хоолны газар, боловсруулах үйлдвэрт түүхий эдийн зориулалтаар ашиглаж байгаа мал, амьтан, түүний түүхий мах, өөх, дотор мах, дайвар бүтээгдэхүүн, загас, сүү, цагаан идээ, түүхий өндөг, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч этгээдийн байр, орчин, үйлдвэрлэлийн дамжлагын эгзэгтэй цэгийн ариун цэвэр, эрүүл ахуйн аюулгүй байдлыг хянах” гэсэн гэсэн заалттай нэг талаар, “зах зээлд борлогдож байгаа мал, амьтны гаралтай хүнсийг хянах”, нөгөө талаар, “мал, амьтны гаралтай хүнсний түүхий эдийг зөвхөн хянах” гэсэн энэхүү заалтын 2 ухагдахуунтай мал эмнэлгийн хяналтын үйл ажиллагааны чиглэл зөрчилдөж байна.

ЭМХХ-ийн ЭАХСХА нь хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагын эрүүл ахуйн, халдвар хамгааллын дэглэм, хүнсээр дамжиж үүсгэгдсэн хорлогуудын шалтгаан, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, согтууруулах ундааны чанар, эрүүл ахуйн үзүүлэлтэнд дүгнэлт гаргах үйл ажиллагааг үндсэндээ явуулж байгаа нь согтууруулах ундаанаас бусад хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хянах тухай “Хүнсний тухай” хуулийн 13 дугаар зүйлийн 1.1-ын “эрүүл ахуй, халдвар судлалы улсын байцаагч нь ... хэрэглэхэд бэлэн болсон хүнсний ариун цэвэр, эрүүл ахуйн аюулгүй байдлыг хянах” гэсэн заалттай зөрчилдөж байна. Энэ улмаар хүнсний бүтээгдэхүүний хордлого, халдвар үүсгэхгүй байх аюулгүй байдлын үзүүлэлтүүдийг хянаж, хүнсний бүтээгдэхүүний бохирдлоос хүн амын эрүүл мэндийг хохироохоос урьдчилан сэргийлж, хамгаалах үйл ажиллагаа явуулах бус, харин нэгэнт эрүүл мэндээр хохирсон хойно нь шалтгааныг нь нэхэн судлах хуучин эмчлэн сэргийлдэг байсан тогтолцоо руу ухралт хийж буй хандлага ажиглагдаж байна.


Харин хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээний газруудын эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэм, хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын хяналтыг Нийслэл, аймаг, орон нутгийн МХГ-ын НЭМХХ-ийн хүнсний эрүүл ахуйн асуудал хариуцсан баг болон ЭАХС-ын улсын байцаагч нар тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч, хүнсний үйлдвэрлэлд эрсдлийн үнэлгээ өгөх үйл ажиллагааг явуулж байна.[64]

▪ **Хүнсний ЭАХС-ын хяналтанд тулгарч буй бэрхшээл, дутагдал.**

1990-ээд оны үед хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг төрийн өмчийн томоохон цөөн тооны объектууд байдаг байсан бол зах зээлд шилжсэнээс хойш хувийн хэвшлийн жижиг, дунд үйлдвэр, худалдааны байгууллагууд олширсоор 1996 онд хяналтын 9006 объект байсан бол 2004 онд 14709 болж 1.6 дахин нэмэгдсэн боловч тэдгээрт хяналт тавьдаг хүнсний эрүүл ахуйчдын тоо нэмэгдээгүй байна. Хүнсний ЭАХС-ын хяналтыг улс, нийслэл, аймаг, хотын хэмжээнд 47 хүнсний эрүүл ахуйн улсын байцаагч тавьж, 1 байцаагчид дунджаар 313 объект ногдож байна. (Зураг 2.3.1.)



Зураг. 2.3.1. Хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны объектын тоо



Хүнсний эрүүл ахуйн улсын байцаагчдын хүн хүчний чадамжийг авч үзвэл 24.9% нь магистр, 37% нь хүнсний эрүүл ахуйч мэргэжил дээшлүүлэх, 63% нь олгох курст суралцсан байна.

Хүнсний хяналтын байцаагчид НАССР-ын талаар онолын сургалтанд хангалттай хамрагдсаны үр дүнд сүүлийн жилүүдэд ундаа, хиам, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэлд эрсдлийн үнэлгээ хийх асуудал дээр анхаарал тавьж байгаа юм байна. Гэвч НАССР-ыг хэрхэн нэвтрүүлэх талаар хяналтын байцаагчдын практик, туршлага дутагдалтай байгаагаас хүнсний бусад үйлдвэрлэл, үйлчилгээ, ялангуяа орон нутгийн хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээнд GMP, GHP, НАССР нэвтрээгүй, эцсийн бүтээгдэхүүнд хяналт тавьдаг хуучин арга оршсоор байна.

Хүнсний хяналтын болон судалгаа шинжилгээний лабораторийн хүчин чадал суд, лабораторийн мэргэжилтэй боловсон хүчин, аймаг орон нутаг болон Улаанбаатар хотод ажиллаж байгаа лабораториудад шинжилгээ явуулахад шаардлагатай тоног, төхөөрөмж дутагдалтай, ялангуяа түргэвчилсэн аргаар шинжилгээ хийж дүгнэлт гаргах боломжгүй байна. Аль ч лабораторид хуучин тоног төхөөрөмжүүдийг засаж сэлбэн хэрэглэх, зааврын дагуу бүрэн ашиглах асуудлаар бэлтгэгдсэн боловсон хүчин дутагдалтай байна.

УМХГ, түүний харъяа аймгийн мэргэжлийн хяналтын газраас маш олон тооны хяналт, шинжилгээ хийгддэг боловч шинжилгээний дүнг зөвхөн цаасан дээр үлдээж, архивласнаар орон нутаг болон холбогдох яам, тусгай газарт эргэн мэдээлдэггүйгээс хүн амын өвчлөлтэй холбон үнэлгээ, дүгнэлт өгөх, хэрэглэгчдийн хүнсний аюулгүй байдлын мэдлэг, боловсролыг дээшлүүлэх улмаар ХАБ-ын үндэсний мэдээллийн сан үүсгэх талаар ДЭМБ-ын зөвлөхүүдийн өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлж чадахгүй байна.

2002 онд хийсэн МХГ-ын шинэ бүтцээр дүүрэг, орон нутагт болон мэргэжлийн хяналтын зарим салбарт байсан олон жижиг, хүчин чадал багатай лабораториудыг нэгтгэн УМХГ-ын харъяа Нэгдсэн төв лаборатори болон НМХГ-ын харъяа Төв Лабораторид төвлөрүүлсэн нь лабораторийн үйл ажиллагааны үргүй зардлыг багасгаж, хүчин чадлыг нэмэгдүүлэхэд түлхэц болж байна. Гэвч дээрх лабораториудын бүтээгдэхүүнд тодорхойлж буй үзүүлэлтүүдийн тоо олон улсын жишигт хүрэхгүй байна. Тухайлбал, хүнсний нэмэлт, биологийн өндөр идэвхит бодисууд, листери, кампилобактер, стафилококкын хор, вирус, афлотоксин, моноцитоз, органик бодисын үлдэгдэл, амьтны гаралтай бүтээгдэхүүнд антибиотекийн үлдэгдэл тодорхойлох, хуурамч архийг төгс шинжлэх лаборатори байхгүй байна. Хүнсний сав баглаа боодолд агуулагдах химийн хортой бодисуудыг шинжлэх лаборатори хөгжөөгүй байна.

Манай улс өнөөдөр хүнсний бүтээгдэхүүнийхээ 80%-ийг импортолж, 22 боомтоор хүнсний бүтээгдэхүүн нэвтрүүлж байна. “Хүнсний тухай” хуулийн 12 дугаар зүйлийн 4-т “Байнгын ажиллагаатай хилийн боомтод хүнсний аюулгүйн үзүүлэлт, бусад боомтод хүнсний аюулгүйн анхан шатны үзүүлэлтийг тодорхойлох лаборатори бүхий хяналтын алба ажиллуулна” хэмээн заасан байдаг. Гэтэл байнгын

(13) болон улирлын ажиллагаатай 22 хилийн боомт дээр Хилийн эрүүл ахуй, халдвар судлалын 14 товчоо, салбар ажиллаж байгаа боловч Замын-Үүд боомтод зөвхөн хүнсний аюулгүйн анхан шатны үзүүлэлт тодорхойлох шинжилгээ, бусад боомтуудад мэдрэхүйн (харах, үнэртэх, хүрэх, амтлах зэрэг) үзүүлэлтэд үндэслэн үзлэг шалгалт хийгдэж, нарийвчилсан шинжилгээг Улаанбаатар хотод УМХГ (гүний хяналт) хийж байна. Ийнхүү иж бүрэн хяналт тавьж чадахгүй байгаагаас дээрх 22 боомтоор эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагад тохирохгүй ямар их бүтээгдэхүүн оруулж, хоол хүнсээр дамжиж, хичнээн хүнийг өвчлүүлж буйг тооцохын аргагүй юм. Энэ бол үнэхээр “аймшигтай” зүйлийн нэг юм.

Үйлдвэрлэл эрхлэгчдийн хууль эрх зүйн болон технологи, хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадал, НАССР-ын талаарх мэдлэг боловсрол дутагдалтай байгаа нь үйлдвэрлэлийн технологийн горим зөрчигдөж, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх нөхцөлийг бүрдүүлж байна.

Хэрэглэгчдийн хүнсний аюулгүй байдлын мэдлэг, боловсрол дутагдалтай, мөн анагаахын болон хүнсний чиглэлийн бусад их, дээд сургууль, коллежийн сургалт дахь хүнсний эрүүл ахуйн хичээлийн хөтөлбөр нь орчин үеийн шаардлагад нийцэхгүй, худалдаа эрхлэгчид, багш, оюутан сурагчдад зориулсан сургалтын материал, гарын авлага хүрэлцээгүйн дээр сэдвийн агуулга явцуу байна.

1998 оноос хойш ДЭМБ-аас богино хугацааны олон зөвлөх ирж, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, цаашид монгол дахь хүнсний аюулгүй бадйлыг сайжруулах талаар олон үнэтэй зөвлөгөө өгсөн боловч уг зөвлөмжүүдийг холбогдох байгууллагуудад цаг алдалгүй хүргэх, эргэн хянах, мэдээлэх үйл ажиллагаа дутагдалтай байна.

Монгол улсын эрүүл мэнд, Хөдөө аж ахуйн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан “Биологийн идэвхит хүнсний бүтээгдэхүүнийг улсын бүртгэлд бүртгэж, хяналт тавих” журмыг 2001 оноос эхлэн мөрдөж байна. Гэвч уг бүтээгдэхүүнийг олон тооны үүргийн худалдаачид импортолж байгаа учир тэр бүрчлэн улсын бүртгэлд авч, хяналт хийж чаддаггүй байна. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр улсын бүртгэлд бүртгүүлээгүй биологийн идэвхит хүнсний нэмэгдэл бүтээгдэхүүнийг сурталчлах явдал байсаар байна.

Монголын хүнсчдийн холбоо тус яамтай хамтран ажиллах талаар 3 жилийн хугацаатай протокол байгуулан хүнсний салбарын холбогдолтой хууль эрхийн баримт бичиг, төсөл, хөтөлбөр боловсруулах, дэвшилтэт, техник, технологи нэвтрүүлэх, боловсон хүчнийг сургаж бэлтгэх зэрэг олон талт арга хэмжээг хэрэгжүүлэхэд идэвхитэй ажиллаж байна.

Монголын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, түүний аймаг нийслэл, төмөр замын салбарууд хүнсний аюулгүй байдалд анхаарлаа төвлөрүүлж, хэрэглэгчдээ хамгаалах талаар ихээхэн санаачилга гаргаж ажилладаг байна.[36, 64]

2.3.2. ХҮНСНИЙ ЭРҮҮЛ АХУЙ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ

Манай улс 1990 оноос зах зээлийн харилцаанд шилжиж, улс орны төр, нийгэм, эдийн засаг болон бусад бүхий л салбарт өөрчлөлт шинэчлэлт гарч байгаа өнөө үед хүнсний аюулгүй байдлын асуудал нь тулгамдсан асуудлын нэг болж байна. Чөлөөт зах зээлийн тогтолцоонд шилжсэнтэй холбоотойгоор улсын өмчид тулгуурласан нийтийн хоол, худалдааны салбар задарч, улсын үйлдвэрүүд үйл ажиллагааны хувьд доголдож, хувийн үйлдвэрүүд олноор бий болж, мэргэжлийн бус хүмүүс хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээг эрхлэн явуулах болсон бөгөөд хүнсний чиглэлийн объектуудын тоо эрс өссөн билээ.

Дээрх нөхцөл байдлаас үүдэн хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн дунд нийтлэг зөрчил, дутагдал илэрч байна. Тухайлбал:

Мөрдөгдөж буй хууль эрхийн акт, дүрэм журмыг үйлдвэрлэгч, борлуулагчид жигд мөрдөхгүй байгаагаас чанарын шаардлага хангахгүй хүнс үйлдвэрлэх, тээвэрлэлт, хадгалалтын үед муутгаж хүний эрүүл мэнд, улс орны эдийн засагт үлэмж хохирол учруулах явдал гарсаар байна.

Хүнсний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага сул, хохирлыг эдийн засагтай нь холбож тооцох механизм төгөлдөр болж чадаагүй байна. Ер нь хүнсний чанар, аюулгүй байдлын асуудал, ялангуяа хүнсний зүйлд тавигдах эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага, норм, нормативыг аж ахуйн нэгж, байгууллагууд өөрсдийхөө өсч хөгжих гол үзүүлэлт гэж үзэхийн оронд нэгэн төрлийн “чөдөр, тушаа” мэтээр хандаж байна.

Хүнсний үйлдвэрүүдэд үйлдвэрлэлийн технологи зөрчигдөх, чанарын баталгаажилтгүй түүхий эдээр үйлдвэрлэл явуулах, мэргэжлийн ажилтан, ажилчид дутагдалтай, үйлдвэрлэлийн дотоодын хяналт сул, дотооддоо зохион бүтээсэн зарим тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нь техникийн болон эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал, гоо зүйн шаардлага хангахгүй байх, бүтээгдэхүүнд стандартын шаардлага хангасан хаяг шошго хэрэглэж хэвшээгүй зэрэг дутагдлууд оршсоор байна. Мөн зарим үйлдвэр, аж ахуйн нэгж зардлаа хэмнэх үүднээс зориулалтын тээврийн хэрэгсэл, үйлдвэрийн сав баглаа боодол, жижиглэн савлалтын дамжлагуудыг ашиглахгүй болсон, зориулалтын агуулах байхгүй, баталгаагүй жин хэмжүүр ашиглах болсон байна.

Бөөний болон жижиглэн худалдаа эрхэлдэг зарим аж ахуйн нэгж хадгалах хугацаа дууссан хүнсний бүтээгдэхүүнийг үнэ хямдруулан борлуулах, суурин нөхцөлд тээврийн зориулалтын төмөр чингэлэгт хүнсний бүтээгдэхүүн хадгалах, худалдаалах, түүхий эд, бэлэн болон хагас бэлэн бүтээгдэхүүнийг нэг дор хадгалах, хэмжилт буруу хийх, эрүүл ахуйн шаардлага хангаагүй, зөвшөөрөгдөөгүй байр, орчинд худалдаа явуулах зэрэг ноцтой зөрчлүүд үргэлжилсээр байна. Үүнээс болж хүнсний зүйлийн чанар алдагдаж, шимт чанар, тэжээллэг сайн бодис нь үгүй болох, улмаар хүний биед хор болдог хөгц, мөөгөнцөр үүссэн хүнсний зүйл хүмүүсийн хэрэгцээнд зориулагдаж байна.[64]

Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний зарим нэгжүүд зөвхөн байгууллагын явцуу эрх ашгаа хамгаалж, орлого хөөцөлдөх явдлыг урьтал болгож хадгалалтын хугацаа богинотой, түргэн гэмтэх хүнсний бүтээгдэхүүнийг эрүүл ахуйн шаардлага хангаагүй зориулалтын бус агуулах, төхөөрөмжид хадгалж, тээвэрлэн, худалдаалж байгаа нь хүн амын дунд хоол хүнсний хордлого, харшил гарах нөхцөлийг бүрдүүлж, хүний эрүүл мэнд, амь насанд аюул учруулж болзошгүй байна.

➔ Хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал.

Хоол хүнс хүрэлцээтэй байсан ч хэрэглэх хэмжээ, горим, түүний шимт чанар, эрүүл ахуй, аюулгүй байдлаас шалтгаалан элдэв өвчин, зовлон хүн төрөлхтөнд тохиолдсоор байна. Үүнээс үзэхэд эрүүл байхын үндэс нь чанартай, цэвэр ариун хүнсийг зохистой хэмжээгээр зөв хэрэглэх явдал юм.

2004 онд хийсэн УМХГ-ын хүнсний хяналт, шинжилгээнд 97451 дээжинд 238073 үзүүлэлт шинжлэгдсэний 16455 буюу 17% , хүнсний түүхий эдийн 463 дээжийн 182 буюу 39% нь тус тус бохирдолтой гарсан байна. Үүнээс хүнсний нян судлалын шинжилгээнд хамрагдсан нийт 70926 дээжийн 92.9% нь дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүн эзэлж байгаа ба нийт дээжийн 9.6% нь нянгийн бохирдолтой гарсан байна. Хүнсний химийн шинжилгээгээр 4.0%, хор судлалын шинжилгээгээр 10%, хүнд металлын шинжилгээгээр 0.9% нь тус тус бохирдолтой гарчээ. Үүнийг өмнөх онуудтай харьцуулахад химийн бохирдол 2002 оныхоос 2 дахин, хор судлалын шинжилгээгээр бохирдолтой дээжийн хувь 2000 оныхоос 0.2%-аар, 2002 оныхоос 0.8%-аар, нянгийн бохирдол 2000 оныхоос 0.2-аар, 2002 оныхоос 8%-аар, хүнд металлын бохирдол 2000 оныхоос 0.5-аар тус тус өссөн байна.¹⁰ (Хүснэгт 2.3.1.)

¹⁰ УМХГ-ын Хүнсний хяналтын 2004 оны тайлангаас

Хүснэгт 2.3.1. Хүнсний бүтээгдэхүүний бохирдлын түвшин

Он	Хими	Хор судлал	Нян	Хүнд металл
2000		0.8%	9.4%	0.4%
2002	2.0%	0.2%	1.6%	
2004	4.0%	1.0%	9.6%	0.9%

Хүнсний бүтээгдэхүүний хор судлалын шинжилгээгээр ихэвчлэн элэгний хорт хавдрын гол шалтгаан болдог хөгц мөөгөнцрийн хорыг тодорхойлдог бөгөөд энэ үзүүлэлт сүүлийн жилд ихсэх хандлагатай байгаа нь хорт хавдрын ихсэхэд нөлөөлж болох талтай.

Нэгдсэн төв лабораторийн хөгц мөөгөнцрийн шинжилгээнд 1040 дээж хамрагдсаны 6.8% нь хөгц мөөгөнцрийн бохирдолтой гарсны дотор цай, кофе, какао, үр тариа, улаан буудайн дээж хамгийн их бохирдолтой гарчээ. Хорт хавдар үүсгэх, үр хөврөл гэмтээх, удамшилд аюул учруулах өвчин үүсгэдэг 150 гаруй хөгц мөөгөнцөр байдгаас өнөөгийн байдлаар лабораторийн шинжилгээгээр зөвхөн 13 төрлийн хөгцийг хоол хүнснээс илрүүлж чадаж байна.

НМХГ-ын Төв лабораторийн дүнгээр 2004 онд нян судлалын шинжилгээнд хамрагдсан хүнсний бүтээгдэхүүний нийт 5609 дээжийн 2059 буюу 36.7% нь нян судлалын үзүүлэлтээр хүнсний аюулгүй байдлын шаарлага хангаагүйн дотор 65.6%-д нь нянгийн ерөнхий тоо зөвшөөрөгдөх дээд хэмжээ(ЗДХ)-ээс хэтэрсэн, 20.9%-д E.coli (гэдэсний савханцар), 3.2%-д бацилус цереус (Bacillus cereus) 1.2%-д стафилококк ауриус(Staphylococcus aureus), махан консервийн 3 дээжинд энтерококк (Enterococcus) нянгийн бохирдолтой илэрсэн байна. Эдгээр нянгууд нь бүгд гэдэсний халдварт өвчин үүсгэгчид бөгөөд үүнээс Bacillus Cereus нь хиам, махан бүтээгдэхүүнээр, Staphyl. Aureus нян нь өндөг, кремтэй болон нөөшилсөн бүтээгдэхүүнээр дамжиж хүний биед нянгийн гаралтай хоолны хордлого үүсгэдэг. Нянгийн бохирдолтой бүтээгдэхүүнийг хүнсний нэр төрлөөр нь судлахад шоколадан болон кремтэй бүтээгдэхүүн, бэлэн хоол болон гоймон, сүү, сүүн бүтээгдэхүүний 50.3-56.4% нь тус тус, хиам, хиаман бүтээгдэхүүний болон ундны ба зөөлрүүлсэн усны 34.2-34.7% нь тус тус нянгийн бохирдолтой гарчээ.¹¹


Хүнсний бүтээгдэхүүний хүнсний аюулгүй байдлын үзүүлэлтүүд өмнөх онуудтай харьцуулахад ерөнхийдөө өссөн байгаа нь хүн амын хүнсний аюулгүй байдал алдагдаж, улмаар хоол хүнсээр дамжих өвчлөл ихсэхэд шууд нөлөөлж байна.

УМХГ-ын мэдээгээр хүнсний аюулгүй байдлын шаардлага хангаагүй 7578 ширхэг, 2091060.1 л, 671620.2 кг хүнсний бүтээгдэхүүнийг хүн амын хүнсний хэрэгцээнээс хасч устгах арга хэмжээ авчээ. Тэгвэл өмнөх жилүүдийн устгасан хүнсний бүтээгдэхүүнийг мөнгөн дүнгээр илэрхийлбэл 1997 онд 19.5 сая төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг хүн амын хүнсний хэрэгцээнээс хасч устгаж байсан бол 2003 онд 231.5 сая төгрөг болж даруй 11.9 дахин өссөн байна. (Зураг2.3.2.)

Хүнсний бүтээгдэхүүний бохирдол сүүлийн жилүүдэд өсч, хүнсний аюулгүй байдал ийнхүү алдагдаж байгаа нь хэрэгцээнд тохирохгүй хүнсний бүтээгдэхүүнийг устгаж, хэрэглээнээс хасах зэргээр зах зээлийн эдийн засгийн үргүй зардлыг ихэсгэж улс орны үндэсний ашиг сонирхолд ихээхэн хохирол учруулж байна. Нөгөө талаар хүн амын эрүүл мэндийг хохироохын эсрэг тэмцэж буй арга, хэлбэр ч гэж үзэж болох юм.

¹¹ НМХГ-ын Төв лабораторийн Эрүүл зүйн нян судлалын лабораторийн 2004 оны жилийн эцсийн тайлан

Зураг 2.3.2. Хүнсний хэрэгцээнээс хасч устгасан хүнсний бүтээгдэхүүн, төгрөгөөр



➔ **Мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийн чанар, аюулгүй байдал.**

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийг багасгах, хүн амын физиологийн хэрэгцээг хангахуйц амин дэм, уураг, бичил махбодиор баялаг хоол хүнсээр хангах зорилтыг хэрэгжүүлэхэд мал сүргийн эрүүл мэндийг хамгаалах, малаас хүн дамжин халдварладаг элдэв өвчнөөс эрүүлжүүлэх явдал шийдвэрлэх ач холбогдолтой.

Дэлхийн ХХААБ-аас гаргасан мэдээгээр мал амьтны гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүнээр хүнд дамжин халдварладаг 150 гаруй өвчин тэмдэглэгдсэнээс манай орны малд бруцеллэз, боом, ям сүрьеэ зэрэг өвчний өвчлөл өндөр байна.

Манай улсад Мал, амьтны эрүүл мэндийн олон улсын байгууллагын “А” ангиллын гоц халдварт өвчнүүд сүүлийн 20 гаруй жил илрээгүй байна. Иймд манай мал сүрэг ихэнх гоц халдварт өвчний эсрэг өвөрмөц хамгаалалтын дархлаагүй болж байна. Гадаад худалдаа, аялал, жуулчлал, иргэдийн зорчих хөдөлгөөн өргөжиж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэд гадаадаас мал, амьтан, мах, махан бүтээгдэхүүн, түүхий эд импортлох нь ихэслээ. Энэ нь хилийн чанадаас мал, амьтны гоц халдварт өвчнүүд орж ирэх, тархан дэлгэрэх нөхцөлийг эрс нэмэгдүүлж байна.

Малын халдварт болон шимэгчээр халдварлах өвчлөлийн хэмжээ жилээс жилд нэмэгдэж байна. Тухайлбал, мал сүрэгт сүүлийн 10 жилд цусан халдвар, бруцеллэз, галзуу, сүрьеэ, адууны халдварт цус багасах өвчний гаралт 1.2-19.2 дахин өсч, халдварт өвчнөөр хорогдсон малын тоо нийт хорогдлын 30 хувийг эзэлж байна. Малаас хүнд халдварладаг бруцеллэз, сүрьеэ, ям, лейкоз зэрэг өвчнийг оношлох шинжилгээг зохих ёсоор хийхгүй байгаагаас эдгээр өвчнийг хянаж чадахгүй байна.

Манай орны хувьд хүн амын хоол хүнсний зүйлд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн зонхилж байгаа нөхцөлд мал, амьтны мах, сүүгээр дамжин хүний эрүүл мэндэд хожмын нөхөгдөшгүй уршиг учруулдаг хор нөлөө бүхий антибиотик, даавар, хөгцний зүйл, түүний хорын түвшинг стандартаар зохицуулж тодорхойлох асуудал манайд хийгдэхгүй байна.

Мал, амьтан, бүтээгдэхүүний олон улсын худалдаанд үндэсний мал эмнэлгийн байгууллагаар үнэн зөв баталгаажуулалт хийлгэдэг болгохын тулд Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орнуудын үндэсний мал эмнэлгийн албыг магадлан итгэмжлэл олгодог тогтолцоонд дэлхий нийтээрээ шилжихээр бэлтгэж байгаа энэ үед манай улсад үндэсний мал эмнэлгийн тогтолцоо бүрдээгүй, малын өвчлөлийн байдалд болон мал, амьтан, бүтээгдэхүүн, түүхий эдэд ариун цэврийн хяналт шинжилгээ хийгдэхгүй, мал эмнэлгийн байгууллага, мэргэжилтний мэдлэг, нэр хүнд ч сайнгүй байна.[6]

Худалдан борлуулж байгаа нийт махны 25% нь мал эмнэлгийн шинжилгээнд хамрагдаагүй, мах худалдан борлуулах зах, худалдааны цэг, салбаруудын 40 орчим хувь нь ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангаагүй ил задгай хог, шороо тоостой

бохир орчинд, хөргөлтийн тоног төхөөрөмжгүй, худалдан борлуулагчид зориулалтын хувцас хэрэглэлгүйгээр худалдаалж байна.[47(2)]

Мал, амьтны гаралтай мах, сүү, өндөг зэрэг түүхий эдүүдийг мал-эмнэлгийн үзлэг шинжилгээнд тэр бүр бүрэн хамруулж чадахгүй байгаа бөгөөд үзлэг шинжилгээг иж бүрэн хийж чадахгүй зөвхөн мэдрэхүйн эрхтнээр үнэлгээ өгч дүгнэлт гаргаж байгаа дутагдал ажиглагдаж байна. Мах, сүүг гол төлөв үйлдвэрийн боловсруулалт хийлгүйгээр хүн амд худалдаалдаг. Ялангуяа ямар ч хяналт, шинжилгээнд хамрагдаагүй түүхий сүүг Улаанбаатар хот, хүн ам олноор төлвөрсөн хот, суурин газруудын гудамж талбайд ил задгай ямар ч зориулалтын байр, хөргөлтийн тоног төхөөрөмжгүй нөхцөлд, цэвэрлэгээ ариутгал хийгдээгүй сав суулганд, анхан шатны боловсруулалт хийгдэлгүйгээр, эрүүл мэндийн шинжилгээнд хамрагдаагүй хүний гар дээрээс худалдаалагдаж байна. Ийм сүү нь чанарын ямар ч баталгаагүй байх бөгөөд тэр нь ихэвчлэн малын мах, сүүгээр дамжих хүний биед халдварладаг бруцеллёз, сүрьеэ, лейкоз зэрэг өвчний үүсгэгчийг агуулдаг, ариутгаж, цэвэрлээгүй сав суулга, ил задгай газрын тоос, шорооноос бохирдсон, эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамрагдаагүй худалдан борлуулагчаас элдэв өвчин үүсгэгчээр давхар бохирдон, хөргүүргүй халуун дулаан нөхцөлд тэдгээр өвчин үүсгэгчүүд хэд дахин үржиж, улмаар ийм сүүг боловсруулалгүй шууд амсах төдийд хүний биед элдэв өвчин үүсгэгчид орж халдварт өвчин тархаах гол хүчин зүйл болдог байна.

Гар дээрээс зарагдаж байгаа сүү нь хувиараа мал аж ахуй эрхэлж буй хувь хүмүүсийн гэрийн нөхцөлд сааж, бэлтгэсэн сүү байдаг бөгөөд тэдний зарим нь сүүний тосыг нь машиндах буюу хөөрүүлж аваад, үлдсэн шингэн сүүг ус, түүхий гурил зэргийг хольж арвижуулан, өтгөрүүлж зардаг байна. Мөн зах, лангуун дээр худалдаалагдаж буй ихэнх ааруул, хуруудыг мөн шар усыг гүйцэт аваагүй аарц нэртэй цагаанд түүхий гурил хольсон байдаг аж. Судлаачдийн үзэж буйгаар түүхий гурил нь сүүний сахартай холилдохоороо сахрын этилийн спирт үүсэх процессыг улам түргэсгэж, улмаар улаан хоолой, ходоодны хорт хавдар үүсгэдэг байна.¹²

Мөн мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээр үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж байгаа шалгалтанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн 62.7% нь хууль тогтоомж, дүрэм заавар зөрчсөн, үүнээс 28.2% нь ямар нэг байдлаар стандарт, ариун цэвэр, эрүүл ахуйн хэм хэмжээг хангаагүй орчинд үйл ажиллагаа явуулдаг байна. Тэрчлэн тухайн аж ахуйн нэгжүүдийн ажилтан ажилчид, удирдлагууд уг үйлдвэрлэлд тавигдах наад захын дүрэм журам, стандартын үзүүлэлтүүдийн талаар тун хангалтгүй ойлголт мэдлэгтэй байдаг. Түүгээр ч барахгүй “Хэрэглэгчийн найдвартай түнш” байгууллагын бүтээгдэхүүн технологи, стандартын шаардлага хангадаггүй явдал ч байна.[64]

➔ Ургамлын гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдал.

Ургамлын гаралтай бүтээгдэхүүний түүхий эдэд ургамал, хорио цээрийн шинжилгээгээр илрүүлдэг хог ургамал, ургамлын өвчин, хөгц мөөгөнцөр, хортон шавьж, мэрэгч зэрэг нь түүхий эдийг бохирдуулснаар бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж, үр тарианы гарцыг эрс бууруулдаг байна.

УМХГ-ын Нэгдсэн төв лабораторийн Таримал ургамлын үр, хорио цээрийн хяналтын лабораторийн 2004 оны тайлангийн мэдээгээр 10 аймаг, 86 аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн 13103.9тн үр, үрийн материалыг төлөөлөх 592 дээжинд шинжилгээ хийсний дотор тарих үрийн 566, технологийн 3, хүнсний буудайн 11 дээжийг шинжлэхэд 97.8% нь стандарт, чанарын шаардлага хангаагүй байна.

2005 онд тариалах улаан буудайн 3559.7 тоннын арвайн 163, 47.4 тоннын 2, овъёосны 81.4 тоннын 4, хөх тарианы 11.8 тоннын 1, төмсний 203 тоннын 2, хүнсний ногооны 11 төрлийн 2.05 тн 26 дээж шинжлэгдсэний 57 дээж буюу 62% нь стандартын шаардлага хангаагүй байна.

Ургамлын хорио цээрийн шинжилгээг дотоодын үйлдвэрлэлийн 12978.2 тн бүтээгдэхүүнийг төлөөлөх 14 нэрийн 162, импортын 134826.9 тн бүтээгдэхүүнийг төлөөлөх 54 нэрийн 2013, экспортын 17454.3 тн бүтээгдэхүүнийг төлөөлөх 15 нэрийн

¹² Д.Пүрвээ, Сүү, цагаан идээний үйлдвэрлэлийн “Сангийн далай” ТББ

225 дээж буюу нийт 2400 дээжинд хог ургамал, хөнөөлт шавьж, ургамлын өвчин, хорт бодисын үлдэцийг илрүүлж, тодорхойлох шинжилгээ хийхэд 1401 дээж буюу 58.3% нь гадаад болон дотоод хорио цээртэй хог ургамлын үр, ногоон, ягаан хөгц, шимэгчдийн үршил, хатуу харуу өвчин, агуулахын хачиг, номын бөөс зэрэг нь амьд, үхсэн хэлбэрээр илэрч стандартын шаардлага хангаагүй байна.

Шинжилгээгээр улсын нөөцийн агуулахад хадгалагдаж байгаа 9750.1 тн үр тариаг төлөөлөх 120 дээжинд 3 төрлийн хог ургамал 2450 ш/кг хүртэл хэмжээгээр, 5 төрлийн ургамлын өвчин 1-49% хувь хүртэл, агуулахын хачиг амьд, үхсэн хэлбэрээр, номын бөөс зэрэг хөнөөлт шавьж илэрчээ.

➤ **Импортын хүнсний аюулгүй байдал.**

2003 онд 31 улсаас 27 төрлийн 146 нэрийн 81.138.2 тн хүнсний бүтээгдэхүүнийг импортолсны дөнгөж 16.4% нь лабораторийн шинжилгээнд хамрагджээ. Эдгээрээс химийн шинжилгээгээр шинжилгээнд хамрагдсан хүнсний бүтээгдэхүүний 31.2%, хор судлалын шинжилгээгээр 0.6%, нян судлалын шинжилгээгээр 5.3% нь хүнсний аюулгүй байдлын шаардлага хангаагүй байна. Давхардсан тоогоор 64 аж ахуйн нэгжийн 207 импортын согтууруулах ундааг шинжлэхэд 7.0% нь эрүүл ахуйн шаардлага хангаагүй байна.

2004 оны эхний хагас жилийн байдлаар УМХГ-ын харьяа 23 лабораторит хийсэн шинжилгээгээр 53472 хүнсний бүтээгдэхүүнд шинжилгээ хийсний 18% нь импортын хүнсний бүтээгдэхүүн эзэлж байгаа ба 120741 үзүүлэлтээр шинжилсний 16.7% нь чанар, аюулгүй байдлын шаардлага хангаагүй байна. Төрөлжсөн 6 лабораторит хийгдсэн шинжилгээний үзүүлэлтээр хөгц мөөгөнцрийн лабораторийн шинжилсэн сорьцын 18.9% хөгц мөөгөнцөрөөр бохирдсон байсан ба үүнийг хүнсний нэр төрлөөр нь авч үзэхэд цай кофе, какаоны 16.7%, жимс, жимсгэний 11%, бусад бүтээгдэхүүний 38.5%-д нь бохирдол илэрсэн байна. Хөгц мөөгөнцөрөөр бохирдсон хүнсний зүйлийг хэрэглэснээр хорт хавдар үүсгэдгийг дээр дурьдсан билээ.[48]

Нийт импортлогдож буй төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний 80 гаруй хувийг БНХАУ-аас оруулж байна. Тэдгээр нь ургамал, хорио цээрийн талаас төдийлөн их бохирдолтой гардаггүй ч 2002 оны байдлаар Улаанбаатар хотын хүнсний захуудад худалдаалагдаж байсан хүнсний ногоо, жимсийг Нийслэлийн ЭАХСХА-д шинжлэхэд тэдгээрээс авсан нийт 170 сорьцын 4.1%-д нь нитратын агууламж ЗДХ-ээс их илэрч байсан тохиолдол байдаг.[44(18)]

Нитрат нь хүний биед хорт хавдар үүсгэдэг нитрозаминуудын урьдал нэгдэл болдог бөгөөд орчин үед хорт хавдар үүсгэдэг 100 гаруй нитрозонэгдлүүдийг судалсны зарим нь ходоодонд сонгомлоор үйлчилдэг болохыг нотолжээ. Мөн онд НЭМХ-ээс явуулсан судалгаагаар БНХАУ-аас импортолсон хүнсний ногооны 113 дээжийн 33 буюу 29.2% нь нитратыг ЗДХ-ээс ихээр агуулсны дотор төмсний дээж хамгийн их хувийг буюу 42.4%-ийг эзэлж, түүний дараа лууван (36.4%), байцаа (15.1%) зэрэг нь нитратын бохирдолт ихтэй байв. Нитратыг ЗДХ-ээс ихээр агуулж байсан жимсний 5 дээж(нийт 61 дээжийн 8.2%)-ийн дотор алим хамгийн их хувийг (60%) эзэлж байв. Хятад улсаас импортолсон хүнсний ногооны нитратын агууламжийг өөрийн орны хүнсний ногооныхтой харьцуулахад төмс, байцаа, лууван, булцуут сонгино дахь нитратын агууламж манай орны мөн нэрийн ногооныхоос өндөр, манжингийнх бага агууламжтай байв.[49(5)]

Дээрх нөхцөл байдлаас үүдэн Хятадаас оруулж ирдэг төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний ургамлын хорио цээрийн нөхцөлийг тохиролцсон байдаг. Гэтэл БНХАУ манайд экспортолж буй гурил, будаа, элсэн чихрийн нөхцөлөө тохиролцоогүй, чөлөөтэй оруулж ирж байна. ХАБХААХХ нь импортын бүтээгдэхүүн тус бүрээр мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн нөхцөлийг тохиролцохын тулд эрсдлийн үнэлгээ хийдэг бөгөөд Европын холбооны улс Монголоос зөвхөн мах авахын тулд судалгааны 74 хуудас материал ирүүлдэг. Гэтэл Европын холбооны улсуудын бүтээгдэхүүн манайд чөлөөтэй орж ирж байна.[64]

Энэ мэт ухамсар дорой хүнс импортлогч, үйлдвэрлэгчдийн бэлтгэсэн хүнсийг хэрэглэсэн хүн амын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдалд ихээхэн хор хохирол учруулсаар байна.

2004 онд АНУ-ын тусламжаар импортлогдсон 48000 мян. тн улаанбуудайнаас 0.1% хог ургамал илэрчээ. Мөн Япон улсын буцалтгүй тусламжаар импортлогдсон 19.0 мян. тн улаанбуудайг ХХААЯ-ны Сэлэнгэ, Хөтлийн салбарт хүлээн авахад 14-15 төрлийн хог ургамал илэрч байжээ.

2004 оны 11-р сараас ХХААЯ “Дэлхийн зөн-Монгол” ОУ-ын байгууллагатай буцалтгүй тусламжийн цагаан будааны төсөл хөтөлбөр хэрэгжүүлж эхлээд 2005 оны 1-р сард тус байгууллагын тусламжаар импортолсон 2700 тн цагаан будааны дээжинд агуулахын хортон шавьж илэрсэн байна. Энэ нь “Ургамал хамгааллын тухай” хуулийн 3.10.3 дахь заалт, “Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай” хуулийн 7.1.5 дахь заалтыг зөрчиж байгаа тул хуулийн дагуу буцаан гаргахыг хуулинд зааж өгсөн байдаг. Уг будааг УМХГ-ын ХМХА-наас буцаахыг шаардсан байна.¹³

Энэ мэт манай улсын ядуурал, ажилгүйдэл болон байгалийн гамшгийн улмаас бий болсон хоол хүнсний хомсдлыг бууруулах, энэ хүнд нөхцөлөөс гарахад олон улсын хүмүүнлэгийн буцалтгүй тусламж нь гол үүрэг роль эзэлж байгаа хэдий ч энэ эргээд манай улсын хүнсний аюулгүй байдалд нөлөөлөхөөргүй байх олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг зарим үед зөрчигдөж байдгийн нэг жишээ энэ болой.

◆ Хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээний эрүүл ахуй, халдвар хамгааллын байдал.

УМХГ-ын 2004 оны 1-р улирлын хүнсний эрүүл ахуйн хяналт шалгалтанд хамрагдсан нийт байгууллагын 36.2% нь хүнсний дэлгүүр, 34.5% нь хоол үйлдвэрлэл, 4.1% нь гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэр, үдсэн хувь нь архи, пиво, ус, ундаа, сүү, сүүн бүтээгдэхүүн, мах, махан бүтээгдэхүүн, талх, талхан бүтээгдэхүүний үйлдвэр болон хүнсний төв (супермаркет), агуулах эзэлж байна.

Дээрх объектуудад хийсэн шалгалтаар илрүүлсэн нийт 14 зөрчлийн дотор ажиллагсдын хувийн ариун цэвэр, ажлын хувцас хэрэгсэл, эрүүл мэндийн байдлын зөрчил 22.6%, чанар, аюулгүй байдлын шаардлагад нийцэхгүй болон нийцсэн эсэх нь тогтоогдоогүй бүтээгдэхүүнээр үйлдвэрлэл, үйлчилгээ явуулсан зөрчил 15.8%, гадна орчны тохижилт, хог хаягдлыг тээвэрлэж, зайлуулахтай холбоотой зөрчил 11.1%, үйлдвэрлэлийн байр, тоног төхөөрөмж, сав суулгыг угааж халдваргүйжүүлэх горим алдагдсан зөрчил 10.1%, түүхий эд, бэлэн бүтээгдэхүүн хадгалах, үйлдвэрлэх, борлуулахад тавигдах эрүүл ахуйн хэм, хэмжээ, температурын горимын зөрчил 8.2%, хүнсний, түүхий эд, бүтээгдэхүүн тээвэрлэх тээвэрлэлтийн горим зөрчигдсөн зөрчил болон инженерийн шугам сүлжээ, халаалт, салхивчийн төхөөрөмж шаардлага хангаагүй зөрчил тус тус 6.6% эзэлж, эдгээр нь хамгийн их анхаарал татаж байна. Дээрх зөрчил дутагдлууд нь хүнс бохирдож, улмаар хүнсээр дамжих өвчин, хордлого гарах нөхцөлийг бүрдүүлдэг байна.

2001 онд Улс, нийслэлийн эрүүл мэндийн хяналтын албадаас хиам, махан бүтээгдэхүүний үйлдвэрүүдэд аюулын дүн шинжилгээ, хяналтын эгзэгтэй цэг(НАССР)-ийн зарчмуудад үндэслэн хяналт, судалгаа хийхэд ажлын байрны эрүүл ахуйн нөхцөлийн хувьд зориулалтын байргүй нь 48.7%, хэрэглээний халуун, хүйтэн цэвэр усны төвлөрсөн систем, төвийн бохир зайлуулах татуургад холбогдоогүй 14%, үйлдвэрлэлийн технологи урсгал буруу 39.5%, түүхий эд бэлтгэх өрөөгүй 25.6%, агуулахгүй 21.8%, бэлэн бүтээгдэхүүнийг хадгалах өрөөнд бичил цаг уурын хэмжилт хийхэд шаардлага хангаагүй үйлдвэр 76% тус тус эзэлж хүнсний эрүүл ахуйн шаардлага хангаагүй нөхцөлд хүнсний үйлдвэрлэл явуулж, хүнсний аюулгүй байдлыг алдагдуулж байлаа. Дээрх нөхцөл байдалд үйлдвэрлэгдсэн хиам, махан бүтээгдэхүүн нь ботулизм болон *Vac.cereus*-ээр үүсгэгдсэн хоолны хордлого үүсгэх магадлал өндөр байдаг.[44(18)]

¹³ УМХГ-ын ХМХА-ны дүгнэлтийг хавсаргав.

2002 онд нийслэлийн 6 дүүргийн хиам, махан бүтээгдэхүүний 53 үйлдвэрт НАССР-ын шалгалт хийж өмнөх оныхтой харьцуулахад эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байртай үйлдвэрийн тоо 4.6%-аар, тоног, төхөөрөмж, технологийн хувьд шаардлага хангаж байгаа үйлдвэрийн тоо 3.6%-аар, угаалга, цэвэрлэгээ, ариун цэврийн нөхцөл нь сайжирсан үйлдвэрийн тоо 2.7%-аар тус тус нэмэгдсэн байна.

2003 оны эхний 6 сарын байдлаар нийслэлийн хүнсний 16 худалдааны төв, зах ажиллаж байгаагийн 60 гаруй хувь нь зориулалтын бус байртай, 27% нь ажилчдын хувцас солих өрөөгүй, 47% нь агаарын температурыг зохицуулах төхөөрөмжгүй, 20% нь онцгой түргэн гэмтэх хүнсний бүтээгдэхүүнийг хадгалалх хөргүүргүй нөхцөлд худалдаалж байв.

Улаанбаатар хотод 2003 оны байдлаар хүнсний чиглэлийн ажил, үйлчилгээ эрхэлж буй 7085 объектын 26%-ийг түргэн үйлчилгээний цэг (ТҮЦ), 3.3%-ийг чингэлэг эзэлж байгаа нь хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын баталгаа алдагдах, улмаар хүн амын дунд халдварт өвчин нэмэгдэх гол хүчин зүйл болж байна.

➤ Хоол хүнсээр дамжих өвчин эмгэгийн байдал.

Хоол хүнсээр дамжих өвчний тандалт нь хүнсний бүтээгдэхүүнтэй холбоотой эрсдлийг бууруулахад тухайн орны үндэсний хэмжээнд баримтлах стратеги бодлогыг боловсруулах үндэс болдог байна.

Хоол хүнсний чанар доголдол, бохирдол, шимт бодисын дутагдалтай холбоотой үүсэх үр дагавар нь эрүүл мэндийн ба эдийн засгийн үзүүлэлтээр илэрч байна. Хүнсний бохирдолтой холбоотой ихэнх өвчнүүд ялангуяа гэдэсний суулгалт өвчин нь хүмүүст тэртээ тэргүй хомс байгаа хоол хүнсийг ашиглах, шингээх, боловсруулах чадварт муугаар нөлөөлж, бодисын солилцоог өөрчилсөөр хоол тэжээлийн дутагдалд орох нөхцөлийг улам бүр бүрдүүлж байна.

Сүүлийн жилүүдэд улсын хэмжээнд гарсан халдварт өвчнийг авч үзэхэд: 2001 онд халдварт өвчний нийт 51668 тохиолдол гарсны 23.5%, 2002 онд 37741 тохиолдол гарсны 30.2%, 2003 оны эхний хагас жилийн байдлаар 14757 тохиолдол гарсны 25.1%-ийг тус тус гэдэсний халдварт өвчин эзэлж байна.[36]

2003 он болон 2004 оны хагас жилд бүртгэгдсэн гэдэсний халдварт өвчнүүдийг сүүлийн 5 жилийн дундажтай харьцуулахад 2004 онд гэдэсний балнад өвчнөөр 4 хүн өвчилсөн нь 5 жилийн дунджаас 2-оор багассан боловч өмнөх оноос 1-ээр нэмэгдсэн байна. 2004 онд сальмонеллэзын өвчлөл буурсан боловч харин цусан суулгаар 1171 хүн өвчилж 10000 хүн амд ногдох өвчлөл 4.7 байгаа нь өмнөх онуудаас 0.6-0.7%-оор нэмэгдсэн ба бусад гэдэсний халдварт өвчнүүдээс хамгийн өндөр өвчлөлтэй байна. (Хүснэгт 2.3.2.)

Гэдэсний халдварт өвчнүүдийн үүсгэгчийг эмнэл зүйн лабораторийн шинжилгээгээр тодорхойлж байгаа боловч эх үүсвэр, тархах замыг нарийвчлан тогтоосон эпидемиологийн (тархвар зүйн) тандалт судалгаа тэр бүр байдаггүй байна.

2004 онд нянгийн гаралтай хоолны хордлогод 236 хүн өртсөн нь 10000 хүн амд 0.9% болж, сүүлийн 5 жилийн дунджаас даруй 3 дахин нэмэгдсэн байна. Тухайн онд гарсан хордлогод өртсөн нийт хүн амын 93.2% буюу 220 хүн бялуунаас үүдсэн хордлогын нэг удаагийн тохиолдолд хамрагдсан хүмүүс юм. Уг хоолны хордлого нь 2004 оны 5 дугаар сарын сүүлээр Улаанбаатар хотод гарсан нянгийн гаралтай хордлогын томоохон тохиолдол байсан ба хордлогын шалтгаан нь бялууны найрлагад ордог сүүн кремэнд агуулагдаж байсан нянгаар үүсгэгдсэнийг тогтоосон байна.

Манай улсад хоолны хордлогын бүртгэл, мэдээлэл цэгцтэй бус, зөвхөн олныг хамарсан хордлого, халдварууд мэдээлэгдэн оношлогдож, гэр бүлийн хүрээнд ганц нэг хүнд тохиолдсон өвчлөл, суулгалт халдвар үндсэндээ мэдээлэгдэхгүй байна.



Хүснэгт 2.3.2. 2003, 2004 оны эхний 6 сард бүртгэгдсэн гэдэсний халдварт өвчний харьцуулсан үзүүлэлт (Бодит тоо, 10 000 хүн амд)

№	Гэдэсний өвчнүүд	2003		2004		Сүүлийн 5 жилийн дундаж	
		Б/ тоо	10000-д	Б/ тоо	10000-д	Б/ тоо	10000-д
1.	Балнад	3	0.0	4	0.0	6	0.0
2.	Сальмонеллөз	94	0.4	89	0.4	112	0.5
3.	Цусан суулга	985	4.0	1171	4.7	984	4.1
4.	Хүнсний гаралтай бактерт хордлого	7	0.0	236	0.9	64	0.3
5.	Халдварын гаралтай суулгалт	38	0.2	17	0.1	24	0.1

Химийн гаралтай хоолны хурц хордлогууд манай оронд ослын байдлаар үе үе ихээр тохиолдож байна. Тухайлбал, импортын төмсөнд ДДТ пестицид(хортон шавьж устгадаг химийн хортой бодис)-ын үлдэгдэл ЗДХ-ээс их байснаас цэцэрлэгийн ангийн 27 хүүхэд хордсон тохиолдол байдаг бол ахуйн нөхцөлд нитритийн давс андуурч хэрэглэснээс нитритийн хордлого гарч байсан тохиолдол цөөнгүй байдаг.

2003 оны байдлаар улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт нас барсан хүний тоог үхэлд хүргэсэн өвчнөөр нь жагсаахад хавдар нас баралтын 2 дахь гол шалтгаан болж, хоол боловсруулах эрхтний өвчин 5 дугаарт орж байна.

Сүүлийн жилүүдэд манай улсад хавдрын өвчлөл дотроос элэгний хорт хавдрын өвчлөл тэргүүлэх байрыг тогтмол эзэлж байна. Анх оношлогдсон элэгний хорт хавдар 100'000 хүн амд 1996 онд 40.2 байсан бол 2000 онд 47.3 болж жил тутам 100'000 хүн амд 1.5-2.6-аар өссөн бөгөөд үүнийг насны байдлаар авч үзвэл 39 хүртэлх насны хүмүүст 3.3-4.2% болж тогтвортой өндөр байгаа нь хүнсний хор судлалын шинжилгээний үзүүлэлттэй шууд хамааралтай байна. Сүүлийн 5 жилийн судалгаагаар анх оношлогдсон хорт хавдрын өвчлөлийг өвчний назологоор нь жагсаавал элэгний өмөн, ходоодны өмөн, уушигны өмөн, улаан хоолойн өмөн, хөхний өмөн гэсэн дараалалтайгаар тогтмол байрлаж байгаа нь хоол боловсруулах замын хавдрууд их байгааг харуулж байна.[45]

Иймд эрүүл мэндийн хяналт, судалгаа, эмнэл зүйн болон холбогдох байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулж, гэдэсний халдварт өвчин, ялангуяа хоолны хордлогын бүртгэл, мэдээллийн зохистой тогтолцоо бүрдүүлж, эдгээр эмгэгийн шалтгаан зүйн судалгааг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр явуулж, өвчлөлөөс сэргийлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах асуудал чухлаар тавигдаж байна.

ОИХ.МН
СУДАЛГААНЫ САН



2.4. Хоол тэжээл, түүний шимт чанартай холбоотой эрүүл мэндийн эрсдэл (Nutrition and Related Health Risks)

Хоол тэжээлийн дутагдал, илүүдэл нь хүн төрөлхтөнийг зовоож буй олон өвчин эмгэгийн шалтгаан болж байна. Хөгжингүй орнуудад хоол тэжээлийн илүүдлээс үүдэлтэй таргалах, даралт ихсэх, зүрх судасны өвчин элбэгшиж байхад хөгжиж буй орнуудад, хоол хүнсэнд агуулагдах шимт бодисын дутлын асуудал голлон тохиолдож байна.

Манай улсын хүн амын дунд хоол тэжээлийн дутал болон илүүдлээс үүдэлтэй эмгэгүүд аль аль нь тохиолдож байна. Хоол тэжээлийн дутал нь ихэвчлэн хүүхэд, эмэгтэйчүүд, эмзэг бүлгийнхний дунд уураг илчлэгийн дутал (УИД), цус багадалт, сульдаа, иод дутлын эмгэг (ИДЭ) зэрэг хэлбэрээр илэрч буй бол илүүдэл нь таргалалт, судасны хатуурал, цусны даралт ихдэх, харвалт, инсулин үл хамааралт чихрийн шижин, хавдар зэрэг хэлбэрээр тохиолдож байна.

Хоол тэжээлийн дутлын улмаас бага насны хүүхдийн оюуны болон биеийн хөгжил хоцорч улмаар тэдний ойлгох, санах, тогтоох чадвар аажим суларч, сурах чадварт сөргөөр нөлөөлдгийг дэлхий дахины олон судлаачид тогтоожээ. Мөн биеийн эсэргүүцэл сулран халдварт амархан өртөж олон дахин өвчлөх ба өвчин нь ужиг явцтай, дахих хандлагатай байдаг.

Цус багадалт, УИД, ИДЭ зэрэг нь ихэнхдээ хөнгөн, далд хэлбэрээр илэрдэг тул эцэг, эх, эмчийн анхаарал татахгүй, урьдчилан сэргийлэлт хийгдэлгүй байсаар ужигран эмчилгээ, сэргийлэлтийн зардал нэмэгдэн нийгэм, эдийн засагт ихээхэн хохирол учруулдаг байна.

2.4.1. Хоол тэжээлийн талаар төрөөс авч буй арга хэмжээ

◆ Төрийн бодлого, хууль эрх зүйн орчин

Хүн амын хоол тэжээлийн асуудал бол хүний өлсгөлөнгөөс ангид байх эрхтэй салшгүй холбоотой ойлголт мөн. Хүн амыг өлсгөлөнгөөс ангид байлгах эрхийг хэрэгжүүлэхийн тулд нэн тэргүүнд хүн амын хоол тэжээлийн тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлж, хоол тэжээлийн хэрэгцээг нарийн, зөв тогтоож өгснөөрөө уг хэрэгцээг хангахуйц хүрэлцээтэй, зохистой хоол хүнсээр хангах асуудал зүй ёсоор тавигдах ёстой.

Хүн амын хоол тэжээлийн талаарх манай улсын хууль, эрх зүйн гол баримт бичиг бол “Хүнсний тухай” хууль (1999 оны) юм. Уг хуулийн зорилгод хүн амын “хүнсний хэрэгцээг хангана” хэмээн дэвшүүлсэн санаа нь хүний бие махбодийн өсөлт хөгжилтийг хангах, илч зарцуулалтыг нөхөхөд шаардагдах шим тэжээл бүхий хүнсний түүхий эд, бэлдэц, хоол, идээ, ундаа, ундны усаар хангах гэсэн ойлголтыг багтааж байна. Хуулийн 5.1.7-д Засгийн газрын бүрэн эрхэд “хүн амын хүнсний бодит хэрэглээ, хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл, найрлага, шим тэжээлийн зохистой харьцаа болон зориулалтын хүнс хэрэглэгчийн хоолны нормын хангалтад судалгаа, дүгнэлт хийж, жил тутам УИХ-д мэдээлэх” гэсэн заалт оруулсан нь Засгийн газар нь хүнсэнд агуулагдах хүний бие махбодийн өсөлт хөгжилтийг хангах, илч зарцуулалтыг нөхөхөд шаардагдах шим тэжээлийн зохистой хэмжээ, харьцаа ямар түвшинд байгааг зөвхөн мэдээлэх үүрэг хүлээнэс бус харин түүнийг хэрхэн тогтоох, хүнсний бодит хэрэглээ, шимт чанарыг сайжруулах асуудлыг УИХ, Засгийн газрын бүрэн эрхэд тодорхой тусгаагүй байна.[17]

“Хүнсний тухай” уг хуулинд хоол тэжээлийн хэрэгцээг хангах ойлголтуудад зориулалтын хүнс, стратегийн хүнс, хүнсийг баяжуулах гэсэн асуудлууд орсон байна. “Зориулалтын хүнс”-ийг тус хуулийн 3.1.5-д “хүний эрхэлж байгаа хөдөлмөр, бие махбодийн онцлогт тохируулан, эсхүл эмчилгээний зориулалтаар тусгайлан бэлтгэсэн хүнсийг хэлнэ” хэмээн тодорхойлж, 5.1.7-д Засгийн газар зөвхөн уг асуудлыг судлахаас

өөр бусад зориулалтын хүнсийг хэрхэн бэлтгэж, хангах асуудлыг орхисноор зогсохгүй “зориулалтын хүнс хэрэглэгч” гэж хэн байхыг ч тодорхойлоогүй байна.

Мөн хуулийн 6.1.4-т Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийн хүрээнд: “хүнсний тэжээллэг чанарыг сайжруулах, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, уламжлалт болон дэвшилтэт технологийг нэвтрүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ” гэж заагаад үүнийг “хүнсийг баяжуулах” арга замаар хэрэгжүүлэхээр тусгажээ. “Хүнснийг баяжуулах” гэдгийг 3.1.7-д “хүний эрүүл мэндэд чухал шаардлагатай тухайн бүтээгдэхүүнд агуулагддаггүй, эсхүл боловсруулалтын явцад алдагддаг аминдэм, амин хүчил болон бичил бодисуудыг тусгай технологи, стандартын дагуу нэмэхийг хэлнэ” хэмээн тодорхойлж, 5.1.6-д Засгийн газар бүрэн эрхийнхээ хүрээнд “өргөн хэрэглээний хүнсийг баяжуулах үйлдвэрлэлийг дэмжиж, харин 6.2.3-т Төрийн захиргааны төв байгууллага бүрэн эрхийнхээ хүрээнд “хүнсийг баяжуулахад шаардлагатай бичил бодисын зохистой хэмжээг тогтооно” гэж тусгасан нь уг асуудлыг хэрхэн хэрэгжүүлэх ажлыг орхигдуулжээ.

Үүнээс гадна, чиглэсэн үйлчилгээтэй хүнсний бүтээгдэхүүн гэж юу болох, энэ талаар төрийн бодлого ямар байх асуудал энэхүү хуулинд үгүйлэгдэж байна. *Хүнснийг баяжуулах* гэдэг нь нэг ёсондоо “чиглэсэн үйлчилгээтэй хүнсний бүтээгдэхүүнийг үйлдвэрийн аргаар бий болгоно” гэсэн үг бөгөөд *чиглэсэн үйлчилгээтэй хүнсний бүтээгдэхүүн* гэж хүний бие махбодид бүхэлд нь, эсвэл тодорхой эрхтний үйл ажиллагааг дэмждэг, биологийн идэвхит нэгдэл, бичил бодис, амьд бичил биетэн агуулсан бүтээгдэхүүнийг хэлж байна.[38]

Мөн уг хуулинд хүүхдийн хоол тэжээлтэй холбоотой нэг ч заалт байхгүй байгаа нь хүүхдийн хоол тэжээл, түүний хангамж, хүрэлцээний асуудал үндсэндээ төрийн зохицуулах ёстой үүрэгт огт хамаарагдахгүй байна.

“Хүүхдийн эрхийг хамгаалах тухай” 1996 оны хуулийн 5 дугаар зүйлээр 2-т “Хүүхдийн эрүүл мэнд өсч бойжих, аюулгүй орчинд амьдрах, хүчирхийллээс ангид байх эрх”-ийг баталгаажуулж, хүүхдийг хувцас, хоол хүнс, ... зэргээр санаатай гачигдуулахыг хориглосон байна. Мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 4-ийн 3-т: “хүүхдийн өсөлт хөгжилт, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн баталгаат хоол хүнс ... зэргээр хангах асуудлыг хүүхдэд үзүүлэх нийгмийн халамжийн арга хэмжээнд тусгажээ.[21]

Манайд “бичил тэжээлийн өлсгөлөн”, түүний дотор Иод дутлын эмгэг бодитойгоор оршиж буйг төр онцгойлон анхаарч бодлого, хөтөлбөр хэрэгжүүлсний үр дүнд “Давс иоджуулж, иод дутлаас сэргийлэх тухай” хуулийг 2003 оны 10 дугаар сарын 10-ны өдөр баталж, иод дутлын эмгэгтэй тэмцэх үйл ажиллагааг хуулиар зохицуулжээ.

Монгол улсын засгийн газраас хүн амын хоол тэжээлийг төгөлдөржүүлэн сайжруулах замаар нялхас, 5 хүртэлх насны хүүхдийн өвчлөл, нас баралтыг бууруулж, дундаж наслалтыг уртасган, оюуны болон хөдөлмөрийн чадварыг нэмэгдүүлэн нийгэм, эдийн засгийн хөгжлийг хурдасгах бодлого баримталж байна.

Хүн амын хоол тэжээлийн байдлыг төрөөс баримтлах хэд хэдэн бодлого стратегид тусган хэрэгжүүлж байна.

2001 оны Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын Эрүүл мэндийн анхны тусламжийн хүрээнд хүн амын хоол тэжээлийн хэрэгцээг хангах арга замыг 4.1.4-т: “Хүүхдийг хөхөөр хооллох, гэр бүл, нийгмийн орчинд өсгөн бойжуулах, асран хамгаалах, эрүүл өсгөх таатай орчин бүрдүүлэн тэдний бие бялдар, оюун санаарын өсөлт, хөгжилтийг хангана” гэсэн заалт болон 4.1.13-т: “монгол хүн амьдралынхаа туршид тэжээллэг чанар бүхий аюулгүй, экологийн цэвэр хоол хүнсээр хангагдах, зөв хэрэглэх нөхцөлийг бүрдүүлнэ” гэсэн заалтуудаар хэрэгжүүлж байна.[8]

2003 оны Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогод хөдөө аж ахуй, газар тариалан болон хүнсний үйлдвэрлэлийн бодлогоор дамжуулж хүн амын хоол тэжээлийн байдлыг сайжруулах, тэжээллэг, чиглэсэн үйлчилгээтэй баяжуулсан хүнсний үйлдвэрлэлийг дэмжиж, хэрэгжүүлэх үйл ажиллагаанууд тусгагдсан байна. Тухайлбал: бодлогын чиглэлийн 7-ын 2-т: “Хүний биеийг бичил тэжээлийн дутлаас сэргийлэх, чиглэсэн үйлчилгээтэй, нярай, өсвөр насны хүүхдийн болон сувиллын хоол тэжээл, хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх

а/ баяжуулсан болон чиглэсэн үйлчилгээнтэй хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих” гэсэн үйл ажиллагаануудыг тусгаж хэрэгжүүлж байгаа аж.

2004 оны Монгол улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогын хүний амьдралын чанарыг сайжруулах талаар баримтлах үндсэн чиглэлд хоол хүнсний талаарх бодлогын арга хэмжээг дараахь байдлаар тусгажээ. Үүнд:

“3.6.1. Хүн амын хоол хүнсний хангамжийг сайжруулж, илчлэг, аминдэмээр баялаг экологийн цэвэр бүтээгдэхүүнээр ханах чиглэл баримтална.

3.6.2. Монгол хүний хоол хүнсний физиологийн нормыг нас, хүйс, ажил мэргэжлийн онцлог, нутаг дэвсгэр, уур амьсгалын онцлогтой уялдуулан тогтооно.

3.6.4. Бага насны хүүхэд, жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй эхчүүд, ахмад настан болон тусгай хоол, хүнс хэрэглэдэг хүн амын хоол хүнсийг үйлдвэрлэх, хадгалах, түгээх үйлчилгээний сүлжээг хөгжүүлнэ.

3.6.5. Хоолыг орлох, дутагдалтай эрдэс бодисыг нөхөх нэмэгдэл бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааг дэмжинэ.” [10]

➔ Төрөөс авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

Монгол улсын засгийн газар 1994 онд “Хүн амын хүнсний хангамжийг сайжруулах, монгол хүний хоол тэжээл” Үндэсний хөтөлбөрийг батлан хэрэгжүүлсэн хэдий ч улс орон төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих эхэн үеийн эдийн засгийн хямрал, хүн амын ядуурал, ажилгүйдэл болон бусад хүчин зүйлүүдээс шалтгаалан хөтөлбөрийн зарим зорилтууд хэрэгжиж чадаагүй байна. Иймд өнөөдөр манай улсын хүн амын хоол тэжээлийн бодит байдал нь нийгмийн тулгамдсан асуудлуудын нэг болсон хэвээр байна. Нөгөө талаар Монгол улсын Ерөнхий сайд 1996 онд Дэлхийн хүнсний дээд хэмжээний уулзалтад оролцож, монгол хүний хүнсний хангамж, хоол тэжээлийн бодит байдалд үнэлгээ өгч, хүн амыг хүнсээр хангах, өлсгөлөн, бичил бодис, аминдэмийн дутлаас урьдчилан сэргийлэх асуудлаар өөрийн орны гол бодлого, чиглэлийг тодорхойлж, үзэл бодлоо илэрхийлснийг үндэс болгон Монгол улсын Засгийн газар НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудын хооронд 1998 онд харилцан тохиролцож “Хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол тэжээл” ойлголцлын санамж бичгийг хэрэгжүүлэх зорилгоор “Хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол тэжээл” Үндэсний хөтөлбөрт хоол тэжээлийн асуудлыг тусад нь боловсруулан оруулж 2001 онд батлуулжээ. Тус хөтөлбөрийн хоол тэжээлийн зорилтуудыг ЭМЯ, түүний харьяа НЭМХ, ХХААЯ, БСШУЯ болон бусад төрийн болон төрийн бус байгууллагууд, олон нийтийн байгууллага, олон улсын байгууллагуудын нягт хамтын ажиллагаагаар хэрэгжүүлэх юм. НЭМХ-ийн ХСТ-ийн ирэх 10 жилд хийх судалгаа, шинжилгээний ажлын зорилт, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээг тус хөтөлбөрт оруулж баталгаажуулаад байгаа юм байна. Иймд хөтөлбөрийн хүрээнд ХСТ нь дараахь арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Үүнд:

- Хүн ам, олон нийт, эмзэг бүлгийн хоол тэжээлийн байдлыг сайжруулах, хоол тэжээлийн талаарх мэдлэг, дадлыг сайжруулах тогтолцоо бүрдүүлэх,
- Хүн амын эрүүл мэндийг бичил бодис, аминдэмийн дутлаас сэргийлэх зорилгоор өргөн хэрэглээний зарим хүнсний бүтээгдэхүүнийг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн арга, технологийн дагуу баяжуулан хэрэглэж хэвших,
- Болзошгүй гамшиг, онцгой байдлын үед хүн амын хоол тэжээл, эрүүл мэндийн байдалд үнэлгээ өгөх, мэдээлэх, хяналт тавих,
- Шаардлагатай зориулалтын хүнсийг үйлдвэрлэх, бэлтгэх, туслах тогтолцоог бүрдүүлэх,
- Хоол тэжээлийн мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний тогтолцоог боловсронгуй болгох,
- Үндэсний боловсон хүчний чадавхийг сайжруулах зэрэг зорилтыг холбогдох яам, тусгай газар, олон нийт, төрийн бус байгууллагуудын оролцоотойгоор хэрэгжүүлэх болно.

Дээрх зорилтуудыг 2 үе шаттайгаар хэрэгжүүлснээр хүн ам ялангуяа эхчүүд, бага насны хүүхдийн хоол тэжээлийн дутлын эмгэгийн тархалт, хоол тэжээлтэй

холбоотой архаг өвчлөл, нас баралт буурах юм байна.[44(1)] Эдгээр зорилтуудын хүрээнд дараахь арга хэмжээнүүдийг төлөвлөжээ.

Зорилт 8. Хүн ам, олон нийтийн хоол, тэжээлийг сайжруулах зорилтыг хэрэгжүүлэхээр:

а/ хоол тэжээлийн үндэсний лавлагаа, норм хэмжээ, зөвлөмжүүдийг хянан шинэчлэх;

б/ хүн амын эрүүл мэндийг дэмжих зохистой хооллох үндэсний зөвлөмж боловсруулж хэрэгжүүлэх;

в/ цэцэрлэгийн насны болон өсвөр үеийн хүүхдийн хоол тэжээлийн байдлыг сайжруулах стратеги боловсруулан хэрэгжүүлэх;

г/ хүн ам, олон нийтийн хоол тэжээлийн асуудлыг шийдвэрлэхэд нийгэм, сэтгэл зүйн таатай орчинг бүрдүүлэх, нийгмийн эрүүл мэндийн тусламжийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, тогтвортой санхүүжилтийн механизмыг бий болгох, стандарт шалгуур боловсруулж хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг тусгасан байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн байдлыг харахад эхний арга хэмжээ болон насанд хүрсэн хүн амын хоол тэжээлийг сайжруулахаар төлөвлөсөн арга хэмжээнүүд хэрэгжээгүй байна. Үүний шалтгаан нь уг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх санхүүжилтийн гол эх үүсвэрийг улсын төсвөөс жил бүр төсөвлөн гаргах ёстой байтал санхүүжилт огт хийгдээгүйгээс санхүүгийн эх үүсвэргүй болсонтой холбоотой аж.

3-р арга хэмжээний хүрээнд 2002-2003 онд Цэцэрлэгийн насны болон өсвөр насны хүүхдийн хоол тэжээл, хүнсний аюулгүй байдлыг судалж, үнэлгээ өгсөн боловч цаашид авах арга хэмжээний зөвлөмж, аргачлал боловсруулаагүй байна.

Зорилт 9. Эмзэг бүлгийн хүн амын хоол, тэжээлийн байдлыг сайжруулах зорилтыг хэрэгжүүлэхээр:

а/эхчүүд, бага насны хүүхдийн хоол, тэжээл, амьдралын хэв маягийг дээшлүүлэх чиглэлээр Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих хөтөлбөрийн газартай хамтарч ажиллах;

б/нялхас, 06-24 сартай бага насны хүүхдүүдийн хоол, тэжээлийн байдлыг сайжруулах, нэмэгдэл хоолны тэжээллэг чанар, асран хамгаалахуйн эерэг дадлыг дэмжих;

в/жирэмсэн болон хөхүүл эхчүүдийн хоол тэжээлийн байдлыг сайжруулах;

г/бага (5 хүртэлх) насны хүүхдийн өсөлтийг дэмжих болон хянах тогтолцоог бүрдүүлэх;

д/бага насны хүүхэд, жирэмсэн болон хөхүүл эхчүүдийг төмөр дутлын цус багадалтаас урьдчилан сэргийлэх, хянах үйл ажиллагааг сайжруулах;

е/иод дутлын эмгэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хянан нэмэлт, өөрчлөлт оруулж, хэрэгжилтийг эрчимжүүлэх;

ж/бага насны хүүхэд, жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүдийг Д аминдэмийн дутлаас урьдчилан сэргийлэх, хянах үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээнүүдийг авахаар тусгасан нь зохих түвшинд хэрэгжиж байгаа юм байна. Гэвч эмзэг бүлгийн хоол тэжээлийг сайжруулах талаар орон нутгийн сан байгуулах, энэ чиглэлийн үйл ажиллагааг орон нутгийн төсөвт тусгахад орон нутгийн удирдлагуудын оролцоо, санаачлага хангалтгүй байгаагаас хэрэгжихгүй байгаа аж.

Зорилт 10. Хүн амын хоол, тэжээлийн талаархи мэдлэг, дадлыг сайжруулах тогтолцоо бүрдүүлэх зорилтыг хэрэгжүүлэхээр: хүн ам, олон нийтийн зөв зохистой хооллолтын талаар мэдээлэл, сургалт сурталчилгаагаар хангах ажлыг эрчимжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагууд, аж ахуйн нэгж, иргэдийг оролцуулсан салбар хоорондын хамтын ажиллагааны сүлжээг бий болгох арга хэмжээ төлөвлөсөн нь үндсэндээ хэрэгжиж хэвшээд байгаа аж. Тухайлбал, салбар дундын мэдээллийн тогтолцоо бүрдүүлэх эх үүсвэр тавигдсан (ажлын баг ба хэсгүүд, вэб, түүний портал, мэдээллийн сэтгүүл) ба Foods@mongolia-gateway.mn мэйлэн лист үүсгэн мэдээлэл солилцож байгаа аж.

Зорилт 11. Хүн амын эрүүл мэндийг бичил бодис, аминдэмийн дутлаас сэргийлэх зорилгоор өргөн хэрэглээний зарим хүнсний бүтээгдэхүүнийг олон улсын

хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн арга, технологийн дагуу баяжуулан хэрэглэж хэвших зорилтыг хэрэгжүүлэхээр:

а/ хүнсийг баяжуулах, ялангуяа гурил, гурилан бүтээгдэхүүнийг Д аминдэм болон төмрөөр, сүү, сүүн бүтээгдэхүүнийг С аминдэмээр баяжуулах орчин үеийн технологийг нэвтрүүлэх;

б/ хүнсийг баяжуулах стандарт, технологийн орчинг бүрдүүлэх арга хэмжээнүүд тусгагджээ. Уг арга хэмжээний хүрээнд 2002 оноос АХБ, Ядуурлыг бууруулах Японы сангийн санхүүжилтээр “Ядуу эх, хүүхдийн хоол тэжээлийн байдлыг сайжруулах” төсөл хэрэгжиж байна. Уг төслийн ядуу эх, хүүхдийг төмрийн дутагдлаас сэргийлж, төмөр дутлын цус багадалтыг багасгах зорилтын хүрээнд гурилыг төмрөөр баяжуулан хүнсэнд хэрэглэх технологийг гурилын үйлдвэрүүдэд нэвтрүүлсэн байна. [19, 50]

Дэлхий дээр олон сая хүн цус багадалт, креатинизм, хараагүй болох, бамбайн бахлуур зэрэг өвчинд нэрвэгдээд байгаагийн шалтгаан нь аминдэм, эрдэс бодис буюу бичил бодисын дутал гэдэг нь олон арван жилийн өмнөөс тодорхой болсон. Гэвч сүүлийн үеийн судалгаа шинжилгээний ажлууд энэ асуудал нь маш том мөсөн уулын зөвхөн орой буюу өчүүхэн хэсэг гэдгийг харуулсаар байна.

Аминдэм, эрдэс бодисын дунд зэргийн дутал ч аюул учруулж болохуйц сөрөг үр дагаварт хүргэж болох нь өнөө үед тодорхой болсон байна. Мөн аминдэм, эрдэс бодисын дунд зэргийн дутал нь түгээмэл тархсан бөгөөд дэлхийн хүн амын 1/3 нь нэрвэгдээд байгаа төдийгүй улс үндэстний эрч хүч, оюуны чадавхи болон хөдөлмөрийн бүтээмжид заналхийлэх аюулд хүргээд байна.

Монгол улсад хоол тэжээлийн дутлаас гадна **“Бичил тэжээлийн далд өлсгөлөн”** бодитойгоор оршиж байгааг төрөөс онцгойлон анхаарч эмзэг бүлгийн хүмүүст ялангуяа эх, хүүхдийн хоол тэжээлийн асуудалд гол анхаарлаа төвлөрүүлж олон хөтөлбөр, төсөл хэрэгжүүлж байна. Тухайлбал, 1996 онд Монгол улсын Засгийн газраас баталсан “Иод дутлын эмгэгтэй тэмцэх” Үндэсний хөтөлбөр боловсруулж, хөтөлбөрийн хүрээнд хүн амын дундах иод дутлын эмгэгийн тархалтын байдлыг судлан, хүнсний давсыг иоджуулах техник, технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлж, иоджуулсан давсны чанарт үйлдвэрлэл, худалдаа, хэрэглэгчийн түвшинд хяналт тавих, иод дутлын эмгэгийн хор хөнөөл, түүнээс урьдчилан сэргийлэх талаар сурталчилгаа явуулах зэрэг бодлого, үйл ажиллагаа явуулжээ. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд 2003 онд “Давс иоджуулж, иод дутлаас сэргийлэх тухай” хууль батлагдан гарч одоо мөрдөгдөж байна. Дээрх хөтөлбөрийн үйл ажиллагааг сайжруулж, өргөжүүлэх шаардлагын үүднээс 2002 оноос “Иод дутлын эмгэгтэй тэмцэх” үндэсний шинэчилсэн хөтөлбөр боловсруулсан байна.[3]

Монгол улсын засгийн газраас 2002 оны 12 дугаар сарын 4-ний 245 тоот тогтоолоор батлан гаргасан “Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах” үндэсний хөтөлбөрийн эрхэм зорилго нь Монгол улсад хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхэд өөрийгөө хөгжүүлэх, ажиллаж амьдрахад шаардлагатай боловсрол, мэргэжил эзэмших орчин нөхцөлийг бүрдүүлж, тэдний аж байдлыг улам сайжруулахад оршиж, хүүхэд эсэн мэнд аж төрж, нэр төртэй, өв тэгш хөгжих эрхийг хангах тэргүүлэх чиглэлд “Хүүхэд бүрийн төлөө халамж анхаарал тавина. Хүүхэд бүрт амьдралын хэвийн нөхцөл бүрдүүлнэ. Халдварт өвчинтэй тэмцэх, хүүхдийн хоол хүнсээр дутагдах гол шалтгааныг арилгах, улмаар хүүхдийг эрүүл чийрэг, оюун ухааны хөгжил сайтай байх орчин нөхцөлд өсгөж хүмүүжүүлэхийн төлөө хүчин чармайлт гаргана” гэж тусгасан байна. “Хүүхдийн амьдралын эрүүл, аюулгүй орчин” гэсэн хэсэгт 5-р зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг тусгаж, 2003-2004 онд хэрэгжүүлж дуусгах юм байна. Үүнд:

Зорилт 5. Хүүхэд, өсвөр үеийнхний зохистой хооллолтыг дэмжих, аюулгүй хоол хүнсний хангамжийг нэмэгдүүлнэ.

1. Хүрэх үр дүнг “Хүүхэд, өсвөр үеийнхний зохистой хооллолт, хоол хүнсний чанар, хангамж Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийн нийтлэг жишигт хүрсэн байна.” гэж тодорхойлоод үүнд чиглэсэн үйл ажиллагааг тусгажээ.

2. Хүүхэд, өсвөр үеийнхний хооллолтын байдалд судалгаа хийж, хоолны чанар, хүртээмжийг сайжруулах арга хэмжээ авах;
3. Хүүхэд, өсвөр үеийнхний эрэлт хэрэгцээнд нийцсэн шимт чанар сайтай, аюулгүй хоол хүнсний үйлдвэрлэл болон нийлүүлэлтийн дагнасан сүлжээ байгуулах;
4. Ядуу амьдралтай болон байгалийн гамшигт нэрвэгдсэн жирэмсэн болон хөхүүл эх, бага насны хүүхдийн нэмэлт хоол хүнсний хангалтын байдлын үр нөлөөг тандан судлах;
5. Өрхийн хүнсний аюулгүй байдлыг хангах, хүнсний баяжуулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологийг сайжруулах арга хэмжээ авах зэрэг 5 үйл ажиллагааг тусгагджээ.[20]

Уг хөтөлбөрийг хэрэгжүүлснээр Монгол улс 2010 он гэхэд нялхсын эндэгдэл 1000 амьд төрөлтөнд 25 ба 5 хүртэлх насны хүүхдин эндэгдэл 35 хүртэл буурсан байх, хүүхдийн 6 сар хүртэл хугацаанд зөвхөн эхийн хөхөөр хооллодог хувь 2005 онд 60%, 2010 онд 90% болж, 5 хүртэлх насны хүүхдийн тураал/өсөлтийн хоцрогдол 2005 онд 8/18, 2010 онд 5/10 болсон байх ёстой аж. Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах үүргийг Хүүхдийн төлөө үндэсний газар, аймаг, нийслэл, дүүрэгт Хүүхдийн төлөө төв, сумдад ЗДТГ-ын хүүхэд, гэр бүл, хүн ам зүйн асуудал эрхэлсэн ажилтан хариуцах юм байна.

Үндэсний хөтөлбөрийн 5-р зорилтын 2 дахь арга хэмжээний хүрээнд хоол тэжээлийн үндэсний судалгааг 2004 оны 3 дугаар сараас эхлээд байгаа ба одоо тайлангийн эцсийн шатанд явж байна.

Хүүхдийн асуудлаарх үндэсний дээд хэмжээний чуулга уулзалт дээр Эрүүл мэндийн дэд сайд асан Н.Удвал хөтөлбөрийн 3 дахь арга хэмжээний хэрэгжилтийн талаар “Засгийн газар 2001 оноос бага насны хүүхдийн өсөлтийг дэмжих тогтолцоог боловсронгуй болгох аргачлал боловсруулан ажилласнаар хүүхдийн өсөлтийг хянаж, мэдээ, тайланг нэгтгэн эх, хүүхдийн хоол тэжээлийн мэдээллийн бааз байгуулагдсан ба сүүлийн 2.5 жилийн мэдээ хадгалагдаж байна” гэж мэдээлсэн нь үнэндээ хүүхэд өсвөр үеийнхний эрэлт хэрэгцээнд нийцсэн шимт чанар сайтай, аюулгүй хоол хүнсний үйлдвэрлэл болон нийлүүлэлтийн дагнасан сүлжээ байгуулах арга хэмжээний үр дүн гэж хэлэхэд учир дутагдалтай байна.

Мөн зорилтын 4 дэх арга хэмжээний хүрээнд 2002 онд хоол тэжээлийн байдалд зудын үзүүлэх хор холбогдлыг үнэлэх судалгаа хийжээ. (Уг судалгааны үр дүнгийн талаар дараагийн хэсгээс үзнэ үү.)

Зорилтын 5 дахь арга хэмжээний биелэлтэд АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй “Ядуу эх, хүүхдийн хоол тэжээлийн байдлыг сайжруулах” төсөл хамрагдаж байна. Харин эдгээр үйл ажиллагаанд Засгийн газрын төсөв хөрөнгө зарцуулалтын байдал харагдахгүй байна.

Хүүхэд, өсвөр үеийнхний хоол тэжээлийн байдалд судалгаа хийж, хоол тэжээлийн дутагдалтай холбоотой өвчлөлийг бууруулах, 5 хүртэлх насны хүүхдийг А аминдэм, төмрийн бэлдмэлээр хангах зорилтын дагуу А аминдэмийн хангалтын тогтолцоог тогтворжуулахад 2004 онд “А аминдэмийн тогтвортой тараалтыг хангах” бодлогын чанартай стратегийн баримт бичгийг гарган батлуулах үйл явц эхлээд байгаа аж.[56]

Хүн амын хоол тэжээлийн талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөрийг боловсруулж, хүн амыг шинжлэх ухааны үндэстэй хоол тэжээлээр хангах, хоол тэжээлийн илүүдэл, дутлаас үүсэн гарах, өвчин эмгэгээс сэргийлэхийн тулд хоол тэжээлийн бодисуудын зөвлөмж хэмжээг улс орон бүр өөрийн нутаг дэвсгэр, газар зүйн онцлог, хүн амын ёс заншлыг харгалзан олон улсын жишигт нийцүүлэн боловсруулан гаргах шаардлагатай байдаг. Энэ нь хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, төлөвлөлт, хуваарилалтыг зөв шийдвэрлэх үндэс болж, хоол тэжээлийн хангамжинд үнэлгээ өгөх шалгуур болдог.

НЭМХ-ийн Хоол судлалын төв(ХСТ)-өөс 1997 онд “Хүн амын хоол тэжээлийн бодисуудын зөвлөмж хэмжээ”-г ДХХААБ-ДЭМБ-аас гаргасан зарчмыг баримталж хүн амын ажил хөдөлмөр эрхлэлтийн онцлог, нас, хүйсийн ялгаа, физиологийн онцлог байдлыг (хөхүүл, жирэмсэн) харгалзан тогтоосон байдаг. Уг зөвлөмжид хүнсний

бүтээгдэхүүний бүтэц, найрлага дахь уураг, өөх тос, нүүрс ус, амин дэм, эрдэс бодис зэрэг шимт болон биологийн өндөр идэвхит бодисуудыг хүн амын бүлэг тус бүрээр нормчилсон байдаг. Хүн амын үндсэнд нь хөдөлмөрийн чадвартай хүн ам болон зориулалтын хүнс хэрэглэх хүн ам гэж 2 бүлэгт хувааж, хөдөлмөрийн чадвартай хүн амаа ажил эрхлэлтийн байдлаар нь 3 бүлэгт хувааж, зориулалтын хүнс хэрэглэдэг хүн амд жирэмсэн эмэгтэй, хөхүүл хүүхэдтэй эх, ахимаг насны хүн тус бүрээр дээрх шимт бодисуудыг нормчилсон байна. Гэвч уг зөвлөмжинд мах, гурилыг түлхүү хэрэглэхээр тусгаж, монгол хүний уламжлалт хэрэглээ болсон хүнсний ногоо, жимс, жимсгэнэд агуулагддаг зарим аминдэм, эрдэс бодисыг юугаар ч орлуулашгүй зохистой хэлбэр, хэмжээ, харьцаагаар агуулсан сүү, цагаан идээний нормыг багасгаж тусгажээ. [33(1, 2)]

Мөн тус төвөөс монгол хүний хоногийн хоол хүнсний “Гэр” зөвлөмжийг боловсруулж, хүний хоногт хэрэглэвэл зохих хоол хүнсийг 5 бүлэгт хувааж тус бүрийг хүний хоногт зарцуулсан нийт энергийг нөхөх хоол хүнсний нийт илчлэг (ккалори)-т эзлэх хувь хэмжээг тогтоосон байдаг.

1992 онд Эрүүл мэнд, ШУБ-ын сайдын хамтарсан А140/451 тоот тушаалаар “Бага насны хүүхдийн хоногийн физиологийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний норм, илчлэгийн хэмжээ”-г баталсан бөгөөд энэ нь сургуулийн өмнөх насны хүүхдийн өсөж, хүмүүжих цэцэрлэг, ясли, амралт, сувиллын ба бусад хүүхдийн байгууллагуудад хоол хүнсний хангамж, үйлчилгээ, хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг төлөвлөж, олгох шинжлэх ухааны үндэслэл болдог.

2.4.2. Хоол тэжээл, түүнтэй холбоотой өвчлөлийн өнөөгийн байдал.

➤ 5 хүртэлх насны хүүхдийн хооллолтын байдал

▪ Хүүхдийн хөхөөр хооллолт.

Хүүхдийг эхийн сүүгээр хооллохыг дэмжих талаар 1980 оноос хойш 14 удаа хэлэлцэж шийдвэр гаргажээ. Тухайлбал:

1989 онд “Хүүхдийн эрхийн тухай” Конвенци батлагдаж, Конвенцийн 24 дүгээр зүйлийн 2-ын е-д: “Хүүхдийг эхийн сүүгээр хооллох талаар гэр бүл, эхчүүдэд зохих мэдлэг өгөх, дэмжлэг туслалцаа үзүүлэх нь улс орон бүрийн үүрэг мөн” хэмээн заасан байна.

1990 онд 32 орны Засгийн газар, НҮБ-ын 10 байгууллага хамтран “Гэм зэмгүй нялхсын тухай” Инносентийн Тунхаглал боловсруулж баталжээ. Энэхүү тунхаглалд: “Хүүхдийн 4-6 сар хүртэл нь зөвхөн хөхөөр тэжээх, үүнээс хойш 2 нас хүртэл нь нэмэгдэл хоолыг эхийн сүүтэй хослуулан тэжээх нь зүйтэй.” гэсэн зөвлөмжийг баталсан билээ. Тэр үеэс НҮБ-ын Хүүхдийн сан, ДЭМБ хамтран хүүхдийг хөхөөр тэжээхийг дэлхий даяар дэлгэрүүлж хэвшүүлэх, түүнд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Хүүхдийг хөхөөр хооллох”, “Хүүхдэд ээлтэй эмнэлэг” санаачилгыг дэвшүүлсэн байна.

1992 онд “Хоол тэжээлийн тухай” Дэлхийн Тунхаглалд “хөхөөр хооллолтыг дэмжих байдлаар нялхсын өвчнөөс урьдчилан сэргийлэхийг дэмжинэ” хэмээн тунхагласан байна.

1991 онд Хүүхдийг хөхөөр хооллох бодлогыг хэвшүүлэх 10 зорилтыг хэрэгжүүлэх талаар Монгол улсын Эрүүл Мэндийн сайдын тушаал гарч, “Хүүхдийг хөхөөр хооллох”, “Хүүхдэд ээлтэй эмнэлэг” санаачилга манай оронд НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр хэрэгжих эхэлсэн байна.

Эхийн сүү нь төгс тэжээллэг чанартай бүтээгдэхүүн бөгөөд эхийн сүүнд хүүхдийн биед шаардлагатай уураг, өөх тос, нүүрс ус, амин дэм, бичил тэжээлийг хамгийн зохистой харьцаагаар агуулсан байдаг тул хүүхдийн хэвийн өсөлт хөгжилтийг бүрэн хангаж чаддаг.

Хүүхдийг дөнгөж эхээс төрөнгүүт ангир уургийг нь амлуулах нь олон талын ач холбогдолтой байдаг. Ангир уураг нь А аминдэм болон уургаар найрлага тогтмолжсон сүүнээс илүү баялаг, хүүхдэд тохирсон хамгийн анхны хоол юм. Ангир уургийг амлуулах нь хүүхдийг халдвараас хамгаалах анхны дархлаажуулалт болдог.

Мөн туулгах үйлчилгээ үзүүлж хүүхдийн гэдэсний зунгагийг хурдан гадагшлуулж, улмаар нярайн шарлалтаас сэргийлдэг байна.

Хүүхдийг 6 сар хүртэл нь эхийн сүүгээр дагнан хооллох хэрэгтэй бөгөөд харин 6 сартайгаас нь эхлэн хүүхдэд нэмэгдэл хоолыг аажим дасган өгч эхлэх хэрэгтэй юм.

1995-1999 онуудад хүүхдийн хөхөөр хооллолтын байдлыг судалсан дүнгээс үзэхэд 2000 он хүртэлх 5 жилийн дунджаар нийт судалгаанд хамрагдсан хүүхдийн 92.6% нь төрсний дараа 30 минутын дотор хөхөө амласан байна. Эхний 4 сар хүртлээ дан хөхөөр хооллож байгаа хүүхэд 99.5%, 4-6 сар хүртлээ хөхөө хөхөж байгаа хүүхэд 96.7%, 6-9 сар хүртлээ – 93.1%, 9-12 сар хүртлээ – 92.9%, 2 нас хүртлээ – 75.9%-тай байгаа нь өмнөх онтой харьцуулахад буураагүй байгаа ч ерөнхийдөө хөхөө хөхөх байдал ой хүртлээ бага багаар буурсаар, 2 нас хүртлээ нилээд буурах хандлагатай байна.[46]

2000 онд хийсэн олон үзүүлэлт судалгаагаар 4 сар хүртэл дан хөхөөр хооллож байгаа хүүхэд 54% болсон байна. мөн 2001 онд зохион явуулсан “Хөхний сүү орлуулагч бүтээгдэхүүний хэрэглээ, маркетинг ба хөхөөр хооллолт” судалгаагаар 6 сар хүртэл дан хөхөөр хооллолт 32.6% болж жил дараалан буурч байгааг үндэслэн 4 сар хүртэл дан эхийн сүүгээр хооллох бодлогыг 6 сар хүртэл болгон өөрчилсөн байна. [56]

▪ **Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүн (ЭСОБ) нь угжаар хооллолтыг нэмэгдүүлж, хөхөөр хооллолтыг бууруулахад нөлөөлөх нь**

1981 онд НҮБ-ын Хүүхдийн сан, ДЭМБ-ын санаачилгаар “Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүний маркетингийн олон улсын хууль” гарсан. Энэхүү хуулийн зорилго нь хүүхдийг эхийн сүүгээр хооллохыг хөхүүлэн дэмжих, хамгаалах, эхийн сүү орлуулагч буюу нялхсын сүү, сүүн тэжээлийг зөвхөн шаардлагатай үед зөв найруулах, бэлтгэх, хооллох горимыг чанд баримтлах зэрэг зохих мэдээллийн үндсэн дээр борлуулах, түгээх замаар зохистой хэрэглээг хэвшүүлж нялхсыг аюулгүй, шаардлага хангасан хоолоор хооллоход хувь нэмэр болоход оршжээ.

Угжаар хооллож буй хүүхэд, халдварт, ялангуяа суулгалт болон амьсгалын замын өвчинд өртөмтгий, өвчлөмтгий болдог. Олон дахин өвдсөнөөр хүүхэд жингээ алдах ба улмаар хүүхдийн бие бялдрын болон оюун ухаан сэтгэхүйн өсөлт хөгжил нь хоцорно. Хүүхдийн өсөлт хөгжилтөд зайлшгүй шаардлагатай зарим амин дэм, бичил бодисуудыг хангалттай хэмжээгээр авч чаддаггүй тул угжны хүүхэд хоол тэжээлийн дуталд амархан ордог. Мөн угжаар хооллодог хүүхэд харшилд өртөмтгий байдаг. ЭСОБ нь үнэ өртөг ихтэй, худалдан авах, бэлтгэх, хооллоход цаг хугацаа их шаарддаг зэрэг олон сөрөг үр дагавартай. Сүүлийн үеийн жишээ дурьдахад: 2003 оны 11-р сард Израйлд 2-10 сартай 4 хүүхэд тодорхой бус шалтгаанаар тархины эмгэгээр өвчилсөн тохиолдол гарсны Израйлын ЭМЯ мэдээлжээ. Дараа нь мөн сард ийм тохиолдол 2 хүүхдэд тохиолдсон байна. Тэдгээр хүүхдүүд Герман улсад үйлдвэрлэсэн Remedia Soy Formula гэдэг ЭСОБ-ээр хооллодог байжээ. Лабораторийн нарийн шинжилгээгээр уг бүтээгдэхүүнд В1 аминдэм агуулаагүйн улмаас дээрх өвчний шалтгаан нь хүнд хэлбэрийн В1 аминдэмийн дутлаас болсон нь нотлогдсон байна.

Сүүлийн үед нялхас болон бага насны хүүхдэд тохиолдож буй гэдэсний халдварт өвчний үед Энтеробактер саказаки нян ихээр илрэх болсон. Энэ нян нь ихэвчлэн нярай хүүхдэд нярайн хүнд хэлбэрийн мэнэн, хоолны хордлогыг үүсгэдэг байна. Нялхсын сүүн тэжээлийн үйлдвэрлэлийн ариутгах явцад Энтеробактер саказаки бүрэн гүйцэд устдаггүй нь тогтоогджээ.

Тэгвэл 2001 онд ЭМЯ, НЭМХ-ийн ХСТ, НҮБ-ийн Хүүхдийн сангаас хийсэн “Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүний маркетинг, хэрэглээг тодорхойлох судалгаагаар:

Манай оронд сүүлийн 5 жилд 13 орны 543.7 тн эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүн импортоор орж ирсэн нь урьдах онуудаас даруй 6.6 дахин ихэсчээ. Гол импортлогч орон нь (импортын 65%) Швейцари улс байна.

Эдгээр худалдаалагдаж буй бүтээгдэхүүнүүдийн шошго 100% гадаад хэл дээр бичигдсэн, эхийн сүүний ач холбогдлыг сурталчилсан бичвэр нь далд, таглаан дор нь байрлуулсан байжээ.

Манай орны зах зээл дээр худалдаалагдаж байгаа эхийн сүү орлуулагч хэмээгч бүтээгдэхүүнүүнд угжаар хооллохыг эхийн сүүгээр хооллохтой адилтгасан зурагтай (66.7%), тийм утга санаа бүхий бичвэртэй (100%) байгаа нь судалгаагаар тогтоогджээ.

Судалгаанд хамрагдсан худалдааны газруудын 42.7% нь энэ бүтээгдэхүүнийг худалдаалж байсан ба тэдний дөнгөж 2.7% нь л холбогдох байгууллагын дүгнэлт, зөвшөөрөлтэй байсан байна.

ЭСОБ-ийг эхийн сүүг орлоно хэмээн сурталчилж байгаа нь эхчүүдийг буруу дадал, хэвшилд сургаж, улмаар угжны хүүхдийн тоо нэмэгдэх аюулд хүргэж байна.

Гэтэл манайд одоогоор ЭСОБ-ийг хянах, зохицуулах, хүүхдийг эхийн сүүгээр хооллолтыг дэмжих хууль, эрх зүйн зохицуулалт байхгүй байна. Харин “Хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол тэжээл” үндэсний хөтөлбөрийн хүрээнд “Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүний зах зээлийн зохицуулалтын тухай” хуулийн төсөл боловсруулаад байгаа аж.[49(4), 55(2)]

■ Хүүхдийн нэмэгдэл хооллолт.

Бага насны хүүхдийн УИД, цус багадалт, сульдаа өвчний тархалт нь тухайн улс орны эхчүүд, жирэмсэн эмэгтэй, бага насны хүүхдийн хооллолтын ёс жаяг, хоол тэжээлийн хангамжийн байдалтай салшгүй холбоотой юм. хүүхэд 6 сартай болоход эхийн хөхний сүү тэдний хоол тэжээлийн хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй болох бөгөөд энэ үед нэмэгдэл хоол зайлшгүй шаардлагатай болдог. Хүүхдийг нэмэгдэл хоолонд орсон үеэс хойш (6-18 сартайд) хөхнөөс гадна өдөрт доод тал нь 4 удаа илчлэг, тэжээллэг хоолоор хооллох хэрэгтэй байдаг билээ.

1997 онд ХСТ, Дэлхийн зөн-Монгол олон улсын байгууллагаас хамтран зохион байгуулсан “Хоол тэжээл, хүнсний аюулгүй байдал” судалгаагаар хүүхдийн өсөлт хоцролт ихэвчлэн 6 сартайгаас эхэлдэг, эхчүүд хүүхдээ 4-6 сартайд нь нэмэгдэл хоолонд оруулдаг боловч нэг төрлийн, тэжээллэг чанар муутай хоол өгдөг, өдөрт хооллох давтамж цөөн, хоолны хэмжээ хангалтгүй байгаа нь тогтоогдсон байна.

Эцэг эхчүүд хүүхдээ хэрхэн хооллож буйг авч үзвэл: 4-12 сартай нийт хүүхдийн 43.3%-д нь тусад нь хоол бэлтгэж өгч харин үлдсэн хувь нь гэр бүлийн хоолонд оруулж байгаа нь хоол тэжээлийн дуталд орох эрсдлийг нэмэгдүүлж байна. Мөн нийт хүүхдийн 54.4% нь нэмэгдэл хоолыг бантан, зутангаар эхэлж, цаашид энэ хоолоороор 1 нас хүртэл дагнан хооллож байна. Харин нэг наснаас хойш гэр бүлийн хоолноос өгдөг байна. Бага насны хүүхдийн хоолонд хэрэглэж буй хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл, давтамжийг авч үзвэл: гурил, гурилан бүтээгдэхүүнийг 100%-д нь, мах, махан бүтээгдэхүүнийг 89.8%-д нь сүү, сүүн бүтээгдэхүүнийг 72.4%-д нь өдөрт 1-3 удаа тогтмол нэмэгдэл хоолонд хэрэглэж байна. Хүүхдийн хоол тэжээлд зайлшгүй шаардлагатай жимс, жимсгэнэ, хүнсний ногоог зөвхөн 21.9% нь хэрэглэсэн байна.

Энэ байдлаас харахад өдөрт цөөн удаа хооллож, голлон 2-3 нэр төрлийн илчлэг, тэжээллэг чанар муутай хүнсний бүтээгдэхүүнийг удаан хугацаагаар тогтмол хэрэглэж байгаа нь хоол тэжээлийн хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй байна. Улмаар энэ нь хоол тэжээлтэй холбоотой бусад өвчлөл, сульдаа, цус багадалт, улмаар хоол тэжээлийн архаг дуталд орох нэг шалтгаан болж байна.[46]

➔ 5 хүртэлх насны хүүхдийн хоол тэжээлийн дуталтай холбоотой эмгэгүүд

■ Уураг илчлэгийн дутал

Уураг илчлэг дутлыг *тураал* (ж/н <-2SD), *өсөлтийн хоцрогдол* (ө/н <-2SD), *туранхай хүүхэд* (ж/ө <-2SD) гэсэн үзүүлэлтүүдээр хэмжиж, үнэлж байна.

Монгол улсын засгийн газрын “Хүүхэд хөгжил хамгаалал үндэсний хөтөлбөр”-т 2000 он гэхэд 5 хүртэлх насны хүүхдийн хоол тэжээлийн хурц дутал буюу тураалыг 1990 сны түвшнээс 50%-аар бууруулах зорилтыг тавьсан билээ.

1989 онд НҮБ-ын Хүүхдийн сангийн зөвлөх доктор Шофильдын судалгаагаар тураал сургуулийн насны орон сууцанд амьдардаг хүүхдэд 15%, гэрт амьдардаг хүүхдэд 20% байгаа нь тогтоогджээ.

1999 оны байдлаар 5 хүртэлх насны хүүдийн дунд тураал 12.5%, өсөлт хоцролт 24.6%, туранхай хүүхэд 3.7% байгаа нь 1997 оны үзүүлэлтүүдээс өсчээ. Харин 2001 онд хийсэн судалгаагаар тураал 6%, өсөлт хоцролт 22.3%, туранхай хүүхэд 0.9% болж тус тус буурчээ.[44(7)]

УИД-ын тархалт төв суурин газраас, хөдөө орон нутагт хоёр дахин их тархалттай байна. УИД хотуудад 7.1% байсан бол аймгийн төвд 15.7%, суманд 19.4% буюу тураалтай хүүхдийн 97% нь аймгийн төв, суманд байгаа нь тогтоогдов. Тураалтай, өсөлт хоцролттой, туранхай хүүхэд нэмэгдэл хоолонд орж, борог хоолонд шилжих шилжилтийн чухал үе болох 7 сартайгаас эхлэн 2-3 дахин өсч, 13-24 сартайд бусад насны бүлгээс хамгийн өндөр тархалттай байна.

Өдөрт 1-2 удаа хооллодог 6-12 сартай хүүхдийн 16.4% тураалтай, 32.8% нь өсөлт хоцорсон байхад 4-5 удаа хооллодог хүүхдийн тураал 4.4 дахин, өсөлт хоцролт 8.7%-аар бага байна.

Ядуу өрхийн хүүхдүүдийн тураалд өртөх магадлал 3 дахин их байна. Тураалд өртөж байгаа ядуу өрхийн 10 хүүхдийн 9 нь хөдөөд байна.

Зуданд нэрвэгдсэн бүс нутагт 5 хүртэлх насны хүүхдийн дунд тураал 15%, өсөлт хоцролт 36.1% байгаа нь зуданд нэрвэгдээгүй бүс нутгийн мөн насны хүүхдүүдийнхээс бага зэрэг их байгаа нь ажиглагдаж байгаа бөгөөд 1999 оны судалгаатай харьцуулахад өссөн байна.[44(3)]

Хэдийгээр бага боловсролтой эхийн хүүхэд УИД-д өртөх магадлал өндөр байгаа ч аймгийн төв, суманд амьдарч буй боловсролын түвшин өндөр эхчүүдийн хүүхэд УИД-д өртөх эрсдэл ихтэй байна.

Энэ нь хөдөө орон нутагт хүнсний хангамжийн хомсдолоос гадна байгаа хүнсний бүтээгдэхүүнээр хүүхэддээ тохирсон хоолыг бэлтгэн өгч, зөв зохистой хооллох талаарх эхчүүдийн мэдлэг, дадлага дутмаг байдагтай холбоотой байж болох юм.

■ Аминдэм эрдэс бодисын дутал

Аминдэм, эрдэс бодисын холбогдолтой мэдээ нь бүрэн бус байгаа бөгөөд асуудалд нухацтай хандаж, хяналтыг сайжруулах шаардлагатай байна. Аминдэм, эрдэс бодисын дутлын байдалд үнэлгээ хийх асуудал үндэсний түвшинд шийдвэр гаргахад чухал зүйл юм.

Аминдэм, эрдэс бодисын дутлын улмаас Монгол улс, хүн амд учирсан хохирлыг дараах байдлаар гаргажээ. Үүнд:

- 6-24 сартай нийт хүүхдийн ойролцоогоор 40-60% нь сэтгэн бодох чадвар хоцрох эрсдэлтэй байна. *Шалтгаан: Төмөр дутал*
- Жирэмсэн үеийн иод дутлын эмгэгээс болж жил болгон шинэр мэндэлж буй 8000 монгол хүүхэд оюун ухааны хоцрогдолтой төрж байна. Бахлуурын тархалт 10% буюу түүнээс их Монгол шиг (15%) улсад иод дутлын эмгэгийн дунд зэргийн хэлбэр илүү байх бөгөөд үндэсний хэмжээнд IQ 10-15-аар доогуур байна.
- Жил бүр халдварт өвчинд өртсөнөөс 300 гаруй хүүхэд эндэж байна.


Шалтгаан: А аминдэмийн дутал (ААД)

- Монгол хүүхдийн 30 орчим хувь нь дархлаа суларснаас өвчлөх нь ихэсч, өсөлт хөгжлөөр хоцорч байна. *Шалтгаан: ААД*
- Хэдэн арван Монголын төрөх насны эмэгтэйчүүд жирэмсэн болон төрөх явцдаа эндэж байна. *Шалтгаан: Төмөр дутлын цус багадагдлын хүнд хэлбэр*
- Жил бүр 100 гаруй хүүхэд төрөлхийн гажиг, саажилттай төрж байна.

Шалтгаан: Фолийн хүчлийн дутал. Энэ нь хоол хүнсэнд агуулагддаг аминдэм бөгөөд хэрэв энэ дутагдахад жирэмсний эрт үед төрөлхийн гажигтай хүүхэд төрөх гол шалтгаан болдог.

- Зүрх судасны өвчин, харвалтын улмаас нас баралт нэмэгдэж байж болзошгүй.

Шалтгаан: Фолийн хүчлийн дутал



- Насанд хүрсэн ажиллах хүчний хөдөлмөрийн бүтээмж бууруулснаар дотоодын нийт бүтээгдэхүүн 0.6%-аар буурч байна. Шалтгаан: Төмрийн болон иод дутал
- Эрүүл мэндийн үйлчилгээ, боловсролын тогтолцоо, мөн тахир дутуу эсвэл оюуны хоцрогдолтой хүүхэдтэй гэр бүлд ачаалал их нэмэгдэж байна.[55(1)]

■ Цус багадалт.

Цус багадалт нь дэлхий дахинаа эрүүл мэндийн салбарынхны анхаарал татсан гол асуудлын нэг бөгөөд дэлхийд нийтлэг тархсан хоол тэжээлийн дутлуудын нэг хэлбэр юм. Цус багадалтыг үүсгэх шалтгаан олон янз байдаг боловч бүх төрлийн цус багадалтын 80-90% нь хоол тэжээлийн, ялангуяа гемоглобины нийлэгжилтэнд чухал шаардлагатай төмөр хоол тэжээлд дутагдсантай холбоотой байдаг.

Цус багадалтанд төрөх насны (ялангуяа жирэмсэн) эмэгтэйчүүд, 5 хүртэлх насны хүүхэд илүү өртдөг байна.

1999 оны Хоол тэжээлийн судалгаагаар 5 хүртэлх насны хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүдийн цус багадалтын тархалтыг судлахад: 5 хүртэлх насны хүүхдийн дунд цус багадалтын тархалт 48.5% байгаа нь маш өндөр үзүүлэлт бөгөөд суманд амьдарч буй хүүхдүүдийн дунд энэ үзүүлэлт 56.5% байгаа нь хөдөөд хоол тэжээлийн хомсдол их байгааг баталж байна. Цус багадалтын тархалт 13-24 сартай хүүхдүүдийн дунд хамгийн өндөр хувьтай байна.[46]

2001 онд 5 хүртэлх насны хүүхдийн 49.3% (2 хүүхэд тутмын нэг) нь төмөр дуталд, 3 хүүхэд тутмын нэг нь буюу 30.2% нь хүнд хэлбэрийн төмөр дуталд өртсөн байна.[55(3)]

5 хүртэлх насны хүүхэдтэй эхчүүдийн 58.5%, суманд амьдарч буй эхчүүдийн 71% нь цус багадалттай байгаа нь маш өндөр юм. Цус багадалттай эхчүүдийн хүүхдүүд бусад хүүхдүүдээсээ 2.3 дахин их цус багадалтанд өртөж байна.

■ Д-аминдэмийн дутал

Сульдаа өвчин буюу рахит нь XIX зууны 2-р хагас хүртэл баруун Европын орнуудад түгээмэл тархалттай байсан хэдий ч XX зууны 2-р хагасаас эхлэн өндөр хөгжилтэй орнуудад бараг устсан өвчинд тооцогдох болсон байна. Гэвч Ази, Африкийн зарим орнуудад энэ өвчин одоо хүртэл тохиолдсоор байгаа бөгөөд эдгээр орнуудын бага насны хүүхдүүдийн эрүүл мэндийн шийдвэрлэвэл зохих асуудлуудын нэг нь болсоор байна.

Монгол улсын 5 хүртэлх насны хүүхдийн дунд нилээд их тархалттай байгаа рахит өвчин нь хүүхдийн хоол тэжээлийн дуталтай холбоотой өвчнүүдийн дунд гол байр суурийг эзэлж байна.

1999 онд 5 хүртэлх насны хүүхдийн 32.1% (1335) нь рахитын шинж тэмдэгтэй илэрсэн байна. Үүнийг оршин суугаа нутаг орны байдлаар ангилан авч үзвэл: Улаанбаатар хотын 5 хүртэлх насны хүүхдийн 34.1%, хөдөө аймгуудын мөн хүүхдийн 33.4, сумдын хүүхдийн 29.2% нь тус тус рахиттай байна.

Судалгаанд хамрагдсан 5 хүүхэд тутмын нэгд нь яс зөөлрөх болон ясны хэлбэр алдагдлын аль нэг шинж тэмдэг илэрч байв. Эдгээр хүүхдүүдийн хүйсийн ялгааг авч үзэхэд эрэгтэй хүүхдүүд эмэгтэй хүүхдүүдээс 18%-аар илүү өртөж байна. Монгол орны 1 хүртэлх насны 4 хүүхэд тутмын нэг нь рахит өвчинд өртөж байна.

1 хүртэлх насны хүүхдийн рахитын тархалт Улаанбаатар хоттой харьцуулахад аймгуудад 9.8%-аар өндөр, хөдөө сумдад 13.1%-аар өндөр байна. Энэ нь хөдөө орон нутагт эх хүүхдийн хоол хүнсний хангамж муутай байдагтай холбоотой бөгөөд нэгээс доош насны хүүхдийн рахит нь ихэвчлэн цочмог хэлбэрийн шинжүүдээр оношлогдсон байна.

Тураалтай хүүхдийн 36.5%, өсөлт хоцорсон хүүхдийн 30.8% нь сульдаа өвчинтэй байхад тураалгүй хүүхдийн уг өвчлөл 14.9%-аар, өсөлт хоцролтгүй хүүхдийн өвчлөл 10.7%-аар бага байна. Мөн 4 сар хүртэл дан хөхөө хөхсөн хүүхдүүдийн 14.4% сульдаа өвчинтэй байсан бол дан хөхөөр хооллоогүй хүүхдүүдийн уг өвчлөл 2.2 дахин их

байсан ба харин 6 сар хүртэл дан хөхөө хөхсөн хүүхдийн өвчлөл 2.6%-аар бага байна.[44(7)]

▪ **Иод дутлын эмгэг.**

Сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнуудын устгахаар зорьсон эмгэгийн нэг нь чимээгүй тахал болох иод дутлын эмгэг юм. Хүний ялангуяа хүүхэд, өсвөр насныхны оюун ухааны хөгжилд сөрөг нөлөө үзүүлдэг иод дутлын эмгэгийг устгах хамгийн энгийн, найдвартай арга зам нь давсыг иоджуулан хэрэглэх явдал гэдгийг дэлхий дахинаа хүлээн зөвшөөрч гадаад орнууд хүнсний давсаа иоджуулан үр дүнд хүрчээ.

Монгол Улсын Засгийн газраас 1996 онд баталсан “Иод дутлын эмгэгтэй тэмцэх” Үндэсний хөтөлбөрийн хүрээнд хүн амын дундах иод дутлын эмгэгийн тархалтын байдлыг судлан, хүнсний давсыг иоджуулах техник, технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлж, иоджуулсан давсны чанарт үйлдвэрлэл, худалдаа, хэрэглэгчийн түвшинд хяналт тавих, иод дутлын эмгэгийн хор хөнөөл, түүнээс урьдчилан сэргийлэх талаар сурталчилгаа явуулах зэрэг бодлого, үйл ажиллагаа явууллаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд иоджуулсан давсны 10 гаруй жижиг, дунд үйлдвэр байгуулагдан ажиллаж байна. 2000 онд дотоодын үйлдвэрлэл болон импортоор 5.0 мянган тонн иоджуулсан давс хүнсний хэрэгцээнд нийлүүлсэн нь нийт хүнсний давсны хэрэглээний 57 хувь болж байна. Давс иоджуулах төхөөрөмж болон иодын (кали иодат) баяжмалыг НҮБ-ын Хүүхдийн сан, Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-ын техник, хамтын ажиллагааны тусламжаар хангаж байна. Хөтөлбөрийн үр дүнд сургуулийн насны хүүхдүүдийн дунд бахлуурын тархалт 1992 онд 29.2 хувь байсан бол 1999 онд 21.4 болж бууран айл өрхийн 46 хувь нь иоджуулсан давс тогтмол хэрэглэж байна.

Засгийн газар “Иод дутлын эмгэгтэй тэмцэх” Үндэсний хөтөлбөрийн бахлуурын тархалтыг 2000 он гэхэд 0.5 хувьд хүргэх, иоджуулсан давсаар хүн амын 95 хувийг хангах зорилтдоо хүрсэнгүй. Хүнсний давсны олборлолт хийдэг дотоодын давсны ордыг түшиглэсэн давс иоджуулах үйлдвэр байгуулагдаагүй, жижиг орд, нуураас иргэд өөрсдөө хүнсний давс олборлож хэрэглэсээр байна. Тухайлбал, өрхийн түвшинд иоджуулсан давсны хэрэглээ төвийн бүсэд 63.6 хувь байхад давсны орд бүхий баруун бүсэд 24.3 хувь байна. Давсанд гүн боловсруулалт хийж цагаан давс үйлдвэрлэх техник, технологи нэвтрээгүйгээс энэ төрлийн импортын давсны хэмжээ өсч байна.[3]

➔ **Өрхийн хүнсний хэрэглээ**

Зохистой хоол хүнс нь хүний бие махбод, түүний эрхтэн системийн хэвийн үйл ажиллагааг хангахад зайлшгүй шаардлагатай байдаг.

Манай оронд 1960-аад оны сүүлчээс эхлэн хүн амын хоол тэжээлийн бодит байдлыг тодорхой бүлэг хүмүүсийн илч зарцуулалттай холбон судалж иржээ.

ЭМНХЯ-ны сайдын 1997 оны А/318 тоот тушаалаар баталсан “Хүн амын хоол тэжээлийн зөвлөмж хэмжээ”-д заасан “Жишсэн дундаж хүнд хоногт ноогдох хүнсний бүтээгдэхүүний жагсаалт”-аар насанд хүрсэн хүн хоногт дунджаар 230 гр мах, махан, 380 гр гурил, гурилан, 340 гр сүү, сүүн бүтээгдэхүүн, 27 гр цөцгийн тос, 60 гр сахар чихрийн зүйл, 120 гр төмс, 200 гр хүнсний бусад ногоо, 25мл ургамлын тос, 45 гр будаа, 280 гр жимс, 4 гр загас, загасан бүтээгдэхүүн, 7 гр өндөг хэрэглэснээр 104.85 гр уураг, 76.23 гр өөх тос, 406.74 гр нүүрс ус бүхий 2731.18 ккал илчлэгийг хоол хүнсээрээ авч байхыг тогтоосон байна.

1999 оны өрхийн хүнсний хэрэглээ судалгаагаар хотын өрхийн нэг гишүүний хоногт хэрэглэж байгаа мах, махан бүтээгдэхүүн, цөцгийн тос, ялангуяа аминдэм, эрдэс бодисын эх үүсвэр болох төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний хэрэглээ, хангамж нь зөвлөмж хэмжээнээс хэт доогуур байгааг тогтоожээ.

Харин хүнсний бүтээгдэхүүний илчлэг, шимт чанарыг судлахад: хоногийн хэрэгцээт илчлэгийн 86.2%, уургийн 76.0%, өөр тосны 120.8%, нүүрс усны 74.2%, эслэгийн 1.1%, А аминдэмийн 33.5%, С аминдэмийн 83.3%, В1 аминдэмийн 71.1%, В2 аминдэмийн 83.3%, фосфорын 62.2%, төмрийн 70.0%-ийг хангаж байна. Өөрөөр хэлбэл

дээр дурьдсан хүнсний бүтээгдэхүүний хэрэглээтэй холбоотойгоор зарим аминдэм, эрдэс бодисын хангамж зөвлөмж хэмжээнээс доогуур байна.

Хүнсний бүтээгдэхүүний хэрэглээ өрхийн орлогоос хамааралтай байсан ба өрхийн нэг гишүүнд оногдох сарын дундаж орлого багасах тутам хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл, хэрэглэх хэмжээ эрс буурч байна. Тухайлбал: хотын АБТ-ээс доогуур орлоготой өрхийн нэг гишүүн нь дээгүүр орлоготой өрхийн нэг гишүүнээс төрөл бүрийн хүнсний ногоог 1.9, ургамлын тосыг 3.7, жимс, жимсгэнийг 6.2, сүү, сүүн бүтээгдэхүүнийг 4.7 дахин бага хэрэглэж байна.

Үүнийг илчлэгийн зөвлөмж хэмжээтэй харьцуулахад хотын АБТ-ээс дээгүүр орлоготой өрхийн нэг гишүүний хоногийн хоолны илчлэгийн хангамж 135% буюу ДЭМБ-ын зөвлөмжөөр физиологийн нормоос хэтэрсэн, харин АБТ-ийн өрхийн нэг гишүүний хоногийн хоолны илчлэгийн хангамж 96.2% буюу физиологийн нормыг хангаж байхад АБТ-ээс доогуур орлоготой өрхийн нэг гишүүний хоногийн хоолны илчлэгийн хангамж дөнгөж 68.5%-тай тэнцүү буюу физиологийн нормоос ихээхэн доогуур байна.

Хөдөөгийн өрхийн хүнсний хэрэглээг Улаанбаатар хотынхтой харьцуулахад: хөдөөгийн өрхийн нэг гишүүний мах, махан, сүү, сүүн, гурил, гурилан бүтээгдэхүүний хэрэглээ харьцангуй их, харин төмс, хүнсний ногоо, ургамлын тос, жимс, жимсгэний хэрэглээ бага байна. Хөдөөгийн хүн амын хүнсний бүтээгдэхүүний хэрэглээний нэр төрөл цөөн төдийгүй хот, хөдөөгийн өрхийн хүнсний бүтээгдэхүүний хэрэглээнд зарим нэг ялгаатай тал ажиглагдаж байна. Тухайлбал: Улаанбаатар хотын АБТ-ээс дээгүүр орлоготой өрхийн нэг гишүүн ургамлын тос, цэцгийн тос, төрөл бүрийн хүнсний ногоог нэмүү хэрэглэж байхад хөдөөгийн АБТ-ээс дээгүүр орлоготой өрхийн нэг гишүүн өөхөн тос, сүү, сүүн бүтээгдэхүүнийг нэмүү хэрэглэж байна.


Хөдөөгийн өрхийн нэг гишүүний хоногт хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний нийт илчлэг, шимт бодисууд нь хөдөөгийн дундаж хүн амын уураг, илчлэг болон В1 аминдэмийн физиологийн нормыг хангаж байгаа ба харин өөх тос болон А аминдэм, кальцийн хэрэглээ физиологийн нормоос хэтэрсэн байгаа нь өөх тостой мах, өөхөн тос, сүү, сүүн бүтээгдэхүүнийг түлхүү хэрэглэдэгтэй холбоотой байж болох юм. Харин нүүрс ус, бусад эрдсийн бодисууд нь физиологийн нормдоо ойртож, бусад аминдэмийн хэрэглээ физиологийн нормоос доогуур болон хэт доогуур байгаа нь хоногийн хоолондоо төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийг бага хэрэглэдэгтэй холбоотой юм. Гэвч дээрх үзүүлэлтүүдээс С аминдэмийн агууламжаас бусад нь Улаанбаатар хотын өрхийн нэг гишүүний жишсэн дундаж хэрэглээнээс илүү агууламжтай байна.

Хүнсний бүтээгдэхүүний хэрэглээ хөдөөд мөн өрхийн амьжиргаанаас хамааралтай байна. Тухайлбал: Хөдөөгийн АБТ-ээс дээгүүр орлоготой өрхийн нэг гишүүний хоногийн хоолны илчлэгийн хангамж 134.5% буюу физиологийн нормоос хэтэрсэн, харин АБТ-ийн өрхийн нэг гишүүний хоногийн хоолны илчлэгийн хангамж 104.4% буюу физиологийн нормыг хангаж байхад АБТ-ээс доогуур орлоготой өрхийн нэг гишүүний хоногийн хоолны илчлэгийн хангамж дөнгөж 58.1%-тай тэнцүү буюу хагас өлсгөлөнгийн байдалтай байна.

Үүнээс харахад АБТ-ээс доогуур орлоготой өрхийн нэг гишүүн (хотод өрхийн нэг гишүүнд <17600; хөдөөд <13000-14600 төгрөг оногддог) хоногийн хэрэгцээт илчлэгийнхээ дөнгөж 58.1-68.5%-ийг авч физиологийн нормоос хэт доогуур илчлэгийг хэрэглэж байгаа болон хагас өлсгөлөнгийн байдалтай амьдарч байна.

Айл өрхийн давсны хэрэглээг судлахад насанд хүрсэн үн хоногт дунджаар 15.2 гр давс хэрэглэж байгаа нь ДЭМБ-ын зөвлөмж болгож буй хэмжээнээс бараг 2 дахин их байна. Ялангуяа баруун бүсийн хүн амын давсны хэрэглээ хамгийн өндөр байна.

Насанд хүрсэн хүний 64.9% нь хэвийн, 27.7% нь илүүдэл жинтэй, 7.4% нь тураалтай байна. АБТ-ээс дээгүүр орлоготой өрхийн гишүүдийн дунд тураал 4.2%, илүү жин 43.1% байхад АБТ-ээс доогуур орлоготой өрхийн гишүүдийн дунд тураал 4.9%, илүүдэл жин 10.9%-тай байна. Насны бүлгээр авч үзвэл: 60-аас дээш насны хүн амд тураал эрс нэмэгдэж байна.[44(2)]



➔ Цэцэрлэгийн хүүхдийн хоол тэжээлийн байдал

Хүүхдийн хоолны илчлэгийн хангамж өдрийн цэцэрлэгт физиологийн хэрэгцээний 70%-ийг хангах ёстой боловч 2004 онд Улаанбаатар хотын цэцэрлэгүүдэд хийсэн шалгалт-судалгаагаар 47-64%-ийг хангаж, үндсэн шимт бодисын 43-64%-ийг хангаж байна. ДЭМБ-ын 1990 онд гаргасан “Хүн амын хооллолтын түвшинг үнэлэх” зөвлөмжөөр хоногийн хоолны илчлэг нь физиологийн нормын 50-60 хувийг хангаж байвал тухайн хүнийг “хагас өлсгөлөн”-гийн байдалд оржээ гэж үздэг. Тэгвэл тухайн цэцэрлэгүүдэд хүмүүжиж байгаа 4-7 насны хүүхдүүд нэг ёсондоо “хагас өлсгөлөн”-ийн байдалд байна гэж хэлэх үндэслэлтэй байна. Хүнсний бүтээгдэхүүний нэр төрлөөр авч үзвэл: илчлэгийнхээ 50-70%-ийг зөвхөн мах, гурилан бүтээгдэхүүнээс авч байна. Хүүхдийн хоолоор авч байгаа тухайн илчлэгт эзлэх шимт бодисуудын зохистой харьцаа алдагдсан ба үүний дотор амьтны гаралтай өөх тосны (ханасан тосны хүчил) хэрэглээ 2 дахин их байна. Хүүхдийн бие махбодид чухал шаардлагатай амин дэм, эрдэс бодисын эх үүсвэр болсон жимс, ногоог хэрэглэвэл зохих нормын хэмжээнээс 2-3 дахин, сүү, сүүн бүтээгдэхүүнийг 5-6 дахин бага хэрэглэж байна. Энэ нь хоолны цэсийг 7-14 хоногоор зохион мөрддөг боловч, цэсийг боловсруулахдаа хүүхдийн физиологийн хэрэгцээний шаардлагыг харгалзахгүйгээр зөвхөн хүнсний бүтээгдэхүүний нэр төрөлд зохицуулан хийдгээс нэг хоол дахин давтагдан хийгдэж байгаатай холбоотой юм.[44(6)]

Ингэж цэцэрлэгийн хоол хүнсний хангамж физиологийн хэрэгцээг хангахгүй байгаагийн гол шалтгаан нь 19... онд Нийслэлийн Засаг даргын ... тоот захирамжаар цэцэрлэгийн хүүхдүүдийн хоногт хоол хүнсэнд зарцуулах нийт төсвийг нэг хүүхдэд 361 төгрөг байхаар тогтоож, үүний 50%-ийг эцэг эхээс төлүүлэхээр тогтоосон нь өнөөгийн зах зээлийн үнийн ханш болон хүүхдийн хоол хүнсний физиологийн нормыг огт харгалзаагүйтэй шууд холбоотой байна.

2004 оны 11-р сард НМХГ-аас Улаанбаатар хотын 24 цагийн ажиллагаатай цэцэрлэгүүдэд хийсэн шалгалтын дүнгээс үзэхэд шалгалтанд нийт 6 дүүргийн 11 цэцэрлэг хамрагджээ. Тэдгээр цэцэрлэгийн 4-т нь бодит хооллолтын байдлыг тооцоолох аргаар хоолны цэсэнд анализ хийх байдлаар судлахад хүүхдийн хоногт хоол хүнсээр авах ёстой илчлэгийн физиологийн норм(2000 ккал)-ыг нийт цэцэрлэгийн хоолны илчлэг хангахгүй байсан ба дунджаар нийт илчлэгийн хэмжээ физиологийн нормын 43.6%-ыг дөнгөж хангаж байгаа нь Эрүүл мэнд, ШУБ-ын сайдын хамтарсан А140/451 тоот тушаалаар баталсан илчлэгийн зөвлөмж хэмжээг хангахгүй байна. Энэ нь ДЭМБ-ын зөвлөмжөөр физиологийн нормын 50-аас бага хувийг хангаж нэг ёсондоо тухайн цэцэрлэгүүдэд хүмүүжиж байгаа 4-7 насны хүүхдүүд “өлсгөлөн”-ийн байдалд байна. Тэдгээр цэцэрлэгүүдийн хоолны нэр төрөл цөөн, амт чанар муугаас гадна, хүүхдүүдийн хоногийн хоол хүнсээр авах үндсэн шимт бодисууд болох уургийн физиологийн хэрэгцээний 70.1%, өөх тосны 77.6%, илчлэгийн гол эх үүсвэр болсон нүүрс усны ердөө 30.9%-ыг хангаж байна. Мөн хоол хүнсээр авах эрдэс бодис, аминдэмүүдийн хэмжээ физиологийн хэрэгцээг хангахгүй байсны дотор сүү, сүүн бүтээгдэхүүнээр ихэвчлэн хангадаг хүүхдийн яс, булчин, шүд зэрэг бие бялдрын өсөлт хөгжилтөд зайлшгүй шаардлагатай кальцийн ердөө 7.9%, фосфорын 43.8%, магнийн 29.2%-ийг хангаж байна. Хоол хүнсний илчлэгийн хэрэгцээ хангалтын байдлыг цэцэрлэг тус бүрээр авч үзвэл: Баянгол дүүргийн 94-р цэцэрлэг бусад цэцэрлэгтэй харьцуулахад хамгийн бага хангамжтай байсан ба хэрэгцээт илчлэгийн ердөө 29.37%-ийг хангаж байсан бол Сонгинохайрхан дүүргийн 106-р цэцэрлэг хамгийн их буюу хэрэгцээт илчлэгийн 64.1%-ийг хангаж байгаа нь уг цэцэрлэгийн хүүхдүүд хооллолтын түвшингээр өлөн зэлмүүн байдалд байна. Дээрх цэцэрлэгүүдэд хүмүүжиж буй хүүхдүүдийн бие бялдрын өсөлт хөгжилтийн байдлыг судлахад судалгаанд хамрагдсан нийт 40 хүүхэд жингийн дутагдалтай, өсөлт хоцорсон байв. Ингэж хоол хүнсний хангамж туйлын бага байгаагийн шалтгаан нь нэгдүгээрт, хүүхдийн хоолны цэсийг хийхдээ нийлүүлж буй хүнсний бүтээгдэхүүнд зохицуулан гаргаж байгаа, хоёрдугаарт, хүүхдийн хоолны зардлыг ердийн үйл ажиллагаатай цэцэрлэгтэй болон бүх насны хүүхдүүдэд адилхан тогтоож, мөрддөгтэй холбоотой байна. [57]

Улаанбаатар хотын хэмжээнд 4-5 сувиллын ясли ажиллаж, түүнд хоол тэжээлийн дуталтай, эмзэг бүлгийн хүүхдийг сувилдаг гэх боловч тодорхой хэмжээний

төлбөртэй байдаг тул түүнд гол сувилуулах ёстой хүүхдүүд (тураалтай, сульдаа өвчтэй, эмзэг бүлгийн, ядуу өрхийн) хамрагдаж чадахгүй байна. Энэ талаар “Хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол тэжээл” үндэсний хөтөлбөрт тусгагдсан боловч хэрэгжилт нь хангалтгүй байна. [56]

Ийнхүү сургуулийн өмнөх насны хүүхдүүдийн хүмүүждэг гол байгууллага болох цэцэрлэгүүд нь Олон улсын “Хүүхдийн эрхийн тухай” Конвенцийн 24 дүгээр зүйлийн 2-ын с-д заасан “Хүүхдийг ... зохих тэжээллэг хоол хүнсээр хангах, мөн хөнгөн хялбар технологи хэрэглэх замаар өвчин эмгэг, өлмөн зэлмүүн байдалтай тэмцэх” гэсэн заалт болон Монгол улсын “Хүүхдийн эрхийг хамгаалах тухай” хуулийн 5 дугаар зүйлийн 2-т заасан “Хүүхдийн эрүүл мэнд өсч бойжих, ... эрхтэй. Хүүхдийг хувцас, хоол хүнс, ... зэргээр санаатай гачигдуулах, эрүүл ахуйн шаардлагад нийцээгүй хоол хүнсээр хангахыг хориглоно” гэсэн заалт болон мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 4-ийн 3-т заасан “хүүхдийн өсөлт хөгжилт, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн баталгаат хоол хүнс ... зэргээр хангах” гэсэн заалтуудыг ноцтойгоор зөрчиж байна.

Нөгөөтэйгүүр, ЭМШУИС-ын НЭМС-ийн багш Ц.Цэвэгдоржийн хийсэн тооцоо судалгаагаар хүний хоногт хоол хүнсээр авах илчлэг, шимт бодисуудын физиологийн хэрэгцээг хангахын тулд хоногт хэрэглэвэл зохих хүнсний бүтээгдэхүүний хэмжээг нэр төрлөөр гарган, тухайн бүтээгдэхүүн тус бүрийн тухайн үеийн зах зээлийн ханшаар үнийн дүнгээр илэрхийлбэл 2002 оны байдлаар 4-7 насны хүүхдэд хоногт 606.5 төгрөг зарцуулах шаардлагатай гэсэн тооцоо гардаг. Тэгвэл НЗД-ын дээрх захирамж нь хоногийн хоол хүнсний физиологийн хэрэгцээний ердөө тал хувийг хангахад чиглэж байна.[34]

Иймд Засгийн газар үйл ажиллагаа, тогтоол, захирамжийг холбогдох ОУ-ын болон өөрийн орны хууль тогтоомжийн дагуу өнөөгийн нөхцөл байдлыг харгалзан уян хатан, үндэслэл сайтай батлан гаргах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

➔ **Өсвөр насны хүүхдийн хоол тэжээл, эрүүл мэнд**

Улаанбаатар хотын Налайх, БЗД-ийн 12-15 насны 120 хүүхдэд хийсэн судалгаагаар судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 15% нь цус багадалттай, 28.6% нь Д аминдэмийн дуталтай байв. Судлагдсан нийт хүүхдийн 26.7% нь майга хөлтэй, 6.7% нь сариу хөлтэй, 19.2% нь өвдөгний үе томролттой, 58.3% нь шүдний цооролттой байв.

Хоногт хэрэглэж буй хоол хүнсний хувьд сүү, сүүн бүтээгдэхүүнүүдээс зөвхөн сүүг л судалгаанд хамрагдсан хүүхдийн 45% нь хэрэглэснээс нэг хүүхдийн хоногийн дундаж хэрэглээ 38 мл байгаа нь кальцийн болон хүний биед зайлшгүй шаардлагатай бусад тэжээлт бодисуудын гол эх үүсвэр болсон сүү, цагаан идээг туйлын бага хэрэглэж байна.

Өсвөр насны хүүхдийн хүнсний бүтээгдэхүүний хэрэглээнд гурил, мах, будаа, төмс зонхилж, аминдэм, эрдсээр баялаг, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, сүүн бүтээгдэхүүнүүд маш бага хувийг эзэлж байна. Тэд хаврын улиралд үндсэн шимт бодис, аминдэм, эрдсийн дуталд орох эрсдэлтэй байна.[44(4)]

Сургуулийн насны хүүхдүүд нь өдөрт дор хаяж 4-5 цаг сургууль дээр өнждөг бөгөөд унд, цайны цагаар хүүхдүүд ихэвчлэн сургуулийн цайны газарт үйлчлүүлдэг билээ. Гэтэл цайны газрууд нь хувьд шилжсэнээс ихэвчлэн түрээсийн хувь хүн, аж ахуйн газрууд эзэмшдэг байна. Тэнд өдөртөө хямд үнэтэй хуушуур, бууз, пирожки зэрэг хүнсний цөөн нэр төрлийн, гол төлөв өөх тос ихтэй түүхий эдээр, хуршсан тосонд чанаж, шарж хийсэн хоолоор үйлчилдэг нь өнөөдөр хэвийн үзэгдэл болжээ. Эсвэл хувийн жижиг үйлдвэрт хийсэн чанар муутай гурилаар хийсэн гөөхий зэргээр сургуулийн хүүхдүүд өдөртөө ихэвчлэн хооллодог байна. Учир нь сургуулийн хүүхдүүд ихэвчлэн мөнгөөр дутмаг, эцэг, эхийн өгсөн цөөн хэдэн мөнгөөр хямд үнийг харж хооллодог ажээ. Гэтэл энэ нь тэдний өсч бойжиж буй залуу бие махбодь, эд, эсийн өсөлт, төлжилтийн хэрэгцээ шаардлагыг огт нөхөж чаддахгүйгээр барахгүй тэдний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хүчин зүйл болж байна. Сургуулийн хүүхдийн хооллолтын байдлыг төр засгаас огт анхаарч, арга хэмжээ авахгүй байна. Өнөөдөр манайд хоол боловсруулах эрхтний хорт хавдар, өвчлөл өндөр байгаагийн эх суурь нь хуршсан тосонд чанасан хуушуур, пирожки идэж хэвшсэн энэ үеээс эхэлдэг байх

магадлалтай юм. иймд сургуулийн насны хүүхдийн хооллолтын байдлыг цаашид судалж, хоол хүнсний хортой нөлөөний алсын үр дагаврыг холбон судлах зайлшгүй шаардлага гарч байгаа юм.

➤ **Өндөр настны хоол тэжээл, эрүүл мэнд**

Улсын асрамжийн газрын асруулагчдын бодит хооллолтын байдлыг судалсан дүнгээс үзэхэд: Манай улсын хүн амын 6.9%-ийг өндөр настан эзэлдэг бөгөөд тэдний 29.6% нь амьдралын баталгаа муутай, 8.4% нь ганц бие амьдарч нас нь ахих тутам өөрийгөө асран халамжлах чадваргүй болдог. Ийм нөхцөлд өндөр настанд үзүүлэх эрүүл мэндийн болон бусад тусламж, үйлчилгээ хангалтгүй байдгаас сүүлийн жилүүдэд асрамж халамжийн газар очих нь ихэсч байна. Манай оронд улсын гэсэн нэг л асрамжийн газар байдаг байна.

Судалгаанд Батсүмбэр дэх Улсын асрамжийн газрын нийт 61 хүнийг хамрагдсаны 20-37.2% нь тураалтай байгаа нь хоол тэжээлийн зохистой найрлага алдагдсантай холбоотой байж болох талтай. Хоол хүнсэнд сүү, цагаан идээ болон жимс, жимсгэнийг хэрэглэхгүй байгаа нь хоол тэжээлээр авах чухал аминдэм, эрдэс бодисын дутагдалт орох шалтгаан болж байна.[44(8)]

➤ **Усны чанар, хангамж, хүрэлцээ, аюулгүй байдал.**

Хүн амын ундны усны чанар, унд ахуйн усны эх үүсвэрийн аюулгүй байдлыг хангах нь нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлын нэг билээ. Хөгжиж буй орнуудад бүх өвчин эмгэгийн 80%, нас баралтын гуравны нэг нь бохир ус хэрэглэснээс үүдэлтэй байна.

ДЭМБ-ийн 2002 оны илтгэлд, дэлхий нийтийн болон бүс нутгийн хүрээнд хамгийн түгээмэл тохиолдож буй 10 эрсдэлт хүчин зүйлийн нэгд бохир ус, эрүүл ахуй, ариун цэврийн асуудал орж байгааг дурджээ. Жил бүр дэлхий дээр 1.7 сая хүн усны бохирдолт, ариун цэвэр, эрүүл ахуйн асуудалтай холбоотой халдварын шалтгаант суулгалт өвчний улмаас нас бардаг. Ийнхүү нас барж буй 10 хүн тутмын 9 нь бага насны хүүхэд байгаа бөгөөд бүхэлдээ хөгжиж буй орнуудад тохиолдож байна.

Манай орны хувьд ХӨСҮТ-ийн мэдээллээр 1999 оны 9, 10-р саруудад Дундговь аймгийн төвд гэр хорооллын хүн амын дунд усаар халдвар дамжсаны улмаас 19 хүн гэдэсний балнадаар өвчилсөн байна. Мөн 2000 оны 7- сараас Өвөрхангай аймагт вируст гепатит А дэгдэлт хэлбэрээр бүртгэгдэж, Арвайхээр хотод өвчлөлийн тохиолдол 291-д хүрч, 10000 хүн амд 138.9% буюу аймгийн дунджаас 3 дахин ихэссэн байна. Уг дэгдэлтэд нөлөөлсөн хүчин зүйлсийг тогтооход нийт 96 өвчтөний 93.7% нь гэр хороололд амьдардаг бөгөөд усны эх үүсвэрийн байдлыг судлахад 58.3% нь ус түгээх цэгээс, 35.5% нь ил задгай уснаас, 6.25% нь төвлөрсөн усан хангамжийн крантны ус хэрэглэдэг байна. Ундны усны эх үүсвэрт хийсэн шинжилгээгээр 4 усан сангийн усанд нянгийн бохирдол илэрч, колититр, колииндексийн үзүүлэлт өөрчлөгдөн, нитрит 0.002мг/дм³ хэмжээтэй илэрсэн байна. Дэлгэрэх булаг хэмээх ил задгай усан санд нянгийн тоо тоолох боломжгүй их илэрч, колииндекс 960 хүртэл өөрчлөгдөн, нитрит илэрсэн байна. Энэ усаар дамжиж гэдэсний халдварт өвчин дамжих нөхцөлийг бүрдүүлжээ.

2002 онд Улаанбаатар Баянзүрх дүүргийн 2-р хорооны нутаг дэвсгэрт оршин суудаг хүн амын дунд хэрэглэж буй усан хангамжийн эх үүсвэр болон тэдний өвчлөлийн байдалд судалгаа хийхэд: Тэдний хэрэглэдэг Дарь-Эхийн булгийн усанд хийсэн хими болон нянгийн шинжилгээгээр булгийн ус нь нянгийн болон шим бохирдолтой гарч хүн амын ундны усны хэрэгцээнд тохирохгүй байжээ. Айл өрхөд хадгалагдаж буй ундны усны нянгийн бохирдолтын түвшин усны эх үүсвэрийн устай харьцуулахад өндөр гарч, өөрөөр хэлбэл ундны усыг гэрийн нөхцөлд хадгалах явцад бохирдож байна.

Тухайн хороо нь Улаанбаатар хотын бусад хороо, дүүргээс хамгийн олон оршин суугчтай, зөвхөн гэр хороолол байдаг онцлогтойн дээр уг хороонд жилийн жилд халдварт өвчин хамгийн их гардаг ажээ. Тухайн жилд суулгалт болон гэдэсний халдварт өвчний 255 тохиолдол гарч, 10000 хүн амд 213.5 байсан ба үүний дотор

суулгалт өвчин 83.5%”ийг суулгалт өвчин эзэлж, 10.1%-ийг цусан суулга, үлдсэн хувийг халдварт шар, сальмонеллэз өвчин эзэлж байв.

Хүн амын дундах суулгалт өвчний өвчлөл нь ундны усны нян, шим бохирдолтын түвшинтэй шууд хамааралтай байлаа.[43]

Хот, хөдөө, орон нутгийн усан хангамжийн объектуудад унд-ахуйн устай холбоотой хууль, эрх зүйн актууд, тухайлбал “Усны тухай”, “Ариун цэврийн тухай” хуулийн усны нөөцийг зохистой ашиглах, ус ашиглалтын явцад түүнийг бохирдлоос хамгаалах зэрэг үндсэн заалтууд зөрчигдөж байна. Тухайлбал, Улаанбаатар хотод сүүлийн 10 жилд ундны усны чанар, аюулгүй байдалд хийсэн судалгаанаас харахад химийн үзүүлэлтээр Б, В станцуудын шим бохирдлын түвшин, 4, 10 дугаар саруудад ЗДХ-ээс их байна.

Ундны усны дээд эх үүсвэрийн гүний худгуудын ариун цэврийн хамгаалалтын бүсүүдэд зуны цагт 60 гаруй айл жил бүр зусланд гарч, Гачуурт, Хар усан тохойн орчимд хашаа, байшин, амралтын газрууд баригдаж, 70 гаруй га газарт хувь хүмүүс ногоо тариалж химийн бордоо, малын өтөг бууцаар бордож, энгийн бие засах газар, бохир усны цооног зэргийг байгуулсан нь усны эх үүсвэрийг ахуйн болон химийн бодисоор бохирдох нөхцөлийг бүрдүүлж байна.

Усан хангамжийн эх булгуудад илэрсэнн зөрчлийн 85.8% нь төвлөрсөн бус усан хангамжийн эх үүсвэрүүдэд илэрч байна.[41]

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



2.5. Өрхийн хүнсний хангамж баталгаа (Household Food Security)

Бүлэг 2.2-т ДХХААБ хүнсний хангамж, баталгааг “хүн бүр амьдралынхаа туршид эрүүл саруул, үр бүтээлтэй амьдрахын тулд хоногийн хоолны хэрэгцээг хангахуйц шим тэжээллэг, аюулгүй, хүрэлцэхүйц хэмжээний хоол хүнсийг олж авах (хүртэх) бие бялдрын болон эдийн засгийн чадвартай байхыг хэлнэ” гэж тодорхойлсон байдаг тухай өгүүлсэн.

Тэгвэл **ӨРХИЙН ХҮНСНИЙ ХАНГАМЖ, БАТАЛГАА** гэдэг нь өрхийг жилийн туршид түүний бүхий л гишүүдийн хоногийн хоолны хэрэгцээг чанартай хоол хүнсээр зохих түвшинд хангахыг хэлнэ. Өрх гэр хоол хүнсээ “үйлдвэрлэл” ба “худалдан авах” гэсэн 2 үндсэн арга замаар хангаж чаддаг. Энэ 2 зам нь хоёул тохирох эх үүсвэр буюу орлого шаарддаг. Бусад хоол хүнсээ олж авах ач холбогдол багатай, хялбар бус аргууд болох хоол хүнсийг бэлгийн буюу буяны замаар, эсвэл засгийн газрын тусламжаар олгох, сургуулийн үнэгүй хоол буюу хоолны талон зэрэг аргууд бас байж болно.

Бүлэг 2.2-т хүнсний үйлдвэрлэлийн бууралт ба хүнсний хомсдол нь хоол тэжээлийн дутагдлын өвчний гол шалтгаан болдог тухай өгүүлсэн байдаг. Хөдөө аж ахуйн хүнсний үйлдвэрлэл нь үндэсний болон орон нутгийн хүнсний хангамжийн үндэс суурь болох ач холбогдолтой байдаг. Хүнсний хангамж, баталгаа бүхий л түвшинд ач холбогдолтой болох нь ажиглагддаг боловч өрхийн түвшинд бүр илүү ач холбогдолтой байдаг.

Хүүхдийн (буюу өрхийн) хүнсний хангамж, баталгаа нь хоол тэжээлийн дутлаас сэргийлэх 3 чухал бүрэлдэхүүн хэсгүүдийн (зохистой эрүүл мэнд ба тусламж үйлчилгээний хамт) нэг билээ. Хувь хүний хүнсний хангамж баталгаа нь хоол тэжээлийг хэвийн байлгахад зайлшгүй шаардлагатай байдаг боловч хоол тэжээлийн байдлын баталгаа болдоггүй. Учир нь өвчин эмгэг, тогтмол бус хооллолт, тусламж үйлчилгээний хүртээмж муу, хоолны дуршил муудах зэрэг хүчин зүйлс нь хоол тэжээлийн байдалд сөрөг нөлөө үзүүлж байдаг.

Хүнсний хангамж, баталгаат байдалд тавигдах шаардлагуудад:

- Хоол хүнсээр хүрэлцэхүйц хэмжээгээр хангагдах;
- Хүнсний хангамж нь жилийн туршид болон жилээс жилд тогтвортой байх;
- Хоол хүнс олж авах бие бялдрын болон эдийн засгийн боломж, өрх болон түүний гишүүн бүрт хэрэгцээт бүхий л хоол хүнсийг үйлдвэрлэх буюу олж авах чадвар болон мөнгөтэй байх зэрэг асуудлууд багтдаг.

Өрхийн хүнсний хангамж, баталгаа алдагдахад нөлөөлөгч гол хүчин зүйл бол ядуурал юм. Ази, Африк болон Латин Америкт хүн амын нилээд хувь нь хот, хөдөөд хоёуланд нь ядууралд өртөж байна. Бүх ядуу хүмүүс хоол хүнсний хомсдолтой байдаг бол ихэнх хоол хүнсний хомсдолд орсон хүмүүс ядуу байдаггүй.

Улс орон бүр, тэрбүү хэл хоол хүнс нь баталгаатай улсын өрхийн хүнсний баталгаа нь зарим талаараа орлогын тэгш байдлыг шаардах, газрыг хуваарилах болон үйлчилгээг хүргэх байдлаас хамаардаг байна. Үндэсний бодлого нь зөвхөн фермерүүдэд тусалж хүнсний үйлдвэрлэл сайжрахад хүргээд зогсохгүй, хүмүүст хоол хүнсний шаардлагыг хангахад нь тусалж болно. Өрхийн хүнсний хангамж, баталгаанд хэдийгээр өрхийн түвшин дэх чадавхи хамгийн их нөлөөлдөг боловч үйлдвэрлэл, орон нутаг, үндэстэн болон олон улсын түвшин дэх үйл ажиллагаа бас нөлөөлдөг байна.

➤ Өрхийн хүнсний хангамж, баталгаа алдагдах хэлбэрүүд

Өрхийн хүнсний хангамж, баталгаа нь өөр өөрийн хариу үр дагавар бүхий өөр өөр хэлбэрээр бий болдог. Хүнсний хангамж баталгаагүй байдал нь ужиг удаан үргэлжилсэн (байнга хомс хоол хүнс бүхий өрхөд) байна уу эсвэл түр зуурын (түр зуурын хямралаас үүдсэн) байна уу гэдгээс хамаарч үүсэх арга зам нь янз бүр байдаг. Хүнсний гачигдал нь улирлын чанартай байж болдог. Тухайн өрх жил бүр буюу ихэнх жилийн зөвхөн тодорхой улиралд хүрэлцэхүйц хэмжээний хоол хүнсгүй болж болно.

Өрхийн хүнсний хангамж баталгаагүй байдлын үр дагавар нь заримдаа өрхийн хоол хүнсний дотоод хуваарилалтаас хамаарч харилцан адилгүй байдаг. Зарим өрх хоол хүнсний баталгаагүй байдлыг үл харгалзан хүүхдийн өсөлт хөгжилт болон эрүүл мэндэд нь шаардлагатай бүхий л хоол хүнсээр үр хүүхдээ тэжээдгээс насанд хүрсэн хүмүүст нь хоол тэжээлийн дутагдлын шинж тэмдгүүд үүсч болох бөгөөд тэдний идэвх багасч, хөдөлмөрийн бүтээмж буурснаар энерги зарцуулалт нь багасч байдаг. Хоёр дахь өрхийн хувьд өрхийн тэргүүн нь байнга хоол хүнсний хэрэгцээгээ эхлээд хангадаг байж болох ба түүнээс илүү гарсныг өрхийн эзэгтэй, хамгийн сүүлд нь хүүхэд нь иддэг байж болно. Ийм өрхөд хүүхдүүдэд хоол тэжээлийн дутагдал илэрдэг. Гэвч зарим үед хүнс үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэж буй хоол хүнсний илчлэг болон шимт бодисын зохистой хэмжээ болон худалдан авах чадвар нь өрхийн хоол хүнсний хэрэгцээнд чухал үүрэг гүйцэтгэдэг байж болно.

Хүнсний хангамж баталгаа алдагдахад хамгийн их өртдөг буюу хүнсний гачигдлын өндөр эрсдэлтэй өрхөд нэн ядуу өрх ордог. Хөдөөд ийм өрхүүдэд малгүй, газаргүй айл өрх; ам бүлийн тоотой харьцуулахад хөдөө аж ахуйн зохистой үйлдвэрлэл явуулах боломжгүй бага хэмжээний газартай (эсвэл өчүүхэн газартай) өрх; үйлдвэрлэсэн үр тарианаас харьцангуй бага хувийг авдаг үр тарианы хувь нийлүүлэгч буюу түрээсийн тариаланчид; малынхаа ашиг шимийг төдийлөн авч чадахгүй байгаа цөөн малтай малчид болон бусад маш бага орлоготой буюу өрхийн хэрэгцээнээс ч бага хүнс үйлдвэрлэдэг өрх; өрх толгойлсон эмэгтэй; нас, өвчин, тахир дутуу болон бусад шалтгаанаар насанд хүрсэн хүмүүс нь хөдөлмөрийн чадваргүй болж хараат байдалд орсон ядуу өрх байж болно.

Хотод хүнсний хангамж, баталгаа алдагдах явдал нь хүүхэдтэй өрх толгойлсон эмэгтэй, ганц бие өндөр настан, ядуу зүдүү болон орон гэргүй хүн болон эрүүл мэндийг доройтуулагч архаг өвчин буюу тахир дутуугийн хүнд хэлбэр зэргээс ажилгүй болсон өрх болон нэн ядуу өрхөд илүү ихээр тохиолддог.

Өрхийн хүнсний баталгаат байдалд нөлөөлөх асуудлууд дотор үр тариаг бэлэн мөнгө болгох, өрхийн ногооны талбай, хот, хөдөөгийн хүнсний хангамж, үйлдвэрлэл болон худалдааны үнэ, хүнсний үйлдвэрлэлийг сайжруулах боломж, хүнсний хадгалалт болон хангамжийн тогтвортой байдал, ажил эрхлэлтийн асуудлууд, хөдөлмөрийн хүнд, хөнгөн ажлууд зэрэгт орон нутгийн хүнсний хангамжийн хүрэлцээ чухал ач холбогдолтой байдаг. Үндэсний хэмжээнд эдгээр асуудлуудын заримыг шийдвэрлэхэд хөдөө аж ахуйн яам болон бусад байгууллагуудын үүрэг оролцоо шийдвэрлэх нөлөөтэй байдаг.

Өрхийн хүнсний баталгааг хангах 3 чухал хэрэгцээ бол орон нутгийн хүрэлцэхүйц хүнсний хангамж, хүнсний тогтвортой байдал ба олдоц билээ. Хоол тэжээлийн баталгааг хангах үүднээс зохистой эрүүл мэндийн байдал болон зохистой тусламж үйлчилгээтэй байх ба сайн чанарын хоол тэжээлд шаардлагатай бүхий л шимт бодисоор хоол хүнс нь хангасан байх ёстой.[59]

Хүний эрхийн ойлголтоор ядуу хүн гэдэг нь хоол хүнсээр хангагдах эрх, эрүүл байх эрх, сурч боловсрох эрх зэрэг олон эрхээ эдэлж чадахгүй байгаа хүнийг хэлнэ.

Хүний амьд явахын үндэс нь зохистой хоол хүнс юм. Хоол хүнс дутмаг байснаас хүний тархины ажиллагаа хөгжихөө байж, биеийн өсөлт зогсож, өвчин, сэдрэн, хүч чадал нь хязгаарлагдаж, аргагүйн эрхэнд өлсөн арчаагүй амьдралд орж насан туршдаа тахир дутуу болох аюулт өртдөг. Өлсгөлөн хүүхэд хичээлдээ анхаарлаа төвлөрүүлж чадахаа больж, өлсгөлөн ажилчны ажлын бүтээмж буурдаг. Ядуурал нь хоол хүнсний дутагдалд оруулах ба хоол хүнс дутагдсанаас эргээд ядуурал нь улам гүнзгийрдэг.

Хоол тэжээлийн дутагдал, өлсгөлөн хоёр нь ядуурлын бүрэлдэхүүн хэсэг юм. Иймээс зохистой хоол хүнсээр хангагдах эрхээ эдлэх нь эрүүл байх эрх, сурч боловсрох эрх, хөдөлмөрлөх эрх зэрэг бусад эрхийг хангахад чухал үүрэгтэй. Энэ эрхийг тэжээлгэх биш, харин өөрөө өөрийгөө тэжээх эрх гэж ойловол зохино. Өлсөхгүй байх эрхийг хэрэгжүүлэх нь зохистой хоол хүнсээр хангагдах эрхийн заавал биелүүлэх ёстой наад захын шаардлага юм.[26]

Манайд өнөөдөр ядуу өрхүүд хоол тэжээлийн дуталд орсон байгаа тухай дээр өгүүлсэн билээ. Энэ тухай ч манай улс ЭЗНСЭТОУ-ын Пактын хэрэгжилтийн талаарх

ээлжит гурав дахь илтгэл(1998 он)-ийн “Тэжээллэг хүнсний хүртээмж болон ядуурлын байдал” хэмээх хэсэгтээ 1993 онд хийсэн түүвэр судалгаагаар ядуу өрхийн нэг хүний хоногт хэрэглэсэн хүнсний зүйлийн илчлэг дунджаар 1240 ккал байсан нь физиологийн нормын 30 гаруйхан хувь болж байгаа бөгөөд өрхийн ам бүлийн эрүүл мэндэд ноцтой нөлөөлөх түвшинд хүрсэн байна. Дээрх өрхүүд хүнсэндээ орлогынхоо дийлэнхийг зарцуулдаг байна.” гэж бичсэн байдаг.

Хороо уг илтгэлийн хариуд 2000 онд Ерөнхий зөвлөмж гаргасан ба түүний 13-т “Оролцогч-улс Монголын бүх хүн амын 42%-ийг эзэлж байгаа хүүхдүүдэд ядуурлын үзүүлэх нөлөөллийн сөрөг үр дагаврыг зөөлрүүлж чадаагүйд Хороо зовниж байна.” гээд 14-т “Тэтгэврийнхэн, цөөн малтай малчид, өрх толгойлсон эмэгтэйчүүд, настайчууд, ажилгүйчүүд, хүүхдүүд зэрэг эмзэг бүлгийнхний хүнсний аюулгүй байдалд учирч буй аюулын тухай оролцогч-улсын мэдээг Хороо харамсан хүлээж авав.”... дээрх асуудлуудад Хороо сэтгэл түгшиж буйгаа илэрхийлээд дараахь зөвлөмжүүдийг өгсөн байдаг. Үүнд:

22. Оролцогч-улсыг цаашдаа ядуучуудад хөрөнгө зарцуулж, өөрийн ээлжит дөрөв дүгээр илтгэлдээ дээр дурдагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар Хороонд мэдээлэхийг Хороо хичээнгүйлэн уриалж байна. Үүнтэй холбоотойгоор оролцогч-улс нь Хорооны №3 Санамжийн 12 дугаар хэсэгт заасны дагуу хөрөнгө мөнгөний онцгой гачаалыг үл харгалзан нийгмийн эмзэг бүлгийг хамгаалах үүрэг хүлээснийг Хороо сануулахыг хүсэж байна.

24. Оролцогч-улсыг хүн амын амин чухал хэрэгцээг хангахад тэргүүн зэргийн ач холбогдол өгөх, үүнд олон улсын хүмүүнлэгийн тусламжийг хадуулахыг Хороо хичээнгүйлэн уриалж, үүнтэй холбоотойгоор Оролцогч-улсын анхаарлыг өөрийн Ерөнхий санамжийн 14 дүгээр хэсэгт хандуулж байна.

2.5.1. ядуурал ба өрхийн хүнсний хангамж, баталгаа

➤ Макро эдийн засаг ба хүн амын амьжиргааны ерөнхий байдал

Сүүлийн 5 жилд Монгол улсын эдийн засагт нилээд өөрчлөлтүүд гарав. 1999-2002 онд Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-д ХАА-н эзлэх хувийн жин 36.5% байснаа 20.1% болж 2 дахин буурав. ДНБ-ний бүтцийн энэ өөрчлөлт гарсан 1999-2002 онд жил дараалан зуд, ган болсноор малын тоо бараг 30 хувиар буурав. 2002 оны байдлаар малын тооны бүтцэд өөрчлөлт орсон. Нэг хүнд ногдох ДНБ-ний өсөлт 1999-2002 онд 2 хувьд хүрсэн байна.

Улсын хэмжээгээр хүн амын 36.1% нь буюу 100 хүн тутмын 36 нь хүнсний болон хүнсний бус зайлшгүй шаардлагатай хэрэглээний зүйлийг худалдан авах чадваргүй ядуу байгаагийн дотор ядуурлын хамралтын хүрээ хөдөөд хотоос мэдэгдэхүйц өндөр (хөдөөд 43%, хотод 30%) байна. Ядуурлын түвшинг илэрхийлэгч ядуурлын гүнзгийрэлт болон ядуурлын мэдрэмжийн индекс ч мөн адил хөдөөд хотоос 4 пунктээр өндөр байгаа нь ядуурал хөдөөд илүү байгааг харуулж байна. Ядуу 9 хүний 5 нь сумын төв, хөдөөд, харин нийт ядуу хүн амын 1/3 нь хөдөөд (сумын төвөөс өөр газар) амьдарч байна. Ядуурлын энэ үндсэн хандлага нь макро-эдийн засгийн дээр дурьдсан өөрчлөлттэй хамааралтай.

1999-2001 онд цаг уурын байдлаас голлон хамаарч малын толгойн тоо ихээхэн хорогдсоноос нэмэгдсэн ядуурлын түвшинг бууруулахад хүн амын чөлөөтэй шилжих хөдөлгөөн ч нөлөөлсөн байж болох юм.

Зудын нөлөөллийг багасгах зорилгоор олон улсын байгууллага, донор улс орон, ТББ-уудаас 2000-2001 оны хооронд буюу нэг жилийн хугацаанд 24 сая ам. Долларын (ДНБ-ний 2.4%) тусламжийг авсан байна. Энэхүү тусламж нь малын хорогдлын нөлөөллийг саармагжуулахад нөлөөлсөн байх талтай ба өөр бусад үр дүнгүүд ч тодорхой хугацааны дараа илэрч болох юм.

Ядуурлын өсөлтөд эдийн засгийн салбарууд дахь тэгш бус байдал ч нэмэгдэж болно. Магадгүй энэ тэгш бус байдал нэмэгдсэнээс сүүлийн 5 жилд ядуурал өссөн байж ч болох юм.[42]

Мөн жил бүрийн хэрэглээний үнэ өмнөх оноосоо өсч байгаа нь ядууралд улам бүр нөлөөлж байна. Тухайлбал, хэрэглээний үнийн ерөнхий индекс өмнөх оноос 4.7%-аар өсч, үүнээс хүнсний бүтээгдэхүүний үнийн индекс 4.3%-аар өссөн байна. Хүнсний бүтээгдэхүүний үнэ жилийн туршид маш их хэлбэлздэг бөгөөд ялангуяа бүх нийтийн баяр ёслолын үеэр хэд дахин нэмэгддэг хандлага байна. Жишээлбэл, Улаанбаатар хотод энэ оны 2 сард бүх нийтээр баян, хоосонгүй өргөн тэмдэглэдэг уламжлалт баяр ёслол болох цагаан сараар мах, гурил, майонез зэрэг хүнсний бүтээгдэхүүний үнэ бараг 2 дахин өссөн бөгөөд үүний дотор майонезийн үнэ бараг 6 дахин өсч ард олныг бухимдуулсан явдал гарсан. Гэтэл хүний наад захын зайлшгүй хэрэгцээ болсон хоол хүнсний үнэ тарифт төр засгаас ямар нэг зохицуулалт, үнийн бодлого огт хийгддэггүй байна.

➔ **Ядуу өрхийн хүнсний хангамж, баталгаа**

Ядуу өрхийн хүнсний хангамж, баталгааг бүс нутгуудыг төлөөлж Улаанбаатар хот, Хэнтий, Дорноговь, Говь-Алтай, Архангай аймгуудын нийт 731 өрхөд асуулга судалгаа явуулж, ганцаарчлан ярилцаж тогтоов.

▪ **Өрхийн нийгэм-эдийн засгийн байдал**

Судалгаанд нийт 731 өрхийн 3926 хүн ам хамрагдсан бөгөөд нийт өрхийн 263 буюу 36%-ийг өрх толгойлсон эмэгтэй эзэлж байна.

Ам бүлийн тоогоор доод тал нь 1, дээд тал нь 15 ам бүлтэй өрхүүд судалгаанд хамрагдсан бөгөөд өрхийн дундаж ам бүлийн тоо 5 ± 2.0 байна.

Судалгаанд хамрагдсан өрхийн 656 буюу 89.7% нь 18-аас доош насны хүүхэдтэй байсан ба энэ нь нийт судалгаанд хамрагдсан хүн амын 1842 буюу 47%-ийг эзэлж байна. Харин 5-аас доош насны хүүхэдтэй өрх судалгаанд хамрагдсан өрхийн 385 буюу 52.6%-ийг эзэлж байсан ба нийт судалгаанд хамрагдсан хүн амаас 14.3% нь уг насны хүүхдүүд байв. Энэ нь нэг өрхөд дунджаар 18-аас доош насны 3 ± 1.3 хүүхэд, 5-аас доош насны 1 ± 0.75 хүүхэд оногдож байна. (Хүснэгт 2.5.1.)

Хүснэгт 2.5.1. Өрхийн ам бүл ба хүүхдүүдийн эзлэх хувь

Судалгаанд хамрагдсан	18 > насны хүүхэд		5 > насны хүүхэд		Нийт б/тоо
	б/тоо	%	б/тоо	%	
Өрх	656	89.7%	385	52.6%	731
Хүн ам	1842	47%	564	14.3%	3926
1 өрхөд ногдох хүн ам	Дээд тал нь	8	6		15
	Дунджаар	3	1		5

Нийт судалгаанд хамрагдсан өрхийн гишүүдийн 2084 нь буюу 53.1% нь насанд хүрсэн хүн ам эзэлж байгаа ба тэдгээрийн 53.9% нь ажилгүй хүн ам эзэлж, нэг өрхөд дээд тал нь 7 ажилгүй хүн, дунджаар 2 ажилгүй хүн ногдож байна. Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 75.6%-д нь ажилгүй хүн ам амьдарч байна. (Хүснэгт 2.5.2.) Үүнээс үзэхэд манайд хөдөлмөрийн чадвартай насанд хүрсэн хүмүүсийн тал хувь нь ажилгүй байгаа бөгөөд ажилгүйчүүдийг тэжээж буй өрх нийт өрхийн дотор түүнээс ч олон байгаа нь харагдаж байна.

Үүнийг 2003 оны улсын хэмжээний ажилгүйдлийн түвшинтэй харьцуулахад статистикийн мэдээгээр улсын хэмжээнд 2003 оны эцсийн байдлаар бүртгэгдсэн ажилгүйдлийн тоо 33.3 мянга, ажилгүйдлийн түвшин 3.5% байхад бидний хийсэн түүвэр судалгаагаар ядуу өрхүүдэд 53.9%-тай байгаа нь ажилгүй хүмүүсийн ихэнх нь АБТ-ээс доогуур орлоготой өрхөд байгаа нь харагдаж байна.

Хүснэгт 2.5.2. Өрхийн гишүүдийн ажил эрхлэлтийн байдал

Ажил эрхлэлт	Хүн ам		Өрх		1 өрхөд оногдох хүн	
	б/тоо	%	б/тоо	%	Дээд тал нь	дунджаар
Төрийн байгууллагад ажилладаг	165	7.9%	149	20.6%	3	1

Хувийн компанид ажилладаг	181	8.7%	150	20.5%	3	1
Хувиараа аж ахуй эрхэлдэг	159	7.6%	121	16.5%	5	1
Ажилгүй	1125	53.9%	553	75.6%	7	2
Бусад	454	21.8%				
Нийт	2084	100.0	731	100.0		

Ажилгүй гишүүд бүхий өрхүүдийг орон нутгаар ялгаж харвал: Улаанбаатар хотод нийт 387 өрхийн 71.3% нь ажилгүй гишүүдтэй өрх эзэлж байсан бол Архангай аймагт 88.0%, Хэнтий аймагт 91.7% нь ажилгүй гишүүдтэй өрх тус тус эзэлж байгаа нь ажилгүйдэл Хангай болон Зүүн бүсийн нутгуудад илүү их өндөр байгааг харуулж байна. Ажилгүй өрхийг хот, хөдөөгөөр нь ялгаж нийт өрхтэй харьцуулж үзэхэд: төв суурин газар амьдарч буй өрхөд (хотын нийт өрхийн 77.8%, хөдөөгийн 67.1% нь ажилгүйдэлтэй) ажилгүйдэл илүү давамгайл байгаа нь ажиглагдаж байна. (Хүснэгт 2.5.3.)

Хүснэгт 2.5.3. Ажилгүйдэлд хот, хөдөөгийн ялгаа


Аймаг, хот	Үүнээс:								
	Нийт өрх б/тоо	Хотод		Ажилгүй гишүүдтэй		Хөдөөд		Хөдөөд	
		б/тоо	б/тоо	б/тоо	б/тоо	%	б/тоо	%	б/тоо
Улаанбаатар	387	387		276	71.3	276			
Хэнтий	96	47	49	88	91.7	44	93.6	44	89.8
Говь-Алтай	100	50	50	70	70.0	42	84.0	28	56.0
Архангай	50	50		44	88.0	44	88.0		
Дорноговь	98	48	50	75	76.5	47	97.9	28	56.0
Нийт	731	582	149	553	75.6	453	77.8	100	67.1

Боловсролын байдлаар судалгаанд хамрагдсан нийт өрхийн тэргүүний 282 буюу 38.6% нь бүрэн бус дунд боловсролтой байгаа нь хамгийн их хувийг эзэлж байна.

Судалгаанд хамрагдсан ихэнх өрх буюу нийт өрхийн 70.9 нь орлогын ганц эх үүсвэртэй байна. Өрхийн сарын орлогын эх үүсвэрүүдээс бусад газар ажилласан цалин хөлс (37.8%) болон тэтгэвэр, тэтгэмж (36.3%) хоёр нь хамгийн их хувийг эзэлж, тэдгээрийн дараа хувийн хөдөө аж ахуйн бус орлого (18.6%) орж байгаа нь судалгаанд хамрагдсан өрхийн амьжиргааны гол эх үүсвэр нь бусад газар ажиллаж орлого олох болон тэтгэвэр, тэтгэмжээр амь зуух явдал болж байна. (Зураг 2.5.1.)

Өрхийн хөдөө аж ахуйн орлого сарын нийт орлогын эх үүсвэрийн 10.1%-ийг эзэлж байгаа бөгөөд үүний 77%-ийг өөрийн мал аж ахуйгаас, 20.7% нь газар тариалангийн орлого, үлдсэн хувь нь хоёулангийн нь эрхэлж олсон орлого эзэлж байна. Өрхүүдийн эрхэлж буй бусад аж ахуй 66.2%-ийг арилжаа наймаа эзэлж байгаа бөгөөд үүнд ихэвчлэн зах дээр гар дээрээс худалдаалдаг жижиглэн худалдаа гол байр суурийг эзэлдэг аж. Тэтгэвэр, тэтгэмж ихэнх өрхийн амьжиргааны гол эх үүсвэр болж байгаа бөгөөд үүнээс өндөр насны тэтгэвэр хамгийн их (76.6%) хувийг эзэлж байгаа нь нийт судалгаанд хамрагдсан өрхийн дотор 27.8%-д нь ногдож байна. Зээл, мөнгөн тусламж нь нийт өрхийн орлогын 3.1-4.9%-ийг эзэлж, мөнгөн тусламж дотор улсаас үзүүлсэн тусламж нь 88.9%-ийг эзэлж байна. Бусад орлого дотор нийт судалгаанд хамрагдсан өрхийн 20 буюу 2.7% нь хог түүх, 9 буюу 1.2% нь гуйлга гуйх байдлаар орлого олж байна.

Зураг 2.5.1. Өрхийн сарын орлогын эх үүсвэрийн эзлэх хувь





Өрхийн сарын дундаж орлогыг нэг гишүүнд оногдох мөнгөн дүнгээр гаргаж, бүс нутаг тус бүрээр АБТ-тэй харьцуулан үнэлгээ өгөхөд судалгаанд хамрагдсан нийт өрхийн 381 буюу 60% нь нэн ядуу, 209 буюу 32.5% нь ядуу өрх эзэлж байна. (Хүснэгт 2.5.4.)

Хүснэгт 2.5.4. Өрхийн нэг гишүүнд оногдох сарын орлого*амьжиргааны түвшний үнэлгээ

Орлогын ангилал	Аймаг, хот										Улсын хэмжээнд	
	Улаанбаатар		Хэнтий		Говь-Алтай		Архангай		Дорноговь		б/тоо	%
8 300>	157		38	64,4%	62	79,5%	31	62,0%	31	36,0%		
8 300-8 500	8						1		1		381 ^a	60,0%
8 600-10 500	54	59.1%	3		8		8		7			
10 600-21 200	109		16	27.1%	7	19.2%	6	30.0%	27	40.6%		
21 300-26 500	16	33.8%	2	3,4%					7	8,1%	209 ^b	32.5%
26 600-30 000	5	1,4%					1	2,0%	4	4,7%	10	1,6%
31 000-40 000	15	4,1%			1	1,3%	3	6,0%	3	3,5%	22	3,4%
41 000-60 000	5	1,4%							4	4,7%	9	1,4%
60 000<	1	,3%							2	2,3%	3	,5%
Нийт	370	100.0%	59	100%	78	100%	50	100%	86	100%	643	100%

a. Нэн ядуу өрх



b. Ядуу өрх

▪ **Ядуу өрхийн хоол хүнсний хангамж, баталгаа**

Өрхүүд сарын хоол хүнсээ янз бүрийн замаар олж авч байгаагаас дийлэнх нь ганц эх үүсвэрээс (68.8%) олж авч байна. Өрхийн хоол хүнсээ олж авдаг арга замуудыг авч үзвэл худалдан авах замаар ихэнх өрх (судалгаанд хамрагдсан өрхийн 84%) хоол хүнсээ олж авч байгаа бөгөөд харин нийт өрхийн 24.9% нь зээлээр, 11.8% нь гуйлгаар, 7.8% нь 5.1% нь ах дүүгийн тусламжаар хоол хүнсээ олж авдаг байна. (Зураг 2.5.2.)

Зураг 2.5.2. Өрхийн хоол хүнсээ олж авдаг арга замууд

Зураг 2.5.3. Өрхийн зохистой хоол хүнсний талаарх мэдлэг



Өрхийн сарын хоол хүнсэнд хэрэглэж буй хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг судлахад судалгаанд хамрагдсан нийт өрхийн 34.5% нь хоёр нэр төрлийн, 24.2% нь гурван нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг түлхүү хэрэглэдэг гэж хариулжээ. Ганц нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн хэрэглэдэг 43 өрх байгаа нь нийт өрхийн 5.9%-ийг эзэлж байсан ба тэдний 11 нь зөвхөн мах иддэг, 28 нь зөвхөн гурил иддэг гэж хариулжээ.

Хоол хүнсний хэрэглээг хүнсний бүтээгдэхүүний нэр төрлөөр нь авч үзвэл: судалгаанд хамрагдсан нийт өрхийн 96% нь гурил, гурилан бүтээгдэхүүн, 90.4% нь мах (үүнээс 19% нь дан малын цувдай, дотор махаар хооллодог), 49.9% нь будааг, 43.9% нь төмс, хүнсний ногоог, 17.2% нь сүү, сүүн бүтээгдэхүүн, ердөө 5.2% нь жимс, жимсгэнийг сарын хоол хүнсэндээ хэрэглэдэг байна. Үүнээс харахад гурил, гурилан бүтээгдэхүүнийг өрхүүд мах, махан бүтээгдэхүүнээс илүү түлхүү хэрэглэж, будаа, төмсийг нийт өрхийн ердөө тал нь хэрэглэж байгаа бол монгол хүний гол эрүүл мэндийг тэтгэгч сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээ эрс багасч, эрдэс бодис, аминдэмийн гол эх үүсвэр болсон жимс, жимсгэнийг хамгийн бага хэрэглэж байна.

Мөн түүнчлэн энэхүү хэрэглээ хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж, элдэв өвчлөлтийг нэмэгдүүлж байгаа нь цаашид монгол хүний хоол хүнсний бүтцэд өөрчлөлт хийх шаардлагатайг харуулж байна.

Баримт: Би насанд хүрээгүй 3, үүнээс 2 нь 5 хүртэлх насны хүүхдийн хамт амьдардаг, би өөрөө эрхэлсэн ажилгүй тул өрхийн орлогыг гуйлга гуйж, зарим үед айлд ажил хийж олдог. Иймд хоногийн хоолондоо маш бага мөнгө зардаг ихэвчлэн малын гэдэс дотроор ходоодоо борлуулдаг. Юмны үнэ байнга нэмэгдэж байгаа болохоор хоол хүнсээ авч чаддаггүй.

Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 16-р хорооны 14-343 тоотод оршин суугч иргэн өрх толгойлсон эмэгтэй Я.Нандинцэцэг

Өрхийн сарын хоол хүнсэнд хэрэглэж буй хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл нь тухайн өрхийн нэг гишүүнд сард оногдох орлогын хэмжээнээс хамаарч, өрхийн орлого нэмэгдэх тутам сард хэрэглэх хүнсний нэр төрөл олширч байгаа ба үүнийг корреляци холбоог тогтоох анализ хийхэд $R_{xy}=0.4$ гарч энэ хоёр үзэгдэл хоорондоо шууд дунд зэргийн хамааралтай гарсан нь $P=0.01$ буюу 99%-аар батлагдаж байна. (Хүснэгт 2.5.5.)



Хүснэгт 2.5.5. Өрхийн нэг гишүүнд оногдох орлого ба хоол хүнсний нэр төрөл хоёрын хоорон дахь хамаарал

Орлогын ангилал	Хүнсний нэр төрлийн тоо						Нийт
	1	2	3	4	5	6	
8 300>	24	141	79	51	19	4	318
8 600-10 500	5	24	19	23	7	2	80
10 600-21 200	1	33	55	48	19	9	165
21 300-30 000	1	4	4	5	16	5	35
31 000-40 000	1	1	2	9	6	3	22
40 000<		1		3	3	5	12
Нийт	32	207	161	143	71	28	642


a. rxy=0.4; P=0.01

Өрхийн судалгаанд шууд оролцсон гишүүдийн зохистой хоол хүнсний талаарх мэдлэгийг тогтооход: Нийт өрхийн 54.7% буюу ихэнх өрх нь маш бага мэдлэгтэй байсан ба зохистой хоол хүнсний талаарх ойлголтыг 6 хариултад багтаан бичсэнээс дээрх өрхүүд зөвхөн нэгийг л онож хариулсан бөгөөд 23% нь 2 хариултыг онож, хариултын хувилбар олон болох тутам онож хариулсан өрхийн тоо эрс багассаар 6 хариултыг онож хариулсан өрх нийт өрхийн ердөө 1.2%(9)-ийг эзэлж байлаа. (Зураг 2.5.3.)

Өрхүүдийн өнгөрсөн 12 сард идсэн хоол хүнсний талаарх тэдний санаа бодлыг судлахад: Нийт өрхийн 46.1% буюу бараг тал хувьд нь тэдний өнгөрсөн 12 сарын туршид идсэн хоол хүнс нь зарим үед хүрэлцдэггүй байсан бол 24.8%-д нь хоол хүнс нь хүрэлцээтэй байсан боловч нэр төрлийн хувьд ядмаг байсан, 18.5%-д нь огт хүрэлцдэггүй байсан байна. (Зураг 2.5.4.)

Судалгаанд хамрагдсан өрхүүдийн хүнсний хангамж, баталгаа ямар түвшинд байгааг өнгөрсөн 12 сард идсэн хоол хүнсний хангамжтай холбоотой 17 асуулт бүхий асуулгаар тодруулан асууж, дүгнэн 4 үндсэн түвшингээр үнэлгээ өгөв. Ингэхэд нийт судалгаанд хамрагдсан өрхийн хүнсний хангамж, баталгаа 35.3%-д нь алдагдаж, өлсгөлөнд хүчтэй нэрвэгдсэн байгаа нь хамгийн их өрхийг эзэлж байна. Мөн өрхийн хүнсний хангамж, баталгаа нийт өрхийн 28.3%-д нь алдагдаж, тэд өлсгөлөнд дунд зэрэг нэрвэгдсэн бол 24.8% нь хүнсний хангамж, баталгаа алдагдсан ч өлсгөлөнд нэрвэгдээгүй, 11.6%-д нь хүнсний хангамж баталгаа алдагдаагүй байна. (Зураг 2.5.5.)

Зураг 2.5.4. Өрхийн хүнсний хүрэлцээ



Зураг 2.5.5. Өрхийн хүнсний хангамж, баталгааг үнэлэх түвшин



Үүнийг тэдний амьжиргааны түвшинтэй харьцуулахад өрхийн хүнсний хангамж, баталгаа тухайн өрхийн орлогоос шууд хамааралтай байна. Энэ нь корреляцийн анализ хийхэд $R_{xy} = -0.6$ гарч хоёр хүчин зүйл хоорондоо шууд бус дунд зэргийн хамааралтай байгаа нь $P = 0.01$; 99%-ийн үнэн магадтай байна. Өөрөөр хэлбэл, Өрхийн орлого буурах тутам өрхийн хүнсний хангамж, баталгаа алдагдаж буй түвшин ихсэж байгааг баталж байгаа хэрэг. Тухайлбал, өрхийн орлого буурах тутам өрхийн хүнсний хангамж, баталгаа алдагдаж, улмаар нэн ядуу өрх өлсгөлөнд хамгийн их хүчтэй нэрвэгдэж байна. Нэн ядуу 381 өрхийн хамгийн хувь нь буюу 45% нь өлсгөлөнд хүчтэй нэрвэгдэж байхад ядуу өрхийн хамгийн их хувь нь буюу 50.7% нь хүнсний хангамж, баталгаа алдагдсан боловч өлсгөлөнд нэрвэгдээгүй байгаа өрх эзэлж байна. Гэтэл АБТ-ээс дээгүүр амьдарч буй 70 шахам өрхийн хамгийн их хувь буюу 64% нь хүнсний хангамж, баталгаа алдагдаагүй түвшинд амьдарч байна. (Хүснэгт 2.5.6.)

Өрхийн хүнсний хангамж, баталгаат байдалд хот, хөдөөгийн ялгаа байгаа эсэхийг нягтлахад: Хот, хөдөөд хоёуланд нь өрхийн хүнсний хангамж, баталгаагүй байдал болон өлсгөлөнд нэрвэгдсэн өрх нийт өрхийн тал болон талаас илүү хувийг эзэлж байгаа бөгөөд хотод нийт өрхийн 66.3% нь хүнсний хангамж, баталгааны сүүлийн 3, 4-р түвшинд байгаа нь хөдөөгийн өрх(53%)-өөс арай илүү байна. Мөн хотод амьдарч буй өрхүүд хөдөөгийн өрхүүдтэй харьцуулахад өлсгөлөнд илүү хүчтэй нэрвэгдэж байна. (Хүснэгт 2.5.7.)

Хүснэгт 2.5.6. Хүнсний хангамж баталгаа өрхийн орлогоос хамаарах нь

Өрхийн нэг гишүүнд оногдох сарын орлого	Хүнсний хангамж баталгааны түвшин				Нийт
	хүнсний баталгаа тай	хүнсний баталгаагүй боловч өлсөөгүй	хүнсний баталгаа алдагдаж, өлсгөлөнд нэрвэгдэж байгаа	хүнсний баталгаа алдагдаж өлсгөлөнд хүчтэй нэрвэгдсэн	
8 300>	3	42	111	163	319
8 300-8 500		1	6	3	10
8 600-10 500	8	24	31	17	80
10 600-20 000	21	82	37	25	165
21 300-26 500	13	8	4		25
26 600-30 000	7	2	1		10
31 000-40 000	13	7		2	22
41 000-60 000	8	1			9
60 000<	2	1			3
Нийт	75	168	190	210	643

а. $R_{xy} = 0.6$; $P > 0.01$

Нийт өрхийн 91.5% нь бүх хоол хүнсээ худалдан авахаас өмнө мөнгөө дуусчихдаг байснаас зохистой хоол хүнс хэрэглэж чаддаггүй байсан ба судалгаанд хамрагдсан өрхийн 58%-д нь насанд хүрсэн гишүүд хоолны хэмжээг хасдаг байсан, үүний 43.3% нь “бараг сар бүр хоолны хэмжээг хасах тохиолдол байсан” хэмээн хариулж байна. Ихэнх өрхүүд өдөрт 1 удаа халуун, махан хоол иддэг, ихэвчлэн гурилаар хуурай бин хайрч иддэг бөгөөд бин нь тэдний хувьд иддэг гол хоол нь аж. Насанд хүрсэн өрхийн гишүүдийн 66.9% нь цадталаа иддэггүй байна. Тэрчлэн нийт өрхийн 44.6% нь хоол хүнс хүрэлцдэггүй байснаас насанд хүрсэн гишүүд нь бүтэн өдөр хоолгүй өнжиж бөгөөд тэдгээрийн 38.9%-д нь бараг сар бүр, 46.5%-д нь зарим сард хоолгүй өнжих тохиолдол байдаг байна. Нийт өрхийн тэргүүний 46.2% нь бүтэн өдөр хоолгүй өнжиж байснаас 24.6% нь “жин хасагдсан” гэж хариулжээ.

Хүснэгт 2.5.7. Өрхийн хүнсний хангамж баталгаа, хот, хөдөөгөөр

% of Total

Аймаг, хот	Хот, хөдөө	ТҮВШИН				Нийт
		хүнсний Баталгаатай	хүнсний баталгаагүй боловч өлсөөгүй	хүнсний баталгаа алдагдаж, өлсгөлөнд нэрвэгдэж байгаа	хүнсний баталгаа алдагдаж өлсгөлөнд хүчтэй нэрвэгдсэн	
Улаанбаатар	хот	7,6%	16,8%	18,4%	23,7%	66,5%
Хэнтий	хот	1,7%	1,5%	2,1%	2,7%	8,1%
	хөдөө	1,3%	9,4%	12,8%	9,4%	32,9%
Говь-Алтай	хот		,9%	1,2%	6,5%	8,6%
	хөдөө	,7%	8,7%	15,4%	8,7%	33,6%
Архангай	хот	,5%	2,9%	4,0%	1,2%	8,6%
Дорноговь	хот		1,7%	1,2%	5,3%	8,2%
	хөдөө	16,8%	10,1%	6,0%	,7%	33,6%
Нийт	хот	9,8%	23,9%	26,8%	39,5%	100,0%
	хөдөө	18,8%	28,2%	34,2%	18,8%	100,0%

Өрхийн хүнсний хангамж, баталгааны түвшингийн байдалд өрхийн доторх гишүүдийн ялгаа байгаа эсэхийг нягтлахад: Өрхийн хүнсний хангамж, баталгааны түвшинг тогтоох нийт 17 асуултын 8 нь хүүхдийн хоол хүнсний хангамж баталгаа алдагдаж байгааг батлах асуултууд байсан ба дээрх асуултуудад нийт өрхийн 70.9% нь баталсан хариу өгсөн нь насанд хүрсэн бусад гишүүдийн хоол хүнсний холбоотой асуултуудад баталсан хариулт(65.4%)-аас бага зэрэг илүү байна. Энэ нь нэгд, өрхийн хүнсний хангамж, баталгаа алдагдахын хэрээр тухайн гэр бүлд өсч, бойжиж буй хүүхдүүдийн хүнсний хангамж, баталгаа мөн л алдагдаж хүүхэд хоол тэжээлийн дуталд орох үндэс суурь болж байна, хоёрт, тухайн гэр бүлд амьдарч буй хүүхдүүд бусад насанд хүрсэн хүнээс илүү өлсөж байдаг хандлага ажиглагдаж байгаа нь өрхийн эзэд эхлээд хүүхэддээ хоол хүнсээ өгөхөөс илүү өөрсдийгөө бодох буюу эсвэл яг адилхан жишгээр хооллох хандлага байгааг харуулж байна. Тухайлбал, Өрхийн насанд хүрсэн хүмүүс зохистой хоол хүнс хэрэглэж чаддаггүй байсан айл өрх нийт өрхийн 85.8%-ийг эзэлж байсан бол хүүхдүүдээ зохистой, сайн чанарын хоол хүнсээр тэр бүр тэжээж чаддаггүй байсан өрх 87.4%-ийг эзэлж байна. Мөн нийт өрхийн 66.9%-д нь насанд хүрсэн гишүүд цадталаа иддэггүй байхад, нийт өрхийн 77.3%-д нь хүүхдүүд цадталаа иддэггүй байна. Энэ байдал нь “Хүүхдийн эрхийг хамгаалах тухай” хуулийн 12 дугаар зүйлийн 1.1-д заасан “эцэг, эх асран хамгаалагч нь хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, амьдрах эрүүл саруул, аюулгүй орчин бүрдүүлэх, нэн шаардлагатай хоол хүнс ... зэргээр хангах” үүргээ биелүүлэхгүй байгаагийн нэг илрэл болой.

Судалгаанд хамрагдсан өрхүүдийн ихэнх нь манай улсын нийгмийн эмзэг бүлэг болох ядуу, тэр дундаа нэн ядуу өрх эзэлж байсан бөгөөд ЭЗНСЭ-ийн Хорооноос гаргасан Ерөнхий зөвлөмж №12-ын 28-д “Оролцогч улс эдийн засгийн тэгшитгэл, эдийн засгийн уналт, цаг уурын хүчин зүйл болон бусад хүчин зүйлүүдээс шалтгаалан нөөцийн хязгаартай болсон үед хүртэл хүн амын эмзэг бүлэг болон хувь хүмүүст зохистой хоол хүнсээр хангагдах эрхийг нь баталгаажуулах шаардлагатай” гэж зөвлөсөн байдаг. Тэгвэл тэдгээр хүмүүс, айл өрх, тэнд өсч бойжиж буй хүүхдүүд өнөөдөр хоол хүнсний хангамж, баталгаагаа алдсан, хэрэглэж буй хоол хүнс нь нэр төрлийн хувьд туйлын ядмаг ихэнх өрхүүд ердөө 2 нэр төрлийн хоол хүнс тогтмол

хэрэглэж, зарим үед хоосон хонодог өрх, түүний дотор хүүхдүүд багагүй байгаа бөгөөд тэдгээр хүмүүс нэг ёсондоо “өлсгөлөнгийн байдалд оржээ” гэж дүгнэхэд хэлсдэхгүй боловуу.

Тэгвэл улсаас эдгээр ядуу өрхүүдэд хоол хүнсний болон орлогын ямар нэг тусламж, дэмжлэг үзүүлж байсан эсэх талаар өрхүүдээс асуухад судалгаанд хамрагдсан нийт өрхийн 178 буюу 24.4% нь ямар нэг тусламж дэмжлэг, хөтөлбөрт хамрагдаж байсан байна. Ядуу өрхүүдэд үзүүлж буй тусламж дэмжлэгийг аймаг, хот, дүүрэг, хорооны засаг захиргаа, албан газар зэрэг орон нутгийн засаг захиргаанаас гадна, “Дэлхийн Зөн-Монгол” ОУ-ын байгууллага, “Улаанзагалмай” нийгэмлэг зэрэг олон улсын хүмүүнлэгийн байгууллагаас үзүүлж байсан байна.

Тэдний ойлгож ярьж байгаагаар ямар нэг тусламж дэмжлэгт хамрагдсан өрхүүдийн 38.5%-д нь “Дэлхийн зөн-Монгол” Олон улсын тусламжийн байгууллага, 27.6%-д нь Олон улсын “Улаанзагалмай” Нийгэмлэг, 24.1%-д нь орон нутгийн засаг захиргаа, 9.2%-д нь байгууллага, аж ахуйн нэгжээс тусламж, дэмжлэг үзүүлсэн байна. Тэдгээр байгууллагуудаас үзүүлсэн тусламж, дэмжлэгийн хэлбэрийг авч үзвэл: нийт тусламжийн 90.8%-ийг хүнсний зүйл, 5.7%-ийг ахуйн бусад тусламж, 2.3%-ийг мөнгөн тусламж, 1.1%-ийг бусад дэмжлэг эзэлж байна.

“Улаанзагалмай” Нийгэмлэгээс Хэнтий аймгийн сумуудын ядуу айл өрхүүдэд ногооны үр тараасан нь зарим өрх зундаа ногоо тарьж, түүгээрээ намар, зарим нь өвлийн ногооны хэрэгцээгээ хангаж байгаа аж.

Манай улсад 5 хүртэл насны хүүхдэд улсаас хоол тэжээл, түүнийг орлох аминдэм, эрдэс бодисын бэлдмэлээр тусгайлан хангах олон хөтөлбөр, төслүүд хэрэгжиж, тухайн орон нутгийн өрхийн эмнэлгүүдээр дамжуулан олгодог болоод хэдэн жил болж байгаа билээ. Тухайлбал, Манай Засгийн газар НҮБ-ын Хүүхдийн Сантай хамтран хэрэгжүүлж буй “Хүүхдийг хөхөөр хооллох, өсөлтийг дэмжих” төслийн ажлын хүрээнд 1998 оноос эхлэн 5 хүртэл насны хүүхдийг өндөр тунтай А аминдэмийн тосон бэлдмэлээр жилд 2 удаа бүх хүүхдийг хамруулан хангаж байгаа аж.¹⁴

Бидний судалгаанд 5 хүртэл насны хүүхэдтэй 385 өрх хамрагдсан ба тэдгээрийн 54-т буюу нийт өрхийн 14%-д нь хүүхдүүдэд нь улсаас тусгайлан хоол тэжээлийн бодисуудыг орлох бэлдмэлээр хангасан байна. Тэдгээр бэлдмэлүүдийн дотор А аминдэм 81.1%-ийг эзэлж, хоол тэжээл 17%, эрдэс бодис 1.9%-ийг эзэлж байна. Эндээс харахад А аминдэмийн хангалтын байдалд давхар дүгнэхэд энэ ажил нь үнэн хэрэгтэй амьдрал дээр бараг хэрэгжихгүй, шаардлагатай өрх, хүүхдүүдийг бүрэн хамруулж огт чадахгүй байна.

Баримт: Хэнтий аймгийн Баян-Овоо сумын 4-р багт амьдардаг Т.Дугар гэгч айл 5 хүртэлх насны ихэр 6 хүүхэдтэй. Нөхөр нь хөдөө айлд мал маллаж, бусад нь тодорхой эрхэлсэн ажил байхгүй. Халамжийн төвөөс нэг хүртэлх насны 2 хүүхдэд нь хүүхэд асарсны мөнгө өгдөг. “Улаан загалмай” Нийгэмлэгээс гурил, будаа, хувцас зэргээр хангадаг. Харин хүүхдүүдэд нь А аминдэм зэрэг бэлдмэл өгч байгаагүй гэнэ.

■ Өрхүүдийн санал - Эцэст нь өрхүүдээс өрхийн хүнсний хангамж, баталгааг сайжруулах талаар тэдний санаа бодлыг сонсож, өрхүүд маш олон санал хэлснийг ойролцоо саналаар бүлэглэн тархалтыг гаргахад нийт өрхийн 27.5% нь улсаас хоол хүнсний тусламж, дэмжлэг хүсч, 26% нь ажилтай болохыг хүссэн, 10.5% нь зах зээлд борлогдож буй хүнсний бүтээгдэхүүний үнийг багасгах, 7.3% нь цалин, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэх болон бусад үлдсэн өрхүүд улсаас мөнгөн тусламж, хөнгөлттэй зээл, баталгаатай хүнсээр хангах, малжуулах зэрэг санал хүсэлт тавьсны дээр 7 өрх хүүхдийн хоолны чанар, баталгааны талаар төрийн бодлогод тусгах талаар санал дэвшүүлж байна.

¹⁴ “А аминдэм хангалтын тандалт судалгааны дүнгээс” илтгэл Э.Эрдэнэчимэг, Н.Амардулам, НЭМХ, “Хоол тэжээл-Эрүүл мэнд” Онол практикийн бага хурал, 2002 он 41-р тал

ГУРАВДУГААР ХЭСЭГ: ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ

Дүгнэлт

➔ Зохистой хоол хүнсээр хангагдах эрхийн эрх зүйн зохицуулалт

1. Хүн амын зохистой, аюулгүй хоол хүнсээр жигд хүртээмжтэй хангагдах эрхийг олон улсын түвшинд ерөнхийд нь хүний ХҮНСНИЙ ЭРХ гэсэн ухагдахуунд хамааруулан ойлгож, үүнийг хангахын тулд хүний эдлэх ёстой нийгэм, соёлын бусад эрхтэй салшгүй холбоотой “өлсгөлөнгөөс ангид байх” үндсэн эрх болон “зохистой хоол хүнсээр хангагдах эрх” гэсэн 2 эрхэд гол анхаарлаа хандуулж, улс орнуудыг уг 2 эрхийг төрийн хууль, тогтоомжоор баталгаажуулахын чухлыг онцлон тэмдэглэсэн байна.

2. Манай улс зохистой хоол хүнсээр хангагдах эрхийг Үндсэн хуулиндаа шууд утгаар нь тусгаагүй байна. Харин уг эрхийн хувьд гол хууль бол манайд 1999 оны “Хүнсний тухай” хуулийн шинэчилсэн найруулга болж байна. Гэтэл уг хуулинд хүнсний эрх гэдэг ойлголт бас шууд утгаараа тусгагдаагүй байгаа бөгөөд манай улсад нэг ёсондоо хүн амын зохистой хоол хүнсээр хангагдах эрх үндсэндээ эрх зүйн ямар ч зохицуулалтгүй болжээ гэж хэлэх үндэслэлтэй болж байна.

3. “Хүнсний тухай” дээрх хуулийг заавал “шинэчилсэн найруулга” хэмээн тодотгон хэлэх болсон цаад утга нь анх манай улс 1995 онд “Хүнсний тухай” хуулийг батлан гаргаж байсан байна. Уг хуулинд хүнсний эрхийн асуудлыг нилээд ойлгомжтой нарийн тусгаж, хүн амын зохистой хоол хүнсээр хангагдах эрхийг хэрэгжүүлэхэд төр засгийн үүрэг ролийг нилээд нарийн тусгасан байжээ. Гэтэл 1999 оны хуулийн шинэчилсэн найруулга дээр уг эрхтэй холбоотой, хүнсний хангамж, баталгаатай холбоотой бараг бүх заалтуудыг өөрчлөн хуулиас зарим чухал заалтуудыг шууд хассан нь уг хуулийн гол ач холбогдлыг бууруулахад хүргэсэн байна.

4. Одоо мөрдөж байгаа “Хүнсний тухай” хууль нь “хүн амын хүнсний хангамж, баталгаа” гэдгийг тодорхойлоогүй, түүнийг төрөөс хэрхэн зохицуулж, хүн амаа өлсгөлөн, хоол тэжээлийн дутлаас хамгаалахыг тусгаж өгөөгүй байгаа нь төр ард түмнийхээ хүнсний хангамж, баталгааг хангаж, өөрсдийгөө, гэр бүлээ хүрэлцээтэй хоол хүнсээр хангаж, өлсөхгүйгээр амьдрах эрх зүйн орчныг бүрдүүлж чадаагүй байна. Үүнээс болж улс орны хүнсний хангамжийн асуудал нь урсгал байдалтай болж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрлэл, ажиллах хүчнийг ашиглан хангах асуудал туйлын доод түвшинд хүрснээс тэдгээр бүтээгдэхүүнийхээ ихэнх хувийг гадаад зах зээлээс импортоор хангах болжээ. Энэ нь улмаар улс орны хүнсний хараат бус байдал өнөөдөр алдагдаад байгаа гол шалтгаан болж байна.

5. “Хүнсний тухай” энэхүү хуульд Монгол улсын хүнсний хангамж, баталгаат байдлын гол илтгэгч үзүүлэлт болсон стратегийн хүнс буюу бодлогоор зохицуулах ёстой хүнсний нэр төрөлд монгол хүн хэрэглэж дадсан, хүний физиологийн хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай сүү, цагаан идээ ороогүй байгаа нь хүн амын тухайн хүнсний хэрэглээ багасч хоол тэжээлийн дуталд орох, улмаар хоол хүнснээс шалтгаалсан хоол боловсруулах өвчлөл ихсэхэд нөлөөлсөн байж болох талтай.

➔ Хүнсний хангамж, баталгаа

6. Манай улс хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн болох мах, сүүг дотоодын үйлдвэрлэлээр үндсэнд нь хангаж байгаа мэт боловч сүүг их хэмжээгээр импортолж байгаа нь монгол хүний сүү, цагаан идээний физиологийн хэрэгцээг үндэслэл муутай тогтоож, энэ хэмжээг хэт доогуур нормчилсноос сүүний жилийн хэрэгцээ үндсэндээ хангасан үзүүлэлттэй гардаг байж болох талтай байна. Харин бусад нэр төрлийн

хүнсний бүтээгдэхүүний хувьд өнөөдөр манай улс оронд тэдгээрийг хангах хангамж баталгаа алдагдаж, улмаар хүнсний хангамжийн байдал гадаад зах зээлээс шууд хараат болжээ.

7. Төр засгаас хүнсний хангамж баталгаат байдлын энэ алдагдлыг багасгах, дотоодын үйлдвэрлэлийг сэргээх талаар бодлого, хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэн тодорхой ажил хийж байгаа боловч энэ нь дотоодын хөрөнгө санхүүгийн эх үүсвэр дутмаг, зохион байгуулалт муутайгаас тодорхой нүдэнд харагдаж, мэдрэгдэх үр дүнд хүрч тэр бүр чадахгүй байна.

8. Төрөөс батлан хэрэгжүүлж байгаа хүнс, хөдөө аж ахуйн бодлого нь үндсэндээ уналтанд орсон хөдөө аж ахуйг сэргээх, хангамж баталгааг хангахад чиглэж байгаа ч хүний хөдөлмөр, хөрөнгө мөнгөний оролцоогүй өөрөө нөхөн төлжиж байдаг, хүн амд дутагдаад байгаа хоол тэжээлийн чухал хэрэгцээт шимт бодисуудын эх үүсвэр болсон экологийн цэвэр байгалийн асар их нөөцийг ашиглаж, зарцуулж, түүгээр хүн амаа хангах асуудлыг орхигдуулж байгаа нь нөөц баялгаа бүрэн ашиглаж чадахгүй байгаа нэг том илрэл болж байна.


➔ Хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдал

9. Хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах хууль, эрх зүйн орчин өнөөдөр үндсэндээ бүрдээд байна гэж дүгнэж болох авч, хууль тогтоомжийг биелүүлэх асуудлууд амьдрал дээр бүрэн хэрэгжихгүй байна. Энэ нь нэгд хүнсний аюулгүй байдлыг хангах төрийн зохицуулалт ялангуяа импортын хүнсний аюулгүй байдлыг хангах асуудал дээр ямар нэг хориг арга хэмжээ үгүйлэгдэж байна. **Хоёрт**, хүнсний хангамжийн сүлжээ үндсэндээ хувийн секторт шилжсэнтэй холбоотой хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаалалт, импортлолтыг хэн хүссэн нэг нь эрхэлж байгаа тул тэдгээр хүмүүсийн мэргэжил, мэдлэг, ухамсар, хөрөнгө мөнгөний бололцооноос хүнсний аюулгүй байдал шууд хамаарч байна. **Гуравт**, хүнсний аюулгүй байдалд тавих хяналтын үйл ажиллагаа “Хүнсний тухай” хуулийн заалтуудтай зөрчилдөж, зарим хяналт хийдэгдэх, эсвэл хяналтын зарим ажлууд давхардаж болох хандлагатай байгаа бөгөөд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлын үзүүлэлтүүд болон хяналт тавих дүрэм, стандарт байхгүй, шинжилгээ хийх лабораторийн хүчин чадал сул, ялангуяа импортын хүнсний бүтээгдэхүүн орж ирдэг хилийн хяналтын боомтууд дээр лабораторийн хяналтын шинжилгээ огт хийгдэхгүй байгаа зэрэг зөрчил дутагдлаас шалтгаалан хүнсний аюулгүй байдал алдагдах үндсэн нөхцөл болж байна.

➔ Хоол тэжээл

10. Хүн амыг хоол тэжээлийн дутал, өлсгөлөнгөөс ангид байлгах төрийн гол үүрэг хууль, эрх зүйн ямар ч зохицуулалтгүй байгаагаас хүн амын дунд хоол тэжээлийн дуталтай холбоотой өвчлөл, эрүүл мэндийн эрсдэл манай улсын гол тулгамдсан асуудал болоод байна.

11. Хүүхдийн хоол тэжээлийн асуудал үндсэндээ “Хүүхдийн эрхийг хамгаалах тухай” хуулиар үндсэндээ зохицуулагдаж байна. Уг хуулийн дагуу олон хөтөлбөр, төсөл хэрэгжүүлж байгаа ч өнөөдөр хүүхдийн тэжээлийн дутал тулгамдсан асуудал хэвээр байна. Ялангуяа цэцэрлэг, сургуулийн насны хүүхдүүдийн хоол тэжээлийн байдал туйлын доод түвшинд аминдэм, шимт бодисын дутагдалтай хоол хэрэглэж байгаагаас энэ насны хүүхдүүд тэжээлийн доройтолтой, өлсгөлөн, хагас өлсгөлөн байдалд байна.



➤ Өрхийн хүнсний хангамж, баталгаа

12. Манай улсад ядуурал 2003 оны байдлаар өмнөх түвшингөөсөө буураагүй буюу нийт хүн амын 36.1%-ийг ядуу хүн ам эзэлж байгаа энэ үед тэдгээр өрхийн хүнсний хангамж, баталгаа амьжиргааны түвшинтэй шууд хамааралтай байгаа нь статистик үнэн магадлалтай байгаа ба тэдний өрхийн орлого буурахын хэрээр хэрэглэж буй хүнсний нэр төрөл эрс цөөрч, хүнсний хангамж баталгаа алдагдан, өлсгөлөнгийн байдалтай амьдарч байна. Тэдгээр ядуу өрхүүд хоол хүнсээр өөрсдийгөө хангах эдийн засгийн чадваргүй болсон байна.

13. Гэтэл тэдгээр ядуу өрхүүдэд зохистой хоол хүнсээр хангагдах эдийн засгийн боломжийг бүрдүүлж, тэнд амьдарч буй хүүхдийн хоол тэжээлийг асуудлыг улсаас тусгайлан хангах асуудал бараг хэрэгжихгүй байна. Мөн ядуу өрхүүдэд үзүүлж буй Олон улсын тусламж, дэмжлэгийг үл харгалзвал улсаас тэднийг харж үзэж, хөрөнгө төсөв огт төсөвлөхгүй байна.

Хойшид санал болгох нь

1. Энэхүү судалгааны дүнгийн талаар хүнсний чиглэлээр ажилладаг, хүнсний асуудалд хяналт, тавьж удирдан чиглүүлдэг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдийн удирдлага болон холбогдох ажилтнуудыг оролцуулан хурал, зөвлөгөөн зохион байгуулах;
2. Дараахь санал, зөвлөмжүүдийг доорхь байгууллагуудад явуулах.
 - a. Засгийн газарт хүнсний тухай хуулинд өөрчлөлт оруулах, хүнсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах, төсөв хөрөнгөтэй холбоотой арга хэмжээ авахуулах, хүнсний аюулгүй байдлын төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох талаар;
 - b. Эрүүл мэндийн яаманд монгол хүний хоол тэжээлийн зөвлөмж хэмжээг шинэчлэн, физиологийн хэрэгцээнд нийцүүлэн өөрчлөх, хүн ам, түүний дотор хүүхдийн хоол тэжээлийн дутлын байдалд дүгнэлт хийж, түүнийг даруй багасгах талаар арга хэмжээ авах, хоол тэжээлийн болон хүнсний аюулгүй байдалд хийж буй судалгаа шинжилгээний ажлыг сайжруулах, эрдэм шинжилгээ судалгааг орчин үеийн дэлхийн түвшинд ойртуулах;
 - c. ХХАА-н Яаманд хүн амын хүнсний хангамжийг үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар, хүн амын дунд тохиолдож байгаа хоол тэжээлийн дутал, өлсгөлөнг бууруулах зорилгод нийцүүлэн сайжруулах, хүнсний үйлдвэрлэлийн, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах замаар хүнсний хараат бус байдлыг дэмжсэн бодлого, үйл ажиллагаа явуулах талаар;
 - d. УМХГ-т хүнсний аюулгүй байдалд тавьж буй хяналт, шалгалтын үйл ажиллагаагаа хууль, эрх зүйн орчиндоо тохируулан сайжруулж, үйл ажиллагааны давхцал, чанарыг сайжруулах, лавлагаа лаборатори байгуулах асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэй хяналт шалгалт хийх зорилгын үүднээс засгийн газарт тавьж, шийдүүлэх, хүнсний аюулгүй байдлын хяналтын дүрэм, аюулгүй байдлын үзүүлэлтүүд боловсруулах талаар;
 - e. БСШУЯ-д хүүхдийн хоол тэжээлийн үйлдвэрлэл, хүүхдийн сувиллын хоол болон цэцэрлэг, сургуулийн хүүхдийн хоол тэжээл, хүнсний хангамжийн асуудлыг төрийн зохицуулалтанд авч, хүүхдийг хоол тэжээлийн дутлаас сэргийлэх талаар



ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ: АШИГЛАСАН ХЭВЛЭЛИЙН ЖАГСААЛТ


Судалгаанд ашигласан бодлогын баримт бичгүүд

1. “Ариун цэврийн тухай” хууль, 1998 он
2. Газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээх хөтөлбөр, 1998 он
3. “Иод дутлын эмгэгтэй тэмцэх” үндэсний шинэчилсэн хөтөлбөр, 2002 он
4. Монгол улсын олон улсын гэрээ, “Төрийн мэдээлэл” эмхтгэл, тусгай дугаар, Боть 1, УИХ-ын Тамгын Газар, ГХЯ, УБ, 2004 он
 - 1) Хүний эрхийн түгээмэл тунхаглал, хуу. 5
 - 2) Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт, хуу. 32
 - 3) Хүүхдийн эрхийн тухай Конвенц, хуу. 62
5. Мал сүргийг ган, зудаас хамгаалахад туслах үндэсний хөтөлбөр, 2001 он
6. “Малын эрүүл мэнд үндэсний хөтөлбөр, 1999 он
7. Монгол улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого, УБ, 2004 он
8. Нийгмийн эрүүл мэндийн төрөөс баримтлах бодлого, УИХ-ын тогтоол, № 81, 2001 он
9. Өрхийн орлогыг нэмэгдүүлэх “Ногоон хувьсгал” үндэсний хөтөлбөр, 1997
10. Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, УИХ-ын тогтоол, №29, 2003 он
11. Улсын мэргэжлийн хяналтын албаны нийтлэг дүрэм, ЗГ-ын тогтоол, №37, 2003 оны
12. “Үр” дэд хөтөлбөр, 2001 он
13. Хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, ЗГ-ын тогтоол, №242, II хавсралт, 2001 он
14. Хүний эрхийн конвенцүүдийн хорооноос гаргасан ерөнхий санал, зөвлөмжүүдийн эмхтгэл, ЭЗНСЭХ-ны Ерөнхий зөвлөмж 12-ын 11 дүгээр зүйл “Хүрэлцээтэй хоол хүнс хэрэглэх эрх” UNDP, МУХЭХТ, 2004 он (орчуулга), хуу. 52-60
15. Хүний эрхийн олон улсын гэрээний хэрэгжилтийн талаарх монгол улсын ээлжит илтгэлүүд, НҮБ-ын холбогдох хороодын хуралдааны тэмдэглэл, зөвлөмжүүдийн эмхтгэл, УБ, 2004 он
 - 1) ЭЗНСЭ-ийн тухай Олон улсын Пактын хэрэгжилтийн талаархи Монгол улсын ээлжит гурав дахь илтгэл, 1998 он, Пактын 11-р зүйл, 128-134
 - 2) ЭЗНСЭХ-ны Ерөнхий зөвлөмж, 2000 он, хуу. 142
 - 3) Хүүхдийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтийн талаархи Монгол улсын ээлжит хоёр дахь илтгэл, 2003 он, Хоол тэжээл, хуу. 324
16. Хүнсний аюулгүй байдлын хяналтыг сайжруулах зарим арга хэмжээний тухай Монгол улсын Ерөнхийлөгчийн 172 тоот зарлиг, 2000 он
17. “Хүнсний тухай” хууль (шинэчилсэн найруулга), 1999 он
18. “Хүнсний тухай” хууль, 1995 он
19. “Хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол тэжээл” Үндэсний хөтөлбөр, ЗГ-ын тогтоол, № 242, I хавсралт, 2001 он
20. Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр (2002-2010), ЗГ-ын тогтоол, №245, 2002 он
21. “Хүүхдийн эрхийг хамгаалах тухай” Монгол улсын хууль, 1996 он
22. “Цагаан хувьсгал” үндэсний хөтөлбөр, 1999
23. “Шилмэл хээлтүүлэгч” дэд хөтөлбөр, 2002 он
24. “Эрүүл мэндийн тухай” Монгол улсын хууль, 1998 он
25. Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр, 2003 он
26. “Ядуурлыг бууруулах стратеги боловсруулахад хүний эрхийг тусгах нь” Зөвлөмж, ХЭДКГ, НҮБ, 2004 он, Зөвлөмж 6. Зохистой хоол хүнсээр хангагдах эрх, хуу. 24-27
27. Draft Declaration of the World Food Summit: five years later, FAO Headquarters, Rome, Italy, 2002
28. ESCR-The right to food, Report submitted by the Special Rapporteur on the right to food, Jean Ziegler, (E/CN.4/2003/54

29. Report of the United Nations High Commissioner for Human Rights to the Economic and Social Council, Substantive session of 2003, Economic and Social Council, E/2003/100
30. The Right to Adequate Food, Art. 11, 1999, General Comments adopted by CESCR, published by Office of Human Rights Studies and Social Development, Mahidol University, Thailand, p. 119
31. The Right to an Adequate Standard of Living Including the Right to Food, Economic, Social and Cultural Rights” a textbook second revised ed., edited by Asbjorn Eide and etc., 2001

Судалгааны тайлан, илтгэл, ном хэвлэлүүд

32. Амьжиргааны түвшний түүвэр судалгаа, ҮСГ, 1998 он
33. Анагаах ухааны эрдэм шинжилгээний ажлын үр дүн (1994-1996), ЭМЯ, НЭМХ, 1997 он:
 - 1) “Монгол хүний зохистой хооллох үзэл баримтлал” илтгэл, М.Оюунчимэг, ХСТ, хуу. 126
 - 2) Монгол хүний хоол тэжээлийн бодисуудын зөвлөмж хэмжээ, М.Оюунбилэг, Ш.Чадраабал, ХСТ, хуу. 131
 - 3) Цэцэрлэгийн насны хүүхдийн хоногийн хоолны хэм хэмжээ, хооллох дэглэм, З.Ариунбилэг, ХСТ, хуу. 138
34. “Бид хоолондоо хэдэн төгрөг зарцуулах вэ?”, өгүүлэл, Ц.Цэвэгдорж, ЭМШУИС-ын НЭМС, “Эрүүл мэндийн социологи” сэтгүүл, МУИС-ын Нийгмийн ухааны факультет, 2002 он
35. “Монголын нөхцөлд хүнсний бүтээгдэхүүнийг баяжуулах үндэслэл, шаардлага” Онол-практикийн бага хурлын илтгэлүүдийн эмхэтгэл, НЭМХ, “Хүнс тех” Корпораци, “JFPR-9005” төсөл УБ, 2003 он:
 - 1) Хүнсний бүтэц, найрлагын орчин үеийн хандлага, Б.Хүүхэнхүү, хуу. 14-19
 - 2) Монголын нөхцөлд хүнсний бүтээгдэхүүнийг баяжуулах үзэл баримтлалын асуудалд, Л.Дамдинсүрэн, Ч.Оюунчимэг, хуу. 20-27
 - 3) “Экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх асуудалд” илтгэл, Д.Тунгалаг, С.Цэндсүрэн, хуу 141-148
36. “Монгол дахь хүнсний аюулгүй байдал ба хэтийн төлөв” судалгааны тайлан, НЭМХ, ЭМЯ, ДЭМБ, 2004 он
37. Монгол улсын статистикийн эмхтгэл, ҮСГ, 2003 он
38. “Монгол улсын хүнсний бодлогын тулгуур асуудлууд” ном, Л.Дамдинсүрэн, Л.Лхагваа, 2003 он, 39-р тал
39. Нийслэлийн статистикийн эмхтгэл, 2003-2004 он
40. НМХГ-ын Төв лабораторийн Эрүүл зүйн нян судлалын лабораторийн 2004 оны жилийн эцсийн тайлан
41. “Орчин эрүүл мэндийн одоогийн байдал, тулгамдсан асуудал, Нийгмийн эрүүл мэнд шинэ мянганд, НЭМХ, 2001 он, хуу. 30
42. Өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшний түүвэр судалгаанаас, ҮСГ, 2002-2003 он”
43. “Ундны усны шим бохирдолт, усаар дамжих халдвараас сэргийлэх эпидемиологийн хяналтын тогтолцоо, урьдчилан сэргийлэлт” эрдэм шинжилгээний тайлан, Л.Нарантуяа, Ч.Нямрагчаа, НЭМХ
44. “Хоол тэжээл-Эрүүл мэнд” Онол-практикийн бага хурлын илтгэлийн хураангуй, НЭМХ-ийн ХСТ, 2002 он:
 - 1) “Хүн амын хоол тэжээлийн тулгамдсан асуудал, цаашдын зорилт” илтгэл, Д.Эржен, Б.Энхтунгалаг, НЭМХ-ийн ХСТ, Д.Баттөмөр, ЭМЯ, хуу. 12
 - 2) Биеийн жингийн индексийг өрхийн орлоготой холбон судалсан дүнгээс, Б.Энхтунгалаг, НЭМХ-ийн ХСТ, хуу. 29
 - 3) Хүн амын хоол тэжээлийн байдалд зудын хор холбогдлыг үнэлсэн судалгааны дүн, хуу. 31



- 4) “Өсвөр насны хүүхдийн хоол тэжээл, эрүүл мэнд” илтгэл, У.Цэрэндолгор, З.Ариунбилэг ба бус., НЭМХ-ийн ХСТ, хуу. 35
- 5) А аминдэм хангалтын тандалт судалгааны дүнгээс” илтгэл, Э.Эрдэнэчимэг, Н.Амардулам, НЭМХ
- 6) “Цэцэрлэгийн хүүхдийн хоол тэжээлийн өнөөгийн байдал” илтгэл, С.Тунгалаг, НЭМХ-ийн ХСТ, хуу. 42
- 7) “Төсөлд хамрагдах орон нутгийн 5 хүртэлх насны хүүхдийн хоол тэжээлийн байдал” суурь судалгааны урьдчилсан дүнгээс, Д.Эржен, Б.Энхтунгалаг, НЭМХ-ийн ХСТ, хуу. 44
- 8) “Улсын асрамжийн газрын асруулагчдын бодит хооллолтын байдалд хийсэн судалгааны зарим дүнгээс” илтгэл, З.Ариунбилэг ба бус., ХСТ, хуу. 47
- 9) Улаанбаатар хотын хүн амын хөдөлмөрийн насны хүн амын хооллох дадал, түүний талаарх мэдлэг, хандлага, хуу. 50
- 10) Хөхүүл эхчүүдийг цус багадалтаас урьдчилан сэргийлэх асуудалд, хуу. 57
- 11) Хоол тэжээл хүний хөгжлийг бэхжүүлнэ, хуу. 62
- 12) 5 хүртэлх насны хүүхдийн уураг-илчлэгийн дутлыг өрхийн орлого, эхийн боловсролтой холбон судалсан дүнгээс, хуу. 64
- 13) Иоджуулсан давс, бүтээгдэхүүний хэрэглээг иод дутлын эмгэгтэй харьцуулан судалсан дүн, хуу. 74
- 14) “Монгол улс дахь хүнсний аюулгүй байдал” илтгэл, Ц.Содномпил, В.Сүрэнчимэг, ЭМЯ, В.Даваадорж, П.Цэцгээ, ХХААЯ, Г.Батмөнх, НЭМХА, хуу. 115
- 15) “Монгол улсын хүнсний аюулгүй байдлын тулгамдсан зорилтууд” илтгэл, Л.Дамдинсүрэн, хуу. 117
- 16) “Монгол улсад хүнсний аюулгүй байдал, хоол тэжээлийн чадавх бүрдүүлэх нь” илтгэл, В.Сүрэнчимэг, ЭМЯ, хуу. 123
- 17) “Хиамны үйлдвэрлэлийн эрүүл ахуйн нөхцөл, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг сайжруулах асуудалд” илтгэл, Б.Цогзолмаа, Б.Энхтунгалаг, НЭМХ-ийн ХСТ, Ш.Энхцэцэг, ЭМЯ, Г.Цэндсүрэн, Г.Батмөнх, НЭМХА, хуу. 124
- 18) “Монгол улсын хүнсний аюулгүй байдал, хүнсний хяналтын өнөөгийн тогтолцоо, тулгамдсан асуудлууд” илтгэл, Г.Цэндсүрэн, Г.Батмөнх, НЭМХА, хуу. 125
45. “Хоол хүнсний гаралтай өвчлөл, хоолны хордлогын тандалт, хяналт, бүртгэл мэдээлэл” илтгэл, Ш.Уранчимэг, УМХГ, 2004 он
46. “Хүн амын хоол тэжээлийн байдал” Үндэсний судалгаа-2, ЭМНХЯ, НУБ-ын Хүүхдийн сан, НЭМХ-ХСТ, 2000 он
47. “Хүнсний аюулгүй байдал” товхимол, СХЗҮТ, МХЭАХН, 2001 он
 - 1) “Хүнсний аюулгүй байдал” Үндэсний зөвлөлдөх уулзалтад оролцогчдод Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандиас ирүүлсэн илгээлт, хуу. 4
 - 2) Ч.Содномцэрэн “Хүнсний аюулгүй байдал, баримтлах бодлого чиглэл”, хуу. 9-22
 - 3) С.Сонин “Монгол хүний хоол тэжээл, түүний эрүүл ахуйн шаардлага”, хуу. 23-29
 - 4) Ш.Цэндбаяр “Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нөхцөл нь хүнсний аюулгүй байдал”, хуу. 30-36
 - 5) Г.Гомбо “Хүнсний аюулгүй байдлыг хангах гол хүчин зүйл бол төрөөс зах зээлээ хамгаалах, үйлдвэрлэгчдээ дэмжих таатай нөхцөл бий болгох явдал мөн.”, хуу. 37-48
 - 6) Н.Баярмагнай “Хүнсний аюулгүй байдлыг хангах техникийн бодлого, шийдвэрлэх асуудал”, хуу. 49-61
 - 7) Рейо Салмела “Монгол улс дахь хүнсний хангамж, эрүүл ахуйн аюулгүй байдал хоол тэжээлийн байдлын хөгжил”, хуу. 62-67
48. “Хүнсний аюулгүй байдлын тулгамдаж буй асуудлууд” илтгэл Д.Оюунчимэг, Г.Цэндсүрэн, УМХГ, 2004 он
49. Хүнс импортлолт ба эрүүл мэнд” Хүнс импортлогчдын улсын зөвлөгөөнд зориулсан мэдээллийн эмхтгэл, ЭМЯ, ДЭМБ, НЭМХ, 2002 он

- 1) Номхон далайн бүсийн баруун эргийн бүсээс хүнсний аюулгүй байдлын талаар баримталж буй стратеги, хуу. 3
- 2) Хоол тэжээл, хүнсний аюулгүй байдал-Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, хуу. 9
- 3) Хөхний сүү орлуулагч бүтээгдэхүүний импорт, хэрэглээ, маркетинг ба хөхөөр хоололтын байдал, хуу. 48
- 4) Хөхний сүү орлуулагчийн маркетингийн олон улсын хууль
- 5) “Ургамал, амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүнд нитрат, нитритийн агууламжийг тодорхойлсон дүн, эрүүл ахуйн үнэлгээ” илтгэл, Ч.Нямрагчаа, Б.Халзанхүү, НЭМХ-ийн ХСТ, хуу. 55
- 6) ХХААЯ, БНХАУ-ын чанар, хорио цээрийн хяналт шалгалтын ерөнхий газрын хооронд БНХАУ-аас Монгол улсад зарим хүнсний бүтээгдэхүүнийг экспортлох хорио цээр, ариун цэврийн шаардлагын талаар байгуулсан протокол, хуу. 83
- 7) Ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр импорлоход тавигдах шаардлага, хуу. 88
- 8) Монгол улсын засгийн газрын тогтоол, Хилийн хяналтын албадын ажлыг зохицуулах журам, хуу. 92
- 9) Эрүүл ахуй, халдвар судлалын улсын байцаагчаас хилийн гарц, боомт дээр эрүүл ахуй, халдвар судлалын хяналт хийх ажлын заавар, хуу. 101
50. “Хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол тэжээл” үндэсний хөтөлбөрийн биелэлт, 2002-2004 он
51. “Хүнсний хараат бус байдал” үндэсний семинарын материалууд, ХЭХТ, ХЭҮК, 2004 он
 - 1) “Монгол улсын хүнсний аюулгүй байдлын тулгамдсан зорилтууд” илтгэл, Л.Дамдинсүрэн, Монголын хүнсчдийн холбоо
 - 2) “Монголын газар хувьчлал, үр дагавар, тариаланчдын хүнсээ үйлдвэрлэх эрх” илтгэл, Д.Батмөнх, Газрыг шударгаар хувьчлахын төлөө хөдөлгөөн
 - 3) “Монголын хүн амын хүнсний хангамжийн өнөөгийн байдал, сайжруулах арга зам” илтгэл, Санжхүү, ХХААЯ,
 - 4) “Монголын хэрэглэгчдийн хүнсний эрх, хүнсний аюулгүй байдлын асуудлууд” илтгэл, Ц.Дамчаа, Нийслэлийн ХЭАХН
52. Хүнсний хараат бус байдлын тухай үзэл баримтлалын үндэс, ХХББХЦ
53. Хүнсний эрүүл ахуйн ерөнхий шаардлагууд, Хүнсний хууль эрх зүй, ДХХААБ/ДЭМБ, Хүнсний хууль эрх зүйн хороо, Боть-1б, Хоёр дахь хэвлэл, 2001 он
54. Хүнсний эрүүл ахуйн суурь гарын авлага, Хүнсний хууль эрх зүй, ДХХААБ/ДЭМБ, Хүнсний хууль эрх зүйн хороо, Хоёр дахь хэвлэл, 2001 он
55. “Эх хүүхдийн аминдэм, эрдэс бодисын дутлын байдал-Монголд” тайланг танилцуулах уулзалтын материал, НЭМХ, ЭМЯ, UNICEF, 2004 он
 - 1) “Аминдэм, эрдэс бодисын дутлын улмаас Монгол улсад учирч байгаа хохирлын үнэлгээний тайлан” удирдлагуудад зориулсан мэдээ, UNICEF, Хоол тэжээлийн бичил бодисын санаачилга
 - 2) “Эхийн сүү нялхсын “юугаар ч” орлуулашгүй хоол” сурталчилгаа хэвлэмэл хуудаснууд
 - 3) Эх хүүхдийг бичил тэжээлийн дутлаас сэргийлэх стратегийн төслөөс
56. “Эх хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээлийн тулгамдсан асуудлууд, цаашид хийх үйл ажиллагаа” илтгэл, Н.Удвал, Эрүүл мэндийн дэд сайд, Хүүхдийн асуудлаарх үндэсний дээд хэмжээний чуулга уулзалт, УБ, 2004 он, хуу. 38
57. 24 цагийн үйл ажиллагаатай сургуулийн өмнөх боловсролын байгууллагад эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгасан дүнгийн танилцуулга, НМХГ, 2004 он
58. Guide to measuring household food security, Revised 2000, USDA
59. “Human Nutrition in the Developing World” Food and Nutrition Series - No. 29, by Michael C. Latham, FAO, Rome, 1997

60. Michael C.Latham “Human nutrition in the developing world” Food and Nutrition Series-№ 29, FAO, Rome, 1997
61. Nutrition and food poverty, Developing a local nutrition and food poverty strategy, Tool D3
62. Report: Focus group discussions on food security, Karakalpakstan, Uzbekistan
63. ХХААЯ-ны website-аас
64. УМХГ-ын website-аас
65. www.gateway.mn
66. www.fao.org
67. www.hrea.org

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



ТАЙЛАН БИЧСЭН:

ХЭҮК-ЫН ЧАДАВХИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТӨСЛИЙН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨХ
Д.ЧИМЭДДУЛАМ